



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-100

1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	6-65
2.“Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	65-100

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 14-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 75 гишүүн ирж, 59.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Батсүмбэрэл, Б.Батцэцэг, Д.Ганмаа, Т.Мөнхсайхан, О.Саранчулуун, А.Ундраа, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Батбаатар, Х.Болормаа, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Д.Үүрийнтуяа;

Тасалсан: Х.Баттулга, Ж.Энхбаяр;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-1 цаг 13 минут, Н.Алтаншагай-01 минут, С.Амарсайхан-04 минут, Т.Аубакир-02 минут, Х.Баасанжаргал-37 минут, Ц.Баатархүү-18 минут, М.Бадамсүрэн-21 минут, Д.Батбаяр-40 минут, Д.Батлут-11 минут, Э.Болормаа-10 минут, Ш.Бямбасүрэн-05 минут, А.Ганбаатар-01 минут, Д.Ганбат-01 минут, Т.Доржханд-20 минут, Б.Жавхлан-04 минут, Б.Жаргалан-16 минут, Б.Заяабал-01 минут, С.Лүндэг-17 минут, П.Мөнхтулга-02 минут, З.Мэндсайхан-01 минут, Н.Номтойбаяр-1 цаг 04 минут, С.Одонтуяа-10 минут, Б.Пунсалмаа-29 минут, Д.Пүрэвдаваа-01 минут, Ц.Туваан-04 минут, Н.Учрал-02 минут, Г.Уянгахишиг-05 минут, Д.Цогтбаатар-47 минут, Б.Чойжилсүрэн-02 минут, С.Эрдэнэбат-01 минут, Р.Эрдэнэбүрэн-2 цаг 25 минут.

Нэг.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, мөн газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Саруул, мөн газрын мэргэжилтэн Б.Агиймаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс

баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, мөн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Г.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга З.Баярхүү, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга Ж.Мөнх-Оргил, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн мэргэжлийн шинжээч, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, Захиргааны удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн, Геологи, уул уурхайн албаны ахлах инженер А.Алтанхундага, мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр, Г.Жамсрандорж, Я.Ганболд, Д.Баярхүү, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, С.Ганбаатар, Ж.Ганбаатар, П.Сайнзориг, Л.Мөнхбаясгалан, О.Батнайрамдал, Да.Цогтбаатар, Ө.Шижир, Ц.Мөнхбат, Ж.Золжаргал, Б.Уянга, Д.Энхтүвшин, Б.Заяабал, А.Ганбаатар, Д.Пүрэвдаваа, З.Мэндсайхан, Д.Батлут, М.Бадамсүрэн, Х.Баасанжаргал, Б.Түвшин нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн мэргэжлийн шинжээч, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, Геологи, уул уурхайн албаны мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр, Я.Ганболд нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 11 сарын 15-ны Баасан гарагт явуулахаар зарлав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 27 минут үргэлжилж, 12 цаг 27 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 15 цаг 00 минутад эхлэв.

Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Улсын Их Хурлын даргын зөвлөх Р.Алтангэрэл, ажлын хэсгийн зөвлөх У.Хосжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны референт А.Наранцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, С.Ганбаатар, С.Бямбацогт, П.Сайнзориг, О.Номинчимэг, У.Отгонбаяр, М.Мандхай, Л.Соронзонболд, Б.Уянга, Р.Батболд, Ж.Галбадрах, Г.Очирбат, О.Батнайрамдал, А.Ганбаатар, Д.Пүрэвдаваа, С.Амарсайхан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн С.Эрдэнэболд, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг ажлын цаг дууссан тул дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр тогтов./17:55/

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцөөж, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 5 цаг 22 минут үргэлжилж, 126 гишүүнээс 111 гишүүн хүрэлцэн ирж, 88.1 хувийн ирцтэйгээр 17 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанд нийт 75 гишүүн ирж, 59.5 хувьтай ирц бүрдсэн учраас өнөөдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал байна.

1 дүгээрт, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

2 дугаарт, Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

3 дугаарт, Монгол Улсын Их Хурлын 2024-өөс 28 оны стратеги төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа танилцуулна. Болормаа гишүүнийг индэрт урьж байна.

Э.Болормаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2024 оны 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 01-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 233, 235 дугаар захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Г.Тэмүүлэн, Ч.Анар, Б.Батбаатар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Ж.Баясгалан, Н.Номтойбаяр, Б.Уянга, Г.Уянгахишиг болон холбогдох бусад албан тушаалтнууд орж ажилласан.

Ажлын хэсэг 2024 оны 11 дүгээр сарын 06, 12-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийг хэлэлцэж, зарчмын зөрөөтэй саналын томьёолол 8, төслийн бүтэц нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх 1 саналын томьёоллыг хэлэлцэн дэмжиж, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно. Үүнд төрийн эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ноогдох хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болох цацрагийн хамгаалалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг улсын байцаагчаар хянуулж, баталгаажуулан мөрдөх, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийг олон улсын хөндлөнгийн шинжээчээр хянуулах зэргээр томьёолсон.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар ажлын хэсэгт хуулийн төсөлтэй бүрэн танилцах, гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын эрх зүйн харилцааны талаарх ойлголтыг бүрэн авахад хугацаа шаардлагатай байгаа учраас хойшлуулах, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төслийн талаар хууль зүйн судалгаа, дүгнэлт хангалтгүй, татварын хөнгөлөлт чөлөөлөлттэй холбоотой хуулийн төслийн зарим зохицуулалт ялгавартай байгаад анхаарч, ажлын хэсгийн түвшинд ярилцах шаардлагатай, Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр хуулийн төслийн хэлэлцүүлгийг тодорхой хугацаа товлож хойшлуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, хуулийн төслүүдийг зүйл тус бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир цацрагт идэвх ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч, АМНАТ дээр 0-130 ам доллар байхаар тусгах нь оновчтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр уг хуулийн төсөл нь ажлын байр бий болгох, манай улсын эдийн засагт валютын орлого чухал ач холбогдолтой талаар дурдаад, хуулийн төсөлд туссан гадаад улсын цацрагт идэвхт хаягдал ашигласны цөмийн түлшийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглоно гэсэн заалтыг хөндөж болохгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар АМНАТ-өө нэмээд явах нь бизнес талаасаа ашигтай боловч тооцооллын хувьд хөрөнгө оруулалтыг хумих эрсдэл үүсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар цацрагт идэвхт хаягдал ашигласны цөмийн түлш шар нунтгийг булшлах, устгах, аюултай хог хаягдлын үйлдвэр байгуулах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хууль, эрх зүй татварын орчныг анхаарах, татварыг нэмэгдүүлж, АМНАТ-ийн суурийг нэмснээр Монгол Улсад орж ирэх хөрөнгө оруулалт буурах эрсдэл үүсэх, дэлхийн бусад улс оронд АМНАТ-ийн хэмжээ ямар байдаг талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар АМНАТ-ийн 30 хувь, ААНОАТ-ын 40 хувийг орон нутагт үлдээх хуулийн зохицуулалт хэрэгжихгүй байгаа. Улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийхдээ эрэмбэ тогтоодоггүй, төсвийн хуваарилалт шууд тодорхой бус байгааг анхаарах, аймаг, орон нутагт үлдэх үр өгөөжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, орон нутгийн хөгжлийг дэмжих, цацраг идэвхт ашигт малтмалыг эцсийн бүтээгдэхүүн болгон экспортлох нөхцөлд

тухайн бүтээгдэхүүнээс нэмэгдсэн өртгийн албан татвар авах эсэх, ямар учраас энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаагаар сольж болох талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат газрын ховор элемент болон ураны талаарх ойлголтыг ард иргэдэд тодорхой өгөх, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням төслийн хаалтын гэрээ, менежмент, мөнгөн хөрөнгө эсвэл бүтээгдэхүүний аль хэлбэрээр хаалтын зардлыг тооцох, мөнгөн хөрөнгөөр тооцох бол 34 жилийн дараа ямар хэмжээтэй үлдэх, хаана мөнгөө байршуулах зэрэг асуудлыг гэрээнд нарийн тусгах, хөрөнгө оруулалтаа ямар хугацаанд нөхөх талаар хуулийн өөрчлөлтөд туссан эсэх, гүний усны аюулгүй байдлын эрсдэлийг тооцсон эсэх, заавал 10 хувь авахгүй байх хувилбар байгаа эсэх, гэрээний дүгнэлтийг хэдэн жилээр хийх талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Оюутолгой гэрээн дээр эдийн засгийн тооцоолол ямар боломжийг алдсан талаарх дүгнэлт байгаа эсэх, Рона группийн талаарх мэдээлэл, эрсдэлийн судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн эсэх талаар хууль санаачлагчаас асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-т төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж, санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй бөгөөд ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна гэсний дагуу санал харуул санал хураалт явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 8 санал, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигээс зарчмын зөрөөтэй 2 санал, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос зарчмын зөрөөтэй 1 санал, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, П.Сайнзориг нараас зарчмын зөрөөтэй 1 саналын томъёолол ирүүлснийг санал тус бүрээр санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Төсвийн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан зарчмын зөрөөтэй 1 саналыг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд уг саналаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг хэлэлцсэн нийт 7 зарчмын зөрөөтэй санал гаргасан бөгөөд эдгээрийг Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан бусад саналын хамт Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцсэн.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анараас зарчмын зөрөөтэй 1 санал, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяраас Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн талаар зарчмын зөрөөтэй 3 санал, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Б.Уянга нараас зарчмын зөрөөтэй 1 санал, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгээс

зарчмын зөрөөтэй 1 саналын томъёолол ирүүлснийг санал тус бүрээр санал хураалт явуулсан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшинээс Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрөөтэй 1 саналын томъёолол гаргасныг Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн бөгөөд уг саналыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, Байнгын хорооны гишүүдийн дэмжсэн болон дэмжээгүй зарчмын зөрөөтэй саналын томъёоллуудыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Болормаа гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник технологийн хэлтсийн дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Зэнэмидэрийн Батбаяр Усны газрын дарга, Баатарын Мөнхтогтох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Мавагийн Чадраабал Цөмийн энергийн комиссын Цөмийн технологийн бодлогын газрын дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил СЗХ-ны эрх зүйн газрын дарга, Батмөнхийн Агиймаа ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал, Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер, Доржбалын Далайжаргал Мон-Атом компанийн гүйцэтгэх захирал, Дашдаваагийн Сугарсүрэн Мон-Атом компанийн Захиргаа удирдлагын газрын дарга, Амарсайханы Алтанхундага Мон-Атом компанийн Геологи уурхайн албаны ахлах менежер, Норовын Тэгшбаяр Мон-Атом компанийн мэргэжлийн шинжээч, Галсангийн Жамсрандорж Мон-Атом компанийн мэргэжлийн шинжээч, Яндагийн Ганболд Мон-Атом компанийн мэргэжлийн шинжээч, Лхагвасүрэнгийн Жаргалсайхан Мон-Атом компанийн мэргэжлийн шинжээч.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Нийтдээ 16 гишүүнээс нэр ирсэн байгаа. Энд 1 зүйлийг бас тодруулж хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Гишүүд Улсын Их Хурлын хуралдааны дэгийг Амарбаясгалангийн дэг юм шиг ойлгож юм ярьдгаа бас 1 дүгээрт, болих хэрэгтэй. Энэ Улсын Их Хурлаар батлагдсан дэг. Мөнхтулга гишүүн гараад явчихсан байх юм. Би Мөнхтулга гишүүнийг шээсний шинжилгээ өг гэж хэлээгүй шүү дээ. Тэгж байгаа бол би дэглээд байна гэсэн үг. Харин дэгийн дагуу үгээ хэлэх, асуултаа асуух эрх нь өөрөө Улсын Их Хурлын дэгээр зохицуулагдаж байгаа гэдгийг маш сайн ойлгож байгаарай. Тэгэхгүйгээр Улсын Их Хурлынхаа нийтлэг нэр хүндэд алдаж, Монгол Улсын парламентын ардчилсан тогтолцоогоо гутаах, гадаад, дотоодын элдэв долоон явуулгад огт автаж болохгүй гэдгийг бас гишүүд хариуцлагатай ойлгож байгаарай гэдгийг хэлье.

Ингээд гишүүд ирүүлсэн дарааллын дагуу асуулт асууна.

Б.Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Гишүүддээ өглөөний амгаланг айлтгаж мэндчилье. Миний хувьд Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэх үед нэг тодорхой асуудлаар тайлбар хүсэж байсан. Хэлэлцүүлгийн явцад тодруулъя гэж. Тэр нь энэ Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Татварын ерөнхий хуульд татварын орчныг тогтвортой байлгах гэдгийг тогтворжуулах татварын орчныг тогтоох гэж өөрчлөөд, тогтворжуулах татварын орчин гэдэгтээ татварын хувь хэмжээ, элэгдэл хорогдол тооцох хугацаа, татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацааг ойлгоно гэдэг ийм өөрчлөлт оруулж байгаа юм. Энэ өөрчлөлттэй холбоотойгоор Татварын ерөнхий хуулийн энэ заалт нь бол Монгол Улсын урьд өмнө байгуулсан хөрөнгө оруулалтын болон ирээдүйд байгуулах томоохон төсөл, хөтөлбөрүүдтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээнд нөлөөлөх ийм үр дагавартай гэж үзэж байгаа.

Тийм ч учраас манай улсын тухайтад 2009 онд байгуулагдсан Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой өнөөдөр Лондоны арбитрын бирж дээр татварын маргаантай байгаа. Яг энэ маргаан явж байх цаг хугацаанд Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах нь энэ маргаанд айлын тал болон манай талд яаж тусах вэ гэдэг дээр тайлбар асуулт хүссэн. Улмаар ажлын хэсэгт 6 хуудас өөрийнхөө саналыг бас хүргүүлсэн. Энэтэй холбоотойгоор Байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад бас тодруулж асуусан. Ажлын хэсгийн ахлагч хариулахаас түдгэлзсэн. Туваан сайд итгэлтэй байна гэдэг ийм хариулт өгсөн.

Тийм учраас би Улсын Их Хурлын албан ёсны протоколд ажлын хэсгийн ахлагч Пүрэвдорж, салбарын сайд Туваан, ХЗДХ-ийн сайд Алтангэрэл нараас энэ Лондоны арбитрын маргаанд байгаа татварын маргаанд энэ орох татварын хуульд орж байгаа өөрчлөлт айлын талд давуу байдал үүсэхгүй гэдгийг та хэд маань яг батлан хэлж өгөөч гэж хүсэх гэж байна. Яагаад гэхээр энэ бол томоохон хэмжээний хэдий их наядаар тооцогдох татварын дүнтэй маргаан байгаа.

Мөн цаашдаа манай улсын байгуулах нүүрсний Чайна Энержитэй байгуулах томоохон гэрээ хэлцлүүдийн татварт бас нөлөөлөхөөр байгаа. Яагаад гэхээр татварын хууль тогтоомж тухай бүр шинэчлэгдэж гараад, тухайн хөрөнгө оруулалтын гэрээнд ямар заалтууд байгаа вэ гэхээр шинэ гарсан татварын хууль тогтоомж нь тухайн хөрөнгө оруулагч талд давуу байдал олгох юм бол тэр давуу байдал олгосон заалтыг нь хэрэглэнэ гэдэг ийм заалтаар тогтворжуулалт яригдаж явагддаг учраас би энэ асуултыг албан ёсоор асууж, чуулганы хуралдаанаар протоколд тэмдэглүүлэхийг хүсэж байна.

Сая асууж байгаа 3 гишүүний хариултаас хамаарч, санал хураалгах гэж байгаа саналаа яах вэ гэдэг асуудлаа би дараа нь бас шийдвэрлэх болно. Сангийн яамны төлөөлөл болсон. Би энэ дээр Жавхлан сайдыг нэмж байгаа юм. Татварын асуудал хариуцаж байгаа учраас. Ингээд 3 сайд ажлын хэсгийн ахлагчаас асууж байгаа. Сангийн яамны газрын дарга итгэлтэй байна гэж хэлээд байгаа. Гэхдээ энэ маань улс төрийн хариуцлага хүлээдэг ийм албан тушаалтан биш байгаад байгаа юм. Төрийн жинхэнэ албан хаагч байгаад байгаа.

Тийм учраас Монголын ард түмний төлөөллийн дээд байгууллагад тангараг өргөсөн, хариуцлага үүрэх энэ улс төрийн албан тушаалтнуудаас энэ асуултыг асууж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн дарга Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж гишүүн хариулна.

Б.Пүрэвдорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр яг энэ асуудал дээр тухайн асуудлаар Арбитрын хуралд Сангийн яамнаас төлөөлж оролцож байгаа. Мөн өнөөдрийн энэ хуулийн хэлэлцүүлэг дээр энэ татварын асуудлаар хариулт өгч байгаа хүн бол Тэлмүүн дарга тодорхой хариултыг өгсөн.

Тэгэхээр яг Энхбаяр гишүүн бол ажлын хэсэг дээр болон Байнгын хорооны даргад тодорхой асуудал бүхий 5 хуудас материал ирүүлсэн байгаа. Энэ дээр мэдээж Монгол Улсынхаа өмнөөс санаа зовнисон, энэ тогтворжуулах татварын асуудлаар тодорхой саналуудыг хэлсэн байгаа. Тэгэхээр энэ дээр нэг зүйл дээр л бүр бөөрөнхийлсөн маягтай байгаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл яг тодорхой саналаа гаргаад өгчхөөч. Тэгвэл бид нар үүгээр чинь хураалгаад, мэргэжилтнүүдийн саналыг сонсоод, хариултыг нь сонсоод, тодорхой санал хураалгая гэхээр ажлын хэсэг дээр ч санал өгөөгүй, дээрээс нь Байнгын хороон дээр ч санал өгөөгүй байгаа.

Тэгэхээр яг энэ асуудлаараа бас тодорхой санал өгөхөд хэрвээ байгаа бол энэ буцаагаад, хэлэлцүүлэгт буцаагаад тэр саналыг хураах бүрэн боломжтой. Энэ бол дэгийн тухай хуулиар зохицуулагдсан байгаа. Тийм учраас та энэ дээрээ өөрийнхөө тэр боломжийг бүрэн ашиглаарай гэж хэлэх байна. Тэгээд мэргэжилтэн Тэлмүүнээс хангалттай өчигдөр асуултаа хариултыг нь авчихсан байж байгаа. Тэгэхээр энэ дээр яг улс төрийн албан тушаалтан Жавхлан сайд яг энэ арбитрын асуудал болон энэ заалт ямарваа нэгэн байдлаар холбогдохгүй гэдэг тэр талаар тайлбарыг хийнэ ээ.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье өө. Ер нь бол бид цаашдаа улам туршлагажиж, улам чангарч, Монгол талдаа илүү их ашигтай хууль,

эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа гэж хэлж болно. Оюутолгой болон бусад хөрөнгө оруулалт бусад гэж дээ их цөөхөн шүү дээ тийм ээ, саяын тэр Чайна Энержи чинь бол Хөрөнгө оруулалтын гэрээ биш. Энэ чинь өөр худалдааны гэрээ. Энэнд хамрагдахгүй. Цөөхөн хэдэн гэрээ л байгаа. Энд ямар ер нь нөхцөл байдал дунд бид 10 гаруй жил явж ирсэн бэ гэхээр Оюутолгойн тойрсон тэр энэ татвартай холбоотой маргааны асуудал бол одоо бидний нарийвчлах гээд байгаа хувь хэмжээ, элэгдэл хорогдол, алдагдлыг шилжүүлэх хугацааны ийм 3 асуудалтай ерөөсөө огт маргадаггүй. Энэ дандаа аргачлалын хүрээнд маргаад байгаа байхгүй юу. Маш тийм өргөн хүрээнд бид задгай тавьчихсан юм байна лээ. Энэ маргах боломжийг нь. Одоо тухайлбал бид нар юун дээр ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Нэмэлт минут өгье.

Б.Жавхлан: Энэ нэлээн бас чухал тайлбар учраас минут өгөөрэй дарга аа. Зардлыг бүртгэх эсэх, хиймэл өсгөсөн байна гэж байгаа юм. Хүлээн зөвшөөрөх эсэх, эс зөвшөөрөх, хөрөнгийн ангилал барилгууд, тоног төхөөрөмжүүд, ханшийн хөрвүүлэлт мөн энэ давхар даатгалын гэрээг ашиглах эсэх гээд, үнэ шилжилт гээд дандаа ийм аргачлал дээрээ маргалдаад яваад байгаа юм. Маш задгай тавьчихсан байхгүй юу. Энийг бид саяын таны хэлсэнчлэн тэр 3 зүйл дээрээ л бид тогтворжуулалт хийнэ гэдгийг маш тодорхой нарийвчилж ирж байгаа гэсэн үг.

Хэрвээ энэ хуулийг бид нар яг үүгээр нь батлах юм бол Оюутолгой энэ гэрээнээс аль болох л холдоно. Өөрөөр хэлбэл нөгөө маргаад байгаа асуудлууд нь байхгүй болно. Энэ маргах асуудал биш шүү. Зөвхөн тогтворжуулалтын ийм 3 асуудал дээр л хэдүүлээ цаашаагаа найзална гэдгийгээ л зааж өгч байгаа гэсэн үг.

Тэгэхээр улам чангарч байна гэсэн үг. Улам тодорхой, ойлгомжтой болж ирж байна гэсэн үг. Цаашдаа ч хөрөнгө оруулалт гаднын ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

Б.Жавхлан: Тийм учраас цаашдаа бид энэ алдаагаа засаад, улам их нарийн тодорхой ил болгоод, ойлгомжтой болгоод, гаднын хөрөнгө оруулагч нар ч гэсэн ирээдүйд бид нар ийм зүйл дээр маргаад байх зүйл байхгүй юм байна. Эрсдэл гарвал ийм зүйл дээр л гарах юм байна. Тийм учраас энийгээ эрсдэлээ тооцож, хөрөнгө оруулалтынхаа гэрээг Монголын талдаа хийе гэдэг ийм л бодол руугаа шилжинэ. Тэрнээс биш Оюутолгой бол хэзээ ч энэ нөхцөл рүү орж ирэхгүй. Тэдний хувьд бол байдал нь муудах, нөхцөл нь нэлээн хүндрэх ийм зохицуулалт байгаа учраас бид энийг улам сайжирч чангарч байгаа гэж 100 хувь итгэлтэй байна, 100 хувь шүү, тийм.

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд нэмж хариулах уу? Нэмж хариулъя.

О.Алтангэрэл: Оюутолгойтой холбоотой арбитрын маргаан нь бүхэлдээ ашигт малтмалын нөөц ашигласны татвар тооцох аргачлал. Тэгээд энэ хүчингүй болсон давхар татварын гэрээ, тэгээд энэ татвар суутган тооцох субъект, валютын ханшийн зөрөө гэсэн ийм асуудлууд дээр байгаа.

Тийм учраас энэ дээр арбитрын маргаанд Монголын талын байр суурь сөрөг нөлөө үзүүлэхгүй гэсэн ийм үндэслэлтэй байгаа юм. Би эндээс Оюутолгойтой байгуулсан гэрээний нэг заалт уншихъя.

Уг гэрээний 15.23.1-д татварын тогтвортой орчныг хангахын тулд энэхүү гэрээнд заасан тогтворжуулсан татвартай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын гэрээ, эрх зүйн баримт бичигт энэхүү гэрээ байгуулсан өдөр Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байсан тухайн хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын гэрээ, эрх зүйн баримт бичгийг ойлгоно гээд тодорхой заачихсан байгаа.

Д.Амарбаясгалан: Туваан сайд. Цэвэгдоржийн Туваан сайдад нэмж хариулъя.

Ц.Туваан: Баттөмөрийн Энхбаяр гишүүний санаа зовж, нягталж байгаа асуудлыг ойлгож байна. Тэгээд энэ дээр бас тодорхой хариулт өгье. Энэ юу, Лондон дээр болж байгаа арбитрын маргаан дээр энэ татварын хуульд өөрчлөлт орсноор давуу байдал үүсэх үү гэдэг тодорхой асуултад бол ийм давуу байдал үүсэхгүй гэж микрофонд хариулъя.

Дээрээс нь сая бас энэ Сангийн сайд, Хууль зүйн сайд нар бас тодорхой хэлчихлээ. Татварын хувь хэмжээ, элэгдэл тооцох хугацаа, алдагдал шилжүүлэх хугацаа гээд энэ татварын хуульд орж байгаа тогтворжуулах саналууд нь тодорхой байгаа. Яг энэ асуудлаар Лондоны арбитр дээр маргаан байхгүй. Тэр маргаан нь нөгөө 1,4 их наядын маргааны асуудлыг ярьж байх шиг байна. Энэ асуудал бол Татварын ерөнхий газраас акт тавигдсан. Ер нь энэ мөнгө нь бас татагдаад ороод ирчихсэн. Монголын талд бас ийм л асуудал байгаа.

Д.Амарбаясгалан: Асуулт болсон. Хариулт. Энхбаяр гишүүн тодруулъя. Тодруулж асууя.

Б.Энхбаяр: Тэгвэл арбитр дээр явж байгаа маргаан бол Сангийн сайдын тушаалаар баталсан татварын аргачлалтай холбоотой асуудлаар маргаж байгаа юм байна гэж ойлголоо.

Татвар тогтоох эрх бол Улсын Их Хурлын Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхийн асуудал байдаг. Хэрэг дээрээ Сангийн сайд тушаалаар татварын аргачлал тогтоох эрхийг авчхаад байгаа. Энэ аргачлалаар дамжуулж татварыг ихэсгэдэг, багасгадаг асуудал буюу би энийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа.

Тийм учраас энэ хууль тогтоомжид өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор 2 дугаар хэлэлцүүлэг дээр Сангийн сайдын энэ аргачлал тогтоодог эрхийг ер нь цаад утгаараа татвар тогтоогоод байгаа энэ асуудлыг Үндсэн хуульдаа нийцүүлэх ёстой юу гэдэг дээр Сангийн сайд ямар бодолтой байна вэ?

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Асуудал хөндөхөөр л нэг ийм нэг бөөсний онигоо шиш юм руу л чирж ороод байх юм. Энэ аргачлалаар татвар тогтоодог юм гэж байхгүй шүү дээ. Энэ процессыг энэ чинь нарийвчилсан зүйлүүд зөндөө байна. Маш олон юмнууд байдаг. Татварын байцаагч, гаалийн байцаагч нарт ойлгомжгүй маш олон ийм тохиолдлууд гарч ирдэг. Тэр процессыг нарийвчилдаг л зүйл болохоос биш аргачлалаар хувь, хэмжээ одоо энэ яригдаж байгаа энэ тогтворжуулалтын энэ 3 асуудлыг зохицуулдаг юм гэж юу ч байхгүй.

Тийм учраас энэ дээр таны хардаад байгаа тэр зүйл бол огт тийм тохиолдол үүсэхгүй гэдгийг би дахин, дахин хэлье.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Эрхэм хүндэт гишүүд ээ, ард түмний элч, төлөөлөгч нар аа, бид цацраг идэвхт ашигт малтмалын тухай ярьж байгаа. Өнөөдөр энэ орж ирж байгаа асуудлыг би жадлан эсэргүүцээгүй, харин битгий муутгаач ээ, ард түмний эрх ашигт битгий муужруулаач ээ, эрх ашгийг нь багасгаач л гэж хэлж байгаа.

Цөмийн эрчим хүчний тухай хуульд юу гэж анх орж ирснийг бид яг юу өөрчлөх гээд байгаагаа би хэлье. 5.2 болон 5.3-д ийм заалт байгаа. Улсын төсвийн хөрөнгөөр бол компанийн хөрөнгөөр бол 50, компанийн хөрөнгөөр бол 34 хувь, улсын төсвийн хөрөнгөөр бол 51 хувийг нь Монголын төр үнэ төлбөргүй шууд эзэмшинэ гэдгийг бид өөрчилж, өсөн нэмэгдэх рояалтигаар орлуулъя гэж л оруулж ирж байгаа шүү дээ.

Бидний 34 хувь гэдгийг миний асуулт. Ажлын хэсэг дээр асуугаад би хариулт авч чадаагүй. 34 хувийг рояалтитай харьцуулбал яг хэдэн хувь гэж та нар тооцоолол хийж байгаа вэ? Миний бодлоор бол миний тооцооллоор 51 хувийг Монгол орон авна гэж байгаа бол энэ бол 37,7 хувийн рояалтитай тэнцүү хэмжээний үнэлэгдэхүйц үнэ цэн шүү. Энийгээ бид 0-9 хувь болгох гэж байгаа.

34 хувь гэдэг бол 23,8 хувийн рояалтитай тэнцүү. Энийгээ бид 0-9 хувийн өсөн нэмэгдэх тэр үнэтэй харьцуулж бид оруулах гэж байгаа. Ийм Монголын эрх ашгийг унагасан, муутгасан хуульд бид өөрчлөлт оруулах гэж байгаагаа болиоч л гэдгийг би хэлж байгаа юм.

Дээр нь нэмээд 2015 онд би Улсын Их Хурлын гишүүн байсан, бие даагч байсан. Тэр үед орж ирж байсан 2015 оны 6 сарын 26-нд Цөмийн энергийн комиссын ажлын албанаас орж ирж байсан баримт надад байна. Би өөрөө Их Хурлын гишүүний бланк дээр авсан юм. Энэ дээр юу гэж заасан бэ гэвэл Францууд тэр үед Арева гээд нэртэй байсан санагдаж байна. Францууд 34 хувийг Монголын тал аваад, дээр нь 9.5 хувийн, 9.5 хувийн рояалти өгөхөд бэлэн байна гэсэн бичгээ гарын үсэгтэй ороод ирчихсэн байгаа шүү дээ. Энэнээс яагаад муудах гээд байгаа юм бэ. 0-9 хувийг. Хэрвээ үнэ өсвөл авна гэдгээр л бид оруулж ирж байгаа.

2 дугаарт, эдийн засгийн үр ашиг нь ийм муу байна. Эдийн засгийн үр ашиг яриад бид Цөмийн энергийн тухай хуулийнхаа нэрийг өөрчлөх гэж байгаа гэсэн үг. Та нар цацраг идэвхт ашигт малтмал олборлодог орон болно гэсэн үг. Бид бол цөмийн энерги бий болгодог орон болъё гэж үг нь зорьж байгаа.

Тэгэхээр шар нунтаг гаргадаг орон болно гэсэн үг. Намиби, Нигеритэй бид адилхан болно гэсэн үг. Шар нунтаг гаргахын тулд бид 34 хувиа өгснөөрөө ямар ч хяналтгүй болно. Та нарт өгсөн танилцуулгыг уншаарай. Токаев жил болгон зарлиг гаргаж, энэ ураныхаа талаар зарлиг гаргадаг гэж заасан байгаа шүү. Бид цөмийн энерги гэдэг нэг комисстоо аваачиж өгөх гэж байгаа. 34 хувиа бид өгчих юм бол дараа нь бид буцаагаад бүтээгдэхүүн хуваах, бүтээгдэхүүнээ буцааж энэ Француудаас гуйлга гуйж авах болно. Тэд өгөхгүй гэвэл өгөхгүй. Бид энэ том гүрнүүд цөмийн энерги, энэ бол эдийн засгийн хувьд нэг их ашигтай биш ээ. Энэ маш том хатуу төрийн хяналтад шууд удирдлагад байдаг зүйлийг нэг комисст аваачиж өгөх

гээд байгаа. 34 хувиасаа бид татгалзсанаараа гаднын нэг компанид бүх цацраг идэвхт ашигт малтмалаа өгөх гэж байгаа гэсэн үг.

3 дугаарт, миний асуулт. Миний 2 дугаар асуулт бол энэ бидний бид цацраг идэвхт энэ шар нутгаа дараа нь худалдаж авах уу? Яаж гуйж авах вэ? 34 хувьгүй болчихвол.

3 дугаар асуулт бол хог хаягдал. Жилдээ 750 тонн аюултай хог хаягдал бид газрын ээжийнхээ хэвлий рүү асгах гэж байгаа. Хүхрээ ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хариулт өгнө.

Б.Пүрэвдорж: Үндсэн хуулийн 6.2-ын газрын ашигт малтмалын дийлэнх олонх нь ард түмэнд ноогдох тэр заалтын дагуу энэ заалтыг бүрэн хангаж байгаа. 1 дүгээрт, ААН-ийн орлогын албан татвар 25 хувь байгаа. 6 тэрбумаас дээш учраас.

Мөн түүнчлэн давуу эрхийн 10 хувийн хувьцаа авч байгаа. Яг өнөөдрийн байдлаар уранаас АМНАТ тооцох юм бол 6 хувийн АМНАТ тооцогдоно. Ингээд тооцоход л энэ 3 дээр тооцоход л 51 хувь давж байгаа гэдгийг хэлье.

Дээрээс нь энэ компани гаалийн татвар төлнө. НӨАТ-ын татвар төлнө. Онцгой татвар төлнө. Түгээмэл тархацтай АМНАТ төлнө. ХХОАТ төлнө. НДШ 12,5 хувь төлнө. Үл хөдлөхийн албан татвар төлнө. Агаарын бохирдлын төлбөр төлнө. Усны нөөц ашигласны төлбөр төлнө. Зам ашигласны төлбөр төлнө. Газрын төлбөр төлнө. Улсын тэмдэгтийн хураамж төлнө. Нөөц ашигласны хураамж төлнө. Мөн түүнчлэн авто тээврийн болон өөрөө явагчдын татвар төлнө. Ингээд энэ дийлэнх нь Монголд байх тэр бүх зүйлийг бид нар энэ татвар хураамжаараа бүгдийг нь авна гэдгийг хэлье.

Хоёрдугаарх нь таны хэлж байгаа АЦС-тай болох ёстой гэдэг энэ зүйлийг ажлын хэсгийн даргын хувьд 2 гараа өргөөд дэмждэг. Тийм учраас ОХУ-тай Мардай дээр бид нар АЦС, бага оврын АЦС барих тухай асуудлыг эрчимтэй ярьж байгаа. Оронатай бүтээгдэхүүн хуваах гэрээний зарчмын дагуу тодорхой хэмжээгээр энэ цаашдаа бас тодорхой өөрчлөлт оруулж байгаад энэ АЦС барих тэр асуудлыг шийдэх ёстой.

Тэгэхээр энэ тийм амархан шууд бүтдэг зүйл биш. Өнөөдөр бид нар эхлэх юм бол энэ бүх үйл явц нэг ойролцоогоор 2035-аас 40 оны хооронд л энэ АЦС-аа, станцтай болох асуудал шийдэгдэнэ ээ.

Тийм учраас бид нар энэ шар нунтгийг экспортолсны үндсэн дээр бид нарын дэлхий даяарх нэр нэр хүнд илүү өндөр түвшинд очно. Энэ Оронад компанитай хамтраад энэ тодорхой төлбөрүүд, хог хаягдлын төлбөрүүдийг төлнө. Тийм учраас энэ өөртөө, манайх бол гадагшаа гараад баяжуулчихсан тэр хог хаягдлыг энэ хуулиараа бас хориглож байгаа. Буцааж бид нар энд булшлахгүй. Эндээс ашиглалтын явцад гарсан тэр хог хаягдлыг бид нар ойролцоогоор 320 сая долларыг бид нар тухайн үедээ хаалтын гэрээний дагуу энэ төлбөрийг төлж, аюулгүй болгох тэр ажлыг хийнэ.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Үндсэндээ Оюутолгойтой харьцуулж их ярьдаг. Оюутолгой дээр 34 хувийг худалдаж авна. Бид үндсэндээ өр авна гэдгээ мэдэж байсан. Бид үүний эсрэг байсан. Тэр үеийн Улсын Их Хурал дээр энийг ингэж аймшигтайгаар баталсан.

Дээр нь нэмээд хэлэх юм бол 34 хувийг огт үнэ төлбөргүйгээр гэдэг нь цаад утгаараа газар доор байгаа тэр баялгаа бид үнэлж, 34 хувиар 51 хувиар авч байгаа. Дээр нь нэмж өөрөө өөрийнхөө юмыг өөрсдөө худалдаж авахгүй шүү л гэсэн санаа болохоос биш үнэ төлбөргүй гэдэг үг нь ч өөрөө утгагүй. Бид баялгаа үнэлж байгаа гэсэн үг. 34 хувиараа.

Дээр нь нэмээд хууль баталж, бид үндсэндээ цацраг идэвхт ашигт малтмалдаа төрийн хяналтыг байхгүй болгож байна л гэсэн үг. 34 хувь байхгүй бол бид шар нунтгийг буцаагаад өөрсдөө худалдаж авах эрхгүй болно. Цөмийн энерги алсарна гэсэн үг. Дээр нь нэмээд хэлэхэд хог хаягдал 750 тонн хог хаягдал аюултай хог хаягдал гарна. Энд зориулсан үйлдвэр манайд алга байна. Байгаль орчны яам энэ дээр ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн нэмж хариулъя.

Б.Пүрэвдорж: Яг өнөөдрийн байдлаар Оюутолгой бол АМНАТ-аараа, 5 хувийн АМНАТ-аараа өнөөдрийн байдлаар 800 сая долларын төлбөрийг төлсөн байгаа.

Тэгэхээр өнөөдрийг хүртэл яг энэ 34 хувийг бид нар ямар ч хөрөнгө оруулалт хийхгүйгээр өнөөдрийг хүртэл зээл хэлбэрээр байлгаж байгаа. Тэгээд буцаагаад 34 хувиас авах тэр ашиг маань хэзээ орж ирэх нь мэдэгдэхгүй ингээд хойшилсон хэвээрээ л байгаа. Тийм учраас энэ яг АМНАТ-ыг илүү өндөр болгож, дэлхий даяар хамгийн өндөр болгож байгаа. Өөрөөр хэлбэл АМНАТ 5 хувь, тусгай АМНАТ дахиад 5 хувь.

Дээрээс нь өсөн нэмэгдэх роялтигаар буюу нийтдээ 9 хувь ингээд 19 хувийн АМНАТ-тай орон дэлхий даяар байдаггүй юм. Дээд тал нь 7 хувь байгаа, 8 хувь байгаа. Жишээ нь Австралитай дүйцүүлж ярьдаг. Тэгэхээр Австрали 5 хувийн АМНАТ-тай. Тэгэхдээ 30 хувийн татвартай байгаа. Тэгэхээр манайх нэг типичный ойлголт байдаг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тийм, типичный энэ ард иргэдэд бас нэг типичный ойлголт байдаг. Ерөөсөө юу ААНОАТ бол 10 хувь гэж ойлгодог. Гэтэл 6 тэрбум төгрөгөөс дээш 25 хувийн татвартай байгаа. Тэгэхээр жишээ нь Австрали бол ААН-ийн орлогын татвар болон 5 хүн АМНАТ-тай нийлээд 35 хувийн татвар авч байхад манай энэ оруулж байгаа гэрээгээр л ААН АМНАТ 2 нийлээд 44 хувь хүрэхээр байгаа.

Тийм учраас энэ цаашдаа ямарваа нэгэн тийм алдаа гарахгүйгээр Монголдоо энэ бүх баялгийг авч үлдэх, тэр 6.2-т заасан тэр заалтыг бүрэн биелүүлнэ гэж үзэж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууна.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Өчигдөр Байнгын хороо дээр асуулт асуугаад ихэнх хариултаа авчихсан. Аваагүй 2, 3 асуултаа асууя. Ажлын хэсгийн ахлагчаас.

Ер нь хуулийг дэмжиж байгаа. Тэгэхдээ сая ажлын хэсгийн ахлагч хэлж байна л даа. Тэр НӨАТ-ын татварыг тултал нь авна. Наадах чинь боломжгүй байгаа шүү. Наадах чинь эцсийн бүтээгдэхүүн гэдгээр НӨАТ-аас чөлөөлөгдөж байгаа юм. Үгүй, энэ чинь НӨАТ-аа авах бүрэн боломжтой шүү дээ. Тэгээд өчигдөр би нэг өнөөдөр ороод ирчихнэ гэж бодоогүй юм. Уг нь наадах чинь хуульдаа өөрчлөлт оруулаад, тэгээд Сангийн яам өчигдөр хариулахгүй байна лээ л дээ. Энийг эцсийн бүтээгдэхүүн гэж үзэх юм уу, үгүй юм уу, 90 хувь хүргэснийг нь үзэх юм уу. Одоо манай 30 хувьтай юм уу, 20 хувьтай юм уу, энэ эцсийн бүтээгдэхүүн юм уу, биш юм уу?

Тэгээд НӨАТ гэдэг чинь бараг наад АМНАТ-аасаа илүү татвар шүү дээ, Пүрэвдорж дарга аа. Тэгэхээр наадах дээрээ нүдээ аниад өнгөрч бол болохгүй байх. Тэгэхээр энэ бол НӨАТ-ын татвараас чөлөөлөгдөж байгаа, яг өнөөдрийн байдлаар. Энийг тэгэхдээ Монгол улсын, Монгол Улс татвараа тултал нь авах гэж байгаа бол бүх татвараа авах ёстой. Тэгээд хариулахгүйгээр зүгээр ингээд дунд нь өнгөрөөж болохгүй байна. Би өчигдөр хуульд нь өөрчлөлт оруулах ёстой гэдэг дээр санал хэлсэн юм. Байнгын хороо дээр.

Тэр хаалтын санхүүжилтийн хувьд Пүрэвдорж дарга бас мэдэж байгаа байх. Энэ Засгийн газрын журмаар шийдэгдэнэ гэдэг бол энэ хууль дээр Засгийн газрын журмаар шийдэгдэж байгаа байхгүй юу. Энэ үнэхээр боломжгүй асуудал аа. Энийг зарим гишүүд хэлсэн байна лээ. Энэ хаалтын асуудал бол хамгийн хөрөнгө оруулагч талдаа ч тэр, Монгол Улсын талдаа ч тэр их ойлгомжтой тодорхой байх ёстой. Тэгж байж хөрөнгө оруулагчдын тал чинь өөрөө тэр хаалт, хаалт гэдэг нь ер нь ураны хувьд хамгийн чухал шүү дээ. Хамгийн чухал. Нүүрс ухаагүй бусад ашигт малтмал харьцангуй бас, хаалт бол ураны хувьд хамгийн чухал асуудал аа.

Тийм учраас энэ хаалтын асуудлыг хуульдаа тодорхой оруулах ёстой. Анар гишүүн бас хэлсэн юм байна лээ. Хэлэлцэх эсэх дээр нь. Би санал нэг байна. Энэ бол тодорхой байхгүй бол янз янзын хүмүүсийн саналаар, эс үгүй хөрөнгө оруулагчдыг чинь дарамтална шүү. Дааж давшгүй мөнгө нэхнэ. Эс үгүй бол хаалт дээр тавьчихсан мөнгийг чинь хэрэглэчихнэ. Тэгээд тэр мөнгө нь хүрэхгүй аягүй бол.

Тэгээд нэг тийм нэлээн нэг тийм том асуудлууд үүссэн нэг тийм асуудал гарах вий дээ.

Тэгэхээр Цөмийн энергийн тухай хуульд ийм зохицуулалт байхгүй. Тэрнээс гадна Цөмийн энергийн тухай хуульд орон нутагтай харилцах харилцаа гэж байхгүй. Орон нутагтай харилцах харилцааг тодорхой болсноор таны яриад байгаа тэр хөрөнгө оруулагчдыг яг тодорхой тоглох тэр боломжийг гаргаж өгнө. Тэгэхгүй бол наадах чинь орон нутгийн харилцааг тодорхой болгохгүй бол тэгээд л өнөөдрийн тэр Ховдод үүсэж байгаа асуудал ахиад л үүснэ. Тэгээд эндээс нэг том юм баталчихлаа гээд л тэгээд л очоод хамгаалдаг хүн байхгүй шүү дээ. Очоод өөдөөс нь өмөөрдөг хүн байхгүй.

Тэгээд харж зогсож байгаад л, тэгээд өөрт ашиггүй бол дуугарахгүй. Тэгээд л. Тийм учраас наад орон нутгийн харилцааг тодорхой болгосноороо таны тэр хэлж байгаа хөрөнгө оруулагчдыг хамгаалах тэр зүйлийг хуульд тусгах хэрэгтэй. Цөмийн

энергийн тухай хуульд тийм зүйл заалт байдаггүй шүү. Ашигт малтмалын хуульд харин тодорхой байгаа гэдгийг хэлье.

Тэр НӨАТ дээр хариулт авъя аа. Өчигдөр байнгын хороон дээр хариулт аваагүй.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хариулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би харин тийм НӨАТ-ынхаа, НӨАТ-ыг авах ёстой гэдэг утгаар би яриад байгаа юм, тийм авна гэж хэл. Өөрөөр хэлбэл би тантай санал нэг байгаа юм.

Шар нунтгийг, шар нунтгийг эцсийн бүтээгдэхүүн үзэх үү, үзэхгүй юу гэдэг дээр л гол асуудал байгаад байгаа юм. Гэтэл энэ асуудлыг чинь 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Засгийн газрын 286 дугаар тогтоолоор ураны шар кэйк буюу ураны хүдрийг баяжуулж гаргаж авсан шар нунтгийг эцсийн бүтээгдэхүүний жагсаалтад оруулчхаад байгаа байхгүй юу даа.

Тийм учраас өнөөдөр энэ Засгийн газар чинь оруулж ирж байгаа, оруулж ирж байгаа энэ төсөл дээрээ энэ НӨАТ-ыг авах тухай асуудлыг шийдэж оруулж ирээгүй байхгүй юу даа. Тэгэхээр одоо бид нар яг өнөөдрийн энэ Засгийн газрын гаргаж ирж байгаа энэ хуулийн өөрчлөлтөөр чинь бид нар хөндөгдсөн саналаар л санал хураалт явуулна. Хөндөгдсөн заалтаар л санал хураалт явна.

Тэгэхээр энэ дээр боломжгүй болчихоод байгаа юм. Тийм учраас та яг энэ асуудал шар кэйкийг биш тийм ээ, Засгийн газрын шийдвэрээр эцсийн бүтээгдэхүүн гэж үзсэн нь буруу байна гэж үзэх юм бол та хууль өргөн барих боломжтой.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Олон нийт болон гишүүддээ бас энэ өглөөний мэндийг хүргэе ээ. Ерөнхийдөө хамтарсан Засгийн газар байгуулагдсан олон нийтийн хүлээлт байгуулагдсаны бас байгуулагдаад олон нийтээс хүлээж байгаа зүйл бол эдийн засгийн энэ өсөлтийг яаж бий болгох вэ л гэдэг зүйл байгаа. Энэ хэчнээн одоо юу гэдэг юм хэмжээний хөрөнгө оруулалтыг Монгол Улсад энэ хамтарсан Засгийн газар байгуулагдсанаас татаж чадсанаар энэ Засгийн газрын үйл ажиллагааны үр дүнг бас дүгнэнэ ээ. Түүнээс биш ойр зуурын хурал зөвлөгөөнд явснаар ч гэдэг юм уу, төчнөөн удаагийн тэглээ нэг ийм зүйлээр дүгнэхгүй байх.

Тэгэхээр энэ бас яг энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусчхаад байгаа энэ томоохон эдийн засгийн бодлогыг дэмжих, ажлын байрыг бий болгох, Монголд бас шинжлэх ухаан, технологи, инновацын бас ололтуудыг нэвтрүүлэх, цаашдаа бид нар гадаад харилцааны бодлого дээрээ ер нь ямар байр суурь барих гэж байгаа юм бэ гэдэг зүйлийг ч бас илэрхийлж болох их томоохон чухал сэдэв байж байгаа. Үүний цаана бас олон төслүүд хэрэгжээсэй гэж бодож байгаа.

Тэгэхээр ер нь зүгээр бид хэд бас энэ зүйлүүдийг хамгийн гол нь бас олон нийтээсээ дэмжлэг авч явахын тулд иргэд олон нийтдээ зөв мэдээлэл өгч явах нь зөв байгаад байгаа юм. Тийм учраас бас энэ асуулт, хариултууд дээр иргэддээ бас мэдээлэл өгөх үүднээс би бас хэд хэдэн зүйлийг зүгээр асууя л гэж бодож байгаа юм.

Тэгээд энийг ингээд энэ зүйлүүдийг өгөхгүй болохоор иргэд маань үндсэндээ нөгөө шинжлэх ухаанаар гэдэг юм уу, ерөнхийдөө энэ тогтоогдож байгаа ийм зүйлүүдийг үгүйсгэж, хэт их юу гэдэг юм худал мэдээлэлд төөрөгдөх, эргээд бусдын эрх чөлөөг хөндөх, эсвэл өөр өөрийнхөө эрх чөлөөг бас хохироох явдал бас гарч байна аа. Орон нутгийн иргэд ялангуяа.

Тэгэхээр энэ мэдээллийг өгөхөөсөө гадна яах вэ, зүгээр цаашдаа бас Засгийн газрын холбогдох сайдууд бодолцох ёстой байх аа. Бид хэд энэ АМНАТ-ын орж ирж байгаа орлогын түлхүү хувийг орон нутагт нь үлдээх энэ бодлогыг бас ойрын хугацаанд ярилцаж шийдмээр байгаа юм аа. Ингэж байж энэ уул уурхайн төслүүд бас орон нутгийнхаа дэмжлэгийг, иргэдийн дэмжлэгийг авч явах уу гэдэг асуудлаа тодорхой болгочихмоор байна.

2 дугаарт, яг газрын овор ч байдаг юм уу, уран ч байдаг юм уу, ер нь тодорхой ашигт малтмалын салбарууд дээр энэ төсөл хэрэгжүүлэгч нь бас олон нийтийн компани байх буюу ялангуяа орон нутгийн иргэд тэргүүн ээлжид энэ энгийн хувьцаанаас нь авдаг эрхийг нь нээмээр байна. Авахгүй бол дараагийн шат гэдэг ч юм уу. Ийм байдлаар иргэдэд бас энэ баялагтаа эзэн байх асуудлыг зөвхөн Үндэсний баялгийн сангаар дамжуулах биш яг шууд тэр тухайн тэр төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьцааг эзэмшигч байдлаар бий болгох энэ нөхцөлийг бүрдүүлэхэд Засгийн газар бодлогоо анхаараач ээ, судлаач ээ гэж хүсэж байгаа юм.

Би хувьдаа энэ харилцаа холбоо болон энэ уул уурхайн салбарын төсөл хэрэгжүүлэгч ер нь бүгд олон нийтийн компани байхыг л хүсдэг. Ковидоор харсан шүү дээ. Ганцхан дампуурдаггүй цөм орлого гэдэг салбар бол харилцаа холбоо, контентын салбарууд л байж байсан. Одоо энэ кабель телевизүүд ч байдаг юм уу.

Тэгэхээр ер нь зүгээр баялгийг хүртээнэ гэдэг чинь зөвхөн уул уурхай биш ээ. Ийм тодорхой эдийн засгийн секторуудыг анхнаасаа бодлогоо гаргаад, олон нийтийн байх шаардлагыг тавиад өгвөл бид хэд хаана хаана энэ зүйлүүд явна аа.

Тэгээд би бас үндсэн сэдэв рүүгээ орёе. Ер нь зүгээр бид хэд бас АМНАТ-ыг нэлээн боломжийн гэдэг юм уу авахаар энэ төсөл дээр орж ирсэн. Тэгэхээр олон улсын жишиг хандлага хэр байна аа? Хамгийн өндөр АМНАТ авч байгаа нь жишээ нь Узбек 8 хувьтай байж байгаа. Тэгтэл бид нар яг ямар ямар байдлаар АМНАТ авах гэж байна? Энийг бас иргэд олон нийтэд бас мэдээллийг бас тодорхой өгөөч? АМНАТ-аас гадна түрүүн Пүрэвдорж гишүүн бас хэлж байна. ААНОАТ-ыг ямар хуваарь авах гэж байгаа. Дээрээс нь бусад татварууд байгаа. Тэр бусад татваруудыг ерөөсөө хөнгөлж чөлөөлөх юм байхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ бүх зүйлүүдийн ард Үндсэн хуулийн үзэл баримтлалд заасан тэр байгалийн баялгийн үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдох тэр концепцод нийцэж ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Би Ганбаатар гишүүний асуулт дээр зүгээр нэмэлт юу хэлэх гэсэн юм аа. Өчигдөр Сангийн яам хариулж чадаагүй гээд дурдчих шиг болно лээ. Зүгээр орлого бүрдүүлэх талаасаа авмаар л байна шүү дээ. Гэтэл түрүүний тэр ажлын хэсгийн дарга Пүрэвдорж гишүүний хэлсэнчлэн 2010 оны Засгийн газрын тогтоолоор энэ нунтаг бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн гээд тодорхойлчихсон

юм байна лээ. Мэргэжлийн яам нь оруулаад, ингээд тодорхойлоод ингээд явчихсан. Одоо харин хэдүүлээ бас нэг дараагийн мөчлөг эхлэх гэж байгаа энэ яг цаг үед энэ хуулиа ч хэлэлцэж байна. Дараа нь том Хөрөнгө оруулалтын гэрээ ч хэлэлцэх байх. Энэ үед харин энэ асуудлыг ингээд цаашаа маргаантай тодорхойгүй үлдээж огт болохгүй ээ. Өмнө нь тэр тодорхойлчихсоныг нь хэвээр нь үлдээх юм уу, эсвэл энийг эцсийн бүтээгдэхүүн биш, эцсийн бүтээгдэхүүн нь эрчим хүч гэх юм уу юу гэх юм. Энийг нэг бүгдээрээ энд ард түмний өмнө хэлэлцээд, ил тод ярилцаад, тэгээд 1 тийш нь болгоод цэглээд, ингээд цаашаа явах нь зүйтэй гэсэн ийм бодолтой байгаа шүү гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Энэ ажлын хэсгийн гишүүд суудалдаа сууна шүү. Чуулганы танхимд чөлөөтэй зорчоод байхгүй. Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя. Тэгшбаяр аа, суудалдаа суу.

Ц.Туваан: Сайнзориг гишүүний асуулт дээр нэмж хариулъя. Энэ уул уурхайн ашигласан компанийн ААНОАТ, дээрээс нь энэ гаргаж ирсэн бүтээгдэхүүнээс нь авч байгаа энэ АМНАТ-ын хуваарилалтын асуудал гээд яг тулгамдаад байгаа асуудлыг тавьж байгаа. Энэ дээр тантай санал нэг байгаа. Яагаад вэ гэхээр тэнд уул уурхай ашиглуулж байгаа сум, аймаг, орон нутгийн тэнд амьдарч байгаа орон нутаг болон иргэдэд энэ ашиглуулсныхаа нөгөө талд нь авах ашиг, ач холбогдлын асуудал энэ дээр яригдаж байгаа.

Тэгэхээр Их Хурлын даргын захирамжаар Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Тэгэхээр салбар яамны зүгээс бас яг энэ концепц дээр тантай санал нэг байна. Тэгэхгүй бол яг энэ орон нутагт болоод байгаа асуудлуудыг, уур уурхайгаа ашиглах дээр тулгамдаад байгаа асуудлуудыг шийдэхэд их хүндрэл учирч байгаа, учраад байгаа асуудал байгаа. Тэгэхээр ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн нэмж хариулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр АМНАТ дунджаар нэг 5,5 хувь байдаг юм. Хамгийн их ураны нөөцтэй Казахстан 6 хувь, Канад 5 хувь, Нигери 5 хувь, Австрали 5 хувь, Узбекистан 8 хувь байна. Тэгээд дунджаар нэг 5,5 хувь байдаг.

Тэгэхээр яг энэ урантай холбоотойгоор яг энэ ард иргэдийн болгоомжилдог асуудал дээр манай энэ бүх ордыг нээсэн физикч, геологич Жамсрандорж гуай бас энэ ураны асуудлаар бас тодорхой мэдээлэл өгчхөөч гэж. Ард иргэдийн болгоомжлолыг асуугаад бүх ураныг нээчхээд өнөөдөр далан хэд хүртлээ сайхан наslaад явж байгаа ийм ахмад хүн байна.

Мөн түүнчлэн яг энэ мал амьтантай холбоотойгоор ямар асуудал гардаг вэ гэдгийг Монгол Улсын гавьяат малын эмч Ганболд гуай бас 2 буурай бас нэг мэдээлэл өгчхөөрэй.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Я.Ганболд: Цацрагтай холбоотой ард иргэдийн зовдог асуудал бол ерөөсөө ураны ордуудын орчимд цацрагийн хэмжээ л байгаа шүү дээ. Тэр цацрагийн хэмжээ ерөнхийдөө бол Улаанбаатар хотод 20 микроген цаг байгаа. Тэгвэл юун дээр Халзан бүргэдэй дээр 16 милл зивэрт буюу энэ нь Улаанбаатарынхаас бараг 8 дахин өндөр. Тэгэхдээ ураны хүдэр дээр намайг 2003-аас, 2003 онд Дорнодын

ураны Зөөвч овоогийнхоос бараг 10-20 дахин өндөр хүдэр дээр ажиллаж байхад тэнд бол спектрометрийн заалт бол хязгаарыг даваад ингээд өндөр дуугараад байдаг. Холдох тусам дуу нь багасаад нэг 3-4 метр болонгуут ерөөсөө цацраг байхгүй болдог шүү дээ. Цацраг бол ерөөсөө яг байгаа хүдэр дээрээ л өндөр болохоос 2-3 метр болоод холдохоор ерөөсөө цацраг байхгүй болдог учраас ажиллаж байгаа хүмүүс болон орчин тойрондоо цацрагийн нөлөө эрс багасчихдаг.

Тийм учраас Монгол дээр бол урантай цэг цацраг идэвхтийн цэгүүд хэдэн зуугаараа хаа сайгүй байдаг учраас энэ талаар бол ер нь ойлголт бол бас ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна. Уучлаарай Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд ажлын хэсгийн гишүүддээ бас баярлалаа. Яг ингэж яах вэ, тодорхой зарим асуудлууд дээр цаг бага байна. Олон нийтэд бас ингэж мэдээллүүдийг өгөх нь бас чухал байгаа юм аа.

Ер нь зүгээр яах вэ, төрийн гаргаж байгаа шийдвэр чинь бас харилцан ашигтай, иргэдийнхээ аж ахуй, амьдралыг, орон нутгийг дэмжсэн л бодлого байгаа. Түүнээс биш энэ нэг байгаль орчныг сүйтгэчихье, энэ аюултай зүйлүүдийг Монголд нутагшуулчихъя гэсэн зүйл ерөөсөө байхгүй ээ. Энэ шинжлэх ухаанаар бас зарим зүйлүүд нь бас тийм ээ, ололтууд бас энэ эрсдэлүүдийг бууруулахад боломжийн технологиуд гарчихсан байгаа юм аа.

Тэгэхээр энийг бид хэд бас бодолцох ёстой юм. Тэгээд ер нь зүгээр цаашдаа гадаад харилцааны цөм бодлого нь өөрөө эдийн засгийн харилцаа л байх ёстой. Тэгэхээр бид хэд ч гэсэн энэ бодлогыг энэ дээрээ түлхүү баримтлах ёстой юм аа.

Би зүгээр Туваан сайдын юун дээр ганц зүйлийг л хэлмээр байгаа юм. Бид энэ Улсын Их Хурлын ажлын хэсэгт найдаад энэ зүйлүүдийг орхиж болохгүй ээ. Ашигт малтмалын хуулийг иж бүрнээр нь шинэчлэх, энийг дагасан хуулиудын уялдаа холбоог бодлогын яамаар буюу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам яаралтай оруулж ирнэ ээ. Түүнээс биш Улсын Их Хурал хийж байгаа, би бас дэмжиж байгаа гээд ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг мэдээж Засгийн газар, салбарын яам, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллаад энэ хуулийн шинэчлэх процессыг хурдасгах маш чухал үүрэгтэй байгаа. Тийм, бас олон ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг маш идэвхтэй ажиллаж байгаа. Засгийн газар, салбарын яамууд бас энэ дээр маш том дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Өнөөдөр бас Хууль зүйн яам, Засгийн газар, Улсын Их Хурал хамтраад энэ мэргэжлийн холбоодтой бас хамтын ажиллагааны гэрээ байгуулах, хамтарч ажиллах эхлэлүүд бас албан ёсоор тавигдаж байгаа.

Тэгэхээр энэ ер нь бол ганц гэрээнд зориулсан хуулийн өөрчлөлт биш. Ер нь манай энэ салбарын асуудал гэдэг тал дээрээ мэргэжлийн байгууллагууд маань илүү их том харж ажиллаарай. Зөвхөн юу одоо гэдэг юм, нэг гэрээ хийх гэж хууль өөрчилж байгаа гэдэг агуулга огт байж болохгүй. Цаашдаа энэ ураны салбар юу гэдэг юм, Францтай юм уу, Чехтэй юм уу, аль нэгэнтэй гэрээ хийнэ, хийхгүй гэхээс илүүтэйгээр энэ салбар өөрөө цаашдаа Монгол Улсын хөгжил дэвшилд, эдийн засагт илүү хувь нэмрээ оруулах юм уу үгүй юм уу. Монгол Улсын эдийн засаг

мэдээж уул уурхайгаас хамааралтай. Тэр дундаа ганцхан нүүрснээс хамааралтай байхгүйгээр олон төрлийн уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай байх нөхцөл рүү нь явуулах бодлого мөн үү, биш үү гэдэг дээр бас илүү сайн анхаарч, дээрээс нь бас ингээд нөгөө сургаар биш бодит нөхцөл байдал судалгаан дээр үндэслэсэн үйл ажиллагаа явуулж байх нь зүйтэй болов уу гэж ингэж бодож байна.

Ингээд ажлын хэсгийн дарга, энэ Яндагийн Ганболд Мон-Атомын мэргэжлийн шинжээчээр бас малын эмч, мэргэжлийн хүнээр бас хариулт тайлбар өгүүлээч гэсэн ийм хүсэлт ирж байна. Тэгэхээр Ганболд гуайг микрофонд урьж байна. Ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

Шинжээч Ганболд байна аа.

Тэгэхээр өнөөдөр сүүлийн хийсэн судалгааны дүнгүүдээс үзэхэд бол энэ цацраг идэвхт бодисын улмаас тодорхой хэмжээний нутаг дэвсгэр дээр малын өвчлөл байгаа гэсэн мэдээллүүд явдаг. Тэгээд энийг бол дүгнээд хэлэхэд 1 дүгээрт, өнөөдөр хүртэл Мал эмнэлгийн ерөнхий газрын жил бүр авдаг мэдээлэлд энэ ураны улмаас цацраг идэвхт бодисын улмаас малын өвчлөл хорогдол байна гэдэг мэдээлэл байхгүй.

2 дугаарт нь болохтой зэрэг бол 19, 23 онд хийсэн 17, 8 байгууллага оролцоод хийсэн судалгааны дүнгээс үзэхэд бол Дорноговь аймагт Мал эмнэлгийн газарт нь Сумын мал эмнэлгийн газарт нь бид нарын судалгаагаар ямар нэгэн байдлаар ийм гаж хөгжилтэй төл, мал байна гэсэн албан ёсны мэдээ байхгүй ээ.

Тийм учраас бид цаашдаа хэдийгээр энэ олборлолт ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

Я.Ганболд: Энэ тохиолдолд цаашдаа хамгийн гол нь энэ малчдын амьжиргааны асуудал дээр малын эрүүл мэндийн асуудал байх ёстой. Тэгэхээр цаашдаа 2 асуудал дээр анхаарч ажиллах ёстой юм байгаа юм.

1 дүгээрт нь бол ерөөсөө тухайн орон нутагт гарч байгаа өвчний тандан судалгааг бол мал эмнэлгийн байгууллага өөрийнхөө эрх зүйн хүрээнд, хуулийнхаа хүрээнд хийж явна.

2 дугаарт нь болохтой нь зэрэг бол энэ мал эмнэлгийн радио биологийн үндэслэлээр малд энэ цацраг идэвхт бодисын хордлого байна уу, үгүй юү гэдгийн улирлын, сарын, жилийн мониторингуудыг хийж явна аа.

Тийм учраас цаашдаа бол бүх юм хяналтад байна гэж ингэж ойлгож болно. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаясгалан: Учрал сайд, Жавхлан сайд 2-оос асуух гэсэн юм. Монгол Улсын цөмийн энергийн тухай хууль, төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогод цацраг идэвхт ашигт малтмалыг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч орон болж, цөмийн эрчим хүч ашиглах нь Монгол Улсын тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлыг

хангана. Ард түмний аж байдлыг дээшлүүлнэ. Өртөг багатай цахилгаан, дулаан үйлдвэрлэх болно гээд заачихсан байна л даа.

Хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Франц улстай хамтран АЦС барина гээд бид нар бүгдээрээ дэмжсэн, тийм үү. Франц улстай хамтран ажиллахыг дэмжиж, талархаж байгаа гишүүний нэг ээ. Франц улс өөрөө ураны нөөцгүй, цөмийн эрчим хүчнийхээ 70 хувийг реакторуудаасаа хангадаг ийм улс. Энэ улстай хамтарч ажиллана гэдэг бол боломж. Энэ улс 30 жилийнхээ цөмийн энергийн салбарын бодлогоо тодорхойлохдоо 14 шинэ цөмийн реактор барина гэхихсэн байгаа. 2050 он гэхэд дэлхийн цөмийн реакторууд ураны нөөц нь 30 он гэхэд 28 хувиар, 50 он гэхэд тэр дахиад 2 дахин илүү хэрэглээтэй болно гэхихсэн байна.

Гэтэл бид яагаад АЦС барих асуудлыг орхиод, зөвхөн шар нунтаг үйлдвэрлэхийг дэмжээд байгаа юм бэ? Шар нунтгийг сая Жавхлан сайд хэллээ. 2010 онд эцсийн бүтээгдэхүүн гээд баталчихсан юм байна шүү дээ. Тэгвэл бид нар цөмийн эрчим хүчийг эцсийн бүтээгдэхүүн гэж Засгийн газар яагаад тэгж баталж болохгүй юм. Нэгэнт л хуульдаа өөрчлөлт оруулж байгаа юм бол. Зөвч овоо юу бол, дэлхийн 12 том ордын нэг. Эндээс бид АЦС-ыг байгуулж яагаад болохгүй юм. Яагаад Монгол Улс, би ажлын хэсгийнхнээс асуухаар 15-20 жил болно гээд төвөгшөөгөөд байх шиг байх юм. Бид нар чинь ямар 20 жил болоод мөхөх гэж байгаа улс үндэстэн биш дээ. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар, Монгол Улсын үндэсний амбиц нь АЦС байж, бид нар хямд эрчим хүчийг өөрсдөө бүтээх ёстой шүү дээ. Яагаад энийг хойшлуулаад байгаа юм.

2 асуулт байна л даа. Нэг нь болохоор яагаад АЦС барихаа журмаар зохицуулна гээд байгаа юм. Яагаад хуульчлахгүй байгаа юм.

Нөгөөдөх нь шар нунтгийг эцсийн бүтээгдэхүүн гээд Засгийн газар баталчихсан юм бол эрчим хүчийг эцсийн бүтээгдэхүүн гэж батлаад нэгэнт хуульдаа өөрчлөлт хийж байгаа бол цаашаа явахгүй юм уу, бид нар. 2050 он гэхэд бид нар АЦС-тай болох боломж байна шүү дээ. Европын холбооны ийм том улстай хамтарч байгаа юм чинь.

Дараагийн нэг асуулт нь орон нутагт ямар үр өгөөж өгөх юм бэ? Ийм 3 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Засгийн газрын энэ 14 мега төслийн хүрээнд бид энэ Францтай хамтарсан Оронагийн хөрөнгө оруулалтын гэрээг хийнэ гэдэг ийм зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээндээ өнөөдөр энэ хэлэлцэж байгаа энэ Цөмийн энергийн хууль бол зөвхөн нэг гэрээнд зориулсан хууль ерөөсөө биш. Тэгээд бид нар бол өнгөрсөн алдаагаа давтахгүйн тулд эхлээд хууль, эрх зүйн орчноо тодорхой болгоод, энэ хөрөнгө оруулалтын орчин тодорхой болсон цагт цаашдаа олон төслүүд энэ хуулийн хүрээнд яваасай гэдэг зорилгоор эхлээд хуулиа хэлэлцүүлж байгаа юм. Түрүүн бас Ганбаатар гишүүн ч гэсэн асуугаад байсан. Энэ хууль батлагдсанаараа ямар нэгэн зүйлийг хатуу зохицуулах биш. Тэр одоо тэр АМНАТ-ын таазыг нь байхгүй болгож байна. Нэг ёсондоо тэр өнөөдөр ашиглалтын хуулиар нөгөө төрийн эзэмшлийн хувийг АМНАТ-аар орлуулдаг бол Цөмийн энергийн хуулиараа бас орлуулах боломжийг нээж байна гэхээр бид тэр хөрөнгө

оруулалтынхаа гэрээгээ байгуулахдаа хэрхэн яаж зохицуулах вэ гэдэг бол тэр гэрээгээр шийдэгдэх асуудал.

Яг үүнтэй адилхан энэ Мөнхбаясгалан гишүүний ярьж байгаа энэ АЦС барих асуудлыг хуулиар зохицуулах заавал шаардлага байхгүй. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бид ураны төслийг урагшлуулна. Цаашдаа энэ хөрөнгө оруулалтын гэрээ хийнэ. Дээрээс нь АЦС барих асуудлыг судална, шийдвэрлэнэ л гэдэг ийм л зорилтыг дэвшүүлсэн.

Тэгэхээр цаашдаа ч гэсэн нэгэнт хөгжлийнхөө үйл ажиллагааны хөтөлбөртөө энэ зорилтыг дэвшүүлсэн учраас энэ хөгжлийн бодлогын баримт бичгүүдээрээ тодорхойлоод, хэрэгжүүлээд явах асуудал бол нээлттэй. Тэгэхээр Цөмийн энергийн хуульд энэ асуудал нээлттэй цөмийн энергийг зөвхөн энхийн зорилгоор л ашиглах талаар ингээд тусгагдсан. Тэгэхээр мэдээж өнөөдөр энэ Цөмийн энергийн хууль батлагдаад явж байна гэдэг бол бид том алхам хийж байна л гэсэн үг. Тэгэхээр бол нэг цаашдаа нэг 10-15 жилд мэдээж хөрөнгө оруулалтыг татах ажлууд хийгдэнэ.

Мөн хамгийн сүүлд асуусан орон нутагт ямар тус дэм үзүүлэх вэ гэж. Тэгэхээр үнэхээр ер нь төр эзэмшлийнхээ 34 хувийг нь аваад ирээдүйд өр өгөө, өртэй үлдэх үү, эсвэл өнөөдөр ашиг орлогоо хүртэх үү гэдэг ийм зам дээр л байгаа. Эцсийн эцэст л тэр газрын хэвлийн баялгийн 50 дээр +1-ийг эзэмшиж байхаар хамгийн арга зөв хэлбэрийг сонгох ёстой. Гэхдээ энэ нь өөрөө иргэндээ ноогдол ашиг нь хүртдэг байх ёстой. Тэгэхээр яг өнөөдрийн энэ Цөмийн энергийн хууль юун дээр нийцсэн хөрөнгө оруулалтын гэрээ батлагдах юм бол яг нөгөө хэлэлцээрийн протоколд дурдагдсанаар тухайн орон нутагт бол ямар ч байсан 1 сая долларын тусламжийг бол тогтмол үзүүлж байя гэдгийг хэлэлцээрийн протоколд тусгасан.

Дээрээс нь АМНАТ өндөр болчхож байгаа учраас 65 хувийн АМНАТ-аа аваад тэр Ирээдүй өв сан руу хийчихээр үлдсэн тэр 10 хувь нь орон нутгийн санд орно гэхээр АМНАТ өндөр байх тусмаа орон нутгийг дэмжих санхүүжилт нь дэмжлэг болно. Ер ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Бөхчулууны Пүрэвдорж гишүүн нэмж хариулъя.

Б.Пүрэвдорж: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр магете буюу олон улсын атомын эрчим хүчний агентлагаас тийм амархан бас шийдвэр гараад шууд хөрөнгө оруулалт хийгээд явчихдаг биш, бас энэ чинь яг энэ эрчим хүчийг үйлдвэрлэдэг яг эндээ бас тодорхой хяналт тавьдаг бас нэг тийм хэд хэдэн орон тоо тэд нар нь илүү асуудлаа шийдээд явдаг. Тэгэхээр ер нь нэг 350мвт ваттаас доош юу, станцыг барихад нэг хамгийн багадаа 8 жил болно. 350-аас дээшээ болох юм бол 15-20 жил болоод явчихдаг ийм процедуртай л даа.

Тэгээд ер нь бол тэгээд дээрээс нь манайд яг энэ урантай холбоотой мэргэжилтэн хоёрхон 1 байна уу, 2 байна уу, ийм бага. Тийм учраас бид нар энэ Оронатай хамтарч ажиллаж байгаа нь бид нар бас тодорхой хэмжээний эхний алхам хийгдэж байгаа юм. Дараагийн алхам бид нар АЦС руугаа орно. Эндээ бид нар хүрэх ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Мөнхбаясгалан гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Энэ нэг ийм сонин түүх давтагдаад байна, Мөнхбаясгалан гишүүн ээ. Оюутолгойн гэрээг хийх хүртэл буюу 2009 он хүртэл бүх төрлийн ашигт малтмалаас НӨАТ буцаан олголт хийдэг байсан юм. Авдаггүй байсан гэсэн үг. 2009 онд буюу Оюутолгойн гэрээ хийхээс өмнөхөн НӨАТ-ын хуульд өөрчлөлт ороод, зөвхөн эцсийн бүтээгдэхүүн дээр л буцаан олголт хийнэ. Тэрнээс биш хүдэр баяжмалаас бол буцаан олголт хийхгүй шүү, НӨАТ авна шүү гэсэн ийм өөрчлөлт орсон.

Дараа нь буюу нэг жилийн дараа 2010 онд энэ Засгийн газрын тогтоолоор ийм өөрчлөлт орчихсон юм байна лээ. Яагаад орсныг бүү мэд. Тухайн үед нөхцөл байдал ямар байсан юм, бүү мэд. Одоо харин бид нар шинэ мөчлөг, шинэ бидний хандлага эхэлж байна л гэж би хараад хэлээд байгаа юм. Тэгэхээр энийг бид энд нэг эцэслэх хэрэгтэй, нэг тийш нь болгох ёстой. Яг орлого бүрдүүлэлт талаасаа авах нь зүйтэй.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Мөнхбаясгалан гишүүнтэй яг энэ АЦС барьж ашиглах гэдэг энэ концепц дээр нь нэгдэж байгаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орчихсон. Энэ ажиллагаа хэрэгжээд явна. Жилийн хувьд нэг 10-15 жил шаардагддаг ийм олон улсын практик байгаа юм байна лээ. Цөмийн эрчим хүч ашиглах нь өөрөө хамгийн хямд эрчим хүчний эх үүсвэр. Дээрээс нь хүлэмжийн хийн ялгарал хамгийн бага гаргадаг ийм эрчим хүчний салбар байгаа. Яг энэ өдрүүдэд буюу энэ 11 сарын 18-аас 19-ний хооронд Монгол Улсад энэ Олон улсын цөмийн энергийн агентлагтай манай одоо Цөмийн энергийн комисс, Мон-Атом энэ тэр хамтраад энэ бага дунд оврын цөмийн реактор ашиглах талаар энэ асуудлаар семинар хийж байгаа.

Тэгэхээр бас энэ талаар тухайн үеийн яг энэ семинар дээр яригдсан асуудлыг бас мэдээллийг нэмж Мөнхбаясгалан гишүүнд өгье. Боломжтой бол бас очоод ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууна.

О.Батнайрамдал: Та бүхэндээ энэ өглөөний мэнд хүргэе. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт үүнийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Сая би өөрөө ч гэсэн ажлын хэсэг дээр нь байгаа. Тэгэхээр энэ дээр бас нэг заавал ярих ёстой нэг зүйл байна аа. Энэ ураны төсөл бол 2024 оноос 27 он хүртэл бүтээн байгуулалт явж байгаад, дахиад 2060 он хүртэл уурхай ажиллах юм. 2060 онд энэ уурхай хаагаад, дараагийн уурхай хаагаад дахиад нөхөн сэргээлт байгаль орчны нөхөн сэргээлт явна. Энэ бүхэл бүтэн 10 жил нөхөн сэргээлт явах ийм концепт орж ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр үед уурхайн үйлдвэр хаагаад, байгаль орчны нөхөн сэргээлт яваад, хаалтын дараах бас засвар арчилгаа гэж ийм 3 үндсэн юм байдаг юм. Энэ 3 буцаад маш их мөнгөн хөрөнгө шаардана аа. Энэ хууль явснаараа буцаад дараа дараагийн томоохон уурхайн төслүүд хаалт болоход яах юм, нөхөн сэргээлт болоход яах юм, тэр мөнгөн хөрөнгө хаана эрсдэлгүй найдвартай байх вэ гэдэг маш том концессын асуудал энэ хууль дээр орж ирж байгаа юм л даа. Гэтэл энэ зарцуулах мөнгөн хөрөнгө уул нь бол тэр л компани тэр уурхайн компани өөр дээрээ эрсдэлээ үүрч явах ёстой юм. Сая бид нарын энэ ажлын хэсэг дээр өчигдөр ороод дэмжигдчихсэн санал бол үүнд зарцуулагдах 300 бараг 20 сая орчим доллар. Энэ ингээд жил болгон нэг ойролцоогоор 10 сая төгрөг, 10 сая доллар хуримтлагдаж

явсаар байгаад нөхөн сэргээлт хийх тэр 10 жилд 60-аас 70 онд нөхөн сэргээлт хийхэд 320 орчим сая долларын асуудал яригдах байхгүй юу.

Тэгэхээр энэ мөнгө буцаад Монголбанкны Ирээдүйн өв сангийн дансанд ингээд л харилцах дансанд л суухаар л ингээд дэмжигдээд ороод ирчихлээ л дээ. Уул уурхайн хаалтын мөнгө гэдэг чинь 60 онд энэ 100 хувь байгаль орчин, нөхөн сэргээлтэд зарцуулагдах ёстой мөнгө байхгүй юу. Гэтэл ийшээ аваачаад бид нар Монголбанкаа хутгаад оруулчихлаа. Монголбанк уул уурхайн нөхөн сэргээлтийн мөнгө хадгалдаг, хүү тооцдог, арилжааны банк биш шүү дээ. Тэр дундаа Монголбанк дээр байгаа Ирээдүйн өв сан, одоо бүр Баялгийн сантайгаа хутгасан. Баялгийн санг энэ ирээдүйн Баялгийн сангийн хууль зөрчсөн ийм агуулга ороод ирчхэж байгаа байхгүй юу. Баялгийн сан уул уурхайн хаалтын мөнгийг байршуулдаг нэг харилцах данс болж хувирлаа, ингээд. Болохгүй шүү дээ. Одоо энэ Үндэсний баялгийн сангийн тухай хуулиа ч баталсан. Одоо бид нар концептоо ингээд буцаад нөхөн сэргээлтийн мөнгө Баялгийн сангийн Ирээдүйн ав сангийн Монголбанк дахь данс руу ордог ийм нөхцөл рүү л орчихлоо л доо. Ийм болохгүй шүү дээ.

Олон улсын жишгийг л дагах ёстой юм. Олон улсын жишиг нь өөрөө ерөөсөө олон улсын санхүүгийн байгууллагад баталгаа эсвэл олон улсын тийм санхүүгийн бүтээгдэхүүнд л ингээд байр байршуулдаг байхгүй юу. Энэ бол олон улсад Австрали, Канад, Өмнөд Африк энэ бүх жишиг орнуудад хамгийн түгээмэл хэрэглэгддэг зарчим. Тэгэхээр энэ саналыг оруулаад уначихлаа. Тэгэхээр энийг эрхэм гишүүд минь та бүхэн энийг ойлгоод дэмжиж өгөөч ээ. Сүүлдээ энэ заалт явж явж Үндэсний баялгийн сангийн тухай хууль зөрчсөн заалт боллоо шүү, зарчмаа зөрчсөн.

Тэгэхээр энэ дээр хууль зөрчсөн заалт орохоор яг яах ёстой юм. Эсвэл ХЗБХ-ноос дүгнэлт гарах ёстой юу? Ирээдүйн өв сан, Үндэсний баялгийн сангийн хууль дээр энэ уурхайн нөхөн тэр нөхөн төлбөрт нөхөн сэргээлтэд ашиглах мөнгө хадгалдаг энэ Баялгийн сан гэж бид нар байгуулаагүй шүү дээ. 1 дүгээрт. Энийг тэгэхээр яг Пүрэвдорж гишүүнээс асуумаар байна. Таны санал оруулсан санал.

2 дугаарт, бас энэ хөрөнгө оруулалтын гэрээ энэ хуулийн дараа байгуулагдана. Оюутолгой дээр бас бид нар хөрөнгө оруулалтын гэрээ, хувь нийлүүлэгчдийн гэрээ, менежментийн гэрээ гэсэн цогцоор нь бид нар байгуулах ёстой. Энэ цогцоороо байгуулж байж бид нар яг Монголын талд авах өгөөж эд нар нь ойлгомжтой болох юм. Энэ дээр бас асуулт асуучихмаар байна.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хариулт өгье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр мэдээж ОУБ-ын баталгаа гаргах боломж байгаа. Тэгэхээр баталгаа гаргалаа гэхэд манай талд ашиг байхгүй юм. Яагаад гэвэл баталгаа гаргасан талдаа жишээ нь баталгааны цаас л үзүүлчихнэ. Тэгээд бид нар түүнийг захирна бас тодорхой хэмжээгээр менежмент хийх боломжгүй болчхож байгаа юм. Тэгэхээр миний гаргасан санал бол Ирээдүйн өв сангийн Монголбанк дахь валютын тусгай данс гэсэн. Тэгэхээр би яг өөрөө санал хураах болохоороо Ирээдүйн өв сангийн гэдгийг нь авч хаячихна, аваад хаячихна. Тэгэхээр Монголбанк дахь валютын тусгай данс гэж санал хураалгах юм. Хэрвээ Монголбанк дахь валютын тусгай дансанд байршуулаад явах юм бол бид жишээ нь либер дээр нэмэх нь 1 хувь буюу одоо өнөөдрийн байдлаар нэг 4,8 хувийн шимтгэл аваад байлгана гэдэг чинь ойролцоогоор нэг 600 мянган доллар жилд ирж байгаа тэр 12 сая, 13 сая доллароосоо нэг 600 орчим мянган долларыг бид нар авч үлдэх боломжтой юм.

Хэрвээ энэ дээр жишээ нь Төрийн сангийн Монголбанк дахь валютын дансанд байршуулах юм бол шууд төсөв рүүгээ зарцуулаад явах ийм эрх нь Сангийн яам дээр үлдчих байхгүй юу даа.

Тийм учраас энийг Монголбанкны валютын тусгай данс гэж өөрчилнө. Тэгэхээр илүү менежмент хийгээд явах боломжтой болно.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Энэ тэр Монголбанкны данс байна уу, баталгаа байна уу гэдэгтэй учир нь биш юм байгаа юм аа. Баталгаа чинь зүгээр нэг цаас өгнө, бид нарт. Нөгөөдөх нь мөнгө өгнө. Тэр мөнгө нь орж ирээд Монголбанк Монгол Улсад Монголбанканд байна уу, хаана байна, байршлаа гэхэд бидний гадаад валютын нөөц нэмэгдэнэ. Төлбөрийн тэнцэл дээр нэмэгдэнэ. Цаад талын хүсээд байгаа юм нь цаас бичиж өгөх гээд байгаа байхгүй юу. Мөнгө өгөхгүй. Энэ баталгаа болно шүү дээ та нарт гээд. Үгүй ээ, тэгж байхаар мөнгө аваад нэг хэдэн жилдээ байршуулаад тэр нь манай нөөцийн сан дээр байгаад байж байх нь хамаагүй нэмэртэй байхгүй юу. Хүүтэй, хүүгүй байна уу, тэр бүр дараагийн мянга дахь асуудал.

Тийм учраас энэ дээр нөгөө нэг цаад тал сулруулах гээд байгаа юман дээр нь нэмж хэдүүлээ кнопдоод хэрэггүй байхгүй юу. Хэдүүлээ нэг ганц нэг юман дээрээ ингээд бас нэг давуу байдал олж байгаа юмаа хадгалаад ойлгоод явчих хэрэгтэй. Оюутолгойн гэрээн дээр бид нар бас ер нь нэг иймэрхүү алдаа гаргачихсан шүү дээ. Бүх мөнгөн хөрөнгө, бүх урсгал нь гадна талдаа явна, энэ гаднын банкнуудыг нөгөө шүтдэг байх үедээ. Одоо тэрнээс чинь хойш бас дотоодын банкнууд бас нэг үеэ бодвол энэ чинь бас ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

Энэ саяын асуулттай холбогдуулан Монголбанкны бас албаны хүмүүс ирж бас гишүүдэд яг энэ асуудал дээр тайлбар өгөх нь бас зөв байх аа. Хариулт өгөх нь зөв байх гэж бодож байна. Их Хурлын Тамгын газраас бас Монголбанкны Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийн түвшний албан тушаалтныг дуудан ирүүлэхийг чиглэл болгоё

Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт тодруулж асууна аа.

О.Батнайрамдал: Энэ гэв гэнэт нэг том мөнгө ороод ирж байгаа биш л дээ. Энэ жил болгон ойролцоогоор нэг 10 орчим сая доллар. Ингээд л ороод л явсаар байгаад 2060 он гэхэд нэг ойролцоогоор нэг 320 орчим сая доллар болж байгаа юм. Тэгэхээр жилийн нэг 10 сая доллар Монголын валютын нөөцөд том хувь нэмэр оруулна гэж тэр өнцгөөс нь би харахгүй л байна л даа. Яг олон улсын жишгээс явахгүй бол институц хөгжиж бэхжиж амжаагүй оронд энэ бэлэн мөнгө чинь бид нар өөрсдөө 60 он гэхэд тэр мөнгийг 320 сая доллар гаргах эрсдэлийг бид нар үүрчхээд байгаа байхгүй юу. Энэ эрсдэлийг бид нар үүрч яах гээд байгаа юмб Энэ чинь хувьцаа, тэр компани нь өөрөө үүрээд тэрийгээ хийх л ёстой байхгүй юу.

Тэгэхээр энэ эрсдэлийг буцаад тэр мөнгө нь 60 он гэхэд байх уу. Элдэв янзын юманд үрэгдчих үү. Энэ эрсдэл бид нар дээр бид нар өөрсдөө татаж аваад энийгээ үүрэх гээд байна л даа. Тэгэхээр олон улсын жишиг ч байгаа юм. Олон улсад хамгийн түгээмэл хэрэглэгддэг санхүүгийн хэрэгсэл дээр баталгаа гэсэн бичиг чинь

хангалттай байхгүй юу. Магадгүй тэр хамгийн эрсдэлгүй, найдвартай баталгааны хуудас байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Би нэмж хариулъя аа. Тэгэхээр тэр 10 сая доллар байна уу, 1 доллар байна уу гэдэг нь бас 2, 3 дахь асуудал. Бид байж болох тэр бэлэн мөнгийг тусгаар улс өөрийнхөө Төв банканд байршуулна гэдэг чинь өөрөө аягүй том мессеж байхгүй юу. Тэгээд бид Төв банкандаа ингээд буурай болсон учраас итгэхгүй байна. Тийм учраас гаднын банкны баталгаа хэрэгтэй байна гэж Улсын Их Хурлын заалнаас бид нар тийм тодорхойлолт Төв банкандаа өгч болохгүй ээ. Төв банкандаа илүү их итгэл өгөх хэрэгтэй. Бид манай Төв банкаар дамжсан бүх мөнгөн хөрөнгө Монгол Улсын хувьд бид нар баталгаатай гэж үзэж байна гэдэг энэ мессеж нь өөрөө аягүй чухал.

Дээрээс нь 10 сая доллар бас тийм бага мөнгө ч бас биш шүү. Бид нар энийг бас бага мөнгө гэж үзэхээр бас арай л болоогүй байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсэг дээр гаргасан саналын томъёоллыг би дэмжиж байгаа. Энэ их зөв өө гэж харж байна. Тийм.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Да.Цогтбаатар: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Хөрөнгө оруулалтын гэрээнд татвар тогтворжуулах асуудлыг тодорхой хязгаарлалт зарчимтай болгох шаардлагатай байгаа гэж харж байгаа. Тэгээд одоо болохоор энэ төсөл дээрээ татварын орчныг тогтвортой байлгах гэдгийг тогтворжуулах татварын орчныг тогтоох гээд өөрчлөөд, өөрчлөхөөр энэ ямар давуу байдал үүсэх вэ? Тодорхой мэдээлэл авах гэсэн юм. Энэ Сангийн сайд хариулах болов уу? Татвартай холбоотой өөр бусад хүн байвал хариулах болов уу?

Дараагийнх нь асуулт. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрт бол үл ялгаварлах, адил тэгш л хандах, суурь зарчмын дагуу бусад улсын хөрөнгө оруулагч нар нь барьцах асуудал гарах уу гэдэг нэг ийм асуулт байгаа.

Тэгээд 3 дахь нь болохоор энэ миний сонссоноор бол Япон, Солонгос зэрэг улсуудын техник, технологи нь бол энэ санал болгоод байгаа Францынхаас илүү байгаа. Мөн дээрээс нь энэ хамгийн багадаа 1,5-2 дахин илүү үр өгөөжтэй байх төслүүдээс нь бид нар татгалзаад, бусад орноос энэ хөөгдөөд байна гэж яригдаад байгаа бас л энэ өчигдрөөс. Тэгээд энэ хөөгдөөд байгаа энэ Францын компанийг бид нар энэ төсөл дээрээ хамтаръя гэж уриад байгаагаа бас тайлбарлах хэрэгтэй байна гэсэн ийм 3 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал яригдаж байгаа. Бид ямар нэгэн, аль нэг улстай, ямар нэгэн компанитай гэрээ хийх асуудал өнөөдөр ярилцаагүй гэдгийг бол, хэлэлцээгүй гэдгийг бол бас гишүүд маань их зөв ойлгох ёстой. Намайг бас Улсын Их Хурлын дэгийг барьж ажиллахыг их шаардаж байгаа.

Тийм учраас зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуулт асуун. Мөн түүнд нь ажлын хэсгийн гишүүд хариулт өгнө.

Сангийн сайд Болдын Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь нэг суурь зарчмын асуудалд ярьчихлаа. Тэгэхээр энэ ийм юм байгаа юм. Өнөөдрийг хүртэл энэ татварын тогтвортой орчныг тогтоох, байлгах гэдэг ойлголт нь нөгөө Цөмийн энергийн тухай хууль дотроо бас суучихсан яваад байгаа юм. Тэгэхээр энэ нь өөрөө нөгөө нэг маргаан үүсгэх тийм, аягүй тийм задгай орчныг боломжийг нь тавьж өгчхөөд байгаа байхгүй юу. Тэгээд л нөгөө нэг гэрээ хийнэ, өө энэ чинь нөгөө тогтвортой байдлын гэрээнд тусгачихсан асуудал шүү дээ гээд л аягүй бүр задгай хамрах шаардлагагүй. Ингээд нэг аргачлалтай холбоотой юмаар маргаад л, аль болох л бага татвар төлөх ийм орчин руу бид түлхээд оруулчихсан юм байна лээ. Оюутолгойн жишээн дээр. Жишээн дээр Ашигт малтмалын хууль нөгөө бусад хуулиуд дээр орсон жишээ байна. Хөрөнгө оруулалтын хууль дээр орсон жишээ.

Тийм учраас энэ 2 хууль дээрээс нь аваад зөвхөн Татварын хууль руугаа оруулчихъя гэж байгаа юм. Татварын хуулиар л тогтвортой байдлыг нь тогтооно. Тэгээд нөгөө Цөмийн энергийн хууль дээр чинь Цөмийн энергийн хуулиар татварын орчныг тогтоогоод байгаа юм шиг ийм заалттай байсан байхгүй юу. Тэр 30.1.1 нь татварын орчныг тогтвортой байлгана гээд. Энэ чинь Цөмийн энергийн хууль. Гэтэл ингэхгүй ээ, одоо бол тогтворжуулах татварын орчныг тогтооно гээд өөрчилчихөөр буцаад нөгөө Татварын хууль руугаа заалтаа барина гэдэг зарчим руугаа шилжчихэж байгаа юм. Тэгэхээр маш ойлгомжтой. Хэдхэн юман дээр л тогтвортой байдал үүснэ. Тэрнээс бусад нь бол хогийг нь цэвэрлэж байгаа байхгүй юу. Энэ дээр маргаан үүсэхгүй шүү. Тогтвортой байдал биш хамаарахгүй, үг дуугүй төл өө гэдэг ийм зарчим руугаа шилжиж байгаа юм. Улам чангарч байна, нарийсаж байна, тодорхой болж байна гэсэн үг. Тийм.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Цогтбаатар гишүүний асуулт дээр энэ олборлолтын технологитой холбоотой асуудал дээр нь хариулт өгье. Энэ дэлхий дээр бас энэ уран олборлолт нь бас олон янзын аргуудаар олборлож байгаа. Ил, далд, газрын доор уусган баяжуулах гээд. Тэгээд энэ технологийн арга сонголт нь тухайн ордынхоо нөхцөл байдлаас шалтгаалж сонгогдож байгаа ийм арга аа.

Тэгэхээр манай Монголын энэ Зөөвч-Овоо орд өөрөө газрын доор шаварлаг элсэн ийм битүү ийм орчинд байгаа ийм баяжмал байгаа. Тэгээд энэ рүү газрын доор нь хүхрийн нэг хувийн сул уусмал шахаж, тэр уусмалдаа уранаа шингээж барьж, авч ингэж ашиглах ийм технологи байгаа. Дэлхий дээр өнөөдөр олборлож байгаа ураны ордуудын нэг 55-60 орчим хувийг нь энэ уусган баяжуулах энэ аргаар олборлож байгаа. Тэгээд яах вэ, энгийн үгээр хэлэх юм энэ ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмчих үү? Туваан сайдын микрофоныг нэмж өгье, гүйцээж хариулъя.

Ц.Туваан: Энэ олборлож байгаа энэ технологи нь энгийн хар үгээр хэлэх юм бол бид бүхэн бас нэг ахуйн нөхцөлд нэг зэвэрчихсэн паарыг угаах гээд нэг ийм техникийн сод ашиглаад ингээд зайлаад угаадаг. Жолооч нар бол сайн мэдэж байгаа. Машины мотор угаахад дээрээс нь нэг шингэн хийж байгаад тодорхой хугацаанд нормальдаж байгаад буцааж аваад цэвэрлэдэг. Энэрэхүй битүү орчинд нь доор нь ингэж тэр уусмалаар уранаа барьж аваад, дараа нь тэндээсээ уранаа авах гэсэн ийм л арга гэдгийг бас хэлье.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна.

Ө.Шижир: Өглөөний мэнд хүргэе. Бид нар чинь нөгөө 2024-2028 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээрээ нэг хүнд ноогдох ДНБ-ийг 10 мянган доллароор хүргэнэ гээд биччихсэн. Тэгээд тэрийгээ баталчихсан. Тэгээд тэгсэн мөртөө бид нар одоогийн байдлаар зөвхөн экспорт гээд бодоход нийт экспортын 87 хувийг чинь л алт, зэс, нүүрс 3 л эзэлж байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар дараагийн буюу гуравдагч улсад эсвэл дөрөвдөгч улсад мөн дараагийн өөр төрлийн бүтээгдэхүүн худалдах зайлшгүй шаардлага үүсэж байгаа юм. Тэгж байж бид нар орлогын өөр нэмэлт эх үүсвэртэй болж байж ДНБ 10 мянган доллар хүрэх ийм зорилгодоо хүрнэ ээ.

Тийм учраас Цөмийн энергийн хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ надад нэг хэд хэдэн асуулт байна. Яг одоо бол 2011 оноос хойш ураны салбар яг өсөлтийн жил дээр явж байгаа юм байна лээ. Тэгээд энэ нэг цаашдаа 2070 он хүртэл өсөх ийм хандлагатай байгаа. Тэгэхээр бид нар энэ алтан мөчийг гэх юм уу ашиглах нь зайлшгүй шаардлагатай.

Мөн 2 дугаарт, Засгийн газар, Ерөнхийлөгчийнх нь түвшинд гадаад улстай хэлэлцээр хийхээд, тэр хэлэлцээрийнхээ цаг тухай бүрд нь буюу амласан цаг хугацаандаа Монгол Улс өөрөө хэрэгжүүлдэг байж байж, бид нар дараа дараагийн хөрөнгө оруулагчдад итгэл найдвар сэргээнэ ээ. Тэгэхгүй бол очиж ярьчихаад энд өөр шийдвэр гараад байдаг бас байж болохгүй. Тийм болохоор Засгийн газар бас Их Хуралтайгаа маш энэ асуудлаа сайн цаашид ярьдаг байвал бас их зүгээр байна.

Ер нь одоо бол Монгол ураны нөөцөөрөө дэлхийд бараг эхний 10-д орчихсон. Дэлхийн нөөцийн 2-3 хувь, Хятад бас 3хувь. Тэгэхээр үндсэндээ бид нар Хятадтай яг адилхан ураны нөөцтэй байгаа гэсэн үг.

Тэгээд Учрал сайдаас асууя. Одоо бид нар нэгэнт Францын талд энэ асуудлыг яриад явж байгаа. Тэгэхэд 2009 онд болсон Хан Ресурс гэдэг компанийн хувь заяаг давтахгүй байх гэдэг баталгаа юу байгаа вэ? Тэр чинь үндсэндээ Медведевийг Монгол Улсад дайчлахаас 1 сарын өмнө Канадын компанийн эзэмшиж байсан ураны лицензийг цуцлаад, Орос Монголын хамтарсан компанид өгөөд, түүнээс л улс төрийн асуудал үүссэн шүү дээ. Оросоос ингээд яг 2 дахь удаагаа бид нарт бага оврын АЦС барьж өгнө гэж амлаж байна. Инсийкт дээр хүрээгүй. 2007 онд ярьсан, сая бас Ерөнхийлөгчийг Францаас айлчлаад ирснээс 7 хоногийн дараа ирж бас амласан. Тэгэхээр энэ амлалт бол худлаа шүү.

Тийм учраас бид нар 3 дахь хөрштэйгөө заавал ийм том хэмжээний төслүүдийг хэрэгжүүлэхэд зүй ёсны шаардлагатай. Тэгэхээр 2010 онд болсон тэр Хан Ресурсын асуудал бол бид нар уран ашиглана гэж лицензийг нь аваад, ашигласан ч юм байхгүй 70 сая долларын өрөнд ороод төлсөн шүү дээ. Тэгэхээр энэ хувь заяаг бид нар давтахгүй гэдэг 1 дүгээрт баталгаа юу байна аа? Энийг Учрал сайдаас асууя.

Жавхлан сайдаас. Бид нар ингээд нэг хөтөлбөр хэрэгжих болохоор л татвар өөрчлөөд байгаа юм. Татварын ерөнхий хууль өөрчлөөд байх юм. 2019 оны 3 сарын 22-нд Татварын тухай хууль шинэчлэн батлагдсанаас хойш одоо энэ ингээд 40 дэх өөрчлөлт нь, 40 дэх. Бид нар үндсэндээ 6 жилд 40 удаа Татварын ерөнхий хуульд ямар нэгэн байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулж байна. Тэгээд татварын хууль чинь

өөрөө тогтвортой байж байж, эдийн засаг, санхүүгийн салбар чинь тогтвортой байх байхгүй юу. Монголд хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулж байгаа нь хамгийн түрүүнд Татварын хуулийг уншиж байгаа. Бид нар Монголд оруулж ирж байгаа хөрөнгө оруулагчид хамгийн түрүүнд татварын хуулийг уншаад, татварын хуульд заасан заалтуудаа ТЭЗҮ-үүдээ боловсруулж байгаа. Тэгээд 1 хууль явах болохоор бид нар ингээд л өөрчлөөд байгаа юм. Түрүүн яг Амарбаясгалан дарга хэлж байна шүү дээ. Бид нар нэг төсөлд зориулаад хуулийг өөрчлөөд байж болохгүй гээд. Татварын хууль хамгийн хөдөлгөөнгүй, хамгийн суурийн хууль байх ёстой. Тэгээд ингээд бид нар хуулиудаа бас ингээд өөрчлөөд байгаа нь юу вэ гэдэг асуудал байна.

Мэдээж бас Засгийн газрын мөрийн хөтөлбөрт түрүүн Мөнхбаясгалан гишүүн хэлж байна лээ. АЦС барих зорилтоо тавиад ер нь хэлэлцээр дээр энэ асуудлаа давхар зэрэг яриад явбал яасан юм бэ. 15, 20 жилийн дараа ашиглалтад ороход энэ чинь бас л ашигтай л үр дүнтэй л төсөл, хөтөлбөр болно шүү дээ гээд. Тэгээд ийм 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Шижир гишүүн их чухал юм хөндөж байна. Ер нь Монгол Улсын хууль, ялангуяа Улсын Их Хурлаас хамаарсан энэ улс төрийн болон хууль эрх зүйн орчин дахь энэ тогтвортой байдлын асуудал маш чухал байгаа. Тийм ээ. Одоо бид бол өнгөрсөн цаг хугацаанд хэд хэдэн том асуудал өнөөдрийг хүртэл хөндөгдчихсэн мөртөө шийдэж чадахгүй явж байгаа шүү дээ. Газрын тосны хайгуул, олборлолтын ажил. Гэрээ хийгээд л тогтвортой байдлын гэрээ байгуулаад л, баахан хөрөнгө оруулалт татчихсан. Өнөөдөр 4 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг Монголд хийчихсэн мөртөө тогтвортой үйл ажиллагаа явуулж чадахаа байчихсан. Хайгуул нь, олборлолт нь жилдээ 1 сая тонноос дээшээ гараад ирж байсан нөхцөл байдал өнөөдөр 300 мянга болтлоо унаад, хөрөнгө оруулагч итгэлгүй болчихож байгаа юм.

2 дахь асуудал төмөр замын асуудал. Тавантолгой Гашуун сухайт чиглэлийн төмөр замын асуудлыг урд хөрштэйгөө гэрээ байгуулаад, Улсын Их Хурлаар оруулж асуудлаа шийдвэрлэхээд, араас нь ахиад Улсын Их Хурлын өөр шийдвэр гараад, өнөөдөр хүртэл бид холболт хийж чадаагүй. Бүтээн байгуулалт хийгдсэнээс хойш 12 жил, яриа хэлэлцээр эхэлсэнээс хойш 16 жилийн хугацааг алдчихсан. Тэгээд тэр нь эцсийн бүлэгт хэн хохироод байгаа юм гэхээр Монголчууд л хохирч байгаа юм. Бидэнтэй хамтарч ажиллаж байгаа гаднын хөрөнгө оруулагчид хохирохгүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг энэ Цөмийн энергийн тухай хууль өнөөдөр хэлэлцэж байгаа дээр гишүүд маш сайн анхаарлаа төвлөрүүлэх нэг зүйл бол бид нэгхэн гэрээний асуудал огт яриагүй ээ. Цаашдаа бид энэ цөмийн энергитэй холбоотой, ураны чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалтуудтай холбоотой асуудлын тогтвортой байдлыг 5 жил биш, 10 жил биш, цаашдаа Монгол Улсын бодлого ямар байх юм бэ гэдгийг хэлэлцэж байна гэдэг дээр их сайн төвлөрч ажиллах ёстой шүү. Гишүүд маань энэ дээр бас хариуцлагатай хандаж, энэ олон гишүүн анхаарал тавьж, тэр битгий хэл Улсын Их Хурлын дэд даргаар ахлуулсан ажлын хэсгийг гаргаж ажиллаж байгаа гэдгийг та бүхэн маань тэр ач холбогдол талаас нь илүү сайн анхаарч ажиллаарай гэдгийг хүсэж байна.

Мэдээж Улсын Их Хурлын гишүүн болгоны гаргаж байгаа санал зөв байх албагүй. Бас мэргэжлийн байх албагүй. Яг энэ байдал дээр ажлын хэсэг, мэргэжлийн яам зөв тайлбаруудыг нь өгч, зөв ойлголтыг нийгэмд болон Улсын Их

Хуралдаа бас өгч байж, энэ асуудал шийдэгдэнэ гэдгийг бас хариуцлагатай хэлэхийг хүсэж байна.

Ингээд Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Шижир гишүүний асуултад хариулъя. Ер нь татварын орчин өөрөө их тодорхой, ойлгомжтой, тогтвортой байх гэдэг суурь зарчимтай Тантай 100 хувь санал нийлж байна аа. Энэ удаа энэ тогтвортой байдалтай холбоотой орж ирж байгаа өөрчлөлт бол бид нар алдсан сургамж дээрээ орж ирж байгаа өөрчлөлт гэж ойлгож болно. 2009 оноос хойш 15 жилийн хугацаа дотор бид нар хөрөнгө оруулалтын ийм том гэрээ байгуулаагүй. Энэ хугацаанд хөрөнгө оруулалттай холбоотой, тогтворжуулалттай холбоотой ямар ч өөрчлөлт татварын хуульд ороогүй, 15 жил. Тэгэхээр энийг ойр ойрхон энэтэй холбоотой өөрчлөлт орсон гэж үзэхгүй байх гэж ингэж бодож байна. Тогтворгүй байсан гэж үзэхгүй байх гэж ингэж бодож байна.

Бид Оюутолгой дээр гаргасан тэр алдаа, тэр задгай тавьсан маргаан үүсгэх боломж олгосон тэр алдаагаа засаж, маш тодорхой болгож ирж байгаа, маш тодорхой болгож ирж байгаа. Магадгүй бидэнд дахиад Оюутолгой шиг олон хөрөнгө оруулалтын гэрээ гарч ирээсэй. Тэгвэл бид нар энийгээ барихад маш чанга сууна. Маш тодорхой болж ирнэ. Монгол Улсад маш ашигтай болж ирнэ. Энэ гэрээгээр, энэ заалтуудаар шүү.

Харин татварын орчныг тодорхойгүй болгох гээд байгаа, тогтворгүй болгох гээд байгаа зүйлүүд бас яваад байгаа шүү. Татварын орчинд реформ хийнэ гэдгийг олон улс төрчид яриад байгаа. Энүүгээр харин янз бүрийн лобби, янз бүрийн юм орж ирэх вий, янз бүрийн шахалт орж ирэх вий, цухалзаад байгаа. Тэгэхээр энэ татварын реформ, татварын орчны реформ гэдгийг бид нар маш болгоомжтой бодож, томъёолж, Улсын Их Хурал хөдлөх ёстой. 2019 онд буюу сая хэдхэн жилийн өмнө маш том реформ хийсэн. Бид одоо 8 жил ч болоогүй байгаа ийм хуулийн татварын орчинтой байгаа.

Тэгэхээр яг юуг нь өөрчлөх юм, юу нь болохгүй байгаа гэдэг энийгээ их сайн аудиталж байж байж бизнес хийж байж байж, маш оновчтой оношоо тогтоож байж, энэ дээр бид хөдлөх ёстой шүү гэдгийг хэлэх байна. Энэ дээр таны хэлж байгаагаар би санал нийлэх, бидэнтэй бас санал нийлэх юм байна аа. Агуулга нийлэх юм байна гэж ойлгож байна. Тийм, баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Бөхчулууны Пүрэвдорж гишүүн нэмж хариулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр яг Хан Ресурст бол ашиглалтын 2 лиценз л байсан юм. Бид нар хөрөнгө оруулалтын гэрээ хийгээгүй байсан юм. Тэгээд энийгээ л Засгийн газар цуцлаад тухайн үед Мардайг Орост өгөх тухай асуудал ярьсан. Өнөөдөр ч гэсэн Мардайг бас Орост өг, одоо Оростой хамтарч эзэмшүүлэх тухай асуудал бас идэвхтэй явж байгаа. Ер нь миний байр суурь бол Эмээлтийн Майнсын 2, 3 лиценз байгаа. Түүгээрээ дамжуулж Хятадад, Хятадтай, Луугийн орд дээр, жишээ нь Америк ч юм уу, аль эсвэл бусад ордууд дээр Английг оруулаад, ингээд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 оронтой бид нар хамтдаа энэ ураны салбарт ажиллах юм бол илүү үр дүнтэй байна.

Тэгээд дээрээс нь бид нар Японоор баяжуулчих юм бол тийм ээ, баяжуулах үйлдвэрийг нь хийлгэчих юм бол бүр одоо энэ хөгжлийн түвшинд, хамгийн дээд түвшинд хүрнэ л гэж би үздэг. Тийм учраас таны дэмжиж байгааг бас баяртай байна.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Энэ ондоо бид нар Цөмийн энергийн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаад, гэрээгээ хөрөнгө оруулалтын гэрээгээ тохирно гэж ойлгосон. Зөв үү, Жавхлан сайд аа. Тэгээд 2027, 2028 хүртэл бэлтгэл ажлаа хангаад, 2028 онд эхний экспорт хийнэ гэж танилцуулгаас бас ойлгосон. Яг бид нарын урд хөршид 22 ширхэг цөмийн реактор яг баригдаж байна. Хятадад. Тэгэхээр бид нар энэ юунаас хоцорч болохгүй. Тэгэхээр яг энэ дээр та нэг тодорхой он саруудтай юмнууд дээр саяын асуусан юман дээр хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Пүрэвдорж гишүүн ээ, та хариулсан нь дээр байх тийм ээ, энэ чинь. Одоо бид нар Цөмийн энергийн тухай хууль хэлэлцэж байна шүү дээ. Тэгэхээр сая Шижир гишүүн бол нөгөө гэрээтэй холбоотой хөрөнгө оруулалтын цаг хугацаа, цаглавартай холбоотой асуулт асуугаад байна. Эсвэл нөгөө гэрээний ажлын хэсгийнхэн хариулах юм уу? Туваан гишүүн, Туваан сайд хариулсан нь дээр байх аа.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд гүйцээж хариулъя.

Ц.Туваан: Шижир гишүүн зөв ойлгосон байна. Энэ эхлээд энэ гэрээгээ бид нар энэ ондоо юм уу, он давлаа ч гэсэн нэг их удахгүйгээр байгуулах. Тэгээд гэрээ байгуулагдсан тохиолдолд энэ гэрээ маань өөрөө Улсын Их Хурлаар орж ирж батлагдана. Тэгээд байгуулсан тохиолдолд бүтээн байгуулалтынхаа ажилд орно. Тэгээд энэ нь бас нэг 3 жил орчмын хугацаа яваад, тэгээд эхний шар нунтаг экспортод гарна гэж ойлгогдож байгаа.

Атомын станцын хувьд би түрүүн бас хэлсэн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орчихсон энэ ажиллагааг аваад явна аа. Цөмийн энергийн комисс энэ дээр бас ажиллаад, цааш нь ажлаа эрчимжүүлээд явна. Бага, дунд оврын реакторын асуудал бол нэг 10-15 жилийн хугацаанд баригдах ийм боломжтой. Хамгийн бидэнтэй ойрхон бол Казахстан улс ураны олборлолт хийгээд, зэрэгцүүлээд АЦС-ын асуудлаа шийдээд явж байгаа жишээ бас ойрхон байгаа.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхбат: Ураны асуудал бол эмзэг сэдэв. Манай ард иргэдийн дунд ч, ер нь бидний хувьд ч гэсэн энэ дээр бол ойлголт маш сул явдаг. Мэргэжлийн экспертүүд, мэргэжлийн хүмүүс нь энэ тал дээр эерэг, сөрөг ойлголтыг ээлжилж ярьдаг ийм л сэдэв. Тэгээд өнөөдөр бол энэ Цөмийн энергийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах тал дээр бол энэ олон нийтийн ойлголтыг сайжруулах, энэ чиглэлээр би бас ганц нэг юм асууя гэж ингэж бодсон юм.

Мэдээж манайхан эдийн засгийн талаас нь нэлээн ярьж байна. Монгол Улсад орж ирэх өгөөжийн тухай бас нэлээн ярьж байна. Би байгаль орчны талаас нь ярьж гэж ингэж бодож байгаа юм. Ер нь энэ Монгол Улсад энэ уран, ураны лиценз ер нь хэд байдаг юм бэ? Энийг нэг тодорхой хариулж өгөөч. Хэд нь гадаадын хөрөнгө

оруулалттай байдаг юм. Тэгээд энэ манай төрийн өмчит энэ Мон-Атом гэдэг компани энд ер нь бүгд дээр нь хувь эзэмшдэг юм уу? Зарим дээр нь эзэмшдэг юм уу. Манай Мон-Атом компани маань өөрөө ер нь ямар үүрэг рольтой оролцдог юм? Энэ лицензүүдэд. Энэ дээр нэг тодорхой хариултуудыг авмаар байна аа.

Энэ хууль өөрчлөгдөж байгаа нэмэлт, өөрчлөлт хийгдэж байгаа, мэдээж сайжрах ёстой хууль. Өмнөх алдаануудаа бид нар давтахгүй байх ёстой гэдэг энэ зарчмын юмнуудыг ойлгож байна. Энэ орон нутгийн харилцах харилцааг энэ хуульд яаж тусгаж байгаа юм бэ? Орон нутгийн харилцах харилцааг. Энэ хууль дээр орон нутгийн харилцах харилцааг тусгахгүйгээр явах юм бол дахиад л энд тэнд эсэргүүцэл, тэмцэл, мөргөлдөөнүүд чинь үүснэ шүү дээ. Энэ дээр нэг тодорхой хариулт авмаар байна. Сая тэгээд ярьж байгаа юм, энэ орон нутгийн орон нутагт үүсэх үр өгөөжийг энэ хуульд тодорхой оруулж өгөхгүй, эсвэл гэрээн дээрээ нэмж оруулах юм уу, ингээд явах юм бол энэ өөрөө ойлгомжгүй болно. Энэ нэгхэн лицензтэй холбоотой асуудал яригдаагүй. Энэ говийн бүс нутагт тэр чигээрээ уран байгаа. Зөндөө олон лицензүүд байгаа. Дандаа очих болгонд энэ хөрөнгө оруулж байгаа компани, хайгуул хийж байгаа компаниуд очих болгонд тэмцэл гардаг. Тэгэхээрээ зэрэг энэ дээр бид нар ямар нэгдсэн ойлголттой болох юм.

2 дугаарт, энэ татварын зохицуулалтууд дээр бас нэг ганц нэг тодорхой юмнуудыг асуумаар байна. АМНАТ-ийн 30 хувийг орон нутагт өгнө өө гэж байгаа юм. Тэгсэн хэрнээ сая Учрал сайд юу гэххэв. Ирээдүйн өв санд нэг хэсгийг нь өгөөд, энэ дээр 10 хувийг нь өгнө өө гэхчиг шиг болох юм. Энэ Цөмийн энергийн хууль дээр өөрөөр оруулж ирэх гэж байгаа юм уу гэдэг нэг ийм асуулт байна.

2 дугаарт, НӨАТ төлөх юм уу. НӨАТ төлөх эсэх дээр бас нэг ийм тодорхой хариултууд аваад, тэгээд дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Мон-Атом компанийн захирал Далайжаргал, ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Д.Далайжаргал: Гишүүний асуултад хариулъя аа. Мон-Атом компани 2009 онд байгуулагдсан. Цацраг идэвхт ашигт малтмалын ураныг эдийн засгийн эргэлтэд оруулах, төрийн төлөөллийг хэрэгжүүлэхээр байгуулагдсан байгаа. Яг өнөөдөр манай дээр бол 5, 6 төсөл байгаа. Монгол-Францын төсөл, Монгол-Чехийн төсөл, Монгол-Орос, Монгол-Хятад, Монгол-Казакстан гэсэн ийм төслүүд байгаа. Хамгийн том төсөл нь Монгол- Францын төсөл. Одоо хөрөнгө оруулалтын гэрээ яригдаж байна. Энэний дараа Монгол-Чехийн төсөл явагдана. Бас энэ ураны нөөц нь бас ерөнхийдөө бас том хэмжээний нөөцтэй. ОХУ хуучин Зөвлөлт холбоот улсын үед ашиглаж байсан Мардай ордоо ашиглая гэдэг энэ саналаа тавиад, бид нар хамтарч ажиллаж явж байгаа.

Хятадууд мөн 3 булынхаа орд гээд Дорнодын ордуудыг ашиглая гээд явж байгаа. Бид нар Цөмийн энергийн хуулийн даруй төрийн эзэмшлийн 34 хувиа төлөөлөөд, тэрийг эзэмшээд явж байгаа ийм компани байгаа юм.

Д.Амарбаясгалан: АМНАТ болон НӨАТ-ын асуудлаар уул уурхайн лицензийн асуудлаар Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Энэ Монгол Улсад яг одоо хайгуулын 3, ашиглалтын 8 лиценз байгаа. Энэ тэгээд нийт 7 ААН энэ лицензүүдийг эзэмш эзэмшиж байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. АМНАТ өөрөө тусгай зохицуулалтаар хуваарилагддаг. 65 хувь нь Ирээдүйн өв санд, 10 хувь нь орон нутгийн хөгжлийн санд гээд. Энэ хуваарилалт бол Төсвийн тухай хуулиар зохицуулагддаг. Тэрнээс биш Цөмийн энергийн хууль, Татварын хуулиар энэ зохицуулагдахгүй. Татварын хууль бол татварын орлого бүрдүүлэлтээ л зохицуулна.

Тийм учраас орон нутгийн тэр хуваарилалтууд энд огт зохицуулагдахгүй. Харин зүгээр төсөл энэ ингээд амжилттай хэрэгжээд эхлэх юм бол орон нутагт маш их түлхүү боломжууд нээгдэнэ дээ. Энэ манай энэ зэргэлдээ энэ Төв аймгийн Сэргэлэн сумыг та бүхэн сүүлийн 2, 3 жил гарсан өөрчлөлтийг хараарай. Тэнд зөвхөн ганц нисэх онгоцны буудал байгуулагдаад, энэ сум аймгаасаа татаас авахаа больсон, бүр аймагтаа бүр 10 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө төвлөрүүлж өгдөг болсон байх жишээтэй. Тэгэхээр тэр сум, тэр орчинд бол үл хөдлөх хөрөнгийн татвараас эхлээд ХХОАТ гээд бусад лицензийн татварууд гээд орон ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Орон нутгийн шууд ордог орлогууд ч байна. Дээрээс нь нөгөө, одоо манай говийн гишүүд их сайн мэднэ. Одоо сүүлд бид нэлээн хэд хэдэн удаагийн өөрчлөлтөөр нөгөө томъёо, коэффициентуудаараа түлхүү ашиглаж байгаа аймаг орон нутгуудад хөгжлийн сангийн хуваарилалт түлхүү очдог болсон байгаа. Яг энэ зарчмаараа илүү түлхүү очлоо л гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхбат: Мон-Атом компани 6-д нь оролцдог юм байна. Бид нар бол энэ цаашлаад энэ уранаа хэрхэн яаж үр дүнтэй ашиглах вэ гэдэг дээр өнөөдрийн асуудлыг янз янзаас нь ярьж байгаа юм. Энэ ураны чинь ард түмэн чинь эерэг ойлгож байгаа нэг амьтан байхгүй байгаа шүү дээ. Бүгдээрээ сөрөг ойлголттой. Манай зарим ахмад геологичид буруу ойлголтуудыг олон нийтийн хэвлэл мэдээллээр гаргаж тавьдаг. Тэрнээс нь болоод энэ урантай холбоотой ойр орчимд нь ажиллаж, амьдарч байгаа энэ малчид, тэр иргэд чинь бүгдээрээ сөрөг ойлголттой л байдаг юм шүү дээ. Тэгээд энэ хөрөнгө оруулагчид чинь очихоороо зэрэг бөөн эсэргүүцэл тэмцэлтэй тулгардаг. Тэгээд энд нь эерэг ойлголт өгөх энэ мэдээлэл контентийг танайх хийж болдоггүй юм уу? 1 дүгээрт нь.

2 дугаарт нь, орон нутагт боломж нээгдэнэ гээд Жавхлан сайд хэлж байна аа. Одоо бид нарт говийн бүс нутагт энэ татварын зөндөө ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон. Мон-Атомын захирал Далайжаргал хариулна аа.

Д.Далайжаргал: Гишүүний асуултад хариулъя. Олон нийттэй харилцах чиглэлээр бид нар тодорхой арга хэмжээ сүүлийн 5 жил хийсэн. Яг өнөөдөр 11 сар, 12 сард Үндэсний дотоодын 7 сувгаар Уран гээд баримтат кино гарч байгаа. Энэ кино бол бид нар эрдэмтдээ оролцуулсан кино байгаа. Сэтгүүлчдийг болон ард

иргэдийг бид нар уурхай дээр аваачдаг. Яг өнөөдрийн байдлаар 1600-аад хүн энэ Дорноговийн уурхай дээр очиж ажиллаж үзсэн байгаа. Энэ уурхай бүр нээлттэй байгаа.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Энэ уран олборлохтой холбоотой АМНАТ-ын зохицуулалтуудыг ингээд харсан. Тэр жишээ нь Казакстанд 5-18 хувь хүртэл олборлох хэмжээнээс нь хамаараад шууд ингээд тогтоочихсон байгаа юм. Одоо бид нар энэ төсөл дээр ярьж байгаагаар нөөцийн төлбөр, тусгай төлбөр, тэгээд өсөн нэмэгдэх гээд ингээд бүгдийг нь нэмж, хасаж янз бүр төвөгтэй асуудал болсоор байгаад ер нь тэр интервал дотор л бууна. Тэгэхээр 1 ийм манай эрх зүйн орчны зохицуулалт гэхээр л нэг л ийм орооцолдсон, дараа нь дахиад төсөл болгон дээр өөр өөрөөр гардаг нэг зүйл байдаг. Энийг би харахдаа энэ Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлд нөгөө үнэгүй эзэмших төрийн, 34 хувьтай холбож ойлгоод байгаа байхгүй юу. Тэгээд тэр нь юуг үнэгүй эзэмших гэж байгаа юм, тодорхойгүй. Нөөцөө баталсны дараа төслийн 34 хувь юм уу, эсвэл үйлдвэр барьчихсаны дараа 34 хувь юм уу, үйлдвэр барьчихсан байж байгаад дахиад юм барихаар дахиад бүр том юм барихаар тэрнийх нь 34 хувь юм уу, ингээд мөнхийн үнэгүй юм уу. Үгүй болж таараад байна л даа. Тийм болохоор л нөгөө дараа нь өрөнд орохоос эрсдэлээсээ хамгаалаад АМНАТ руугаа шилжүүлбэ гэсэн иймэрхүү байдал руу бид нар орж ирнэ.

Тэгэхээр төсөл болгон дээр өөр өөр нөхцөл ярина, их маргаантай юмнууд болно. Тэр болгон дээр нь янз бүрийн нөлөөлөл орж ирнэ. Энэ нэг бантан шиг зүйлийг Ашигт малтмалын хууль дээр бид нар өөрчлөх хэрэгтэй гэж бодож байна аа. Энэ оршил.

Асуулт. Тэр 34 хувь, тусгай төлбөр 5 хувь орчим гэж ойлгож байгаа. Энэ жишиг бусад төрлийн ашигт малтмалын стратегийн ордууд дээр бас ер нь цаашдаа иймэрхүү хандлагаар явах болов уу? Энийг би Учрал сайдаас асуумаар байна. Яагаад гэвэл сарын өмнө стратегийн ордуудын талаар бас Засгийн газрын тогтоолыг танилцуулж байсан.

2 дугаарт нь, уучлаарай би нэг жоохон инээдтэй юм асуучихъя. Монгол Улс хуультай. Ашигт малтмалын хуулийн 5.7-д стратегийн ордын 34-өөс илүү хувийг нэг этгээд эзэмшихийг хориглоно. Уран бол стратегийн орд. Тэгэхээр ингээд 34 хувийг, Монголын тал эзэмших 34 хувиа АМНАТ-аар сольж өгөхөөр нөгөөдүүл чинь өөрсдийнхөө 34-ийг яах вэ? Монголын 34-ийг авчихлаа. Тэгэхээр чинь өөрсдөө 34 хувиас илүү эзэмшиж болохгүй шүү дээ, 34 хувиа эзэмшиж байна. Тэгэхээр Монгол ингээд нэмээд 34 гэхээр авч чадахгүй. Авчихлаа гэж бодоод өөрийнхөө 34-өөс татгалзангуутаа Монголын 34-ийг аваад, АМНАТ-ыг нь нэмж өгөөд тэгээд үлдсэн 66 хувийг нь хэн эзэмших юм бэ гээд нэг ийм сонин инээдтэй асуулт байна. Энэ дээр хариулт өгнө үү? Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хариулт өгье.

Б.Пүрэвдорж: Золжаргал гишүүний нэг асуултыг бас тодорхой болгож өгөхгүй бол болохгүй нь. Казакстан урьд нь 18 хувь авдаг байсан. Тэр нь үйл ажиллагааны зардлаасаа авдаг байсан юм. Тэгээд үйл ажиллагааны зардлаасаа авах дээр нөгөө яг ингээд борлуулалтын орлогоос тооцох дээр нэг 3 хувь дээр л

хүрээд байсан байхгүй юу даа. Тийм учраас энэ алдаагаа засаад, 2023 онд өөрчлөлт оруулаад, одоо 6 хувиар АМНАТ-аа тооцоод явж байгаа. Тэгэхээр энэ манайх чинь суурь АМНАТ 5, тусгай АМНАТ 5, өсөн нэмэгдэх нь 9, бид нар үнэхээр өндөр авч байгаа. Энэ бол таны 18 гэдэг чинь бас нийгэмд буруу ойлголт өгөх гэж байна шүү. Одоо бол 6 болчихсон байгаа. 18 бол үйл ажиллагааны зардлаас нь 18 хувь авдаг байсан байхгүй юу. Тэгэхээр бүр нөгөө яг өнөө тэр АМНАТ-аараа тооцохдоо нэг 3 хувь руу л уначхаад байсан байхгүй юу даа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсэг ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Үндэсний баялгийн сангийн хууль дээр төр тэр 34 хүртэл 50 хүртэлх хувийг үнэ төлбөргүйгээр эзэмшинэ гэдэг заалт бол Ашигт малтмалынхаа хуулиар тэр АМНАТ-аар орлуулах бололцоог нээж байгаатай яг адилхан. Энэ 13, 4 жил өөрчлөгдөөгүй Цөмийн энергийн хуульдаа энэ Ашигт малтмалын хуультайгаа уялдуулж байна гэсэн үг.

Тэгэхээр мэдээж цацраг идэвхт энэ стратегийн бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулахад төр эзэмшлийнхээ 34 хувийг АМНАТ-аар орлуулах бололцоотой ийм эрх зүйн орчинтой л болж байгаа гэсэн үг. Тэгэхээр ер нь бол бид нар цаашдаа Баялгийн сангийн хуулийг илүү хэрэгжүүлье гэх юм бол заавал төр эзэмшлийнхээ хувийг тогтоож, санхүүгийн үүрэг хариуцлага хүлээж байхын оронд, хувийн хэвшилтэй ч бай, ГХО нартай ч бай, үүнийг АМНАТ-аар орлуулах ийм хөрөнгө оруулалтын гэрээгээ ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайдад нэмж минут өгье.

Н.Учрал: Тэгэхээр ер нь цаашдаа бид нар төр, эзэмшлийнхээ 34 хувийг АМНАТ-аар орлуулна уу, эсвэл ямар хэлбэрээр авна уу. Гол нь газрын хэвлийн баялаг 50 дээр +1-ийг ард түмэн ард түмэн эзэмших энэ зарчмаа хангуулахын тулд хөрөнгө оруулалтын гэрээгээ байгуулаад, тэгээд хөрөнгө оруулалтын гэрээгээ Их Хурлаар оруулаад, хэдэн хувийг нь АМНАТ-аар орлуулах юм, босго нь хэд байх юм гэдгийг зөвхөн Их Хурал шийдэх энэ онцгой бүрэн эрхийнх нь хүрээнд Их Хурлаар шийдвэрлээд явчихвал энэ нэг талаасаа бол ГХО талдаа ч гэсэн, хувийн хэвшил талдаа ч гэсэн маш зөв арга зам болох юм байна аа. Тэрнээс биш бид өнөөдөр тэр 34 хувь дээр нь хувьцаа эзэмшээд, тэгээд санхүүгийн үүрэг хариуцлага хүлээгээд бол тийм тодорхой үр дүнд хүрэхгүй. Өмнөх Хөрөнгө оруулалтын гэрээнээс харж болж байгаа.

Мөн энэ хууль дээр бол төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн эзэмшсэн хувьцаа, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан бол энд хамаарахгүй гэдэг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Золжаргал: Энэ уран олборлох компани стратегийн орд учраас 34 хувиас илүүг эзэмшиж болохгүй, хуулиараа. Тэгэхээр энэ компани 34 хувийн эзэмших гээд байгаа юм уу, 66 эзэмших гээд байгаа юм уу, хэд болох гээд байгаа юм гэдгийг хариулж өгнө үү. Пүрэвдорж гишүүний хэлсэн тэр АМНАТ энэ танилцуулга дээр байна л даа. Казахстан 23 оны 01 сарын 01-ээс 6 хувиар тогтоосон. 26 оноос хойш хэмжээнээсээ хамаараад 500 тонн олборлож байх юм бол 4 хувь, ингээд нэмэгдсээр

байгаад 4000 тонноос дээш бол 18 хувь байхаар Ерөнхийлөгчийн зарлиг гарсан гээд ийм зохицуулалт байгаа шүү. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал нэмж хариулъя.

Н.Учрал: Ашигт малтмалын хууль дээр, тэр 5.8 дээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшлийн хувьцаа Монгол Улсын Засгийн газартай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээдийн хувьцаанд хамаарахгүй гэдэг Ашигт малтмалын хуультай. Тийм. Тэгэхээр энэ хуулийнхаа дагуу бид нар хөрөнгө оруулалтын гэрээгээ шинэ хуулийн орчиндоо байгуулаад, Их Хурлаар батлагдсан тохиолдолд бол энэ хамаарахгүй гэдэг ийм заалт хэрэгжинэ гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе. Засгийн газрын зүгээс яг энэ хуулийн төсөл дээр Цөмийн энергийн тухай хуулийн төсөл дээр Монгол Улсад аль болох л илүү үр өгөөж байлгах тал дээр хувилбараа боловсруулаад оруулж ирж байгаад баяртай байгаа. Гэхдээ ер нь АМНАТ-ын энэ шар нунтгийн үнээс хамаараад 9 хувь хүртэл, суурь нь 5 хувь, тэгээд тусгай төлбөр нь 5 хувь гээд нэлээд өндөр тавьж өгч байгаа. Энэ нь болохоороо бусад улсад байхгүй өндөр хувь гээд өнөөдөр бас нэлээд олон гишүүд бас хэлж байх шиг байна. Тэгээд удахгүй хөдлөх гэж байгаа энэ Зөөвч-Овоо төслийн хувьд энэ АМНАТ-ыг төлөх боломжтой юм гээд нөгөө талаас үзсэн байж болох юм аа. Гэхдээ яг ийм байдлаар хүснэгтээ ингээд хууль дээр оруулаад өгсөн тохиолдолд ер нь дараа дараагийн өөр яг уран дээр орж ирэх ч юм уу, хөрөнгө оруулалт нь нэлээн хумигдах вий гэсэн ийм эрсдэл, ийм хаалт болох нь гэж харж байгаа.

Тэгэхээр ер нь яг орж ирсэн энэ удаагийн Их Хурал дээр орж ирж байгаа Цөмийн энергийн тухай хууль дээр хөндөгдөж байгаа заалтуудыгаа оруулаад, бусад хөндөгдөөгүй заалтаа аваад үзэх юм бол одоо энэ манай Цөмийн энергийн тухай хууль хөрөнгө оруулалтыг ирээдүйд татах дээр ямар эрх зүйн орчныг бүрдүүлсэн гэж үзэж байгаа вэ? Ер нь бид нар АМНАТ Цөмийн энергийн хуулийнхаа дагуу энэ ураны шар нунтгийг гаргаж экспортолж эхлэхээрээ ураны зах зээл дээр том өрсөлдөгч болно. Тэгээд түрүүн Золжаргал гишүүний хэлснээр тэр Казахстаны АМНАТ нь 18 хүртэл 26 оноос болох нь гэдэг нь болохоороо гаргаж байгаа тоннтойгоо холбоотой. Тэгээд манай Зөөвч-Овоо ордоос болохоор жилдээ 28 оноос эхлээд 2500 тонн ураны исэл гарна. Тэгэхээр яг эдний энэ Казакстаныг манай өрсөлдөгч гэж харах юм бол 3000 хүртэлх буюу 12 хувийн АМНАТ бол Казакстанд ноогдуулж эхлэх юм байна. Тэгээд ураны ислийнх нь үнэ нь бас өндөр байх тохиолдолд нэмээд 2.5 хувийг АМНАТ дээрээ нэмж тооцно гэж үзэж байгаа юм байна. Тэгэхээр 26 оноос Казакстан 14,5, хувийн АМНАТ авч эхлэх нь ээ. Тэгсэн хэдий ч манай Монгол Улсын тавьж байгаа АМНАТ бол их өндөрт тооцогдоно. Тэгэхээр нөгөө өөрсдийгөө зөвхөн Монголдоо гэж харахаас илүү бусад улстайгаа өрсөлдөгч гэж харж эхэлбэл ер нь Казахстанасаа ч гэсэн өндөр болж байна. Узбекстанаас ч гэсэн даруй их өндөр байна. Тэгээд яг ингэж хууль дээрээ хүснэгтэлж оруулах дээр нэлээн хатуу заалт л орж ирж байна гэж харж байна аа.

Тэгэхээр хөрөнгө оруулах, дараа дараагийн хөрөнгө оруулалтын орчин тал дээрээ яг энэ хуулийнхаа ерөнхий үзэл баримтлалыг ямар байгаа тал дээр саналаа хуваалцаач гэж ажлын хэсгээс хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Түрүүн бас хэлсэн. Цөмийн энергийн хууль бол энэ чинь бараг 14 жил нэмэлт, өөрчлөлт орж, яг энэ Ашигт малтмалын хуультайгаа уялдаагүй. Тийм ч учраас бол яг цаашдаа бол бид нар энэ Монгол Францын ураны төслийн хөрөнгө оруулалтын гэрээг Цөмийн энергийн хуулийн хүрээнд хийе гэдэг ийм бас зорилтыг агуулж байгаа. Энэ ч утгаараа яг одоогоос бараг жил болчихлоо л доо. Одоогоос жилийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч Францад айлчлах үеэр энэ протокол дээр гарын үсэг зурсан. Тэр протокол дээр гарын үсэг зурахдаа бол бид нар нэлээд тодорхой асуудлуудыг шийдсэн юм билээ. Одоо мэдээж энэ өсөн нэмэгдэх АМНАТ-ыг ийм байдлаар тохирч болох юм гээд. Тэгээд яг 80-аас ер байвал хэдэн хувиар нэмэгдэх вэ, 90-100 байвал хэдээр нэмэгдэх вэ, 100-110 байвал хэдээр нэмэгдэх вэ гээд протокол дээр тусгасан.

Дээрээс нь тусгай АМНАТ-ыг хэдэн хувиар яаж тохирох вэ гэдгийг Их Хурал шийдэх учраас энийг гэрээнийхээ хүрээнд ярья аа. Мөн тэр компанийн 10 хувийн хувьцаа нь үнэхээр давуу эрхийн хувьцаа гэж үзэх юм бол эргээд тэргүүн ээлжид ноогдол ашгаа авах, цаашлаад тэр дүрэмд өөрчлөлт оруулах тодорхой эрхүүдийг, хориг тавих гээд энэ эрхүүдийг бид нар протокол дээр тусгаж өгсөн нь бас сайн хэлэлцээр болжээ гэж ингэж дүгнээд байгаа юм. Тэгээд энэ хэлэлцээгээ явуулах гэсэн, Цөмийн энергийн хуулиа эргээд харахаар бол эрх зүйн орчин бүрдээгүй. Нөгөө талаас бол хөрөнгө оруулагч талаас өсөн нэмэгдэх АМНАТ-ыг бодоод явж болно гээд зөвшөөрчхөөд байхад хуулиа харахаар яг энэ цацраг идэвхт стратегийн бүтээгдэхүүн дээр ийм ойлголт байгаагүй.

Тийм учраас бол энэ протокол дээр тусгагдсан учраас хэрвээ энэ Цөмийн энергийн хууль дээр энэ өсөн нэмэгдэх АМНАТ-ыг ингэж зохицуулж өгсөн зохицуулалтууд тусгагдаад өгвөл, бид цаашдаа хэлэлцээг үргэлжлүүлээд, хөрөнгө оруулалтын гэрээндээ тусгаад оруулж ирэх бололцоотой гэж үзэж байгаа юм. Тийм учраас бас эрхэм гишүүддээ хэлэхэд, мэдээж хөрөнгө оруулагч тал ашигтай ажиллах ёстой. Тийм ч учраас хэт их хатуурхсан заалтуудаас илүүтэйгээр яг борлуулалтаас нь яг өнөөдрийн нэг фунт ураны үнэ 81, 2 доллар гэвэл 14, ер нь ирэх жилээс ингээд 15 руу орох АМНАТ авах бол бид нарт маш том боломж юм байна.

Тийм учраас яг энэ хүрээндээ бид нар хуулиа хэрвээ баталчихвал, хөрөнгө оруулалтын гэрээ ард түмэнд тэр газрын хэвлийн баялгийн 50 дээр +1-ийн өгөөжийг нь хүртээх ийм гэрээ болж болох юм байна аа. Өнгөрсөн хугацааны алдаа оноогоо бас эргэж харъя аа. Тэрнээс биш төр эзэмшлийн 34 хувийг аваад менежментэд шууд оролцоод, тэгээд ноогдол ашгийг нь хүлээгээд байдаг эртний бас түүхүүд бий. Тийм учраас алдаагаа дахиж давтахгүйн тулд борлуулалтаас нь АМНАТ-аа авъя гэдэг энэ зохицуулалтыг л хуулийн хүрээнд нээж байгаа.

Д.Амарбаясгалан: Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Нэг асуудлын талаар ярих гэсэн юм аа. Тэгээд бид нар сая ээлжит бус чуулганаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн талаар хууль хэлэлцэх үедээ дагалдуулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өөрчилсөн. Өөрөөр хэлбэл, маш чухал хуулиудыг өөр хуулиудаар далимдуулж, ингээд өөрчилж байна. Одоо бараг нэг гэрээ хийхийн тулд өөр нэг хууль өөрчлөөд, дахиад бас ингээд хуулиуд өөрчлөх иймэрхүү хандлага харагдаад байна л даа.

Тэгэхээр энэ оруулж ирсэн хуулийг дагалдуулаад хэд хэдэн тухай хуулиуд, хөрөнгө оруулалтын тухай, татвартай холбоотой, Компанийн хуультай холбоотой энэ заалтууд орж ирж байгаа. Тэгэхээр Компанийн тухай хууль дээр бас энэ ноцтой зүйлийг өөрчлөхөөр оруулж ирсэн байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ компанийн тухай аж ахуй харилцааны чухал харилцааг зохицуулж байгаа энгийн хувьцааг давуу хувьцаанд шилжүүлж болохгүй гээд бүр заачихсан заалтыг хуулийн төсөл дээр оруулж ирэхдээ хуульд зааснаас бусдаар энгийн хувьцаанд хөрвүүлж болохгүй гэдэг байдлаар томьёолж, өөрөөр хэлбэл нэг юм шийдэх гэж байгаад дараагийн одоо өөр суурь, бусад хуулиудын суурь зарчмуудыг ингээд өөрчилж байна. Тэгээд энэ нь бас хууль маань энэ Монгол Улсын хуулиуд маань ерөөсөө дархлаагүй болчихжээ.

Тэгэхээр би Хууль зүйн яамнаас асуумаар байгаа юм. Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дээр энэ хууль тогтоомжийн бүрдүүлбэр гэж байгаа. Тэгээд энэ дээр 40.1.2 дээр нь болохоор яг үндсэн оруулж ирж байгаа хууль дээр болохоор бүрдүүлбэрүүдийг шаарддаг. Жишээлбэл энд нь болохоор үр дагаварт хийсэн нөлөө, үр нөлөөг үнэлсэн судалгаанууд, товч дэлгэрэнгүй танилцуулгууд. Гэтэл энэ дагаж ирж байгаа хуулиуд дээр жишээлбэл Компанийн тухай хуулийн энэ энгийн хувьцааг давуу эрхтэй болгох чиглэлээр ямаршуу судалгаа хэлэлцүүлэг хийж, энийг оруулж ирсэн бэ? Ер нь энэ дагаж орж ирж байгаа хуулиуд дээр энэ хуулийн бүрдүүлбэрүүд хангахгүй байгааг Хууль зүйн яам юу гэж бодож байгаа вэ? Ингээд сая Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд маш чухал заалтыг уул уурхайн бус салбарын өсөлтөөр төсвийн өсөлтийг хязгаарлах тухай заалтыг авч хаяснаас болоод энэ том өсөлтийг хийх бололцоонууд гарч байна. Энэтэй адилхан ингээд бусад эдийн засгийн болон нийгмийн харилцаанд орох энэ нөлөөлөх энэ хуулиудыг суурь зарчмуудыг дагалдуулж орж ирж ямар ч үнэлгээ хийхгүйгээр ингэж өөрчилж байгааг Хууль зүйн яам юу гэж харж байгаа вэ.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Би энэ Энхтүвшин гишүүний энэ зарчмын саналыг бол зөвшөөрч байгаа юм аа. Үнэхээр нэг хөрөнгө оруулалтын гэрээ хийх гээд түүнд тааруулсан хуулийн өөрчлөлт оруулдаг бол буруу. Тийм ч учраас бид энэ жишгийг эвдэх гэж Цөмийн энергийн хуулиа эхлээд хэлэлцүүлж байгаа юм. Тэрнээс биш хөрөнгө оруулалтын гэрээг зэрэг барьж орж ирчхээд, дагаад 10 хууль өөрчилнө өө гэдэг ийм тохиолдол зөндөө л байсан шүү дээ. Тэгээд энэнээс болж маргаан дагуулж байсан.

Тийм учраас бид Хөрөнгө оруулалтын гэрээг оруулж ирэхээс өмнө хуулиа хэлэлцээд авъя аа. Ингээд хууль батлагдсаны дараа хэлэлцээгээ үргэлжлүүлээд хуульдаа нийцүүлээд явбал хамгийн зөв жишиг болно гэдэг утгаараа бол бид энэ өдрүүдэд энэ Цөмийн энергийн хуулийг л хэлэлцэж байна. Цөмийн энергийн хууль нэг төслийг явуулах гэж хэлэлцээд байгаа хууль биш. Энэ Цөмийн энергийн хууль бол цаашдаа энэ цацраг идэвхт стратегийн бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулахад гаднын хөрөнгө оруулагч нар, хувийн хэвшил, ААН-үүд энэ хуулийн орчинд үйл ажиллагаа явуулах бололцоог нээж байгаа юм. Тэрнээс биш өнөөдөр энэ хуулиар яг АМНАТ тэд байна, эсвэл төрийн эзэмшлийн 34 байхгүй болоод оронд нь АМНАТ орлуулж байна, эсвэл гээд ингээд хатуу хуульчилчхаж байгаа юм байхгүй. Зүгээр хуулийн хүрээнд нээж өгч байгаа.

Тэр хууль, эрх зүйн орчин нээгдсэнээрээ Хөрөнгө оруулалтын гэрээ, шаардлагатай бол төрийн эзэмшлийн 34 хувийг шууд авах шаардлагатай гэвэл

үүнийг Их Хурал шийднэ шүү дээ. Засгийн газар нь мэдүүлснээр Их Хурал шийднэ. АМНАТ-аар орлуулах гэж байгаа хувь хэмжээг нь Засгийн газрын өргөн мэдүүлснээр Их Хурал шийднэ. Энгийн ба энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд оруулах асуудлаар бол Энхтүвшин гишүүний санал Байнгын хороогоор дэмжигдсэн. Цөмийн энергийн хуульд зөвхөн тусгайлан зааснаас бусад тохиолдолд энэ хэрэгжихгүй, хамаарахгүй гээд. Яагаад энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаа болгосон юм бэ гэвэл Монголын ард түмэндээ тэр байгалийн баялгийнхаа 50 дээр +1-ийг хангуулахын тулд ирээдүйд бид нар өр үүсгэмээргүй байна аа. Ирээдүйд нэг санхүүгийн хариуцлага хүлээгээд баймааргүй байна аа. Өнөөдөр тэр өнгөрсөн хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын гэрээн дээр тэр 34-ийг танайх авч байгаа юм чинь та нар хөрөнгө оруулалт хийх ёстой. Та нар хариуцлагаа хүлээх ёстой гээд ингээд явсаар байгаад өр үүсчихлээ шүү дээ. Ингээд шүүх дээр оччихлоо шүү дээ.

Гэтэл 10 хувийг авсандаа бид нар санхүүгийн хариуцлага хүлээх байдал руу орохоос урьдчилан сэргийлж, цаашдаа 10 хувийг давуу эрхийн хувьцаа гэж үзэх юм бол зөвхөн энэ Францын хөрөнгө оруулалтын гэрээний жишээн дээр бол тэр Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр хийсэн протокол дээр бол тодорхой асуудлуудыг хуульчилсан нь төрийн эзэмшлийн тэр 10 хувийг давуу эрхийн гэж үзэх юм бол санхүүжилтийн үүрэг хүлээхгүй.

Дээрээс нь хөрөнгө оруулалтын гэрээ хэрэгжих хугацаанд талууд урьдчилан харилцан тогтоосон нөхцөлөөр давуу эрхтэй ноогдол ашгаа тэргүүн ээлжид авна. Дээрээс нь төсөл хэрэгжүүлэх компанид өөрчлөлт оруулах дүрмийн өөрчлөлт энэ тэр дээр хориг тавина л гээд заачхаж байгаа байхгүй юу. Тийм.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсэг хариулна. Тэгээд гишүүд маань нэг зүйлийг их сайн санана. Ялангуяа Энхтүвшин гишүүн. Ажлын хэсэг, Байнгын хороон дээр саналаа гаргана. Санал хураалгана. Асуудал яаж шийдэгдэж байгаа вэ гэдэг дээр их тийм өөрөө их зөв талын ойлголттой байхгүй бол 1 цагаан, 125 хар юм шиг парламент цаашдаа үйл ажиллагаа явуулах боломжгүй. Парламентын тогтолцооны амин сүнс нь өөрөө асуудлыг олон талаас хэлэлцээд, олонхын шийдвэрээр асуудал шийдэгдэж явдаг гэдгийг сайн бодохгүй бол ингээд ажлын хэсэгт орсон гишүүд нь, Байнгын хороонд байгаад дэмжиж магадгүй эсэргүүцэж санал өгсөн олонх болсон гишүүд нь буруу зүйл хийчихсэн юм шиг ийм ойлголт руу оруулах гээд яваад байдаг энэ байдал бол байж болохгүй. Саяын хөндөж байгаа асуудлыг Байнгын хороо, ажлын хэсэг дээр маш их сайн ярьж байх ёстой. Олуулаа яриад, олонхоороо асуудлаа шийдчихсэн бол энэ өөрөө Улсын Их Хурлын шийдвэр болоод явдаг гэдэг дээрээ бид тийм хариуцлагатай байхгүй бол нэг ярьсан асуудал, дэмжээд санал өгчихсөн гишүүд нь эцэстээ буруутай юм шиг байдал руу орж, цаашдаа парламентын үйл ажиллагаа явахад хүндрэл үүснэ ээ. Парламент бол хүссэн болгоноо шийддэг гэхээс илүүтэйгээр улс орон, ард иргэдэд илүү хэрэгтэй ач холбогдолтой, улс орны хувь заяа, ард иргэдийн өсөлт хөгжил, дэвшилт хэрэгтэй гэдэг талаасаа асуудалд хандаж шийддэг юм шүү гэдгийг л их сайн ойлгож байхгүй бол өнгөрсөн хугацаанд болсон процесс санал нийлээгүй зүйл нь дэмжигдээгүй байсны төлөө Улсын Их Хурал тэр чигтээ буруутай юм шиг байдлаар асуудалд хандаж явдгаа бол болих хэрэгтэй.

2 дугаарт нь, энэ дэгийн тухай хууль болон бусад энэ Улсын Их Хурлын явагддаг зарчим, дүрэмтэй маш сайн танилцаж байж асуудалд олон ургалч үзлээр хандаж байгаарай гэдгийг бас захиж хэлэх гэсэн юм аа.

Ажлын хэсгийн дарга Пүрэвдорж гишүүн нэмж хариулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр яг таны саналыг хураалгачихсан шүү дээ, та дэмжигдчихсэн. Тэгэхээр энэ дээр би нэг давуу эрхийн хувьцаа яагаад заавал Монгол Улсын Засгийн газар эзэмших ёстой юм бэ гэхээр жишээ нь, 10 хувь бид нар эзэмшчих 10 хувиа авчихна. Дээрээс нь ААН-ийн орлого нь албан татвараар 25 хувь авчихна. Ингээд 35 боллоо. 35 дээрээ бид нар 10 хувийн суурь болон тусгай АМНАТ авчихна. Ингээд 45 болно. Тэгээд хэрвээ үнэ нь байна шүү дээ, тийм ээ, 70 доллар дээр байх юм бол 3 хувийн АМНАТ авна. Бид нарын нөгөө нэг жишээ нь энэ 3 татвараар бид нар 48 хувийн орлого олох нь байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр яах вэ гэхээр давуу эрхийн хувьцаатай Засгийн газар юу шаардах вэ гэхээр, нөгөө Үндсэн хуулийн 6.2-ын дагуу дийлэнх нь ард ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье, гүйцээж хариулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Үндсэн хуулийн 6.2-оор ард түмэнд энэ үр ашгийнх нь дийлэнх нь ноогдохгүй байна гэдэг тэр үндэслэлээр нөгөө давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь заавал ингээд 50 хувь давуул гэдэг байдлаар бас тодорхой асуудлуудыг тавьж шийдвэрлэх ийм эрхүүд нь бүгдээрээ нээгдэх байхгүй юу даа.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Та нар асуусан асуулт ойлгохгүй байна шүү дээ. Тэгээд битгий тэгж дайраад бай. Би энэ хуулийн дагалдуулж орж ирж байгаа энэ хууль чинь өөрөө хуулийн дархлааг байхгүй болгочоод, энэ хууль оруулж ирэхдээ асар олон судалгаа хийлгэдэг байж дагалдаж оруулж ирж байгаа хуулиуд чинь ингэж болохгүй байна гэж асуусан болохоос, би шал өөр юм асуултад буруу хариулаад байна. 1-д.

2 дугаарт, Их Хурлын дарга би ард түмний эрх ашгийг 1-д тавих болохоос биш хэн нэгэн бүлэг, хэсгийн жишээлбэл эрх заавал дагаж явах гэсэн тийм юун дээр байхгүй, би тэгэхгүй, би дуугарах ёстой юман дээрээ дуугарна, хамгаалах эрх ашгуудаа хамгаална, би тэр нь жижиг хэсэг бүлгийн эрх ашиг, би нийт олны эрх ашгийг хамгаалж явна. Би зарчмын зөрөөтэй ...

Д.Амарбаясгалан: Төсвийн 2 дугаар хэлэлцүүлэг дээр Энхтүвшин гишүүн ирээгүй. Ажлын хэсгийн хурал дээр ороогүй. Байнгын хороон дээр ороогүй байж байгаад асуудлыг өнгөрчихсөний араас зориуд улс төр хийгээд байгаа шүү дээ, Энхтүвшин гишүүн ээ. Таныг бас олон хүн харж байгаа. Боловсролтой, мэдлэгтэй, соёлтой бас хувийн хэвшилд ажилласан туршлагатай гэж харж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ нөхцөлийг их зөв ашиглана шүү. Улс төрд танигдах нэг хэрэг байдаг байх. Зүгээр улс төрч хүн ажлаа хийж үр дүн гаргана гэдэг бас нэг өөр байдаг юм шүү гэдгийг бас хэлье ээ.

Учрал сайд нэмж хариулах уу.

Н.Учрал: Яах вэ, Цөмийн энергийн хуулийг өчигдөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцэх үеэр Энхтүвшин гишүүн зарчмын зөрөөтэй санал гаргаад, энгийн хувьцааг давуу эрхэд хувьцааг шилжүүлэх заалтыг Цөмийн энергийн хуульд тусгайлан зааснаар гэж өөрөө хураалгаад, дэмжүүлээд, өчигдөр

тун сэтгэл өндөр гараад яваа биз дээ. Тэгээд өнөөдөр болохоор дахиад эхэлчихлээ л дээ. Тэгээд. Пүрэвдорж гишүүн эхнээс нь хариулах уу?

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд нэмж хариулъя.

О.Алтангэрэл: ХЗДХЯ-ны зүгээс энэ хуулийн төсөл, тэгээд дагалдах хуулийн төслүүдийг энэ хууль тогтоомжийн тухай хуулийн хуульд заасан шаардлага хангаж байна уу, үгүй юу гэдгийг шалгаж тодруулж байгаа юм аа. Судалгаа хийж байгаа. Тэгээд судалгаа хийгдсэн юм уу, хэлэлцүүлэг хийгдсэн юм уу, хууль зүйн техникийн хувьд шаардлага хангаж байгаа юм уу, бусад хуультай зөрчилдөж байгаа юм уу гэдэг дээр бид нар дүгнэлт гаргаж байгаа юм.

Тэгэхээр ХЗДХЯ саяын ярьсан 4 асуудлын хүрээнд дүгнэлт гаргаад, тэр дүгнэлтийн дагуу хэлэлцэгдээд явж байгаа. Тэгээд энэ бол Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хууль тогтоомжийн тухай хуульд нийцэж байгаа гэдгийг хэлье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зүйл бол хууль тогтоомжийн хуулиараа манайх 5 жил тутамдаа гээд заачихсан байдаг. Бусад улсуудад бүр 3-5 жил дотор заавал гэж заачихсан байдаг. Хууль бол цаг үргэлж сайжирч байх ёстой. Нийгмийнхээ хурдтай хөгжилтэй хөл нийлүүлээд сайжруулдаг байх нь бол чухал үүрэг. Улсын Их Хурлын ч бас чухал үүрэг нь энэ дээрээ оршдог гэдгийг бас их зөв ойлгох хэрэгтэй.

Мэдээж гишүүд олон ургалч үзлээр асуудалд хандана. Өөрсдийн санал бодол, үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлнэ. Тэрийг ерөөсөө хориглох зүйл огт байхгүй. Харин асуудлыг шийдчихээд, олонхоороо санал хураагаад шийдчихсэний дараа бусад руугаа янз янзын байдлаар улс төр хийдэг байдал бол энэ танхим дотор бас байж болохгүй зүйл юм аа. Ялангуяа 126 гишүүнтэй парламент бий болчихсон. Энэ 126-тай болсон нь зөв юм уу, буруу юм уу гэдэг ойлголт, хүлээлт олон нийтийн дунд маш өндөр хувьтай байгаа. Олон нам, эвсэл оролцсон энэ парламент өөрөө аливаа асуудлыг шийдэхдээ илүү их тунгалагшуулах ёстой юм гэдэг ийм байр суурь явж байгаа. Сая төсвийн хэлэлцүүлэг дээр бас хэдий хуулийн гадуур ч гэсэн 20 гаруй гишүүд гарын үсэг зурчихсан асуудлыг хүндэтгэж үзэх нь зүйтэй юм аа. Парламентын дотоод эв нэгдлээ хангах нь зөв юм.

Цаашдаа бид аливаа шийдвэрийг гаргахдаа, ёстой 7 хэмжиж, 1 огтлох ёстой юм гэдэг энэ байр суурийг хадгалах үүднээс Улсын Их Хурлын дарга болон дэд дарга нар, бүлгийн дарга нар, парламентад суудалтай намын дарга нар бас энэ асуудлыг ярилцаж байгаад төсвийн тодотгол хийе гэдэг хэрэгжүүлэх арга хэмжээ авах тогтоолыг баталсан. Энэ бол Монгол Улсын парламентын түүхэнд 3 дахь удаагаа ийм зүйл тохиолдож байгаа явдал. Гэхдээ энийг бид буруутгахгүй байгаа юм. Яагаад гэхээр бидний гаргаж байгаа шийдвэр улам бүр тунгалаг болох ёстой. Энэ олон гишүүдийн үр нөлөө яг энийг дагаж тийм байдлаар гарах ёстой юм л гэдэг зүйл дээр бид хандаж байгаа. Тэгэхдээ би бас 3 дугаар хэлэлцүүлэг дээр хэлсэн. Асуудал болгон дээр бид ингэж явахгүй ээ. Төсөв өөрөө хугацаатай. Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх үүргийн асуудал байдаг учраас бид энэ дээр ингэж хандаж байна аа. Түүнээс бусад хэлэлцэж байгаа хууль болгон дээр олонхоороо шийдчихсэн асуудал болгоны араас хувийн байр сууриа гаргаж, улс төр болгож явах нь өөрөө парламентын нэгдсэн зарчимд нийцэхгүй ээ.

Цаашдаа Монгол Улс парламентынхаа дархлааг, парламентынхаа засаглалыг улам бүр баталгаажуулахын төлөө л явна уу гэхээс энд бид бас аливаа асуудлаар хоцрогдол, эс үгүй бол олон нийтийн дунд буруу, зөрүү ойлголт өгөх асуудал дээр тэвчиж болохгүй ээ. Тийм учраас би парламентын спикерээр ажиллаж байх хугацаандаа энэ бүгдийн эсрэг бол хатуу зогсоно. Тэр сайн, муугаар хэлүүлэх бол дараачийн асуудал. Гол нь парламентын зарчмаа бид хадгалж байх ёстой гэж ингэж бодож байна аа.

Дараачийн хүн асуулт асууя. Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгэхээр бид нар Их Хурлын гишүүд бид нарын үндсэн эрх ашиг, үндсэн гол зүйл бол яг л энэ л дээ. Монгол Улсын хөгжил дэвшлийн төлөө, Монголын ард иргэдийн аж амьдрал сайн сайхан байлгахын төлөө л бид нар бүгд л анхаарч байгаа. Энэ агуулгаараа өнөөдөр Цөмийн энергийн тухай хууль дээр орж ирж байгаа өөрчлөлт дээр манай гишүүд нэлээд маш их анхаарал хандуулж, хэлэлцэж явж байгаа нь бас үүний илрэл юм байгаа юм аа.

Монгол Улсын энэ энэ хөгжиж дэвших, ард иргэдийн амьдрал сайн сайхан байхын тулд хамгийн гол зүйл бол энэ Монгол Улс бид нар өөрсдөө баялаг бүтээгч орон болох ёстой. Баялаг бүтээгч иргэн болохын тулд бид нар гадаад гэлтгүй дотоодынхон нь өөрсдөө дотооддоо бид нар бас баялаг бүтээх, бизнес эрхлэх, аж ахуй эрхлэх ийм таатай нөхцөл боломжийг бол бид нар бас хууль, эрх зүйн хувьд бид нар бүрдүүлж өгөх ёстой юм аа.

Стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүнийг ашиглахтай холбоотой асуудал яригдаж эхлэхтэй зэрэгцээд, ингээд хөрөнгө оруулалтын гэрээ хийхтэй зэрэгцээд ингээд салбарын хуулиуд дээр өөрчлөлт ороод, нэмэлт, өөрчлөлт оруулж ирээд ингээд яваад байгаа нь хэр зэрэг оновчтой юм бэ гэдэг дээр бас гишүүд бид нар анхаарах ёстой.

Монгол Улс өөрийн гэсэн бодлоготой байх ёстой. Бодлого нь тодорхой байх ёстой. Тэр нь ингээд үе үе өөрчлөгддөггүй байх ёстой. Ялангуяа энэ дээр манай уул уурхайн салбарыг хариуцаж байгаа Уул уурхайн яамны бодлого энэ дээр тодорхой байх ёстой. Нэг ордын асуудал яригдаад дагаад хууль яригддаг ийм нөхцөл байдал руу бид нар цаашдаа урт хугацаанд явах нь буруу гэж ингэж үзэж байгаа гэдгийг бас энд хэлэхийг хүсэж байна.

Өнөөдөр энэ Цөмийн эргийн тухай хуулийг дагаад орж ирж байгаа бас нэг асуудал бол энэ татвартай холбоотой харилцаануудыг оруулж ирж байгаа юм. Тэгээд татвар гэж юу юм бэ гээд аваад үзэхээр зэрэг тодорхойлолт нь албан татвар, төлбөр хураамжийг татвар гэж хэлнэ гээд ингээд тодорхойлоод заагаад өгчихсөн байгаа. Тэгээд өнөөдрийн энэ Цөмийн энергийн тухай хууль дээр орж ирж байгаа гол өөрчлөлтийн нэг бол энэ АМНАТ-ын төлбөртэй холбоотой асуудлууд орж ирж байгаа. Монгол Улс бол АМНАТ-өөрөө Монгол Улсынхаа төсвийн орлогын 20-30 хувийг бүрдүүлдэг. Яг энэ төсөв улсынх нь төсвийнх нь 20-30 хувь нь энэ роялти таксаас бүрддэг орон манайхаас өөр байна уу, үгүй юү гэдэг асуудал бас энэ зарчмын асуудал байгаад байгаа юм. Эндээс хандаад би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр зэрэг энэ АМНАТ-ийнхаа хууль дээр бид нар бас ингээд тусад нь бие даасан ийм төлбөрийн хуулийг АМНАТ-ийн бие даасан хуулийг оруулж ирэх асуудал зайлшгүй шаардлага байна гэж ингэж харагдаж байгаа.

Бид нар газар ашигласны төлбөрийн хууль байдаг. Агаарын бохирдлын төлбөрийн хууль байдаг. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хууль, ус ашигласны төлбөрийн хууль гэх мэтчилэн тусдаа бие биедээ хуультай. Гэтэл АМНАТ нь ингээд Ашигт малтмалын тухай хуулийг дагаад нэг явж байдаг. Одоо ингээд Цөмийн энергийн хуулийг дагаад явах юм байна. Дараагийн ямар ашигт малтмалыг дагаж энэ АМНАТ-ын хууль явах юм бэ гэдэг ийм асуудал орж ирээд байгаа юм.

Тэгээд миний 1 дүгээр асуулт бол энэ АМНАТ-тай холбоотой асуудал. АМНАТ-ын хууль хэзээ орж ирэх вэ. Энэ тусдаа бие даасан хууль явах уу гэдэгтэй холбоотой асуудал. Ер нь энэ АМНАТ-ыг өндөр тогтооно гэдэг бол эргээд олон улсад юу ярьдаг вэ гэхээр зэрэг ашигт малтмалынхаа ордыг сорчилж ашиглах ийм бас ийм сөрөг үр дагавартай гэдэг ийм зүйл бас давхар явагддаг. Тэгэхээр энэ дээрээ бас АМНАТ-ын хуулийг бид нар бас анхаарах ёстой гэж ингэж үзэж байна.

2 дугаарт нь, энэ АМНАТ-тай холбоотой бас нэг орж ирсэн зүйл нь бол энэ Цөмийн энергийн тухай хуулийг дагаж орж ирэхдээ зөвхөн баяжмал дээр АМНАТ тооцно гэдэг юм орж ирж байгаа юм. Гэтэл Ашигт малтмалын тухай хуулийн 47.5 дээр чинь ашигт малтмал дээр АМНАТ тооцохдоо хүдэр дээр нь, баяжмал дээр нь, бүтээгдэхүүн дээр нь гээд 3 янзын юм байдаг. Гэтэл энэ Цөмийн энергийн тухай хууль дээр орж ирж байгаа АМНАТ чинь өөрөө зөвхөн баяжмал дээр нь гээд ороод ирчихсэн байгаа. Монгол Улс хүдэр гаргахгүй юм уу, Монгол Улс энэ ураны эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй юм уу гэдэг ийм асуудал руу орж ирж байгаа юм аа.

Дараагийн нэг асуудал нь энэ АМНАТ-тай холбоотой асуудал нь Засгийн газрын 2015 онд гарсан Эцсийн бүтээгдэхүүний 502 дугаар журам дээр байгаа зөрчил ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэгье. Заяабал гишүүний микрофоныг нэмж өгье. Нэг минут.

Б.Заяабал: Тэгэхээр энэ Цөмийн энергийн тухай хуулийг дагаж орж ирж байгаа энэ АМНАТ-ын хувь хэмжээн дээр бол эцсийн хүдрийн баяжмал нь өөрөө эцсийн бүтээгдэхүүн байхуйц ойлголтыг дагаж орж ирээд байна л даа. Гэтэл Засгийн газрын 502 дугаар эцсийн бүтээгдэхүүн буюу уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг тэр 502-оор зохицуулагдсан журмаар бол эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа энэ нөхцөлд эргээд нэмэгдсэн өртгийн албан татварын төлсөн бүх татваруудыгаа буцаагаад авчихдаг. Өмнөх асуултууд гишүүдийн асуулт дээр Пүрэвдорж гишүүн эд нар бол НӨАТ төлнө өө гээд байгаа юм. Гэтэл энэ хуулийн энэ заалтаар чинь бол НӨАТ-аа буцааж авахаар байгаад байгаа юм. Тэгээд энэ нь өөрөө бас ийм хууль зүйн хувьд бас ийм ялгаатай. Үүнээс чинь болоод ийм ойлгомжгүй байдал үүсээд байгаа юм аа.

Тэгээд Улсын Их Хурлын 9 дэх удаагийн энэ шинэ парламент 126 гишүүнтэй бид нар бас шинэ ийм төгөлдөршил ярьж байгаа. Баталсан хууль маань илүү тийм хэрэгжихүйц ойлгомжтой ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан. АМНАТ, НӨАТ.

Б.Жавхлан: Заяабал гишүүний асуултад хариулъя. Энэ гишүүд маань нийтлэг нэг ийм зүйл хөндөөд байгаа юм байна. Гэрээ хийх гээд хуульд өөрчлөлт

оруулж байна гээд яриад байх шиг байна. Түрүүн Учрал гишүүн ер нь зарчмаа хэлчихсэн юм шүү дээ. Гэрээ бол дараагийн асуудал. Хэзээ нэгэн цагт энэ орж ирж яригдаж л таараа. Дараа нь дахиад ч энийг дагаад хөрөнгө оруулалтын орчин нь сайжраад, ингээд хөрөнгө оруулалтууд нэмэгдэхийг үгүйсгэхгүй. Тэгвэл одоо ингээд хууль суурь зарчмууд дээрээ бид нар нэг ийм дүрэмтэй болчихъё л гэдэг ийм зарчмаар орж ирж байгаа гэж би ойлгож байгаа.

Тэгэхдээ бид огт ингэж хуулиа өөрчилж болохгүй, тогтвортой байлгах ёстой гэдэг нэр доор өмнө гаргасан алдаагаа, муу зүйлээ хадгалаад байж болохгүй. Бас тийм сонирхол байхыг үгүйсгэхгүй шүү, хаа нэгтээ. Тийм учраас муу юмаа сайжруулаад, өөрчлөлт бид нар хэдэн ч удаа хийж болно. Бүгдээрээ хэлэлцээд ил тод. Тийм учраас тийм, ийм өнцгөөс нь хараасай гэж бодож байна.

Дээрээс нь бас нөгөө талаар татварын орчинд реформ хийх ёстой гэдэг дээр бас янз бүрийн муу лобби орж ирэх вий. Энэ дээр бас болгоомжтой байх ёстой. Ийм нэг 2 өнцөг байгаа шүү гэдгийг хэлье.

Тэр АМНАТ-ын хууль тусдаа оруулж ирэх ёстой гэдэг дээр манай Заяабал гишүүн өөрөө татварын байгууллагад олон жил ажилласан хүний хувьд их зөв юм хэллээ. Бараг уйлмаар сайхан санаа хэллээ. Одоо яг энэ Ашигт малтмалын тухай хууль дээр ажлын хэсэг гарчихсан ажиллаад явж байгаа. Тэр ажлын хэсгийнхэн харин энийг нэг салгаад өгөөсэй. Энэ АМНАТ-ыг яг эндээс нь гаргаад бие даасан ийм төлбөрийн хуультай болчихвол үгүй мөн их сайн байна аа. Тэгвэл энэ олон хууль ярихад салбар салбарын хууль ярих болгонд энэ ингээд дурдагдахгүй, ингээд явчих юм байгаа юм.

НӨАТ дээр харин санал нийлж байна аа. Тэр буцаан олголт, чөлөөлөлт 2 их өөр ойлголт шүү. Ажлын хэсгийнхэн маань энийгээ хольж хутгаагүй гэдэгт би итгэлтэй байна. Зөв тал руугаа явж байгаа. Гэхдээ бид нэг тийш нь болгох ёстой. Энэ НӨАТ-ын асуудлыг. Гагцхүү тэр ньуанс нь бол тэр эцсийн бүтээгдэхүүн үү, үгүй юу гэдэг дээр л байгаа шүү дээ. Тэгэхээр эцсийн бүтээгдэхүүн гэдэг дээрээ энэ түүхий эд нунтгаа гэж үзэх юм уу, эрчим хүчээ гэж үзэх юм уу. Энийг ёстой салбарын яам энэ бодлогоо тодорхойлох нь чухал. Тийм учраас энийг Засгийн газар дээр бас эрх нь байгаа учраас энэ бас хөндөгдөж ярих болов гэж ингэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Тодруулах минутаа авчихсан. Заяабал гишүүн.

Уг асуудлыг хэлэлцэх хугацааг 120 минутаар Даргын дэргэдэх зөвлөл дэгийн тухай хуулийн дагуу тогтоосон байгаа. 120 минутын хугацаа дуусгавар болсон. Дууссан. Хугацаа дууссан байна. Дэгийн тухай хуулийн 41.3-аар нэгдсэн хуралдаанд асуулт асуух, хариулт авах үйл ажиллагааг зөвлөлөөс тогтоосон хугацаанд зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд хуралдаан даргалагч 1 хүртэл цагаар сунгаж болно гэсэн заалт байгаа.

Тэгэхээр 13 цаг хүртэл энэ асуудлыг хэлэлцэх хугацааг сунгалаа. Олон гишүүний асуулт үлдсэн учраас.

Ингээд Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуултаа асууна.

А.Ганбаатар: Өдрийн мэнд хүргэе, гишүүдэд. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаас нэг эш татаад заалт харчихъя гэсэн легал инфо руу ороод өчигдөр байхгүй байсан, өнөөдөр бас алга байж байна. Энэ нөгөө 2 дугаар зүйл

дээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад орчинд тулгамдаж байгаа сорилт эрсдэл гээд. Энэ ерөөсөө дотор нь ямар ч текст байхгүй байна. Энийг нэг манай хуулийн хэсэг шалгачихгүй юу.

Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Учир нь юу вэ гэхээр мега төсөл 14 мега төсөл цаашаа явах ёстой. Алт, зэс, нүүрс тойрсон эдийн засагтай орон бол ингээд байгаад байж болохгүй. Энэ хамтарсан засгийн гол утга учир бол зоригтойгоор том том төслүүдийг явуулах гэсэн ийм үндсэн концепт дотор байгаа учраас дэмжиж байна.

Гэхдээ Туваан сайдаас тухайлж асуух гээд байгаа юм. Энэ хуулийн төслөө оруулж ирэхдээ бид нар хамгийн түрүүн дарааллаа яаж тогтоож байгаа вэ? Энийг хэрвээ эдийн засгийн утгаар нь авч үзэх юм бол жишээлэхэд энэ алттай харьцуулахад 1 кг алт 80 мянган доллар зах зээл дээр байж байхад, уран 280 доллар байх юм байна. Энэ талаас нь харах юм бол эдийн засгийн ач холбогдлыг нь өмнөө тавих, тавихгүй хүмүүс гарах байх. Миний зүгээс энэ үндэсний аюулгүй байдлын стратегийн талаасаа, үндэсний аюулгүй байдал гуравдагч хөршийн бодлого гэдэгтэй яаж нийцүүлж харж байгаа юм бэ. Үндэсний аюулгүй байдлын заалт дотор үндэсний аюулгүй байдлын ард түмний эрх ашгийг онцгойлон анхаарна аа. Аливаа төслийг хэрэгжүүлэхдээ, ялангуяа гаднын төслийг хэрэгжүүлэхдээ. Тэр дотроо тусгаар тогтнол, аюулгүй байдлаа дипломат яриа яриа хэлэлцээний замаар шийдвэрлэнэ гэсэн байдаг. Тухайлбал гуравдагч хөршийн хамтын ажиллагааны талаар ч тусгай заалтууд байж байна.

Тэгэхээр энэ төсөл маань үндэсний аюулгүй байдлын энэ 2 үзэл баримтлалын заалтаа барьсан ийм төсөл мөн үү? Та дарааллаа яаж харж байна? Эхлээд энийгээ тавиад, дараа нь эдийн засаг. Магадгүй 3 дахь нь тэр АМНАТ, татварын асуудлууд. Тэгээд орон нутаг хохирч үлдээд байгаа гээд манай энэ орон нутгийн гишүүд яриад байгаа. Тэр үнэн байна аа. Орон нутагт өгөөж нь ерөөсөө очдоггүй эсвэл орон нутгийнхаа иргэдийг турхирсан энэ том төслийн эсрэг ингээд буруу, зөрүү ойлголттой үйл ажиллагаа хөдөлгөөнөөр явуулчихдаг. Тэгэхээр энэ дарааллын та нэг тов тодорхой гаргаж өгсөн ямар бодлого барих вэ?

Туваан даргаас нэмээд асуух нь энэ дарааллын дараа та надад нэг зүйлийг хэлж өгөөч ээ. Ер нь энэ Оюутолгой бусдын том төслүүд явахад төр нь өөрөө энэ том төслөө дуустал нь хамгаалдаг байх ийм хуулийн зохицуулалт байгаа юм уу? Гэрээ байгуулж өгөөд л хаячихдаг. Ард нь нөгөө янз бүрийн зорилготой, үймүүлэх, том төслийг унагах, илүү дутуу олон толгойтой амьтан мал гарлаа, ус ундаа ууж болохгүй байна гэх мэтээр ингээд орон нутаг болон нийгмийг ингээд буруугаар ойлгуулсан стратегийн ач холбогдолтой төслийг унагасан ийм пи ар сурталчилгаанууд хийгээд байдаг л даа. Санаатай, санаандгүй. Энэ дээр төрийн дархлаа гэж байх юм уу. Энийг хуульчилж гэдэг юм уу, хууль зүйн утгаар нь хамгаалах ийм зохицуулалт хийж өгөх үү гэж Туваан даргаас асууя гээд.

2-т нь, энэ мэргэжлийн хүн Тэгшбаяр манай физикч байж байна. Энэ Зөөгч-Овоо ордыг ямар технологиор олборлох юм бэ? Байгаль экологид хамгийн аюулгүй арга нь юу юм бэ? Тухайн уранаа орчимд амны ус хэрэглэж болохгүй гэсэн ийм ойлголт нийгэмд яваад байна аа. Энэ талаар та нэг цэгцтэй ойлголт өгөөч гээд.

Сүүлийнх нь бол хэрвээ энэ стратегийн төсөл юм бол Засгийн газар буюу Ерөнхий сайдын доор хуучин байсан шүү дээ, Тохируулагч агентлаг гээд. Тэгээд одоо болохоор ингээд яамны доор орчихоор ач холбогдол нь яадаг юм бол оо? Энэ

бүтцийн талаасаа Учрал сайд нэг хариулж өгөөч гэж зөв юм уу, буруу юм уу? Нэг ийм 3 асуулт.

Д.Амарбаясгалан: Хууль зүйн талаас нь хариулт өгөх хэрэгтэй байна. Алтангэрэл сайд хариулах уу? Ажлын хэсгийн хэддүгээр микрофон бэ? Ажлын хэсгийн 19 дүгээр микрофоныг өгье. Микрофон ассан байна хариулт өгье.

Н.Жамъянхүү: ХЗДХ-ийн яам Жамъянхүү. Энэ ер нь бол өнөөдөр бид нар нөгөө хуулийн яг энэ Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцэж байгаа байх. Зүгээр яг энэ төсөл хэрэгжүүлэх талаар бол дараа нь бид нар нөгөө хөрөнгө оруулалтын гэрээгээ оруулж ирээд, Их Хурлаар бол бас энэ виз авах, хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөлүүдийн талаар бол яг Их Хурлаар тодорхой энэ зүйл тус бүрээр нь бас зөвлөгөө авч, энэ дээр чиглэл авч хэлэлцэх болно. Яах вэ, яг дархлааны хувьд бол бас энэ Хууль зүйн яамнаас бас энэ тал дээр хариулах нь бас зохимжгүй байх аа. Ажлын хэсгийн ахлагчаас энэ талаар асуух, юу хариулт нь өгөх нь зүйтэй байх аа.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулсан 14 мега төслийн 1 төсөл байгаа. Энэ ураны төсөл бол. тэгэхээр ач холбогдлын хувьд бас Засгийн газрын зүгээс өндөр ач холбогдол өгч байгаа нэлээдгүй хугацаанд яригдсан ийм төсөл. Хөрөнгө оруулалтын хувьд бид нар гаднын хөрөнгө оруулалттай 2 дахь томоохон төсөл, 2 дахь томоохон гэрээ болно. Тэгээд энийг бас аюулгүйн зөвлөлийн 5 орны 1 гуравдагч хөрштэйгөө хийж байгаа нь бас өндөр ач холбогдолтой ийм төсөл болно гэдгийг хэлье.

Мэдээж эдийн засгийн үр өгөөж талыг нь мэдээж тооцсон. Энэ бас эдийн засгийн маш том үр өгөөжөө өгөх ийм төсөл өө гэдгийг бас хэлье. Орон нутгийн иргэд яг энэ асуудал дээр ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Олон улсад явагдаж байгаа энэ уул уурхайн салбарын чиглэлээр ашиглалттай холбоотой энэ судалгаанууд байгаа юм, байгаа. Энэ олон судалгаан дотор ингээд харахад бараг 8, 9 судалгаа нь 10 судалгаа дундаас 8, 9 нь энэ орон нутгийн эрх ашгийг хэрхэн хамгаалах вэ, тэнд байгаа иргэдийн асуудлыг яаж шийдэх вэ, орон нутагтайгаа энэ уул уурхайн компани хэрхэн зохицож ажиллах вэ гэдэг ийм шийдвэртэй яваад байгаа юм байна лээ, дэлхий дээр. Тэгэхээр бид хэд ч гэсэн энэ асуудал руу нэлээн анхаарч ажиллана. Түрүүний хариултууд дээр энэ уул уурхай, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр энэ асуудлыг оруулж ирнэ.

Мөн тодорхой тэр санхүүгийн үр ашиг өгөх гэдэг дээр маш олон гишүүн ярьж байна. Тэгэхээр сая бас энэ АМНАТ-ын тухай хуулийг, юу ашигт малтмалын нөөц ашигласны хуулийг тусад нь гаргах асуудал ч гэсэн ярьж байна. Тэгэхээр энийг ер нь ойрын хугацаанд тодорхой болгож, шийдэх ийм зорилготой салбарын яам ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Түрүүн нөгөө Заяабал гишүүний асуултад минут хүрээгүй нэг зүйл, гол бас асуулт үлдчихсэн юм. Хуулиар тэр АМНАТ авахдаа зөвхөн баяжмалаас гэхийсэн байна ямар учиртай юм бэ, хүдэр яачихсан юм бэ гээд. Тэгэхээр энэ хуулиар цацраг идэвхт ашигт малтмалаас бид хүдрээр гаргаж болохгүй, зөвхөн боловсруулна шүү, баяжуулна шүү гээд ингээд заачихсан. Яг АМНАТ-ын орлого бүрдүүлэлт талдаа энэ Монгол Улсдаа ашигтай, зөв байхгүй юу. Бид нар илүү АМНАТ авна л гэсэн үг. Дээрээс нь энд бид илүү өртөг шингээнэ, боловсруулалт хийнэ.

Дээрээс нь энэ чинь ингэчихсэн юм байна лээ шүү дээ, 2009 онд тэр Улсын Их Хурлаар батлагдсан Монгол Улсын төрөөс баримтлах цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн тухай баримтлах бодлогын бичиг баримт дотор Монгол Улс хүдрээр нь түүхийгээр нь гаргаж болохгүй ээ, заавал баяжуулна шүү, баяжмал гаргана шүү гээд ингээд заачихсан юм байна лээ. Тэр хүрээндээ хуульдаа оруулж өгөөд, АМНАТ-аа тэндээсээ өсөн нэмэгдэхээр ингээд арай илүү ахиу авна гээд ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгье. Шинжээч Тэгшбаяр хариулна.

Н.Тэгшбаяр: Их Хурлын гишүүн Ганбаатар таны асуултад хариулъя. Ураныг олборлох үндсэндээ 3 янзын технологи байна. Ил аргаар, далд. Тэгээд газар доор уусган баяжуулах. Ер нь далд, уусган баяжуулах 2 бол нэг төрлийн ийм арга байгаа. Газар доор уусган баяжуулах энэ технологиор бол дэлхий дээр олборлож байгаа нийт ураны 51-60 орчим хувийг нь бол олборлож байна. Өөрөөр хэлбэл энэ дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн ийм арга байгаа. Гадуур хүмүүсийн ингээд энэ төслийн эсрэг ярьж байгаа зүйлүүд энэ яг тэр уран байгаа тэр орчмын усыг бохирдуулчихна гэсэн тийм эсрэг юм ярьж байгаа. Гэтэл тэр нэгэнтээ олборлохуйц хэмжээний уран байгаа бол уран нэг талаасаа бол ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэгшбаяр шинжээчийн микрофоныг нэмж өгье, гүйцээж хариулъя. 5.

Н.Тэгшбаяр: Нэгэнт олборлохуйц хэмжээний ураны нөөцтэй байгаа яг тэр давхаргад байгаа ус бол ууж болохгүй, бүр тэр байтугай өөр уран олборлохоос өөр юмнууд ашиглаж болохооргүй тийм техник ус байгаа. Техникийн усан дээр тэр хүхэр хийсэн ч, сүү хийсэн ч, ус хийсэн ч техник орчин болно гэдгийг бас нийтээрээ ойлгоосой гэж хүсэж байна. Ер нь бол би энэ миний хувьд бол энэ сая энэ газар доор уусган баяжуулах аргын технологийн зургийг авч ирсэн. Гишүүдэд үзүүлье, шаардлагатай үзүүлэх боломжтой энэ камер байвал.

Дээрээс нь энэ Монгол орны ундны ус дахь ураны тархалтын зураглалыг хийсэн. Тэгэхээр энийг гишүүдэд өгөх боломжтой. Ийм юм байгаа юм. Тэгээд устай холбоотой илүү асуудлыг Жаргалсайхан доктор нэмж хариулж болох байх аа.

Д.Амарбаясгалан: Ингээд 12 цаг 30 минут, 26 минут болж байна. Үдээс өмнөх хуралдаан завсарлая.

Үдээс хойших хуралдаан 15 цагаас үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА

Д.Амарбаясгалан: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдааныг эхлүүлье. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж байгаа. Ажлын хэсгийнхнийг орж ирэхийг хүсэж байна. 15 цаг болчихсон байна. Ажлын хэсгийн гишүүд яаралтай суудлаа эзэлье. Тэгшбаяр шинжээч суудлаа эзэлье. Улсын Их Хурлын чуулган эхлэх гээд та бүхнийг хүлээгээд байна.

Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье асуулт асууна.

Д.Пүрэвдаваа: Өдрийн мэнд хүргэе ээ. Эрхэм гишүүд болон ажлын хэсгийнхэндээ үдээс хойших мэндийг хүргээд товчхон хэдхэн асуулт асууя. Ажлын хэсгээс энэ нийт нөөцийн 67 хувь нь газар доорх уусган олборлох аргаар олно гээд энэ танилцуулга дээр бичсэн байна л даа. Тэгэхээр зэрэг энэ орон нутагт өгөх энэ АМНАТ-аас өгөх тэр мөнгөн дүнг та нар яг ижилтгээд ингээд тавьчихаж байна аа. Тэгэхээр зэрэг 3 төрлийн аргаар ураныг олборлодог гэсэн. Тэгээд энэ устай холбогдсон зүйл нь байгаль орчинд хэр их хор хөнөөл өгдөг юм бэ? Тэрэнтэйгээ уялдуулаад энэ орон нутагтаа татаасыг нь олгож болдоггүй юм уу? Бүгдийг нь яагаад ийм тэгшитгэх аргаар тооцсон юм бэ гэдгийг нэг асуумаар байгаа юм.

Хоёрдугаарт Туваан сайдаас асуумаар байна. Энэ 2009 оноос хойш хайгуулын 140 лиценз байж байгаад 2019 онд 9 болоод одоо бол 3 болж буурсан юм байна аа. Тэгээд өнгөрсөн энэ хугацаанд яагаад энэ хайгуулын лиценз нь энэ их байж байгаад ингээд богинохон хугацаанд хэд дахин буурсан шалтгаан нь юу байдаг юм бэ гэдгийг асуумаар байна. Тэгээд энэ танилцуулга дээр бол өнгөрсөн хугацаанд ялангуяа 2020 оноос хойших одоо энэ үзүүлэлтүүд 4 жилийн хугацаанд бол ердөөсөө өөрчлөгдсөн зүйл байхгүй. Хамгийн сүүлд 2020 онд 192 мянган тонн нөөц байна гээд тогтоосон байна. Тэгээд энэ өнгөрсөн 4 жил энэ хуулийн төслийг оруулж ирэхгүй байсан шалтгаан нь ямар шалтгаан байдаг юм оо. Яагаад энэ удаа нэн яаралтай горимоор ингэж оруулж хэлэлцэж байгаа юм бэ гэж асуумаар байна. Тэгээд хамгийн сүүлд нь 34 хувийг улс эзэмших бололцоотой хуулийн нөхцөл байдлыг юу яаж байна. АМНАТ-аар тооцох аргыг хэрэглэж байгаа юм байна аа. Ямар тооцооллын аргыг хэрэглэсэн юм бэ? Тэгэхээр үр өгөөж нь 34 хувийг улс эзэмшсэнээс илүү эерэг нөхцөл байдал үүсэх юм байна гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр тэр үүсэх эерэг нөхцөл байдал нь хөрөнгө оруулагч талдаа ямар ямар нөхцөл байдал үүсэж байгаа юм.

Дээрээс нь Монгол Улсын талдаа ямар нөхцөл байдал үүсэж байгаа юм бэ гэдгийг асуумаар байна аа.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя аа. Энэ ураны хүдрийн 67 хувийг нь гэж байгаа юм. Тэгэхээр одоо нөгөө тогтоогдсон байгаа нөөцийн 67 хувь нь одоо энэ ашиглалтын үед олборлогдоно л гэж ингэж ойлгогдоно. Тэгээд мэдээж энэ хөрөнгө оруулалтын гэрээ Улсын Их Хурлаар орж ирнэ. Энэ хөрөнгө оруулалтын гэрээн дотор бас энэ орон нутагт шууд тухайлах юм бол Дорноговь аймгийн Улаанбадрах суманд жил болгон 1 сая долларын хөрөнгийг орон нутагт нь өгнө өө гэдэг зүйл байгаа. Энэ ашигт малтмалын нөөц ашигласны татвар одоо бид хэдийн яг энэ яриад байгаа энэ татварын асуудлаас орон нутагт нь тухайн уул уурхайг эрхэлж байгаа орон нутагт нь түлхүү олгох гэдэг энэ асуудлыг гишүүд маш их хөндөж ярьж байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр бол яам адилхан байр суурьтай байгаа. Тэгэхээр энэ авчихсан АМНАТ-ыг тэндээс олж байгаа аж ахуйн нэгжийн

орлогын албан татвар гэх мэт татваруудаас энэ олж байгаа мөнгөний тэр татваруудынхаа нэлээд боломжийн хувийг орон нутагт өгөх гэдэг энэ асуудлыг гишүүд хөндөөд байгаа. Тэгэхээр Ашигт малтмалын тухай хууль одоо удахгүй шинэчлэн найруулагдаад орж ирнэ. Энэ дотор энэ концепцыг тусгаж өгнө гэдгийг танд хэлье.

Дээрээс нь түрүүн бас Заяабал гишүүний үгэнд ч гэсэн гарч байсан. Ашигт малтмалын нөөц ашигласны татварын энэ хуулийг бүүр тусад нь гаргая гээд хүртэл ийм зүйл ярьсан. Тэгэхээр одоо бид нар бол концепцын хувьд бол уур уурхайг хэрвээ хөгжүүлж үндэсний баялгийн сандаа ихээхэн орлого олъё гэсэн энэ бодлого явах юм бол зайлшгүй орон нутагтай хэл амаа ололцож тэнд амьдарч байгаа ард иргэд нь илүү их хувийг хүртэх гэдэг ийм ойлголтыг бид нар зайлшгүй хийж өгөхөөс өөр аргагүй байгаа юм аа. Уул уурхайн лиценз олголтын асуудал ярьж байна. Тэр дотроо энэ цацраг идэвхт бодисын лицензийг Ашигт малтмалын тухай хуулиар олгодог. Тэгэхдээ энэ дээр Ерөнхийлөгчийн зарлиг үндэсний аюулгүй байдлын зөвлөмжөөр энэ лиценз олголтыг Засгийн газар олгодог. Ийм одоо давхар журам нэмэгдээд ингээд олгоод явж байгаа. 2009 оныхыг нь би яг сайн мэдэхгүй байна. Яг одоогийн байдлаар бол хайгуулын 3 ашиглалтын 8 лицензийг 7 компани эзэмшиж байгаа. Өнгөрсөн хугацаанд бол нэг 7-оос 8 лиценз бас ингээд цуцлагдсан байдаг. 200 тэр тоог нь сайн мэдэхгүй байна. Би бас энэ яг салбарынхнаасаа асуугаад хэлье.

Энэ хуулийн төсөл яагаад нэн яаралтай горимоор оруулж ирэв гэж байгаа юм. Энэ дээр бол энэ шууд төсөлтэйгөө цуг оруулж ирээгүй. Ерөнхийдөө энэ Оронгийн энэ гэрээг бас байгуулахад боломжийг гаргаж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ 34 хувийг авах гэдэг энэ зүйл бол хуульдаа байгаа.

Д.Амарбаясгалан: Туваан сайдын микрофоныг өгье, нэмж хариулъя.

Ц.Туваан: Тэгээд энэ хуулийн оруулж ирсэн үзэл баримтлал дотор энэ төрийн эзэмших 34 хувийг ашигт малтмалын нөөц ашиг ашигласны төлбөрөөр орлуулж болох энэ гаргалгаа буюу вариантыг гаргаж оруулж ирж байгаа. Тэгээд ер нь бол энэ Оронатай хийсэн гэрээ чинь хийх энэ хэлцэл чинь хэлэлцээр маань маш олон жил явчихсан. Цаг хугацаа маш их алдсан асуудал байгаа.

Хоёр улсын Ерөнхийлөгч энэ асуудал дээр 2 ч удаа уулзаад ярьчихсан. Тэгээд гэрээ нь бас урагшлахгүй цаг хугацаа удаад байгаа. Тэгэхээр бид бүхэн шинэ Засгийн газар, хамтарсан Засгийн газар байгуулагдчихсан энэ үедээ гацаад байсан ийм томоохон төслүүдээ бас яаралтай явуулахгүй бол ингээд өөх ч биш булчирхай ч биш байлгаад байх нь цаг хугацаа алдаж байгаа учраас яаралтайгаар оруулж ирж байгаа.

Мэдээж энэ 34 хувийг энэ тусгай АМНАТ-аар сольж байгаа асуудал. Энэ бол үндсэндээ үндсэн хуулийн 6.2-ын дагуу энэ стратегийн ордын үр өгөөж дийлэнх нь Монгол Улсад үлдэх гэдэг энэ агуулгыг.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн нэмж хариулъя. Ажлын хэсгийн дарга.

Б.Пүрэвдорж: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр усны ус бохирдуулсны төлбөрийн асуудал дээр бол яг өнөөдрийн байдлаар энэ Байгаль орчны тухай хууль болон Байгаль орчны яамнаас гаргаж байгаа дүрэм журмаар бол тэр ус бохирдуулсны төлбөрийг яг ингээд детальний тэгж оруулна гэсэн тийм нарийвчилсан заалт байхгүй учраас яг энэ Оронагийн хэлэлцээр явагдах үед тодорхой энэ мэдээж манай талаас бол ус бохирдуулсныхаа төлбөрийг бол авна. Авах байр суурин дээрээ байж байгаа. Тэгэхээр энэ дээрээ яг хэлэлцээр дээрээ нарийвчилж орж байна. Тэгэхэд нь та бас сайн асуувал зүгээр.

Хоёрдугаарт нь бол энэ үр ашгийн хувьд бол жишээ нь одоо 34 хувиа аваад суурь АМНАТ-аа авах юм бол 1.6 тэрбум долларын тодорхой зардлыг нь 34 хувьдаа таарах тэр санхүүжилтийг 1 дүгээрт гаргана. Тэгээд үүний үр дүнд жилдээ нэг 169 сая доллар жилдээ олох юм цэвэр ашиг нь.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн гүйцээж хариулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэх дээр нөгөө давуу эрхийн 10 хувь, суурь АМНАТ нөгөөдөх нь юу билээ, тусгай АМНАТ, өсөн нэмэгдэх АМНАТ энэ бүгдээрээ авахад бол нэг яг 34 хувь эзэмшсэнээсээ 11 сая доллароор л бага авна. Өөрөөр хэлбэл 53 сая доллар авна гэсэн үг. Тэгэхээр бид нар энэ 34 хувь эзэмших юм бол нэгдүгээрт их хөрөнгө оруулалт нэгдүгээрт гаргана.

Хоёрдугаарт нь яг тэр нөгөө Оюу Толгойн араас ороод тийм нөгөө зардлыг нь тооцож чадахгүй хэр зэрэг зардал гаргаж байгаа юм. Тэрийгээ тооцож чадахгүй бид нар хэзээ ноогдол ашгаа авах тэр асуудал нь тодорхой биш үлдэх байхгүй юу даа. Тийм учраас энэ суурь АМНАТ, тусгай АМНАТ, өсөн нэмэгдэх АМНАТ энүүгээр авахад бол илүү баталгаатай байна аа. Илүү шууд борлуулалт хийнгүүт тэрнээсээ шууд аваад явах учраас.

Д.Амарбаясгалан: Пүрэвдаваа гишүүн тодруулж асууя.

Д.Пүрэвдаваа: Олон нийт бол энэ хамтарсан Засгийн газар энэ цөмийн энергийн тухай хуулийг нэн яаралтай горимоор өргөн бариад улс үнэгүй авах бололцоотой байсан 34 хувийг татвар хэлбэрээр авахаар ингээд оруулж ирж байна гэдэг дээр хардаж байгаа юм.

Тийм учраас аль болохоор энэ иргэдэд энэ нөгөө өгөөжтэй талыг нь санхүүгийн хувьд ямар өгөөжтэй юм. Эдийн засгийн хувьд ямар өгөөжтэй юм бэ гэдгийг маш тодорхой энэ танилцуулах материал дээр тавимаар байгаа юм. Энэ дээр аягүй тодорхойгүй байна. Тэгэхээр та бол сая санхүүгийн өгөөж тодорхой дүн хэллээ. Эдийн засгийн өгөөжийг бас хэлэх нь зүйтэй байх гэж хэлмээр байгаа юм. Нөгөөтээгүүр энэ байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн талаар маш тодорхой хариулт өгөх хэрэгтэй байна. Тэгээд орон нутагт энэ ойлголт нь бол маш хортой байгаа. Тэгээд энэ газар доор уусгах арга нь.

Д.Амарбаясгалан: Хэн хариулт өгөх билээ? Ажлын хэсгийн 16 дугаар микрофон.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн. Гишүүний асуултад нэмж хариулъя аа. Үндсэндээ бол 1997 онд Ашигт малтмалын хууль шинэчилсэн найруулагдсан цагаас хойш бол цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгож явсан байгаа. Өнгөрсөн хугацаанд бол нийт 21 тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан. Бүхэлд нь өөрсдөө тусгай зөвшөөрөл эзэмшигч нь

өөрөө буцааж өгсөн 22, хүчингүй болсон 4, цуцалсан 7 цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл байгаа. Хүчинтэй байгаагүй гэж сая Туваан сайд хэлчихлээ. Байгаль орчны тухайд бол бид нар бол энэ дээр маш онцгой анхаарал хандуулж хөрөнгө оруулалтын гэрээний явцад яригдаж байгаа. Тухайлах юм бол уурхайн хаалт нөхөн сэргээлтийн асуудлыг 5, 5 жилээр тодотгоод явах асуудлыг бол бас энэ хууль дээр тусгаж орж ирж байгаа. Юуны тухайд бол нөхөн сэргээлт байгаль орчны нөгөө унаган төрхөд нь оруулах асуудал дээр бол энэ төсөл өөрөө 44 жил хүргэчих юм. Тэрнийх нь 34 жил нь ашиглалт буюу сүүлийн.

Усны газрын дарга Батбаяр байхгүй байна уу? ажлын хэсгийн 17 дугаар микрофон.

Баярлалаа. Маш товчхон хэлэхэд Усны тухай асуудал дээр нэгдүгээрт нь усны чанарын өөрчлөлтийн эрсдэл, усны хэт ашиглалт гэдэг ийм 2 эрсдэл байгаа. Энэ 2 эрсдэлээс хамгаалахын тулд одоогийн тохиролцсон байгаа байдлаар мониторингийн цоонуудыг байрлуулна. Мониторингийн цооног дээр одоогийн байдлаар зөвхөн газрын доорх усны түвшний бууралт өсөлтийг ажиглаж байгаа бол энэ төсөл хэрэгжиж эхэлснээр чанарын хяналтыг тавьж эхлэх юм. Тэгээд олборлолт эхлэхээс өмнө газрын доорх усны судалгааг хийгээд энийгээ суурь үзүүлэлт болгож аваад юу хийгдэх үед уурхай хаагдах үед тэр суурь үзүүлэлтээс ямар өөрчлөлт гарсан байна тэр өөрчлөлтөө нөхөн сэргээх замаар хийхээр ингэж тооцоолж явж байгаа. Түрүүн Пүрэвдорж гишүүний хэлсэн дээр нэмээд хэлэхээр усны асуудлыг тогтворжуулахгүй буюу тухайн үед аливаа асуудал гарахад тухайн үед хүчин төгөлдөр.

Д.Амарбаясгалан: Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууна аа.

З.Мэндсайхан: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд энэ дээр нэг асуулт байгаа юм аа. Энэ АМНАТ-ийн татварыг зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч нэмэгдүүлнэ гээд бид нар хүснэгтлээд оруулчихсан байна л даа 20.4 дээр. Тэгээд энэ дээр бүтээгдэхүүний нэр төрөл гэдэг дээр ураныг зөвхөн дангаар нь оруулчихсан байгаа юм. Цөмийн энергийн хуулийг нь харахаар 3.1.4 дээр заасан цацрагт идэвхт ашигт малтмалууд гэж яг энэ томъёоллоор нь оруулчихвал яагаад оруулахгүй ингэж салгаад оруулчихсан юм болоо. Тэрэн дээр чинь уран болон торын бүлийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс баялгийн хуримтлал цөмийн бодис гэж цөмийн технологид хэрэглэгдэх уран, төрөл бүрийн цацраг, газрын ховор элементийг агуулсан бодисыг хэлнэ гээд хууль дээрээ тусгачихсан мөртөө яг энэ дээр зөвхөн яагаад ураныг тусад нь салгаад оруулчхаж байгаа юм бэ? Энийг бүхэлд нь оруулаад оруулаад явах боломж байхгүй юм уу? Нэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт энэ татварын тэг хувь хэрэглэх заалт гэдэг Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль дээр 12.1.7 дээр байна л даа. Тэгээд энэ шар нунтгийг чинь бид нар эцсийн бүтээгдэхүүн гэж яг үзэх юм уу, үзэх юм бол ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүнээс нэмэгдсэн өртгийн албан татвар авахгүй гээд энэ хөнгөлөлтийнх нь заалт дээр тавиад өгчихсөн байгаа юм. Тэгэхээр цаашдаа бид нар би бол энэ хуулийг нь харахаар энэ бол эцсийн бүтээгдэхүүн юм гэж ойлгоод байгаа. Манайхаар экспортод гарч байгаа ашигт малтмал учраас. Ингэхээр бид нар нэмэгдсэн өртгийн албан татварыг авах боломжгүй болох нь гэдэг ийм эрсдэл байна гэж харж байгаа. Энэ дээр юу гэж харж байгаа юм бэ?

Гуравдугаарт одоо энэ уурхайн хаалт хийхэд нөхөн сэргээлтийн асуудал дээр 300 сая доллар аваад ингээд болчихно оо. Тэрийг Төрийн тусгай дансанд Монголбанканд байршуулна ч гэдэг юм уу ийм танилцуулга явж байна лээ л дээ. Тэгэхээр энэ чинь урт хугацааны асуудал шүү дээ. Жил тутам түрүүн би Сангийн сайдын хариулж байгаагаас харахад жил тутам нэг 10-аас арван хэдэн сая долларыг энэ нөхөн сэргээлтэд зориулаад хаалтад зориулаад өгөөд явна тэр нь бид нарт хэрэгтэй гэж. Гол нь энэ төсөв чинь эргээд тэр ирээдүйд нөхөн сэргээлтийг чинь өнөөдрийн хийж байгаа ТЭЗҮ-ийн чинь зардалд хүрэхгүй байдал үүсэх үү? Ингэвэл хэн хариуцах вэ? Бид мөнгийг нь аваад Монголд хадгалчихдаг. Татаж төвлөрүүлснээрээ бид нар эргээд энэний эрсдэлийг өөрсдөө үүрэх асуудал руу орох юм биш биз дээ? Энэ дээр ямар бодлого байгаа вэ гэж.

Дөрөвдүгээрт ер нь одоо энэ төр олгосон тусгай зөвшөөрлүүдээ ер нь яаж хамгаалах бодлого барьж байгаа юм. Би энийг Туваан сайдаас асууя гэж бодож байна. Саяхан үүссэн Халзан Бүргэдэйтэй холбоотой асуудал дээр ард иргэдийг бухимдуулаад тиймээ бөөн юм боллоо. Та бол байхгүй болчихлоо. Тэр хувийн хэвшил, иргэд хоёрын хооронд том зөрчил болоод харагдаж байна. Төрийн байгууллага нь 2 жилийн өмнө очоод Цөмийн энергийн газраас байх ёстой цацрагийн хэмжээнээс 8 дахин илүү цацрагийн идэвхтэй байна энэ нь бол хүн амьтны байгаль орчинд сөрөг нөлөөтэй юм гээд төрийн байгууллага нь өөрөө дүгнэлт гаргачихсан. Энэ нь өөрөө бид нарын амьдралд нөлөөлөх юм уу, үгүй юу гэдгийг л тэр ард түмэн мэдэх гээд тэмцээд байгаа асуудал шүү дээ. Тэгээд та яагаад ажлаа хийхгүй байна. Таныг би очиж энэн дээр тайлбар өгөөч гэсэн. Танаас би асуулга тавьсан. Өнөөдрийг хүртэл хариу байхгүй. Тэр иргэдийг мэдэх эрхээ эдэлснийх нь төлөө гаднын дотнын бүлэглэл байна гээд хэвлэлээр нүдээд сууж байх юм. Тэр Хууль зүйн сайд энэнийг тэгвэл тийм бүлэглэл байгаа юм бол тогтоосон нь хаана байгаа юм.

Яагаад тэр сумын иргэдийн эрүүл орчин, тайван амьдралынхаа төлөө, мэдэх эрхээ хангахын төлөө тэмцсэн тэмцлийг нь та нар гадна дотнын бүх гар хөл байна гээд зарлаад сууж байдаг юм. Үнэхээр тийм байгаа бол тэр Хууль зүйн сайд энийг тогтоох ёстой шүү дээ. Тэгээд тийм биш байгаа бол тэр ард иргэдийг доромжлоод сууж байдаг хэвлэлийнх нь тэр оногдох ёстой хүмүүст нь хариуцлагыг нь хүлээлгэх ёстой шүү дээ. Нэг ёсондоо одоо бид.

Д.Амарбаясгалан: Мэндсайхан гишүүн нэмэлт нэг минут өгье.

З.Мэндсайхан: Хэлэх гээд байгаа санаа нь бол ард түмэн ААН-үүдийг ингэж хооронд нь зодолдуулахаа болио. Төр нэгэнт өөрөө лиценз олгож байгаа бол тэрийгээ хамгаалдаг байх ёстой. Тэр ард түмний эрх ашгийг сонсдог байх ёстой. Тэгээд энэ эрхээ хэрэгжүүл л дээ энэ үүргээ биелүүл л дээ. Ингээгүйгээс болоод тэр иргэд чинь зодолдоод байна шүү дээ. Тэр ААН-тэй зодолдоод. Тэр ААН нь иргэдээ доромжлоод. Үгүй тэр зөвшөөрлийг төр өгсөн шүү дээ. Тэгээд яагаад энэ үед нь төр алга болчихдог юм? Энийг тодорхой болгомоор байна аа. Одоо энэ яг Цөмийн энергийн хууль хэлэлцэж байна. Дараа нь энэ гэрээ нь орж ирнэ. Энэ яг асуудал ийм болно шүү. Тэгээд тэр элдэв янзын амьтан, мал, амьтан хордлоо гээд нэг бүлэг хүмүүс гарч ирээд тэгээд энэ гаднын компанитайгаа зодолдоод эхэлнэ шүү. Тэгээд энэ дээр төр ямар бодлого барих гэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хариулт өгье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 20¹.4-д заасан тэр хүснэгт байгаа. Тэр хүснэгт дээр ураны хүдрийн баяжмал, ураны исэл U3O8 гээд. Энэ бол цэвэр л урантай холбоотой. Бусдаар газрын ховор элемент энэ тэртэй ерөөсөө хамаагүй. Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлт хийж байгаа гол зорилго бол ер нь яг энэ хуулийг дагалдаж орж ирэх Улаанбадрахын Зөөвч овоо Орона болон Бадрах Энержигийн гэрээний асуудлыг л зохицуулагдана. Бусдаар бол тэгээд манай Ардын намын 3 гишүүн шиг Уран гэхээр л аваачаад л тэр нэг Халзан Бүргэдээ дээр наагаад л ураны лобби бүлгийг Пүрэвдорж ахалж байна гэдэг ийм юмтайгаа хольж хутгаад байх хэрэггүй гэж бас танд хэлмээр байна.

Хоёрдугаарт нь тэр хаалтын асуудал буюу ТЭЗҮ дээр туссан тэр хэмжээгээр л нөхөн сэргээх тухай асуудлаа бүгдийг нь шийдвэрлэнэ. Тэгээд нарийн тооцоо дүнг бол яг уул нь яг Оронагийн гэрээ орж ирэх дээр нь бас яривал зүгээр байгаа юм. Тэгэхдээ одоо яг энэ асуудал дээр Уул уурхай яам, Мон-Атом хоёр хоёулаа тодорхой тайлбарыг нь хэлээд өгчих.

Д.Амарбаясгалан: Далайжаргал захирал байна уу? Мон-атомын. Цэвэгдоржийн Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: 16 хариулчих тэгээд би нэмээд хариулчихъя. Ажлын хэсгийн 16 дугаар микрофон. Гишүүний асуултад хариулъя аа.

Г.Намчинсүрэн: Цацраг идэвхт ашигт малтмал бол энэ зүгээр таны хэлж байгаатай адилхан. Бид нар бол цацраг идэвхт ашигт малтмал бол газрын ховор элементийг шууд хамруулж ойлгож болохгүй байгаад байгаа юм аа. Цацраг идэвхт ашигт малтмалд бол уран, тори зэрэг бүтээгдэхүүнийг бол хамруулж ойлгож болно. Яах вэ зүгээр энэ цөмийн бодис гэдэг дээр нь бол газрын овор гээд оруулчихсанаас болоод л ийм ойлголт авчхаад байдаг. Түрүүн бас сайд хэлсэн. Үндсэндээ бол Монгол Улсад бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 77 дугаар зарлигийн дагуу бол цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийг ашиглах бодлогыг бол ҮАБЗ-өөр, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох харилцааг бол Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлсний үндсэн дээр олгох бол харилцааг зохион байгуулаад энэ дагуу бол манай яам хэрэгжилтийг нь хангаад ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Мэндсайхан гишүүн тодруулж асууя.

З.Мэндсайхан: Туваан сайдаас асуусан асуултууддаа хариулт авмаар байна. Гол нь би энэ юу асуугаад байгаа байхгүй юу. Цөмийн энергийн тухай хууль дээр чинь 3.1.5 дээр би зохиогоод газрын ховор элемент юмыг наагаад байгаа асуудал огт биш л дээ 3.1.15 дээр цөмийн бодис гэж цөмийн технологид хэрэглэгдэх уран торын бүлийн, цацраг идэвхт изотеп, газрын ховор элемент агуулсан бодисыг хэлнэ гээд энд хууль дээрээ л ийм юм байна лээ. Тэгээдэ яагаад салгаж оруулаад байгаа юм бэ бүхэлд нь оруулж болохгүй байгаа юм уу л гэдгийг асуугаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Э.Нямдаваа: Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Нямдаваа Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Цацрагт ашигт малтмалд уран, тори зэрэг энэ байгалийн цацраг идэвхт материалуудыг бол ер нь хамруулан ойлгодог байгаа. Гэхдээ цацраг идэвхт энэ

уран, тори зэрэг маань ер нь байгаль дээрээ байнга оршин байдаг. Энгийн одоо байгалийн фон бол ерөнхийдөө 20 бекрел килограмм орчим гэж Монгол Улсын фон хэмжээнд байж байдаг. Олон улсын атомын энергийн агентлагийн стандарт мөн Монгол Улсын цацрагийн хамгаалалт аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм дээр мянган бекрел килограммаас хэрвээ бага хэмжээтэй байх юм бол хяналтаас чөлөөлнө. Байгаль орчинд нийлүүлж болно гэсэн иймэрхүү зохицуулалттай байдаг.

Хэрвээ мянган бекрел килограммаас дээшээ байх юм бол цацрагийн хамгаалалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ. Тухайн энэ төслөөс гарах цацрагт хаягдалд менежмент хийх ёстой гэсэн ийм шаардлагууд туссан байдаг.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд гүйцээж хариулъя.

Ц.Туваан: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя аа.

Энэ төр яагаад энэ олгосон тусгай зөвшөөрлөө хамгаалахгүй байна гээд. Төрийн үүрэг дотор бол мэдээж бүх л том утгаар нь бол энэ хуулийн байгууллагад энэ хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа компанийн үйл ажиллагааг шалгах, хамгаалах энэ асуудлууд нь бол явах ёстой. Та түрүүн бас хэллээ. Хууль зүйн сайд нь тэр асуудлаа тодруулна биз гэж.

Манай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хамаарах асуудлын хүрээнд бол энэ лицензийг олгох асуудал явж байгаа. Тэгээд би бас таны асуулгын хариултыг явуулсан. Дээрээс нь МАН-ын бүлэг дээр таны тодруулж асуусан асуултыг дахиад бичгээр хавсаргаад нийлүүлээд тан руу бас хүргүүлсэн. Тэрэн дээр би бас тодорхой заасан гэдгийг хэлье. Ер нь бол тэр Халзан бүргэдэйн ордын асуудал дээр бол Засгийн газраас ямар нэгэн хаасан хориглосон шийдвэр гараагүй яамнаас ч тийм шийдвэр бол гараагүй.

Д.Амарбаясгалан: Дамбын Батлут гишүүн асуулт асууя.

Д.Батлут: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал орж ирснээрээ уран бол хортой, хоргүй, Монгол Улсад ашигтай, ашиггүй, АМНАТ-ыг бол тэдэн хувиар нэмж авна үнэ зах зээлийнх нь үнэтэй холбогдуулж ингэж нэмэгдүүлнэ энгийн хувьцааг нь ийм давуу эрхийн хувьцаа болгож өөрчилнө гээд л янз янзын маргаан дэгдчихлээ. Тэгэхдээ энэ бол зүгээр улс төрийн хүрээнд л голцуу дэгдэж байна. Иргэдэд мэдээлэл алга. Эрдэмтэн мэргэдийн байр суурь үндсэндээ алга байна аа. Би энэ асуудлыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ яаралтай горимоор 10 сарын 25-нд оруулж ирээд одоо анхны хэлэлцүүлэг явж байгаа. Яаралтай горимоор ямар асуудлууд яаж орж ирдэг юм бэ? Бид иргэддээ мэдээлэл өгөхгүй инженер судлаачдын олон талын байр суурийг авалгүй ингэж хуульд хуумгай хандсанаараа эргээд энэ хууль хэрэгжих боломжгүй болчихож байгаа юм. Хөрөнгө оруулалт орж ирэх боломжгүй болгочих вий дээ.

Нөгөө нэг Халзан бүргэдэйн ордын ашиглалттай холбоотой асуудал шиг иргэдийн эсэргүүцэлтэй тулаад бүр завхарсан юм болцгоох вий дээ? Энэ бүхнийг бүгдээрээ тооцож аливаа асуудалд хандмаар байгаа юм аа. Иргэддээ зөв мэдээлэл өгье л дөө хангая. Яагаад заавал яаралтай гэж? Зөвхөн Засгийн газрын 14 мега төслийг хэрэгжүүлэх Франц Монголын хамтарсан тэр гэрээг хэрэгжүүлэх үүднээс энэ асуудалд хандаж байна гэж үзвэл илүү биеллээ олох шийдлийг гаргахын тулд олон талын байр суурийг авч үзэх ёстой шүү дээ.

Өнөөдөр Улсын Их Хурлаар 2 дахь асуудал болгож хэлэлцэх Монгол Улсын 2024-2028 оны Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөний 1.3-д ч гэсэн яг энэ байр суурийг тодорхой заагаад өгчихсөн. Бид нар удахгүй батлах гээд сууж байна шүү дээ. Үгүй энэ нэг маргаантай асуудлуудаа бүгдээрээ эцэслэе л дээ. Эцэслэж байж явъя л даа. Тэгэхгүй бол энэ чинь ингээд цаашаа улбаалаад л улбаалаад л юун бидний баталж гаргачихсан хууль хэрэгжих вэ. Хэрэгжихгүй нөхцөл байдал очно. Иргэдийн эсэргүүцэлтэй тулна. Магадгүй бүр хөрөнгө оруулалт орж ирэх нөхцөл байдлыг хаагаад хаячихвал яах вэ. Мэдээж ашиггүй юманд хэн хөрөнгө оруулах юм бэ гээд.

5 дээр нэмэх нь 9 дээд тал нь шүү дээ АМНАТ дээр. Тэгээд бодоод л үзэх хэрэгтэй. Урьд урьдын алдаан дээрээ сургамж авах нь зүйтэй гэсэн хэдий боловчиг дэлхийн жишгээр л явах ёстой гэж би харж байгаа юм.

Тийм учраас бид нар энэ асуудал дээр хуумгай хандаж болохгүй ээ. Өөр байдлаар иргэдэд мэдээллээ зөв таниулж өгөх хэрэгтэй. Эрдэмтэн мэргэдийнхээ тэр асуудлыг тал талын байр суурийг хангаж энэ чухал асуудал дээр анхаар хандуулаач гэж хүсмээр байна аа. Хэрвээ тийм ажиллагаа хийсэн бол энэ талаараа бас нэг тайлбар хэлээч нөхдөд. Магадгүй иргэдэд өгөөч энэ асуудал дээр.

Хоёрдугаарт нь Бадрах Энержи гэж компани туршилтын олборлолт хийсэн юм уу? Туршилтын олборлолт хийсэн гэдэг мэдээлэл байна. Цөмийн энергийн комиссын мэдээлэл дотор. Энэ хугацаа нь бол ирэх онд дуусах юм байна. Туршилтын олборлолтоор хэчнээн хэмжээний ураны тийм баяжмал олборлолцоод байгаа юм бэ? Ямар технологи ашигласан юм? Үүнээс үүдэлтэй байгаль болон хүнд сөрөг нөлөөлөл үзүүлсэн судалгаа байна уу? Эсвэл сөрөг нөлөө үзүүлээгүй юм уу энэ туршилтын олборлолтоор. Цаашлаад бид нар ямар технологийг авч хэрэгжүүлэх юм бэ гэдэг асуудлуудыг бас зүгээр ярих ёстой байхгүй юу. Энэ дээр нэг хариулт өгөөч. Энэ бүхэн чинь нөгөө иргэдэд зөв мэдээлэл болгож очих мессеж л байхгүй юу даа. Тэгэхгүй зүгээр бид нар нэг АМНАТ-ийн асуудлыг Монгол Улсад татвар оруулж ирэх мөнгө олж ирэх асуудлыг хөөцөлдөөд байхдаа гол биш технологийн асуудал. Цаашлаад бид ямар ямар.

Д.Амарбаясгалан: Батлут гишүүн нэмж авах юм уу? Хариулт өгье. Мон-Атомын захирал байна уу? Ажлын хэсгийн 16 дугаар микрофон.

Г.Намчинсүрэн: Батлут гишүүний асуултад хариулъя аа. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн. Туршилтын олборлолтыг бол 2 жилийн хугацаанд бол зөөж яваа төсөл дээр бол хэрэгжүүлсэн байгаа. Үндсэндээ бол нэг 10.5 тонн ураныг бол олборлосон. Тэрийгээ бол туршилтын үр дүнгээ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээр танилцуулаад одоо энэ туршилтын үр дүн дээрээс үндэслэсэн орд ашиглах ТЭЗҮ-ийн төслөө бол төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс боловсруулаад явж байгаа. Манай яамны зүгээс бол энэ хөрөнгө оруулалтын гэрээний дэд ажлын хэсгүүдэд орж байгаа төлөөллүүдийг оролцуулаад тал бүрийн мэдээллийг эрх тэгш байдлаар нь хангаад энэ хөрөнгө оруулалтын гэрээнийхээ төсөл дээр сууна гэсэн үндсэн зорилгоор сайдын тушаалаар шинжээчдийн хэсгийг бол томилоод санал, дүгнэлтийг нь бол гаргуулаад Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээрээ цаашлуулаад орд ашиглах ТЭЗҮ-ийг нь хэлэлцүүлээд явна гэсэн төлөвлөгөөтэйгөөр бол шинжээчдийн хэсгийг томилсон байгаа.

Д.Амарбаясгалан: Дамбын Батлут гишүүн тодруулж асууя.

Д.Батлут: Тэгэхээр би эхний асуулт дээрээ бараг хариулт авсангүй л дээ. Энэ эрдэмтдийн саналыг аваагүй юм байна. Иргэдэд мэдээлэл өгөөгүй юм байна. Тэгэхээр эсэргүүцэлтэй тулж л таарна бид нар. Бидний хууль тэгэхээр яах вэ хөрсөн дээрээ буухгүй байна гэсэн үг. Хэрэгжих боломжгүй болно л гэсэн үг.

Хоёрдугаарт нь зүгээр яах вэ жижүүрийн хариултаар битгий хариулаач гэж хүсмээр байгаа юм. Одоо ингээд нөгөө нэг туршилтын олборлолт нь дуусах гэж байхад бид нар одоо тэр байгаль хүнд хортой эсэхийг нь судлах багийг томилох гэж байна гээд сууж байдаг тийм ээ. Одоо магадгүй томилоо ч үгүй байгаа. Энэ асуулт асуусан учраас томилох хэрэгтэй юм байна гээд ажиллах нь л дээ. Ийм л баймааргүй байгаа юм. Бүгдийг нь нэгэн зэрэг тооцож аливаа эрсдэл бус зүйлийг тооцож ажлаа төлөвлөдөг, цаашлаад зохион байгуулалтаа хийдэг байх ёстой шүү дээ. Энэ тал дээр нэг тодорхой хариулт өгөөрэй нөхөд өө.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Д.Л.Жаргалсайхан: Асуултад хариулъя аа. Ер нь аливаа ийм үйлдвэр олборлолтын үйлдвэр туршилт хийхдээ эхлээд лабораторийн түвшинд туршилт хийгээд дараа нь тэр лабораторийн түвшинд гаргасан параметруудээ туршилтаа ийм томсгосон туршилтаар баталгаажуулаад тэгээд тэр гарсан үр дүн дээрээ үндэслэж ТЭЗҮ-ээ боловсруулдаг. Тэгэхээр у энэ төсөл яг энэ зарчмаар явж байгаа. 2021 онд Засгийн газраас үүрэг акт ШУА-д өгөөд ШУА-аас Академийн Ерөнхийлөгчийн тушаалаар бол ийм ажлын хэсэг гарсан. Ажлын хэсэг маань бол ус, хөрс, ургамал тэгээд малчдын мах, сүү, цацрагийн түвшинд ямар нөхцөл байдал байна вэ гэдгийг бол судлах яг бодит нөхцөл байдал дүгнэх ийм ажлын хэсэг байгуулагдсан. Энэ дагуу бид нар 2021 онд яг туршилт явуулж эхлэх гэж байхад бол яг шинжлэх ухааны үндэслэлтэй бүх судалгааг хийж суурь нөхцөл байдлаа гаргаад.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Л.Жаргалсайхан: Тэгээд дараа нь бол бид нар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны юу захиалгаар ШУА бол нөгөө шинжлэх ухаан технологийн захиалга төслийг хэрэгжүүлж байгаа. Бид нар 2023, 2024 онд яг өмнөх авсан цэгүүдээсээ бүх дээжүүдээ аваад ийм мониторингийн судалгаа явж байгаа. Мониторинг хийгдэж байгаа. Тэгэхээр энэнд бол бид нар туршилтын явахаас өмнө байгаль орчны суурь нөхцөл ямар байсан. Тэрний дараа ямар болсон гэдгийг ингээд явж байгаа. Ирэх жил бид нарын төсөл дуусна.

Тэгэхээр Монголд хэрэгжиж байгаа төслүүд дотроос анх удаагаа тиймээ яг энэ төсөл хэрэгжихээс өмнө суурь нөхцөл байдлыг нь тодорхойлсон ийм дэвшилттэй төсөл болж байгаа гэж би хэлмээр байна.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Жаргалсайхан.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд гүйцээж хариулъя.

Ц.Туваан: Батлут гишүүний асуултад хариулъя.

Тэгээд хүн мэдэхгүй юмныхаа дайсан гэж хэлдэг шиг ийм логиктой зүйл хэлж байна аа. Энэ маш зөв. Тэгээд түрүүн бас Мон-атомынхон хариулж байсан. 6, 7

жилийн хугацаанд бас ийм тодорхой нөгөө байгаа төсөвтөө тохируулаад л бас нэг кино хийгээд л нэг FM радиогоор явуулаад, хэвлэлийн юм хум бас хүн амьтан үзүүлээд л ингээд л явдаг. Тэгэхдээ энэ бол хангалтгүй байна аа. Өөр сайн ойлгуулъя. Тийм ээ? Ялангуяа иргэдэд. Ойрхон гаднын улс орнуудад ямар ашиглаж байгаа жишээ юу байна? Жишээлбэл бид нарт хамгийн ойрхон гэхэд Казахстан байж л байна. Энэ тэрийг бас үзүүлье.

Дээрээс нь иргэддээ бас мэдлэг олгоё. Зүгээр нэг юм хэлээд энэ чинь ашигтай ашиггүй гээд явчихдаг биш, эрдэмтдээ ашиглаад мэдлэгжүүлээд энэ чинь ийм шүү тийм шүү гэдэг нарийн мэдлэг олгож байж энэ асуудал бас эсэргүүцэл, тулах эсэргүүцэл нь явна аа. Тэгэхээр таны саналыг хүлээж аваад энэ талдаа бас цааш нь анхаараад ажиллана.

Д.Амарбаясгалан: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Ашигт малтмал шавхагддаг баялаг учраас үнэ цэн нь бол олон улсад тогтмол өснө өө. Энэ бол ойлгомжтой. Тэгэхээр миний гаргаж байгаа гол санал болохоор энэ Цөмийн энергийн тухай хуулийн 6.1-д тодорхой заасан байна л даа. Цацраг идэвхт ашигт малтмалыг ордыг хэмжээнээс нь үл хамаараад стратегийн ордод хамааруулна гээд. Тэгэхээр стратегийн ордтой адилтгаж үзэж байгаа нь Ашигт малтмалын тухай хуульд мөн зааснаар стратегийн орд гэж юу вэ гэдгийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөөлөхүйц ийм эрдэс баялгийн хуримтлал ордыг хэлнэ гэж заасан байгаа юм. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг байна. Тэгээд Ерөнхийлөгчийн зарлигаар бол 1 дүгээрт цацар гэдэгт ашигт малтмал, 2 дугаарт газрын ховор элемент, 3 дугаарт газрын тос гэсэн энэ 3 ашигт малтмалыг ҮАБЗ-д танилцуулж байх. Мөн түүгээр үл барам энийг Ашигт малтмалын газар буюу Засгийн газрын агентлаг энэ тусгай зөвшөөрлийг олгодог эрх шилжүүлдэг биш зөвхөн Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэдэг байх талаар ийм зарлиг гаргаад хэрэгжүүлээд явж байгаа мэдээллийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан дээр миний хувьд бол асуулт асууж бас мэдэж авсан.

Тэгээд үүнтэй холбоотойгоор энэнээс өмнө өнгөрсөн 7 хоногт зарчмын зөрүүтэй саналыг бас гаргаж санал хураалгасан. Эдийн засгийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр. Тэгэхээр энэ дээр жоохон ойлголт бас дутуу явсан юм шиг байна лээ. Өөрөөр хэлбэл Цөмийн энергийн тухай хуулийг өргөн барьж байгаа энэ үедээ Ерөнхийлөгчийн зарлигаар одоо зохицуулалт хийгээд явж байгаа энэ харилцааг Цөмийн энергийн тухай хуульдаа оруулж өгөх ёстой гэдэг л ийм байр суурьтай байгаа юм. Тэгээд энийг бол бас Туваан сайд хариулсан. Зарчмын хувьд бол дэмжиж байгаа гэж би ойлгож байгаа. Ашигт малтмалын тухай хуулиа шинэчилсэн энэ төслийг өргөн барихдаа үүнийг бас анхаарах хэрэгтэй байгаа юм. Өөрөөр хэлбэл тэр жонш, нүүрс гэдэг юм уу тэр бусад ашигт малтмалыг ердийн журмаараа явж байгааг ойлгож байна аа. Ганцхан үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц ийм томоохон ордыг Засгийн газар өөрөө шийддэг байя гэдэг энэ зүйл байгаа. Тэгээд Улсын Их Хурлын зөвшөөрснөөр энийг шийддэг байя гэдэг саналыг миний хувьд оруулсан боловч Их Хурал дээр бүх зүйлийг шийддэг байх нь тохиромжгүй байна гэж бас энэ санал хураалтад оролцсон Байнгын хорооны гишүүд үзсэн учраас энэ зүйлийг Ерөнхийлөгчийн зарлигаар зохицуулж байгаа энэ харилцааг энэ хуульдаа оруулаад явах нь зөв байна гэдэг л ийм л саналтай байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр би бас Туваан сайдын яг албан ёсны бас хариултыг сонсох нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгээд энэ бол бид олон зүйлээс бас сэргийлж чадна аа.

Өөрөөр хэлбэл лицензийн эзэн хэн байна. Энэ лиценз анх яаж тэр хуулийн этгээдэд очсон бэ гэдэг бол хамгийн чухал байдаг шүү. Дорнод аймаг гэхэд газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг АНУ-ын Соко гэдэг компанитай их бага нөхцөлтэйгөөр бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулаад Монгол талд ашиггүй. Тэгээд энэ нь сүүлдээ БНХАУ-ын төрийн өмчит Петро Чайна Дачин Тамсаг гэдэг компанид энэ бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүрэг шилжсэн шүү. Тэгээд үүнээс хойш энэ бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчилж чадахгүй их олон жил болж байгаа.

Тийм учраас энэ мэтчилэнгээр хуулийн зохицуулалтыг Их Их Хурал өөрөө хийх ёстой. Ард түмний мандаттай байгууллага. Их Хурал өөрөө энийг Үндсэн хуульд зааснаар энэ байгалийн баялаг бол ард түмний өмч. Ард түмний төлөөлөл буюу Улсын Их Хурал парламент. Энэ утгаараа энэ зүйл дээр бас өндөр ач холбогдол өгч байх зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа юм.

Тийм учраас энэ дээр бас ямар байр суурьтай байгааг би салбарын сайдаас асууя гэж бодож байна. Энэ зарчмын саналыг маань та бас дэмжиж байна уу, үгүй юу гэдэг талаар.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ цацраг идэвхт ашигт малтмал буюу энэ урантай холбоотой асуудлыг бол шууд хуулиараа стратегийн ордонд оруулж байгаа. Тэгэхээр бол энэ нэлээн ач холбогдол өгөх салбар зүйл гэдэгтэй санал нэг байгаа. Тэгэхээр энэний цацраг идэвхт ашигт малтмалын лиценз олгох, шилжүүлэх энэ асуудлыг бол Засгийн газар дээрээ шийдэж байх асуудлыг нь хуульд байхгүй ч гэсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Засгийн газарт чиглэл өгөөд ингээд Засгийн газар дээр шийдээд явж байгаа. Тэгэхээр таны санал бол маш зөв зүйтэй санал. Тэр нь юу вэ гэхлээр энэ асуудлаа хуульдаа оруулъя гээд. Тэгэхээр үүнийг Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга дээр Их Хурлын ажлын хэсэг оруулж байгаа. Энэ дотор яамны зүгээс таны энэ саналыг яг энэ төрлийн асуудлыг тэр нөгөө Ерөнхийлөгчийн зарлигаар биш хуульдаа бүүр тусгаж өгнө гэдэг дээр яг энэ зарчмаар явна гэдгийг хэлье.

Үүнтэй холбоотой тэр газрын ховор элемент дээр Ерөнхийлөгчийн зарлиг дотор бол энэ бодлогын асуудлыг нь танилцуулж байх гэдэг Засгийн газарт байх гэдэг ийм ангилал дээр байгаа гэдгийг хэлье ээ.

Энэ лицензтэй холбоотой асуудал. Бид бүхэн бол одоо ингээд энэ Монгол Улсын 2 дахь том хөрөнгө оруулалтын гэрээ. Энэ оюу Оюу Толгойгоос хойш хийгдэж байгаа. Тэгээд бас юу гэдэг юм ялангуяа таны сонгогдсон тойрогт байгаа Дорнод аймагт байгаа энэ БНХАУ-ын төрийн өмчит Петро Чайна Дачин Тамсаг гээд энэ компанитай холбоотой энэ гэрээ бол анх Соко компанид хайгуулын лиценз байгаад сүүлдээ тэндээс газрын тос гараад тиймээ манай Ерөнхийлөгч хүртэл очиж байгаад ингээд сүүлдээ энэ компанид худалдсан. Үүнтэйгээ дагалдаад энэ тухайн үед байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ нь цуг очсон. Түүнээс хойш 2014 онд энэ чинь 1993, 1995 онд байгуулагдсан гэрээний асуудал. Тийм ээ. Тэгэхээр түүнээс хойш 2014 онд шинээр хууль гарч ирээд энэ хуулиараа бид нар бас энэ татварын одоогийн яригдаад байгаа энэ 300 хэдэн тэрбум төгрөгийн маргааны асуудал яригдаад байгаа юм аа.

Тэгэхээр одоо бол бид нар бас нэг зарчим барихгүй бол ялангуяа Засгийн газар дээр энэ хөрөнгө оруулалтын хууль орж ирж байгаа энэ үед Монгол Улс нэг олон улсын түвшинд, олон улсад, ялангуяа энэ хөршүүддээ нэг тийм барьцгүй хүн гэж байдаг шиг нэг ийм юмнаасаа буцдаг өөрчилдөг нэг ийм нэр хүндтэй болчхоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид бүхэн баталсан хуулийг бол хууль буцаж үйлчилдэггүйгээр нэгэнт хэлэлцээр хийгээд гэрээ байгуулсан бол тэр нь яг найдвартай тогтвортой байдаг байдлаар асуудалд хандаж явахгүй бол бидэнд итгэж хөрөнгө оруулах энэ айл их цөөхөн болоод байна аа. Яагаад вэ гэхээр танайхан гэрээгээ байгуулчхаад буцаад хуульдаа өөрчлөлт оруулаад ингээд шинэ нөхцөл байдал үүсгээд.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хариулъя.

Б.Пүрэвдорж: Монгол Улс энэ давуу эрхийн хувьцаатай байгаа. Энэ бол бета эрхтэй. Өөрөөр хэлбэл ноогдол ашиг хуваарилах хувьцааг нааш цааш болгох тэр бүх асуудал дээр илүү давуу эрхтэй байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Засгийн газрын шийдвэргүйгээр манай талын хувьцаа эзэмшигчийн шийдвэргүйгээр нааш цааш шилжүүлэх тухай асуудал энэ дээр байхгүй гэсэн үг.

Хоёрдугаарт нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар өнөөдрийн хэрэгжиж байгаа Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар бүх стратегийн гэрээнүүд, ордууд бүгдээрээ хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ёстой. Тэр хөрөнгө оруулалтын гэрээнүүд бүгдээрээ Их Хурлаар орж ирнэ гэсэн үг. Тэгэхээр тун удахгүй мэдээж яг энэ хуулийг дагасан Коронагийн гэрээ орж ирэх ёстой. Тэрэн дээр нь бас яг энэ хувьцааг шилжүүлэх тухай асуудлыг бас тусгайлан оруулж оруулж ирнэ.

Д.Амарбаясгалан: Энэ нөгөө хэлэлцэх асуудал 120 минутад багтаж хэлэлцэх байсан. 50 минутаар сунгасан. Одоо 3 минут үлдсэн байна. 2 гишүүн асуулт асууж хариулт авч амжаагүй байгаа учраас Дэгийн тухай хуулиараа нэг цаг хүртэл хугацаагаар сунгах боломжтой учраас 10 минутаар нэмж сунгая. 2 гишүүнийг асуултыг нь асуулгая.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Тэгэхээр Туваан сайдаа би Ашигт малтмалын тухай хуульд бол ингээд орох юм байна, нэг.

Тэгэхээр энэ Цөмийн энергийн тухай хуулийн хөндөгдөж байгаа заалт дээр би зарчмын зөрөөтэй санал хураалгаж байгаа учраас энийгээ шийдчихээч. Зүй нь бол ингээд Ерөнхийлөгчийн зарлигаар хэрэгжиж байгаа зохицуулж байгаа зүйлийг нэгэнт энэ хуулийн өөрчлөлтөө өргөн барьж байгаа юм чинь шийдээд явах ёстой шүү дээ. Тэгээд энэ дээр би таны байр суурийг асууж байгаа. Түүнээс тэрнийг би Байнгын хорооноос асуучихсан.

Хоёрдугаарт нь хөрөнгө оруулалтын асуудал дээр ч гэсэн, энэ Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр ч гэсэн хөндөгдөнө. Яах вэ уран ашиглаж байсан туршлага Дорнодод байгаа. Дорноговьд туршилтаар ашиглаж байна. Гэхдээ нэг зүйлийг би баталгаатай хэлье. Орон нутгийн удирдлагаар ажиллаж байсан хүний хувьд энэний чинь тохиолддог саад бэрхшээлийг мэдэрч байна биеэрээ. Тийм

учраас энэ зүйл дээр анхаараач л гээд байгаа юм. Тэгэхээр энийг та бүхэн маань бас яг миний хэлж байгааг онцгой анхаараач.

Гуравт нь би танд хэлэхэд та түрүүн бас буруу мэдээлэл өгчихлөө. Ерөнхийлөгчийн нь 2015 оны зарлиг дээр энэ заачихсан байгаа шүү. Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн хайгуул олборлолтын тусгай зөвшөөрөл олгох эрх шилжүүлэх, газрын тосны хайгуул, олборлолт гээд.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд гүйцээж хариулъя.

Ц.Туваан: Энэ дээр микрофонд байр сууриа хэлье ээ. Энэ Засгийн газраас өргөн барьсан төслийн хэмжээнд асуудал явж байгаа учраас бид бүхэн яг энэ таны байр суурийг шууд санал болгоод тусгаад энэ Цөмийн энергийн хуульдаа шууд оруулж ирэх боломжгүй болоод байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууна. Түвшин гишүүнд минут үлдээх үүднээс асуулт.

Х.Баасанжаргал: Тэгье тэгье.

Миний ерөөсөө гол асуулт олон нийтийн хүлээлтийн нэг зүйл нь юу вэ гэвэл яг энэ олон нийтийн оролцоо хяналтын асуудал байгаа. Тэгэхээр бид нар олон нийтэд мэдээлэл өгч байгаагаа оролцоог нь хангаж байна гэж ойлгоод байх шиг байна л даа. Сая энэ олон хүмүүсийн асуулт хариултад сонсохоор. Хүмүүс энэ уран гэдгийг ойлгохгүй байгаа учраас эсэргүүцээд байна гээд. Ойлгохоос гадна энэ хүмүүсийг өөрсдийг нь оролцуулаад өөрсдийг нь оролцуулж хамтдаа шийдвэр гаргах ийм механизм тогтолцоо манайд зайлшгүй хэрэгтэй байна аа. Тэгэхээр одоогийн яг энэ орж ирж байгаа хуулиуд дээрээс нь цаашид энэ салбар нь өөрөө барьж байгаа бодлого дээрээ орон нутгийн иргэдийн оролцоог хангах яг ямар механизм хууль зүйн баталгааг нь би асууж байгаа. Тэгээд яг хууль зүйн баталгаа байна уу? Хуулийн төсөл дээр болоод одоогийн байгаа хууль дээр ерөөсөө ийм баталгаа ерөөсөө байхгүй байгаа.

Дээрээс нь төр дандаа уул уурхайн компани, иргэд 2-ыг хооронд нь зодолдуулаад, хоорондоо учраа ол гээд ингээд хаядаг. Энэ алдаанаасаа бид нар сургамж авах ёстой гээд байгаа юм. Төр өөрөө ерөөсөө зохицуулагчийн үүргийг л гүйцэтгэх ёстой. Тэгэхээр иргэдийг оролцуулах энэ механизм дээр яг тодорхой хариулт хэлээч ээ? Түрүүн бас хүмүүс асуугаад байхад бас яг тодорхой хариулт ерөөсөө хэлж чадахгүй байна.

Хоёрдугаарт жишээ нь малын өвчлөл, эрүүл мэндийн мониторинг тогтмол хийгээд бүрэн хяналтдаа авна гээд судлаач эрдэмтэд хариулаад байна. Үүнд бас иргэдийн оролцоо яаж байх юм? Нөгөө л нэг эрдэмтэд сууж байгаад л дүгнэлт танилцуулдаг. Үгүй энэ та нар өөрсдөө л гаргасан шүү дээ гээд л иргэд энийг чинь хүлээн зөвшөөрөхгүй шүү дээ энэ дүн дүгнэлтийг. Тэгэхээр яг энэ оролцооны асуудал дээр маш тодорхой хариулт хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Маш чухал сэдэв хөндөж байна. Хэн хариулах вэ? Иргэдийн оролцоо Энэ Мон-атомын захирал Далайжаргал захирал хаачсан юм? Энэ ажлын хэсгийн гишүүн хамгийн чухал хуулиа хэлэлцэж байхад. Цөмийн энергийн зөвлөлөөс хариулах уу? Олон нийтийн оролцоог ер нь хэрхэн яаж хангаж

байгаа вэ гэдэг асуудал хөндөгдөж байна. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон хариулт өгье.

Г.Намчинсүрэн: Олон улсын атомын энергийн агентлагийн стандарт дүрэм журмууд дээр цөмийн эрчим хүчний станц, энэ цөмийн байгууламж, тэгээд цацраг идэвхт ашигтмал буюу энэ ураны төсөл хөтөлбөрүүд дээрээ хяналт тавихад бие даасан хараат бус хяналтын байгууллага байх ёстой. Олон нийтийн итгэлийг даасан ийм байгууллага байх ёстой гэж бас заасан байдаг. Тэгэхээр энэ хяналтын байгууллага маань олон нийттэй бас хамтарч ажиллаад хамгийн гол нь энэ олон нийтийн итгэлийг хүлээсэн ийм байгууллага байх нь чухал байдаг. Олон нийтийн оролцоог хангахад бол төрийн бус байгууллагууд бас зөвлөх үйлчилгээ үзүүлж оролцож байгаа. Мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэхэд бас олон нийтийн саналыг авч батлах ийм асуудал байдаг байгаа.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах хүн байна уу? Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Я.Ганболд: Шинжээч Ганболд байна. Олон нийтийн оролцооны ялангуяа малчдын оролцооны хувьд бол би гуравхан юман дээр ярья.

Нэгдүгээрт нь 2003, 2024 онд 3 сумын 76 айлын малчидтай шууд ажилласан бид нар. Тэр хүмүүстэй шууд ажиллаад тэндээс бүх дээж, шинжилгээнийхээ юмыг аваад эргээд бид нар 3 сарын дараа, 6 сарын дараа хүн бүрд нь айл бүрд нь шинжилгээний дүнгээ танилцуулсан. Тэгэхээр энийг бид нар, малын эмч нар, мал эмнэлэг, малчид хоорондоо ажиллаж байгаа нэг хэлбэр.

Хоёрдугаарт нь болохтой зэрэг бол манай мал эмнэлэгт энэ оролцооны эпидемологи гэж энэ судалгааны арга байдаг юм. Тандан судалгааны. Энэ тандан судалгааны арга бол ерөөсөө ингээд мал эмнэлэг мэдээгүй юмыг малчид яаж мэдэж байна гэдэг 2 талаасаа энэ мэдлэгээ нийлүүлж байж тэгээд нөгөө оношилгоогоо зөв хийдэг ийм юм байгаа юм. Тэгэхээр энэ аргаар бид нар бас хамтарч ажиллаж байгаа. Цаашдаа хамтраад ажиллана. Тэгэхээр харин энэ дээр бол нөгөө бусад олон хүмүүсийг хамруулах ийм л асуудал байж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууя.

Б.Түвшин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Цөмийн энергийн хуулийн тухай Цөмийн энергийн тухай хуулийн 5.3 дээр 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй шууд эзэмшинэ гээд ингээд заачихсан байж байгаа. Энийг энэ яаравчилсан тэгээд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар болохлоороо энэ хувь хэмжээг тогтооно гэж байгаа юм. Доошгүй гэж байгаа учраас тогтоож болох л байх. Энэ нөгөө талаасаа ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах эсэх гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл 5.3-ыг юу гэж ойлгож байгаа вэ гэхлээрээ лиценз эзэмшсэн л бол үйлдвэр барьсан ч, олборлосон ч, ухсан ч, экспортолсон ч 34-өөс доошгүй хувийг төр эзэмшинэ гэсэн заасан. Энэ хуулийнхаа заалтыг улам хүчгүйдүүлээд тэр үнэ төлбөргүй эзэмшинэ гэсэн заалтыг нь ямар нэгэн юмаар орлуулах болгоод дараа нь тэр орлуулахаар барах уу бүүр ямар нэгэн өр төлбөрөөс суутгах юм шиг ийм агуулгатай болгоод байгаа энийгээ нэг тайлбарлаад өгөөч.

Ер нь 5.3-ыг яагаад ингэж үнэгүйдүүлээд байгаа юм бэ гэдэг нэгдүгээр асуулт байгаад байгаа юм.

Хоёрдугаар асуулт. Тэр энгийн хувьцааг давуу эрхтэй хувьцаанд шилжүүлнэ гээд байгаа юм. Мөнгө авах талаасаа бол давуу эрхтэй хувьцаа бол яах вэ арай амар байх. Гэхдээ компанийн үйл ажиллагаанд орох, шийдвэр гаргах, хяналт тавих гэх мэтийн бүх үндсээрээ бол энгийн хувьцаа чинь өөрөө маш давуу эрхийг олгож байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бол зөвхөн мөнгө авах талаас нь харж байгаа гэдгээрээ бол энийг бас хүчийг нь сулруулж байна аа. Энийгээ бас нэг тайлбарлаж өгөөч ээ.

Гуравдугаар асуулт шар нунтгийг эцсийн бүтээгдэхүүн гээд Засгийн газрын тогтоол байдаг юм шиг байгаа юм. Шар нунтгийг ер нь хүдэр юм уу эцсийн бүтээгдэхүүн юм уу гэдгийг нь энэ мэргэжлийн байгууллагуудаар дахиж тогтоолгохгүй бол энэ байгууллагууд ялангуяа шар нунтаг олборлосон байгууллагууд чинь нэмэгдсэн өртгийн албан татварыг 0 болгоод дээрээс нь суутган аваад нэмэгдсэн өртгийн албан татвар авч байдаг ийм төлдөг биш авдаг компаниуд болох шинжтэй байгаад байна аа.

Дөрөвдүгээрт Монгол Улсын татварын суурийг багасгаж болохгүй олон улсын гэрээний хэлэлцээр болох тэр Бепс гээд дүрэм байгаа. Бепс дүрмийн бүх заалтуудыг энэ шинэ орж ирэх хэлэлцээр дээрээ тусгахгүй бол одоогийн байдлаар бид нар яаралтайгаар татварын хувь хэмжээг нь тогтворжуулж байна. Орлогын албан татварын хувь хэмжээ элэгдэл хорогдолд тооцох хугацаа тэгээд л алдагдлыг шилжүүлэх гэсэн 3 зүйлийг тогтворжуулж байна. Яг тэр бепсийн горимыг ингээд бариад явахгүй бол дахиад цаашдаа энэ чинь өөрчлөлт орох гээд байна.

Тэгэхээр энэ талаар бепсийн горимыг яаж барих вэ? Энийгээ хэлэлцээртээ яаж тусгах вэ?

Тавдугаар асуулт бол ерөөсөө өнөөдөр бид нар Орона болон шар нунтгийг яг олборлох гээд байна, гаргах гээд байна гэдэг яаралтай горимоор оруулж ирэхээр энэ хуулиуд, ялангуяа энэ Цөмийн энергийн тухай хууль чинь өөрөө нэг компани дээр төвлөрсөн нөгөө талаасаа яг л энэний АМНАТ-ийн татварыг аль болох их авъя гэсэн хандлага дээр суурилах гээд байна. Гэтэл үүний чинь дараа энэ хуулиуд чинь үлдэнэ. Гадаад дотоодын өөр олон төрлийн хөрөнгө оруулагчид орж ирэхэд бид нар нэг компанийн нэг Кэйсийн тухай харж ярьж ярьсаар байгаад энэ хуулиудынхаа нөгөө гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад нийтлэг үйлчлэх тэр зарчмыг нь эвдээд хаячихаар харагдаад байгаа юм.

Тийм учраас ерөөсөө энэ хуулийнхаа зарчмыг цаашдаа үлдэх буюу хөрөнгө оруулагчдад нээлттэй болгох, дээрээс нь татварыг тогтворжуулахгүй байх эсэхийг нь хийх, дээрээс нь одоо байгаа хууль дээр байгаа тэр 5.3.3 гэдэг заалтыг хүчийг нь сулруулахгүй байх гэсэн ийм боломжууд байна уу гэсэн ийм асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Эрдэнэс Монгол компанийн захирал Наранцогт. Хариулт нь гуравхан минут үлдсэн байна шүү.

Х.Наранцогт: Түвшин гишүүний асуултад хариулъя. Энэ 34 хувьтай холбоотой асуудал их олон гишүүн асууж байгаа учраас нэг мөр бас ойлголт өгөхийг хичээе. Өөрөөр хэлбэл тэр 5.3-ын үнэгүй эзэмших заалт огт хөндөгдөөгүй. Энэ

боломж нь нээлттэй байгаа. Гагцхүү нэмэлтээр юу болгож байна вэ гэхлээр Оюу Толгой төсөл дээр ингээд 34 хувийг аваад ингээд үр ашиггүй өсөн нэмэгдэх АМНАТ авах ёстой байсан гэсэн шүүмжлэл мөнхийн явж байдаг. Тэгэхээр бид нар одоо энийгээ өсөн нэмэгдэх АМНАТ-аар тусгай АМНАТ-аар сольдог ийм боломжоо л нээж өгч байгаа. Ийм заалт нэмэгдэж байгаа гэдгийг бол ойлгож авах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ ганц төсөлд зориулж хуульд өөрчлөлт оруулаагүй бол дараа дараагийн төслүүдэд боломжуудыг нь нээж өгч байна гэсэн үг. Аль болох үр ашгийг нь нэмэгдүүлээд Монгол Улсад дийлэнх үр өгөөж нь нэмэгдэх байдлаар энэ аль нэг үр ашигтай илүү үр ашигтай хувилбарыг энэ Засгийн газар сонгоод тэгээд Их Хурал дээр оруулж ирээд шийдүүлнэ гэдэг ийм ойлголт байж байгаа.

Өмнөх Баялгийн сангийн хууль дээр ч гэсэн Ашигт малтмалын хууль дээр ямар их ямар хязгаарлалт яваад байсан бэ гэхээр энийгээ соливол дээд тал нь тааз нь тавхан хувь гээд таазаар нь хязгаарлачихсан байсан. Тэгэхээр энэ бол бид нар дээшээ хэдэн ч хувь байж болохуйц ийм боломжийг нээж өгч илүү үр ашигтай хувилбарыг сонгох боломжтой. Ийм боломжийг нээсэн заалтыг нэмж оруулж ирж байгаа юм аа. Тэрнээс тэр үнэгүй авах хувилбар байгаа бол тэрийгээ ашиглах боломж нь нээлттэй. Тэрийг хааж өөрчилж сулруулсан зүйл огтхон ч байхгүй гэдэг зүйлийг бол хэлэхийг хүсэж байна аа.

Тэгээд АМНАТ-тай холбоотой тайлбарыг бол Сангийн сайд олон тайлбарласан. Энэ дээр Сангийн яаман дээр нэмж тодруулаад хариулчих нь бол зөв болов уу гэж ингэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах хүн байна уу? Түвшин гишүүний асуулт болсон уу 5 асуулт асуусан чинь Наранцогт захирал базаад хариулчхав уу тиймээ? Нийтэд нь АМНАТ-тай холбоотой.

Баярлалаа. Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Санал хураалтыг Баасан гаргийн үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаанаар санал хураалт явуулна аа. 21 зарчмын зөрүүтэй санал хураалт байгаа.

Санал хураалт тус бүр дээр гишүүд маань асуулт биш үг хэлэх дэгийн зохицуулалт байгаа учраас маргааш зарчмын зөрүүтэй 21 санал хураана. Түүн дээр дэмжсэн, дэмжээгүй байр суурийг илэрхийлж байгаа гишүүд үг хэлэх боломжтой байгаа гэдгийг хэлье ээ.

15.59 цагт

Ингээд дараагийн асуудалд орёе.

2025 оны улсын төсөвтэй холбоотойгоор эцсийн найруулга сонсох асуудал байгаа. Үүнийг бас маргааш санал хураалтын ард дээр гишүүдийн ирц хангалттай байгаа үед нь эцсийн найруулгыг сонсоёе.

Ингээд шууд 3 дахь асуудал руугаа орёе. Монгол Улсын Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн ТББХ-ны дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал стратеги, төлөвлөгөөтэй байх, түүнийг боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих нь Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар заасныг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж байна аа.

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдан ажилласан 34 жилийн хугацаанд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын стратеги төлөвлөгөөг Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомж ОУПХ болон бусад орны сайн туршлагыг үндэслэн 2 удаа 2002, 2019 онуудад боловсруулж баталсан. Монгол Улсын Үндсэн хууль 2023 онд оруулсан өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүдийг 126 болгож Улсын Их хурлын сонгуулийг олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог хослуулан явуулсны үр дүнд 126 гишүүнтэй шинэ парламент байгуулагдан хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэхээс гадна өөрийн бүрэн эрхийн хугацаанд баримтлах стратегиа тодорхойлохоор Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 71 дүгээр захирамжаар Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяагаар ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, О.Цогтгэрэл, Б.Баярбаатар, А.Ганбаатар, Б.Жаргалан, Б.Найдлаа М.Нарантуяа-Нара, О.Саранчулуун, Б.Түвшин, Х.Тэмүүжин, А.Ундраа, Д.Цогтбаатар, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд, Улсын Их Хурлын ЕНБД Б.Баасандорж нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн судалгаа, дүн шинжилгээний тайлан, гадаад орнуудын парламентын стратеги, төлөвлөгөөний бүтэц, загварыг судлан, өөрийн орны онцлогтой нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан, ОУПХ-ны зөвлөмж Улсын Их Хуралд суусан суудал бүхий нам, эвслийн бүлэг, Улсын Их Хурлын гишүүдийн санал мөн иргэд олон нийтийн хамарсан 2 удаагийн хэлэлцүүлгийг оролцогчдоос ирүүлсэн саналыг тусган боловсруулсан.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурал хууль тогтоомжийг боловсруулах, төлөвлөх, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах, биелэлтэд хяналт тавих, тайлагнах бүх үе шатад хүн төвт үзэл санаанд суурилсан хүний эрхийг хангасан байх зарчим шаардлагыг тэргүүн эрэмбэд тавих, Хууль тогтоомж төрийн бодлогын баримт бичиг улс орны хөгжлийн зорилт бодлогын уялдаа залгамж чанарыг хангасан байх. Хууль тогтоох үе шатад үр нөлөөний үнэлгээнд үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийг боловсруулах, үе шатад инновац, технологийн дэвшлийг дэмжих, цаашид парламентын үйл ажиллагаанд олон ургалч үзлийг дэмжих, гишүүд төлөөллийг чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөөг хангах нөхцөл боломжийг бүрдүүлж эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгохоор Монгол Улсын Их Хурлын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг тодорхойлж, 5 зорилго,

тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх 16 зорилтыг хүрэх үр дүнгийн хамт тусгасан болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Монгол Улсын Их Хурлын 2024-2028-ын стратеги төлөвлөгөөний төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Монгол Улсын урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлтөд хамаарах эсэх, 2024 оны парламентын онцлогийг хэрхэн тодорхойлсон мөн өмнөх стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлангуудыг харьцуулсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар стратеги төлөвлөгөөний төсөлд үйл ажиллагаа шалгуур үзүүлэлтийг хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хүний эрхийн зөрчилтэй хууль тогтоомжийг боловсруулалт хэлэлцүүлгийн шатад хэрхэн засах, шударга байдал, хариуцлагын талаарх зохицуулалтыг тусгах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд хэрхэн Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг ардчилсан парламентын индикатор суурь үзүүлэлтийн талаарх дүгнэлтийг хийсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ улс төрийн нам, төрийн нам, парламентад онцгой ач холбогдолтой тул олон намын тогтолцоог бэхжүүлэхтэй холбоотой зорилго зорилтын талаар төсөлд хэрхэн тусгасан талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурал өөрийн онцлогт тохирсон стратеги төлөвлөгөө боловсруулж батлахад парламентын төлөөллийн чадавх парламентын засаглал бэхжихэд чиглэсэн байх шаардлагатайн талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөнд бэхжүүлэхэд бүтцээ чадавхжуулах, чадавхжуулахад анхаарах, стратеги төлөвлөгөөний үйл ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан судлах гаргах талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл тогтоолын төслийг дэмжиж байгаа талаар үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги, төлөвлөгөөний төсөлд тусгах санал гаргасан бөгөөд санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан саналын томъёоллын төсөлд тусгасан болно оо.

Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө. Бүх гишүүд үг хэлж, асуулт асуух эрхтэй байгаа.

Ингээд Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяагаар ахлуулсан нийт 15 Улсын Их Хурлын гишүүн орсон. Ажлын хэсэг богино хугацаанд бас нэлээн сайн ажилласан. Тэгээд өнөөдөр бас та бүхэнд танилцуулгаа хийж байна.

Ажлын хэсэгт ажлын хэсгийн даргаар Хүрэлбаатарын Булгантуяа, ажлын хэсгийн гишүүдээр Лхагвын Мөнхбаатар, Одонгийн Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар, А.Ганбаатар, Б.Жаргалан, Б.Найдалаа, М.Нарантуяа-Нара, О.Саранчулуун, Б.Түвшин, Х.Тэмүүжин, А.Ундраа, Даваагийн Цогтбаатар, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд нарын 15 гишүүн мөн Улсын Их Хурлын Тамгын газрын ЕНБД-ын бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан ажилласан.

Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүдээс гадна ажлын хэсгийн зөвлөхөөр ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан Барсүрэнгийн Баасандорж Монгол Улсын Их Хурлын ЕНБД, Раднаабазарын Алтангэрэл Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх, Чойжилсүрэнгийн Ариунхур Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга, Ундраагийн Хосжаргал ажлын хэсгийн зөвлөхөөр ажилласан. Энэ бүрэлдэхүүн танхимд хүрэлцэн ирсэн байна аа.

Асуулт асууя Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Д.Амарбаясгалан: Их Хурал стратегитай ажиллана гээд хавар шинэ хууль гаргачихсан. Тэгээд тэрнийхээ дагуу хуулиа Их Хурал өөрөө биелүүлээд ажиллаж байна. Урьд өмнө нь ийм байгаагүй. Яагаад гэхээр парламент бол нөгөө дээрээ даргатай аль нэг даргатай биш Монголын ард түмэн гэсэн ганц даргатай ардчилсан олон ургалч үзэл болсон. Үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр нь чуулган болон Байнгын хороод улс төрийн шийдвэрүүд нь намын бүлэг дээр гарч явдаг ийм манай ардчилсан тогтолцооны баталгаа болсон институц байгаа. Тийм учраас бид парламентын ардчиллыг хөгжүүлж, төлөвшүүлэх асуудал өөрөө бас манай үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасны дагуу чухал бүрэлдэхүүн хэсэг болж явдаг аа.

Бид 126 гишүүнтэй болоод илүү мэтгэлцээнтэй, илүү ургалч үзэлтэй болох чиглэл рүү явж байгаа. Тэгээд 1 зүйл анзаарагдаад байгаа нь яах вэ энэ Улсын Их Хурал их л олон ажлын хэсгүүд гаргаад байгаа юм. Их Хурлын дарга маань. Одоо 60 гарсан байх аа. Тэгээд их олон хуулийн төслүүд Их Хурлын гишүүд маань санаачилж боловсруулах чиглэлд идэвх санаачилгыг хөгжүүлж байгаа нь сайшаалтай. Хуучин бол яадаг байсан бэ гэхээр Байнгын хороодын аль нэг Байнгын хорооны биш салбар дундын асуудлуудаар жишээлбэл Газрын хууль гэхэд аль Байнгын хороо юм байгаль орчин юм уу, бэлчээр гэдгээрээ ХАА юм уу, эдийн засгийн агуулгаараа эдийн засаг юм уу, хувийн эрх зүйн суурь гэдгээрээ Хууль зүйн байнгын хороо ч гэдэг юм уу аль нэг Байнгын хороонд тухайлан харьяалуулах боломжгүй асуудлуудаар ажлын хэсэг гаргадаг байсан. Миний зүгээр санаа зовж байгаа юм нь энэ их олон ажлын хэсгүүд хэрэг дээрээ Улсын Их Хурлын дотоод бүтэц буюу Байнгын хороодыг хэрэг дээрээ хүчгүй сул болгож байгаа.

Үндсэндээ Байнгын хороодоос ажлын хэсэг гаргах шаардлагагүй болгочихсон.

Хоёрдугаарт Засгийн газар, сайд нарын эрхлэх асуудлууд хүрээний бодлогын асуудлуудыг парламент нь хариуцах юм уу, засаг хариуцах юм уу гэдэг дээр бас асуулт үлдээгээд байгаа. Жишээлбэл миний хажуу талын Наранбаатар гишүүн Ашигт малтмалын хуулийн ажлын хэсгийг боловсруулахаар ахалж байгаа юм байна лээ. Энэ парламентад орж ирэх эсэх асуудлуудыг манай Наранбаатар хариуцах юм уу? Сүүлд нь Туваан сайд хариуцах юм уу? Миний ойлгож байгаагаар Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг Лодой хариуцах юм уу? Алтангэрэл сайд хариуцах юм уу? Бие биедээ найдаад байгаа юм биш биз дээ? Эсрэгээрээ ийм асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон. ЕНБД Баасандорж хариулъя.

Б.Баасандорж: Энхбаяр гишүүний асуултад хариулъя аа Баасандорж.

Тодорхой 2 асуулт асуулаа.

Нэгт бол сая яг Энхбаяр гишүүний асуусан асуултад хариулахад Монгол Улсын Их Хурлын тухай хууль байгаа. Их Хурлын тухай хууль дээр Монгол Улсын Их Хурлын түвшинд ажлын хэсэг байгуулах, Байнгын хорооны түвшинд ажлын хэсэг байгуулах гэсэн 2 зүйл байгаа. Байнгын хороо Байнгын хорооныхоо түвшинд ажлын хэсэг байгуулах асуудал нь яг Их Хурлын тухай хуулиар явж байгаа. Мөн Их хурлын түвшинд аливаа ажлын хэсгийг байгуулахад Их Хурлын тухай хуулийн 13.1 дэх хэсгийн 13.1.11 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дарга ямар ч асуудлаар ажлын хэсэг байгуулж ажиллуулах эрх нь бол энэ хуулиар нээлттэй байдаг.

Сая сүүлийн ажлын хэсгүүдийн чиг үүрэгтэй холбоотой Засгийн газартай хэрхэн яаж уялдаж холбогдох юм бэ гэдэг зүйлийг асууж байна. Энэ ажлын хэсгүүд бол тухайн хуулийн төсөл дээр ажиллаад, тухайн хуулийн төслийн хэрэгжилттэй танилцаад, судалгаа хийгээд санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг. Санал, дүгнэлтийг холбогдох Байнгын хороон дээрээ танилцуулаад хэрвээ гишүүд шаардлагатай гэж үзвэл хуулийн төсөл цаашаа санаачилж болно. Хууль санаачлах эрхийнхээ дагуу. Хэрвээ шаардлагатай гэж үзвэл их Улсын Их Хурал болон Байнгын хороод аливаа ямар ч асуудлаар Засгийн газарт чиглэл үүрэг өгөх эрх нь өөрөө нээлттэй байдаг. Тэгэхээр энэ асуудлуудаараа зохицуулагдаад явна гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Тодруулж асууя Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Яах вэ урьд нь бол тухайн гишүүнээс нь уг нь асуудаг л байсан юм л даа. Ярилцаж байгаад. Намайг бол 7 ажлын хэсэгт оруулчихсан байна лээ надтай ерөөсөө яриагүй. Би 2 ажлын хэсэг ахалж байгаа юм байна лээ. Тендерийн хууль хийе энэ тэр гэхчхэн. Би Тендерийн хуулийг шүүмжилсэн болохоос биш тендерийн хууль ахалъя гэж ерөөсөө яриагүй шүү дээ. Тэгээд энэ чинь даргын тушаал шийдвэрээр ажилладаг ийм байгууллага бол биш. Юун дээр ажиллах ажиллахгүйг нь дарга заадаг газар бол энэ биш. Ард түмний төлөөлөгч байгаа шүү дээ. Ямар ч асуудал дээр Улсын Их Хурлын гишүүн хууль санаачилж болно. Тэр байтугай ямар ч ажлын хэсэгт орох эрхтэй байгаа байхгүй юу. Тэгэнгүүт одоо жишээлбэл 8 жил судалгаа юмыг нь хийж байгаа энэ өмч, компанийн засаглалын асуудал дээр болохоор оруулдаггүй. Дур зорго үзэмж яваад байгаа юм уу гэдэг ийм асуудал. Энэ өөрөө парламентын төлөв.../минут дуусав/.

Д.Амарбаясгалан: Сүүлийн үед чинь одоо тэгээд барин тавин гөрддөг л болчихоод байгаа юм. Энд Улсын Их Хурлын гишүүдээс, Улсын Их Хурлын Тамгын газар зар тавиад биечилж уулзаад бүгдэнгээс нь аль ажлын хэсэгт орж ажиллах вэ гэдэг саналыг нэгд нэгэнгүй авчихсан. Тэгээд л улаан цагаан гэж гөрдөж ярьдаг байдал ч бүр хэрээс хэтэрлээ л дээ. Бүх л юман дээр нотлогдоогүй янз янзын асуудлаар гөрдөнө, яах вэ тэгээд попроод яваад байж болно. Тэр гишүүний эрхийн асуудал. Тэрэн дээр ерөөсөө асуудал ярих юм байхгүй. Гол нь энэ ажлын хэсгүүдийн зорилго юу юм бэ гэхээр Монгол Улсад хэрэгжиж байгаа хууль өөрөө хүний эрхийн зөрчилтэй эсэх, тухайн салбарыг зохицуулж байгаа хууль нь өөрөө бүрэн чадамжтай. Өнөөдөр мэдээж хэрэгжээд явж байгаа хуулиуд нь аливаа талаар доголдол дутагдал байна уу үгүй юу гэдгийг судалж, дүгнэлт гаргаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачлах тэр бүх эрхийг нь 1 дүгээрт Улсын Их Хурал онцгой бүрэн эрхээрээ хууль хэлэлцэн батална, 2 дугаарт Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулиар олгогдсон хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэх тэр боломжийг нь олгож өгч байгаа юм. Харин өнгөрсөн хугацаанд хууль тогтоомжийн хуулиар Улсын Их Хурлын гишүүдийн зарим төрлийн хууль санаачлах эрхийг хязгаарлачихсан байгаа зүйл нь Улсын Их Хурлын гишүүд энэ хуулийг санаачилж ажиллах боломж хязгаарлагдмал байгаа юм.

Хуулийг хэн санаачилж орж ирээд байна гэхээр мэдээж одоо салбарын яам Засгийн газраар дамжуулж санаачилж орж ирж байгаа юм. Гэхдээ тэрийг Улсын Их Хурлын зарим гишүүд учир дутагдалтай байна. Салбарын эрх ашгийг хэт их зохицуулаад хүний эрхийн болон цаг хугацаатай холбоотой зөрчлүүд үүсээд байна энийг судлах нь зүйтэй гэсэн ийм байдлаар гаргасан байгаа. Мэдээж Улсын Их Хурлын гишүүд заавал ажиллах албагүй. Ажиллах шаардлагагүй. 60 орчим ажлын хэсэг байгуулагдсанаас 9 ажлын хэсэг маш их идэвх султай явж байгаа. Тэр дотроо 3 ажлын хэсэг огт хуралдаагүй явж байгаа. Бид бас өнгөрсөн 7 хоногт энэ чиглэл дээр бол мэдээллүүдээ авчихсан. Тэгэхээр гишүүд заавал ч үгүй ажиллах алба байхгүй ахалж ажиллахгүй гишүүнээр нь ажиллах шаардлагагүй гэж үзэж байгаа бол санал хүсэлтээ ирүүлээд ажлын хэсгийн ахлагчаас өөрчлүүлэх, ажлын хэсгийг өөр хооронд нь солих зарим ажлын хэсэгт шинээр орж ажиллах бүх нөхцөл боломж байгаа.

Хийе гэвэл арга нь олддог, хийхгүй гэвэл шалтаг нь мунддаггүй гэдэг үг байдаг. Тэгэхээр хийе гээд энэ парламент өөрөө хүн төвтэй үзэл санааг хууль эрх зүйн орчинд суулгая гээд зорьж байгаа энэ зорилго бол яав ч буруу байхгүй. Иргэдийнхээ төлөө ажиллах энэ үйлс бол бас бүтэх боломжтой бүтэмжтэй зүйл гэж ингэж үзэж байгаа гэдгийг бас хэлье ээ.

Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар асуулт асууна аа.

С.Ганбаатар: Энэ хуультай холбогдуулж нэлээн техникийн байдалтай юм асууя. Энэ Улсын Их Хурлын тогтоолын төслийн дээрх хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу л хэлэлцэх дэгтэй бололтой. Тэгээд миний тодруулж асууж байгаа зүйл гэвэл 1 дүгээрт хуралдааны товд 11 сарын 11-нээс 11 сарын 15-ны дотор энэ тогтоолын хэлэлцэх дэгийг тодорхой бичээгүй байна. Хэлэлцэх эсэх анхны хэлэлцүүлэг гэх мэт. Яг тэр дээр надад тодорхой хариулт өгөөч, надад ирсэн материалаар шүү.

Хоёрдугаарт тогтоолын үзэл баримтлал ядахдаа танилцуулга энэ дээр алга байна. Энэ дээр ер нь орж ирдэг бас нэг ийм загвартай шүү дээ. Танилцуулга үзэл баримтлал дээр ер нь ямар ойлголтууд байгаа вэ? Энэ тогтоолыг боловсруулсан

өргөн мэдүүлсэн ч бай эзэн нь би ойлгохгүй байна. Яг эзэн нь хаанаас тодорхойлж зохицуулж байгаа вэ? Тэгээд асуулт бол 1.1.2-т байна л даа. Хууль тогтоомжийг боловсруулахдаа судалгаа шинжилгээнд үндэслэсэн хүн төвт үзэл санаанд суурилсан гэж байгаа. Энэний хууль эрх зүйн тодорхойлолтыг надад бас нэг тодруулж хэлж өгөөч.

Хоёрдугаарт хууль зүйн техникийг нэвтрүүлсэн байна гэж заасан байгаа. Дараагийн өгүүлбэр дээр нь. Хууль зүйн техник боловсруулах арга ажиллагаагаа яриад байгаа юм уу? Ийм техникийн чанартай 4 асуултыг би асууж байна хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Эхний асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Бат-Эрдэнэ гишүүн хариулъя, 2 дахь асуултад ажлын хэсгийн гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн хариулъя, 3 дахь асуултад Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяа гишүүн хариулъя.

Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: ТББХ-оор ороод хэлэлцэгдээд ингээд гарч ирсэн стратеги төлөвлөгөө байгаа. Ажлын хэсэг гарсан Булгантуяа Их Хурлын дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг гараад, тэгээд үүнийгээ бол хуулийнхаа дагуу Улсын Их Хурлын дэгийнхээ дагуу ТББХ-нд оруулаад хэлэлцэгдээд ингээд гарсан асуудал байна аа. Батлагдаад гарсан асуудал байж байна.

Д.Амарбаясгалан: Баасандорж дарга хариулъя. Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон.

Б.Баасандорж: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу энэ асуудал орж байгаа. Тодруулах юм бол Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн маань 45 дугаар зүйл гэж байгаа. Тогтоолын төслийг хэрхэн яаж хэлэлцэх юм бэ гэсэн. Энэ хуулийн 45.2 дээр энэ хуулийн 45.1-д зааснаас бусад асуудлаар Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид тухайлан тухайлан заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага эрх бүхий албан тушаалтан саналаа холбогдох хуульд заасны дагуу ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо буюу Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасан байгаа. Ганбаатар гишүүн ээ. Өөрөөр хэлбэл энэ асуудал шууд ТББХ-ны асуудал учраас өргөн барих гэсэн асуудал байхгүй. Хэлэлцэх эсэх гэсэн асуудал байхгүй. Анхны хэлэлцүүлэг гэсэн асуудал байхгүй эцсийн хэлэлцүүлэг гэсэн асуудал байхгүй. Шууд Байнгын хорооноос тогтоолын төслөө боловсруулаад Байнгын хороо дэмжсэн чуулганы нэгдсэн хуралдаандаа шууд танилцуулдаг. Ийм дэгтэй юм гишүүн ээ. Дэгийн дагуу орж ирж байгаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн хариулъя. Хүн төвт үзэл.

С.Эрдэнэболд: Үзэл баримтлал гэсэн байгаа. Тэгэхээр энэ зүйл бол 2024-өөс 2028 оны ирэх 4 жилийн Монгол Улсын парламент, парламентын үйл ажиллагаа явуулах бүх процесстоо ямар шалгуурыг авч явах вэ гэдэг зүйл байгаа юм. Энэ болохоор яг хууль ч гэдэг юм уу юу гэдэг юм нийгмийн хэв журмыг зохицуулах тэр

зүйл гэхээсээ илүүтэйгээр энэ парламентаас гаргаж байгаа шийдвэрүүд өөрөө ямар шалгуурыг дээдэлдэг байх вэ гэдэг энэ зарчим. Тэр утгаараа энэ Монгол Улсын Их Хурал нийт иргэд үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэсэн, тогтвортой хөгжил, инновацад тулгуурласан, нээлттэй, олон ургалч үзлийг хангасан байна гэдэг энийгээ бид нар яаж хэрэгжүүлэх вэ гэдэг механизмаа ингээд 5 тулгууртайгаар ард нь оруулж өгөхийг зорьсон юм аа. Яагаад энэ Ганбаатар гишүүний асууж байгаа бас зохистой зүйл.

Ер нь хөгжингүй орнуудын парламентат ёс олон 100 жилээр тогтчихсон орнуудад бол яг ийм стратеги төлөвлөгөө гэж тусгайлан гаргадаг тохиолдлууд бага. Монголд яагаад энийг гаргах.

Д.Амарбаясгалан: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье гүйцээж хариулья.

С.Эрдэнэболд: Монгол Улсад яагаад энэ зайлшгүй шаардлагатай болчихсон гэхлээр бид 1992 онд Үндсэн хууль батлахдаа эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг зохицуулан хөгжүүлнэ гээд зорилгоо тавьчихсан. Гэхдээ маш олон зүйл дээр бодлогын бичиг баримт, зорилтууд, амьдрал дээр гарч байгаа шийдвэр гаргалт дээр хүмүүнлэг, иргэнлэг байх, хүнд төвтэй байх энэ бодлого нь хаягдсаар ирсэн.

Тийм ч учраас тодорхой хуулиудын үзэл санаа түүнийг дагаж гаргаж байгаа. Зарим тохиолдолд хууль дээр гишгээд байгаа журмууд дээр хүний эрх асар ихээр зөрчигдэж байгаа учраас энэ удаагийн парламентын бүрэн эрхийн хугацаанд хүний эрхийг илүү хангадаг байх энэ хүнд төвт үзлийг л олон шалгуураар шийдвэр гаргалтдаа хангая гэдэг зориулалтаар энэ бичиг баримт боловсруулагдсан байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа Сандагийн Бямбацогт гишүүн, Бямбацогт сайд асуулт асууна аа.

С.Бямбацогт: Улсын Их Хурал 2024-2028 оныхоо өөрийнхөө стратеги бодлого сая бас Эрдэнэболд гишүүн ярилаа. Ямар зарчим ямар үнэт зүйлтэй ажиллах вэ гэдгийн төлөвлөгөө батлах гэж байна. Тэгээд аливаа байгууллага болгон өөрийн гэсэн алсын хараатай, эрхэм зорилготой, үйл ажиллагаандаа баримтлах зарчимтай үнэт зүйлстэй ажилладаг аа. Тэгээд 8 дахь удаагийн парламент маань шинээр бүрдэж байгаа. Энэ шинээр бүрдээд анхныхаа чуулганаа хийж байгаа намрын чуулган. 8 удаагийн чуулган явагдаад анхных нь чуулган хийгдэж байгаа. Энэ эхэндээ энэ асуудлаа ярьж байгаа нь зөв өө. 2019-2025 оны Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө батлах ажлыг би бас ажлын хэсгийг нь ахалж бас батлуулж байсан юм. Тэгээд энд нь уг нь нээлттэй ил тод байх тэгш байдлыг хангах хэд хэдэн зарчим орсон байснаас энэ удаагийн стратеги төлөвлөгөөнд бол үндсэндээ иргэдийн оролцоог хангах гэсэн үнэт зүйл хасагдчихсан байсныг Байнгын хороон дээр оруулсан. Хамтын шийдвэрээ хүндэтгэх гэсэн зарчим 2019-2025 оны стратеги төлөвлөгөөний үнэт зүйл байсан бол энэ хасагдаж байгаа.

Энийг бас нэг анхааралдаа аваад бас анхаарчих л ёстой асуудал байгаад байгаа юм. Одоо энэ дээр санал гаргах эрх байхгүй. Яагаад гэвэл Байнгын хороон дээр санал гараад дэмжигдээгүй. Улсын Их Хурал олон олонхоороо шийдвэр гаргадаг Улсын Их Хурлын гаргасан шийдвэр хууль тогтоол болж батлагдаж Монгол

Улс даяараа Монгол Улсын иргэн болгон мөрдөх хуулийн бичиг баримт болж батлагддаг. Хуулийг хүн болгон дагаж мөрдөх үүрэгтэй. Энэ өөрсдөө хуулиа баталчхаад өөрсдөө баталсан хуулиа маргаашаас нь эхлээд шүүмжлээд, эсэргүүцээд, буруутгаад ингээд байх юм бол Улсын Их Хуралд Улсын Их Хурлын баталсан хууль тогтоомжийг хэн дагаж мөрдөх вэ. Ийм л үүднээс үндсэндээ хамтын шийдвэрийг хүндэтгэдэг байя гэдэг саналыг гаргасан юм. Энэ үүднээсээ бид нар асуудалд ханддаг байх ёстой л гэдэг зарчмыг барьж байгаа юм.

Мэдээж хамтын шийдвэр гарч хууль болж батлагдах хүртлээ хэлэлцэх эсэх хэлэлцэх эсэхийнхээ дараа ажлын хэсэг байгуулагдах шаардлагатай бол Улсын Их Хурлын Тамгын газраас хууль зүйн дүгнэлт гаргуулах, холбогдох мэргэжлийн байгууллагуудыг татаж оролцуулах эрдэмтэн судлаачдыг оролцуулах тэгж байж анхны хэлэлцүүлэг хийх, анхны хэлэлцүүлгийн явцад Байнгын хороон дээр зарчмын зөрөөтэй саналууд гаргаад, хураагдаад цөөнх болоод тэрийгээ чуулган руу оруулж асуулт гаргасан санал болгон дээр ингэж мэтгэлцэж ярилцаад ингэж байж хууль нь батлагддаг л даа. 2, 3 хэлэлцүүлэг явж байж. Энэ процессыг өшөө сайжруулах энэ дэгийн хуулиараа сайжруулах шаардлагатай байна. Ингээд ингэж олон процессоор яваад батлагдаад гарсан бол үүнийгээ л бүгдээрээ дагаж мөрддөг баймаар байгаа юм. Тэрийг л би хамтын шийдвэрийг хүндэтгэж хэлээд байгаа юм. Тэгээд энэ дээр л юу анхаарч ажиллахгүй бол сая бид нар Төсвийн хууль батлахад одоо энэ Цөмийн энергийн хууль баталж байх явцад ерөнхийдөө асуудалтай байна. Тэгээд л хам хум батлаад хаячихдаг. Ард талд нь бөөн гомдолтой бөөн шүүмжлэл.

Д.Амарбаясгалан: Бямбацогт гишүүнтэй санал 100 хувь нэг байгаа. Ер нь парламент бол мэдээж мэтгэлцээний том талбар байх ёстой хэлэлцүүлгийн шатад ялангуяа ажлын хэсэг Байнгын хороо бол маш ихээр гишүүдийн оролцоог хангаж, хэлэлцүүлгийг зохион байгуулж, гаргасан саналд нь хүндэтгэлтэй хандаж дэмжигдвэл дэмжигдэнэ, дэмжигдээгүй бол бас учир шалтгааныг ойлгуулж ажиллаж байх ийм шаардлага бол байгаа. Манай энэ парламент нэг онцлог байгаа. Гишүүд маань их сайн анзаармаар нэг зүйл нь өмнөх 8 удаагийн парламент сонгуулийн үр дүнгээр 40-өөс 45 хувь нь шинээр гишүүн болж орж ирдэг. Үлдсэн хувь бол дандаа өмнөх парламентаасаа дахин сонгогдож орж ирсэн гишүүдийн бүрэлдэхүүн байж ирсэн. Энэ 126 гишүүнтэй парламентын нэг том онцлог нь нийт гишүүдийн 70 гаруй хувь нь анх удаагаа шинээр сонгогдож орж ирсэн гишүүд байгаад байгаа юм. Тэгэхээр энэчээ бол маш олон өөрчлөлт шинэчлэлт олон ургалч үзэл санаа байнга бүх түвшинд бол гарч байгаа. Мэдээж энийгээ Байнгын хороо ажлын хэсгийн түвшинд маш сайн яриад олонхоороо нэгэнт шийдэгдсэн асуудал бол тэрэндээ илүү хүндэтгэлтэй хандаж, энэ парламентынхаа ардчилал, парламентынхаа нэр хүнд ард түмнийхээ итгэлийг хадгалж ажиллах чиглэл дээр бүх талдаа хариуцлагатай байх ёстой юм аа. Өнөөдөр бид бас зарим нэг гишүүддээ бас шүүмжлэлийн хатуу үг хэлж байгаа байдал маань ер нь тийм парламентад итгэсэн иргэдийнхээ итгэлийг бид өөрсдөө л алдагдуулна. Парламент нэг гишүүнийхээ үгийг сонсохгүй байгаа юм шиг хэлбэрээр улс төр хийж явах нь өөрөө парламентынхаа засаглалд итгэх ард иргэдийн итгэл буурах л ийм зүйл болно.

Монгол Улс парламентынхаа дархлааг улам бүр бэхжүүлэх нь зөв юм гэж өмнөх парламент үзээд Үндсэн хуулийн том өөрчлөлтийг үнэхээр том зориг гаргаж хийчихсэн. Тэгэхээр бид энэн дээрээ л илүү хариуцлагатай байх ёстой. Түүнээс ямар санал гаргаад, тэр нь дэмжигдсэн, дэмжигдээгүй гэдэг нь дараачийн асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ их тийм чухал зарчмын байр суурийг Бямбацогт гишүүн маань бас олон сонгогдсон гишүүн их туршлагатай гишүүний хувьд бас хэлж

байна. Гишүүд маань энэнд бас хүндэтгэлтэй хандаж байгаарай гэдгийг хэлэхийг хүссэн юм аа. Булгантуяа дарга хариулья.

Х.Булгантуяа: Бямбацогт дарга ТББХ-н дээр яг энэ саналыг гаргасан. 2 зарчмын зөрүүтэй санал хураалтыг явуулсан.

Нэг дэх нь үнэт зүйлс дээр иргэдийн оролцоог хангах гэдгийг нэмье гээд. Энэ дээр бид нар ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх мөн иргэдийн оролцоог хангах гээд. Энэ дэмжигдээд ТББХ-н дээр санал хураалтаар дэмжигдээд явсан.

Нөгөөх нь олонхынхоо саналыг хүндэтгэх. Хамтын шийдвэрээ хүндэтгэх гээд. Эндээс нэгэнт л Монгол Улсын Их Хурал бол өнөөдөр эндээс гарсан шийдвэр гарах юм бол Улсын Их Хурлыг хэрэлдэх битгий хэл улс орноороо дагаж мөрдөх хууль тогтоомжуудыг бид нар гаргадаг. Тийм учраас энүүн дээр давхар хамтын шийдвэрээ хүндэтгэх гэхээсээ илүүтэйгээр энэ угаасаа л ардчиллын зарчим юм гэж би зүгээр хувь хүнийхээ хувьд бас бодож байгаа юм. Манай ТББХ-н дээр ч гэсэндээ Улсын Их Хурал дээр бол нэгэнт гарсан шийдвэр цөөхөн нэг тэрүүн дээр эсрэг байр суурьтай байсан ч гэсэндээ хэрвээ хууль батлагдаад л гарвал тогтоомж Улсын Их Хурлын тогтоол ч гэсэндээ батлагдаад л гарвал энэ дагаж мөрдөх л бүхий л ард түмнээрээ л дагаж мөрдөх бид нар ийм л хууль тогтоомжуудыг гаргаж байгаа юм аа. Тэгээд энэ бол ардчиллын угаасаа үнэт зүйл зарчим учраас үүн дээр бол дахин дахин үүнийг оруулах хэрэгцээ шаардлага бол байхгүй байх. Улсын Их Хурлын тухай хууль дээр, Дэгийн тухай хууль дээр ч гэсэндээ орсон учраас гэж үзсэн. Нөгөө талдаа бид нар бас олон ургалч үзэл төлөөллийг хангах нь бас нөгөө талдаа чухал. Ялангуяа энэ удаагийн парламентад бол 5 намын улс төлөөлөл орсон, салбар салбарын төлөөлөл орсон олон ургалч үзэл санаа бол ялангуяа сая төсвийн хэлэлцүүлгийн үеэр ч гэсэндээ сая Цөмийн энергийн тухай хууль дээр ч гэсэндээ бас гарч байсан. Олон ургалч үзэл байхыг бид дэмжих ёстой, ийм ч парламент бас байх ёстой гэдэг ийм үзэл санаагаар оруулсан. Тэгэхгүй бол бас хэт хайрцаглах гээд байгаа юм шиг бас нөгөө талдаа харагдаж болохгүй болов уу.

Д.Амарбаясгалан: Тийм тийм. Булгантуяа даргатай бас санал нэг байгаа юм. Ер нь тэгээд 1 дүгээр ангийн хүүхэд ч анги дотроо санал хураагаад олонх нь асуудлаа шийдчихвэл бусад нь дагаад л явдаг шүү дээ. Тэгээд зарим нь энийг ойлгохгүй яваад байгаа байхгүй юу. Энэ чинь өөрөө парламент энэ ардчиллын үнэт зүйл гэдгийгээ бид нар их сайн ойлгох ёстой. Булгаа даргын хэлдэг үнэн үнэн. Бас их стратеги дээр оруулаад тогтоол батлаад хайрцаглаад унавал бас буруу харагдана. Олон нийт бол энийг бас зөвөөр дүгнэхгүй байж мэднэ.

Бямбацогт гишүүн тодруулж асууя.

С.Бямбацогт: Хамтын шийдвэрээ хүндэтгэх гэдэг үг орсноороо ч нэг хайрцаглагдахгүй л байх л даа. Харин ч би бас олзуурхаж байгаа 126 гишүүнтэй боллоо олон шинэ гишүүд орж ирлээ. Олон ургалч үзлээр асуудалд маш хурдан хандаж байна. Урьд нь ч Их Хуралд хэлд орох гэж жил болдог зарим нь 4 жил хэлд ордоггүй байсан бол шууд хэлд орж байна. Зоригтой үзэл бодлоо илэрхийлж байна. Маш зөв маш эрүүл хандлага юм. Ийм байх ёстой. Ганцхан энд чинь тээг болох гээд байгаа юм нь энэ бидний мэтгэлцэж байгаа энэ процесс чинь илүү жаахан тийм хаагдмал болчихоод байгаа юм биш үү? Би ингээд сая гаргасан саналаа Байнгын хороонд гаргаад л чуулган дээр энэ асуудал яригдахгүй хаагдчих гээд байгаа байхгүй юу. Ийм биш өшөө илүү дэгдээ өөрчлөлт оруулаад тийм үү өшөө илүү нөгөө бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэдэгтэй адилхан

ойлголтын зөрүү, үл ойлголцол энэ бүгдийгээ алга болгож байж шийдвэр гаргадаг. Ингээд шийдвэр гарсан бол үүнийгээ үүнийгээ хүндэтгээд байя гэж байгаа. Тэгэхгүй хэтэрхий хайрцаглагдсан хэтэрхий дэгээр явчихаар чинь үл ойлголцол дундаас шийдвэр гарчхаад тэрэндээ сэтгэл дундуураасаа болоод хамт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай гээд Улсын Их Хурлын тогтоол орж ирж байна аа. Ер нь яах вэ зүгээр уг асуудлыг ямар үзэл санаа ямар зарчим барьж, бид юуны төлөө яваа юм бэ ямар үнэт зүйлийг бэхжүүлэх гэж байгаа юм бэ гэдэг зүйлээс нь би энэ талаас нь ойлгож дэмжиж байгаа юм. Тэгэхдээ яах вэ энэ дээр нэг зүйлүүд их дутуу харагдаад байгаа юм аа. Ерөнхийдөө энэ Улсын Их Хурлын үйл ажиллагааг сайжруулах гэх юм бол сая Бямбацогт гишүүний хэлж байгаа энэ дэгийн процессын асуудлыг илүү их тодорхой нээлттэй болгохоосоо гадна энэ чиг үүргийн хуваарилалтын асуудлыг оновчтой болгомоор байна аа. Өнөөдөр жишээ нь Эдийн засгийн байнгын хороон дээр дампуурлын хууль байгаа, Газрын хууль яригдана. Компанийн асуудал ТӨК-ийн асуудал яригдана гэж байгаа мөртөө энэ цэвэр дандаа хууль зүйн үр дагавар хуулийн этгээдийн засаглалын асуудал, өмчийн эрхийн асуудал байдаг. Тэгэхээр энэ асуудлууд нь яг нарийн ньуанстай тэр Байнгын хороогоор хэлэлцэгддэггүй. Би зүгээр яах вэ жишээ авч байгаа шүү ийм зүйлүүд байна аа.

Тэгэхээр энэ Байнгын хороонуудын эрхлэх асуудлын хуваарилалтыг бас маш оновчтой болгож байж цаашдаа бас энэ парламентын бас стратеги ч гэсэн зөв болно оо. Зарим зүйлүүдийг зөвхөн ганц Байнгын хороо биш хэд хэдэн Байнгын хороогоор хамтарч хэлэлцдэг энэ асуудлыг илүү их нээлттэй болгооч гэдэг зүйлийг би бас Хурлын дарга болон Даргын зөвлөлийн дэргэдэх энэ Байнгын хорооны дарга нарт бас хандаж хэлмээр байгаа юм. Ингэж байж тал талын оролцоо нь хангагдаж байж нөгөө Бямбацогт гишүүний яриад байгаа бүгд бас мэдээлэлтэй болж байж дараа нь нэг энэ мэтгэлцээн ч гэсэн эрүүл болно оо. Зарим нь мэдээлэлтэй зарим нь мэдээлэлгүй ч гэдэг юм уу ийм зүйлээсээ болоод асуудлууд бас үүсэж байна.

Хоёрдугаарт ийм байна аа. Би одоо энэ 1992 оны Үндсэн хуулийг баталсны дараа батлагдсан энэ хавсралт хуулийг бариад сууж байна. Энэ хавсралт хуулийг 30 жил биелүүлсэнгүй гээд сая цэц дүгнэлтээ гаргаад яах аргагүй Улсын Их Хурал үүргээ биелүүлэхгүй байгаа учраас 1992 оны Үндсэн хуулиас өмнө батлагдсан 7 хуулийг чинь бид цаашдаа Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг чинь хянадаг больё гэж байна. Наад захын л энэ асуудал байхгүй юу. Бид хэд 30 жил парламент зарим зүйлүүдээ ингээд өөрсдөө хуулиа биелүүлэхгүй байгаа учраас энэ хуульд итгэх энэ итгэлийн асуудал бас цаашдаа яригдаад байгаа юм аа. Тэгэхээр энийг бас цаашдаа анхааръя.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаад ч гэсэн хийгдэх хуулиуд маань хийгдэхгүй л яваад байна шүү дээ. Энэ парламент ч асуухгүй байна. Энэ Байнгын хорооны дарга нарт үүрэг өгчихсэн байгаа. Энэний энэ тогтоолын хэрэгжилтийг хангаач гээд. Яагаад энийгээ ярьдаггүй юм. Тэгээд хэзээ Засгийн газрыг орж ирнэ гээд эсвэл дуугүй байгаад байх юм. Тэгэхээр өнөөдөр уг нь Алтангэрэл сайд байж баймаар байгаа юм. 2024-2028 оны үйл ажиллагааны чиглэлийн хамгийн цөм нь Засгийн газар хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлээ батлаад Улсын Их Хуралд танилцуулах ёстой. Ямар ямар чиглэлийн хуулиуд хэзээ орж ирэх гэж байгаагаа бид мэдэх ёстой. Ингэж байж хүн хүч бүх зүйлүүдээ хуваарилалтуудаа энэ чуулганыхаа хуралдаа намар хаврын

чуулгандаа тохируулах ёстой байхгүй юу. Энэ зүйлүүдийг би мэдмээр байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зүйлүүд байна аа.

Хоёрдугаарт энэ дээрээс бас бизнес эрхлэх хувийн эрх зүйг.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүний нэг минут нэмж өгье.

П.Сайнзориг: Хувийн эрх зүй бизнесийн эрх зүйн орчныг дэмжих гэдэг юм уу ийм зүйлүүд ерөөсөө харагдахгүй байна. Дээрээс нь одоо нэгэнт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орчихоод байгаа ногоон эдийн засаг, уур амьсгалын өөрчлөлтийн гэсэн энэ хүн төвтэй бодлого чинь ерөөсөө энэ байхгүй юу. Тэрнээс биш хүн төвтэй гэж яриад бичээд нэмэргүй. Бид хэд энэ чиглэл рүүгээ хууль эрх зүйн орчноо бүрдүүлнэ гэдэг концепцыг барьж байж дараа дараагийн хууль санаачилж байгаа хүмүүс чинь ногоон эдийн засаг уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах чиглэлдээ бас орж ирэх юм аа. Ингээд бүтцийн хувьд уг нь бас нэг цаашдаа энэ стратеги төлөвлөгөө дээр орчих ёстой юм байгаа юм.

Би Үндсэн хуулийн дэд хороо гэж байгуулмаар байгаа юм. Энэ өөрөөр хэлэх юм блд орж ирж байгаа энэ олон улсын гэрээнүүдийг соёрхон батлахаас өмнө үздэг. Энэ Үндсэн хуулийн хяналтыг бас цаашдаа бас урьдчилж бас нэг харах энэ механизмыг сайжруулах үүднээс энэ Солонгосын парламентын жишиг шиг ийм зүйлүүдийг уг нь хийсэн бас байгаа.

Хоёрдугаарт энэ хууль батлах квотын асуудал хуулийн этгээдийн төрлөөс чинь хамаарч байгаа юм. Кодекс гэх юм бол энэ ерөөсөө эрх шилжүүлэх заалт оруулж болохгүй байхгүй юу. Тэгээд энэ зүйлийг байхгүй учраас Энхбаяр гишүүн жишээ нь.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүнтэй бас санал нэг байгаа нь одоо бас энэ Улсын Их Хурлын Байнгын хороо Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан дээр аливаа асуудал орж ирж хэлэлцэхдээ бас хангалттай цагийг бас зарцуулж чадахгүй байгаад байгаа ийм тал бас байгаад байгаа юм. Тэгээд хууль өөрөө өргөн баригдсан нөхцөл дээрээ бас гишүүдийн саналаар тэр бүр өөрчлөлтүүд ороод байх нөхцөл хангалттай бас гардаггүй. Энэнд бас Улсын Их Хурлын гишүүд их бухимддаг. Тэгэхээр энэ хуульд дүгнэлт гаргах судлах энэ ажлын хэсгүүд байгуулагдаж байгаа нь яг Сайнзориг гишүүний саяын хэлээд байгаа сул талыг нөхөх гэж үзэж байна гэсэн үг. Улсын Их Хурлын гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг Улсын Их Хурлын гишүүдийн орсон ажлын хэсэг мэргэжлийн судалгааны байгууллагатай, мэргэжлийн эрдэмтэд судлаачидтай, парламентын дэргэдэх судалгаа хөгжлийн хүрээлэнтэй хамтарч ажиллаад тэр хуулийн талын бүх талынх нь судалгааг бүрэн хийж оруулж ирж байгаа юм. Ний нуугүй хэлэхэд салбарын яамнаас өргөн баригдаж орж ирж хэлэлцүүлэгдэж байгаа хууль, салбарын байгууллагын эрх ашгийг хэт их зохицуулсан хуулиуд л орж ирдэг.

Гэтэл иргэд бол хуулиа хэрэглэмээр байна. Хуулиар хуулийн засаглалд эрх тэгш амьдармаар байна гэдэг энэ асуудлуудыг ярьдаг учраас бидний энэ стратеги бол маш томоохон алхам болно гэж ингэж бол үзэж байгаа юм. Монгол Улсад өнөөдөр 880 хуультай, 2768 журамтайгаар нийгмийн харилцааг зохицуулалт хийж байгаа юм. Энэ дотор бол ерөөсөө маш ойлгомжтой нэг л зүйл байгаа юм. Өндөр хөгжилтэй улс орнууд аливаа төрлийн хэм хэмжээг зөвхөн хуулиар зохицуулна л гэж байгаа юм. Зарим төрлийн процессыг журмаар зохицуулж болдог. Гэтэл манайд өнөөдөр 30 хувь нь хуулиар зохицуулалт хийгээд, 70 хувь нь журмаар зохицуулж

байгаа байдал бол өнөөдөр энэ авлигал, хүнд суртал арилахгүй байгаагийн үндсэн учир шалтгаан байна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг энэ стратегийнхаа хүрээнд маш идэвхтэй хурдтай ажиллаад ирэх 4 жилийн хугацаанд бид энэ томоохон хуулиудад хүн төвт үзэл санааг суулгах, хүнийхээ эрх, эрх чөлөөг бүрэн баталгаажуулж хамгаалах, салбарын хууль зөвхөн салбарын асуудлыг зохицуулах биш тэр хуулийг хэрэглэж байгаа оролцогч бүх талын эрхийг зөв зохицуулдаг болгоход бүгдээрээ идэвхийлэн ажиллах нь зөв юм гэсэн. Ийм байдлаар Сайнзориг гишүүний асуултад хариулчихъя.

Тодруулга Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд бас яг иймэрхүү дэвшилтэт байдлаар хэдүүлээ цаашдаа дэг энэ тэрээ өөрчилнө гэж байгаадаа бас таатай байна аа. Тэгээд би ч гэсэн энэ хууль, тогтоомжийг батлах квотын асуудлыг 50 дээр нэмэх нь нэг биш. Энэ органик хууль гээд хуулийн этгээдийн төрлөөсөө хамаарч батлах ёстой. Энэ Үндсэн хууль дээр энэ үзэл санаа байж байж руль оф лоу баталгаажна аа. Ингэж байж хууль эрх зүйн орчин тогтвортой байна гэдэг мессежийг гаднын хөрөнгө оруулагчид өгнө өө энэний төлөө бас явна гэдэг зүйлийг бас хэлмээр байгаа юм. Тэгээд ерөнхийдөө бас 1 зүйлийг бас техникийн хувьд бас манай Тамгын газрынхан анхаарчхаасай гэж. Цэцийн болоод Ерөнхийлөгчийн хоригийг авах эсэх асуудал дээр үндэслэл бичиж сурцгаая аа. Тэрнээс биш Цэцийн шийдвэрийг авахгүй авах авна гэдэг ганцхан юм хариулчихаар үндэслэлээ хэлээч. Яагаад авахгүй байгаа юм бэ гэдэг зүйлүүд ингээд явж байна.

Тэгэхээр бид хэдийн гаргаж байгаа шийдвэр хүртэл яг энэ хууль тогтоох байгууллагуудын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх энэ Үндсэн хуулийн дээд хяналтын байгууллага дээр хүртэл үл ойлголцлууд гарах юм аа. Тэгэхээр энэ дээрээ бас анхаарч цаашдаа Цэцийн шийдвэрийг хүлээж авахдаа үндэслэлээ бичиж Улсын Их Хурлын тогтоол дээрээ авах эсэхээ шийддэг.

Д.Амарбаясгалан: Булгантуяа дарга ажлын хэсгийн ахлагч хариулт өгье.

Сайнзориг гишүүнтэй санал нэг байна. Манай ТББХ-н дээр Батбаатар гишүүн бас ярьж байсан. Ер нь энэ Өнөөдрийн Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуульдаа л бид нар стратеги төлөвлөгөөгөө боловсруулж байгаа юм уу эс үгүй бол стратеги төлөвлөгөөндөө хүрэхийн тулд бид нар шаардлагатай бол бусад зарим нэг хуулиудад өөрчлөлт оруулна гэж та бүхэн харж байгаа юм уу гээд. Тэгээд би бол стратеги төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх нь Улсын Их Хурлын хувьд нэн чухал асуудал гэж бодож байгаа. Бид нар олон ургалч үзлийг дэмжсэн гээд. Тэгээд бид нар өнгөрсөн хавар Дэгийн тухай хуулийг жишээлбэл бид нар анх удаагаа нөгөө 126 гишүүнтэй олон намын төлөөлөл уг нь орж ирнэ гэж угаасаа харж байсан учраас Дэгийн тухай хуулийг хийсэн. Тэгэхдээ өнгөрсөн парламентад бас алдаатай оноотой зүйл бас байхыг үгүйсгэхгүй. Шинэ парламент өөрснөө өөрийнхөө дэгийн тухай хуулийг явцын дунд харж байгаад сайжруулах асуудал байж болох юм гэж тухайн үед бас үзэж байсан.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулах бусад олон хуулиуд батлагдаж чадаагүй нь бас үнэн. Энэ түрүүний шүүмжлээд байгаа Улсын Их Хурал дээр энэ олон хуулийн ажлын хэсгүүд гарах шаардлагатай байгаа юм уу үгүй юм уу гэдэг асуудлууд үүний нэг жишээ. Засгийн газраас л хууль орж ирвэл Улсын Их Хурал хэлэлцдэг. Нэг бодлын өнгөрсөн парламентад бас нэг ийм юу үүсэж байсан юм. Улсын Их Хурал нэг Засгийн газрын хуулийн хэлтэс шиг л ажилладаг

боллоо. Алдаа оноо, цэг таслалыг нь хянаад л сууж байдаг бид нар ер нь хүмүүс боллоо гэж. Уг нь энд нам, намын төлөөлөл, салбар салбарын төлөөлөл болсон хүмүүс байж байгаа юм чинь бид ч гэсэндээ энэ хууль боловсруулахад оролцдог тэгэхдээ энүүнийг хийхэд тодорхой хэмжээний Улсын Их Хурлын гишүүд хоорондоо нэгдээд энүүнд ингээд судалгаатай, нотолгоотой ингээд хийх нь зүйтэй.

Хэрвээ Засгийн газраас түрүүлээд өргөн баривал сайн л биз. Энэ нь Улсын Их Хуралд бэлэн болчихсон энэ чиглэлээр судалгаа хийчихсэн, мэргэшчихсэн яваад ажиллачихсан ийм гишүүдтэй байна гэдэг бол энэ хууль улам сайн батлагдахад л нэмэртэй гэсэн үг. Нэг талаасаа Засгийн газраас өргөн барьж байгаа хуулиуд маань хуулиа батлуулахын тулд нөгөө Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу судалгаа хийх ёстой гэхээр. Яг л нөгөө өөрийнхөө хуулийг батлуулах гээд л тэр чиглэлээрээ л судалгаа хийгээд өргөн барьчихдаг. Бид нөгөө талаасаа одоо яг энэ хууль нь яагаад өргөн барьсан хууль нь болохгүй вэ гэдэг талаарх нөгөө талын судалгааг бид нар ер нь сайн хийж хардаггүй. Яг эрх ашиг нь хөндөгдөөд байгаа Улсын Их Хурал дээр ирээд байгаа өргөдөл гомдолтой иргэд олон нийтээс бид нар руу л гол өргөдөл гомдлууд ирж байгаа шүү дээ. Үүнтэй уялдуулж бид нар судалгаа хийж хардаггүй учраас хэдийгээр ийм олон хуулиуд батлагдаад байгаа ч гэсэндээ иргэдийн бухимдал өндөр байгаад байгаа нь л харагдаж байна гэсэн үг.

Тийм учраас бид аль болохоор Улсын Их Хурал дээр энэ холбогдох хуулиудаа стратеги төлөвлөгөө боловсруулахад чиглүүлж улам сайжруулах шаардлага байвал сайжруулах нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна аа.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын стратеги, төлөвлөгөөг ТББХ-н дээр бас хэлэлцэж байх үед зөвхөн хууль тогтоох чиг үүргээс илүүтэй бас өмнөх парламентын үед суурь нь тавигдсан хянан шалгах чиг үүргийг илүү бэхжүүлэх талаар саналаа бас оруулсан байгаа юм. Тэгээд ер нь бид нар бас энэ парламентын ардчилалыг бэхжүүлэхийг нь тулд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тогтолцоогоо бид нар өөрчилсөн тогтолцооны шинэчлэл хийсэн бол энэ тогтолцооны шинэчлэлийн үр дүнд Улсын Их Хурлын үйл ажиллагаа чанарын хувьд өшөө ахисан байх ёстой гэсэн энэ хүлээлт бол ард иргэдийн хувьд ч гэсэн бидний хувьд ч гэсэн угаасаа хүлээгдэж байгаа тиймээ? Тэгэхээр чанарын шинэ түвшинд гарахын тулд буюу ард иргэдэд илүү ээлтэй хүн төвтэй юу гэдэг юм энэ хууль тогтоомжийг гаргадаг байя илүү соргог ажилладаг байя гэдэг энэ гадагшаагаа чиглэсэн асуудлуудыг энэ стратеги төлөвлөгөөнд бас нэлээн сайн тусгасан байна гэж харж байгаа юм. Гэхдээ энэ их олон ажлуудыг бид нар хийхийн тулд дотоод зохион байгуулалт маань оновчтой байх ёстой тэгж байж бид нар одоо энэ стратеги төлөвлөгөөний Улсын Их Хурлын үйл ажиллагаа, үр нөлөө дээшилнэ гэсэн. Энийгээ бид нар биелүүлж чадна. Тэгээд чанарын өөр түвшинд гарах юм бол яг л чанарын өөр түвшинд бид нар зохион байгуулалтаа сайн хийх ёстой гэж үзэж байгаа юм. Тэгээд өмнөх шигээ хуучин арга барилаар биш одоо энэ яг шинэ тогтолцоондоо таарсан нээлттэй хэлэлцүүлгүүдийг хийдэг, нээлттэй бодлогын мэтгэлцээнүүдийг хийдэг байхгүй бол бид нар энэ хүлээлтэд хүрч чадахгүй юм. Нөгөө талаар бид нар энэ одоо дотоод зохион байгуулалт маань ямар байх юм гэдэг дээр бас анхаармаар байна.

Улсын Их Хурал болон мэргэжлийн Байнгын хороодоороо дамжуулж үйл ажиллагаагаа явуулдаг тэгээд чуулган дээрээ эцэслэж шийдвэрлэдэг ийм

байгууллага. Бүлгийн хурал дээр улс төрийнх нь шийдвэр гардаг. Гэтэл одоо бол ямар байна гэхээр бүлэг дээр ажлын хэсэг гардаг. Байнгын хороон дээр ажлын хэсэг гардаг. Улсын Их Хурлын даргын 54 гээд ажлын хэсэг гардаг. Хууль тогтоох бас хянан шалгах асуудлаар. Тэгэхээр энэ нэг асуудал дээр ингээд олон асуудлууд байхаар энэ хоорондоо яаж уялдаа холбоотой байх юм бэ гэдэг асуудал бол бас их сонин байгаа юм. Жишээ нь эрүүдэн шүүлттэй холбоотой энэ асуудлаар бүлэг дээр ажлын хэсэгтэй, 54 ажлын хэсэг дотор байна. Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо гээд мэргэшсэн Байнгын хороод нь байна. Энэ дээрээ бид нар сонсгол хийнэ гээд тэгж байгаа. Эд нарынхаа уялдаа холбоог бид нар бас сайн хангаж ажиллахгүй бол нөгөө бид нарын зорьж байгаа мэргэжлийн Байнгын хороон дээр гол хэлэлцүүлгүүд яваад чуулган дээрээ бодлогын мэтгэлцээний явдаг энэ чиглэл рүү явъя гэсэн сонгодог парламентын ардчилал энэ чиглэл маань явахгүй илүү хаус байдал руу орчих вий дээ гэсэн санаа зовнил байгаа. Тэгэхээр бид дараа дараагийнхаа энэ төлөвлөгөөг хэрвээ жил болгон батална гэж байгаа бол энэ Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалтын асуудал дээр бас нэлээн сайн анхаарах ёстой болов уу гэсэн саналтай байна.

Хоёрдугаарт түрүүн бас халти дурдагдлаа энэ хууль тогтоох процесс ба Улсын Их Хурлын шийдвэр гаргах.

Д.Амарбаясгалан: Номинчимэг гишүүнд нэг минут нэмж өгье.

О.Номинчимэг: Шийдвэр гаргалтын процессоо бид нар бас ил илүү ил тод болгомоор байна. Ер нь бидний том хууль орж ирлээ асуудлууд орж ирлээ. Хамгийн гол нэгж энэ дээр ажиллаж байгаа ажлын хэсэг байдаг. Тэгээд иргэдээс болон ААН-үүдээс энэ хууль тогтоох процесс дээр хамгийн их ирдэг санал гомдол бол хууль орлоо. Ямархуу концепцтой орсныг нь бол бид нар харж байгаа. Нээлттэй. Тэгтэл ажлын хэсэг дээр нэг зарчмын зөрөөтэй санал гээд тэрийгээ Байнгын хороон дээрээ нэг өдрийн дотор хураалгаад ажлын хэсгийн хуралдаан чинь нээлттэй биш шүү дээ тэ. Тэгээд чуулган дээрээ маргааш өдөр нь ингээд хураачихдаг. Бид нар юу болов гэдгийг мэдээгүй байж байтал концепцоосоо шал өөр зарчмын зөрүүтэй саналыг ажлын хэсэг гаргаад Байнгын хороон дээрээ хураалгаад юу болов гээд тэгээд ярилцах одоо хэлэлцүүлэг хийх завдалгүй Улсын Их Хурлаар баталчихдаг аа. Тэгэхээр энэ нөгөө ажлын хэсэг дээр байгаа ямар зарчмын зөрүүтэй саналууд яагаад гарав гэдгийг бассон стейкхолдерууд буюу нөлөөлөл үзүүлэх гэж байгаа иргэддээ танилцуулаад хэлэлцүүлээд ингээд явдаг сайн хэлэлцүүлэгтэй процесс байхгүй бол маргааш.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуулт асууна.

У.Отгонбаяр: Өдрийн мэнд хүргэе. Стратеги төлөвлөгөө үндсэндээ энэ шинэ парламент анхныхаа стратеги төлөвлөгөөг батлах гэж байна. Урьд нь бол 2002, 2019 онуудад бас баталж байсан. Стратеги төлөвлөгөө гэдэг бол парламентаас гарч байгаа хууль тогтоомжийн үндсэн тулгуур зарчим ямар байх юм бэ гэдгийг тодорхойлсон ийм маш чухал бодлогын баримт бичиг. Өнөөдөр бид бүхэн тал талаас нь ярилцаж байгаад санал асуултаа асууж байгаад энэ төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө батлагдах байх л даа. Энэ өөрөө энэ стратеги төлөвлөгөөний бас амин сүнс нь энэ парламентын дархлаа олон ургалч үзэл ардчиллын зарчим байх ёстой гэж би хувьдаа бас ойлгож байгаа.

Тийм ч учраас энэ стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа бас олон талаас нь олон зүйлийг бас судалж тусгасан байх гэж бодож байна 1 дүгээрт дэлхийн чиг

хандлага олон улсын өнөөгийн түвшин ямар байгааг судалж үзэв үү? Ажлын хэсэг. Судалсан бол үндсэн тулгуур зарчим юу байх юм. Стратеги төлөвлөгөөнд хэрхэн яаж тусгав гэдэг дээр бас та бүгд маань бас нэг хариулт өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Отгонбаяр гишүүн үг хэллээ. Асуулт асуулаа. Булгантуяа дарга хариулах уу? Ажлын хэсгийн дарга.

Х.Булгантуяа: Өмнө нь манай парламент 2002 онд, 2019 онд стратеги төлөвлөгөөгөө баталж байсан. 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараагаар ялангуяа бид Улсын Их Хурлын хяналт шалгалтыг сайжруулах нээлттэй дээрээс нь би цахимжих гэх мэтчилэн олон зорилго зорилтууд тавигдаж байсан. Тэдгээр нь бол ялангуяа олон нийтийн зүгээс нэлээд сайшаагдаж үнэлэгдсэн байсан. Бид нар өнгөрсөн 4 жилийн стратеги төлөвлөгөөгөө бас авч ингээд харахад. Нөгөө талдаа тэгэхдээ стратеги төлөвлөгөөг нь бараг 60 гаруй хувь нь дотогшоогоо илүү их чиглэсэн байсан. Энэ удаагийн стратеги төлөвлөгөөг бид нар 60, 70 орчим хувь нь үйл ажиллагаа нь илүү их гадагшаагаа чиглэсэн батлагдаж байгаа хууль тогтоомжуудаа олон нийтэд хүргэх гэх мэтчилэн эдгээр рүү илүү их чиглэгдлээ. Бид олон улсын парламентын холбооны гишүүн 1962 оноос хойш энэ байгууллагын гишүүнээр ажилласан. Үүн дээр бид бас энэ стратеги төлөвлөгөөгөө сая олон улсын парламентын хуралд манай Улсын Их Хурлаас бас очиж оролцсон. Энэ дээр бид нар ОУПХ-ноос бас стратеги төлөвлөгөөгөө танилцуулж үүн дээр санал авсан байгаа юм.

Дэлхийн улс орнуудаас түрүүн бас Эрдэнэболд гишүүн хэлж байсан. Бүр парламент нь төлөвшөөд үйл ажиллагаа нь стратеги төлөвлөгөө шаардлагагүй болчихсон ийм улс орнуудын хувьд стратеги төлөвлөгөөгүйгээр явж байна. Нөгөө талдаа бид нар шинэ энэ Үндсэн хуулиар шинэ 126 гишүүнтэй ийм парламент бүрдсэн цаг үед хэдийгээр Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль байгаа ч гэсэндээ энэ 4 жилд энэ шинэ парламент юу хийх гэж байгаа юм бэ ямар үр дүнд хүрэх гэж байгаа юм бэ гэдгийг бид нар өөрөө өөрсдөдөө бас төлөвлөж энэ төлөвлөгөөгөө гаргаж өгөх ёстой. Үүнийгээ дагаад жил болгон ТББХ-оор бид төлөвлөгөөгөө батлуулна. Жишээлбэл хүний эрхийн зөрчилтэй байгаа зүйл заалтууд байгаа энүүнийг аль аль Байнгын хороон дээр харьяалагдах ямар ямар хуулиуд байна гээд үүнийг нь жил жилээр бүр хувааж өгөөд энэ нэг нэгдсэн журмаар манай ТББХ баталдаг. Араас нь хэрэгжилт дээр нь хяналт тавьдаг ТББХ ийм байя гэж бас бид үзэж байгаа юм аа.

Тэгээд олон улсын хэд хэдэн улс орнуудын бид нар стратеги төлөвлөгөөнүүдийг судлаад дэлхийн чиг хандлага илүү их парламент нь нээлттэй илүү их цахимжсан дата мэдээллийг их өгөгдлийг илүү их ашигласан дээрээс нь ингээд олон ургалч үзлийг илүү их дэмжсэн бас ийм парламентыг байхыг ер нь бүгд зорьж байгаа. Сая бол дэлхий даяар 2024 онд бараг улс орнуудын тал нь шахам сонгууль явагдлаа. Тэгэхээр үүний дараагаар их олон ургалч парламентууд дэлхий даяар яг л манай Монгол шиг бий болж байгааг бас бид нар үүнийг бас хүлээж авч хүлээн зөвшөөрч Үндсэн хууль дээр стратеги төлөвлөгөө дээр бас тусгасан байж байгаа.

Д.Амарбаясгалан: Ухнаагийн Отгонбаяр гишүүн тодруулж асууя.

У.Отгонбаяр: Ер нь олон улсын чиг хандлага бол ер нь одоо Жанжин шугам нь хүн төвтэй зарчим руугаа ер нь түлхүү явж байгаа юм билээ. Тийм учраас бас би энэ дээр бас энэ чиглэл рүү нэлээн зүйлүүд бас тусгагдсаныг бас сая бас олж харж

байна аа. Тэгээд цаашдаа бас бид бүхний бас нэг онцгой анхаарах хэсэг бол энэ парламентын боловсрол гэж энэ стратегийн 5 дээр хүрэх үр дүн дээр Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмж парламентын боловсрол олгох тогтолцоо бүрдсэн байна гэж хүрэх үр дүнд нь тэгж заасан байна.

Тийм учраас цаашдаа нарийвчилсан төлөвлөгөө гарч ажиллана. Энэ дээр энэ парламентын боловсрол олгох энэ чиглэл рүү бүр онцгой анхаарч ажиллах бас зайлшгүй шаардлага байгаа. Энэний ард парламентын дархлаа гэж нэг том зүйл байгаа. Тэрүүгээр дамжуулж энэ боловсролоор парламентын.

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн алга байна. Нанзадын Наранбаатар гишүүн алга байна. Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууна аа.

М.Мандхай: Нэг санал 2 асуулт байна аа. Ямар ч институц байгууллага стратеги төлөвлөгөөгүйгээр явахгүй ээ. Тэгэхээр бас Улсын Их Хурал ирэх 4 жилийнхээ хийх ажлын стратеги төлөвлөгөөг боловсруулаад ингэж гаргаж ирж танилцуулж байгаа нь өөрөө маш зөв зүйтэй зүйл гэж бодож байна. Тэгэхээр энийг хэрэгжүүлэх нь түрүүн бас Энхбаяр гишүүн ч гэсэн нэг талаараа бас зөв юм хөндсөн.

Дээрээс нь нэмээд хэлэхэд энэ 11 Байнгын хороод бол энэ олон асуудал хэлэлцэж байгаа олон хууль хэлэлцэж байгаа дээрээс нь бид нар бодлого тодорхойлох гэж байгаа нөхцөлд 11 Байнгын хороо салбар дундын асуудлуудыг гээх орхигдуулах бас бүрэн бас нарийн орж чадахгүй ийм асуудлууд байдаг учраас энэ стратеги төлөвлөгөөний хүрээнд хийж хэрэгжүүлэх гэж байгаа энэ олон шинэчилж байгаа хууль дээр 54 ажлын хэсэг гарах нь өөрөө маш зөв зүйтэй бүтэц гэж би харж байгаа. Яагаад гэхлээр үндсэндээ бол Засгийн газрын энэ уялдаа холбоог хангуулах дата мэдээллийг нарийвчилж авахын тулд энэ ажлын хэсэг өөрөө маш том бас үүрэг гүйцэтгэж байгаа гэж харж байна. Тэгээд энэ стратеги төлөвлөгөөтэй холбоотой нэг 2 асуулт байгаа нь юу вэ гэхээр Улсын Их Хурлын үйл ажиллагааг бид иргэд олон нийтэд хүргэдэг. Гэхдээ энэ хүргэхдээ энэ иргэдэд хандсан энэ зорилтуудыг бол тусгасан байгаа юу?

Яагаад гэхээр томъёоллын харахаар маш ерөнхий томъёололтой. Дээрээс нь танилцуулга нарийвчилсан танилцуулга байхгүй учраас тодотгож асууж байгаа. Тэгээд одоо байгаагаасаа ерөнхийдөө энэ сайжруулж орж ирсэн үү? Мөн бид бас гадагшаага мэдээллээ хүргэж байгаа мөртөө нөгөө талдаа гаднаас мэдээллийг бид нар Улсын Их Хурлын гишүүд бас тэр болгон авч чаддаггүй. Жишээлбэл иргэд бизнес, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагууд одоо энэ хууль тогтоомжтой холбоотой асуудал хэлэлцэж байгаа энэ асуудлуудтай холбоотой мэдээлэл өгөх тулгамдаж байгаа асуудлуудаа өгөхийн тулд бид нарт тэр болгон мэдээлэл ирдэггүй учраас энэтэй холбоотой асуудлыг яаж энэ мэдээллийг бид нар авдаг байх юм. Тайлан хэлбэрээр авдаг байх юм уу, гишүүд яаж энэ бодитой яг тулгамдаж байгаа асуудлуудыг мэддэг байх вэ гэдэг дээр энэ стратеги төлөвлөгөө дээр тусгагдсан уу гэдгийг бас ажлын хэсгийн гишүүдээс асуумаар байна. Яагаад гэхлээр стратегийн зорилго 2 дээр хүрэх үр дүн нь тэр 2.1.4, стратегийн зорилго 4 дээр 4.1 хангагдах шаардлагатай байгаа учраас энэтэй холбоотой асуулт асууя.

Д.Амарбаясгалан: Сүхбаатар Эрдэнэболд гишүүн хариулъя.

С.Эрдэнэболд: Мандхай гишүүн аягүй чухал асуулт асууж байна аа. Маш энгийнээр бол парламентын засаглал, парламент ёсыг бэхжүүлэх, олон ургалч үзлийг дэмжих ардчиллын амин сүнс болсон энэ тогтолцоогоо хамгаалахад бид ер

нь ямар зарчмыг ямар шалгуурыг шийдвэр гаргалтдаа авч явах юм бэ? Түүнд иргэдийн оролцоо иргэдэд нээлттэй байх тайлагнадаг байх. Ингэхдээ шинжлэх ухаанд суурилсан дээрээс нь цахим боломжийг өргөн хүрээнд ашигласан гэдэг дээр бол энэ стратегийн бичиг баримт чиглэж байгаа юм аа. Өмнө нь бол одоо иргэдийн түгээмэл шүүмжлэлүүд байна. Иргэд юм хүсээд байдаг шийдвэр гаргалт хүсээд байдаг. Парламентын гишүүдийг дарга гээд бодчихдог. Зарим тохиолдолд гишүүд нь ч өөрсдийгөө дарга гээд бодчихдог. Энэ 2-ын дунд нөгөө иргэдийг төлөөлөх иргэдийн өмнө тулгамдсан асуудал бэрхшээлийг бодлогын шийдвэр болгож гаргаж амьдралд хэрэгжих тэр зохицуулалтыг хийх нь өөрөө бид нарт хамгийн чухал байгаад байгаа.

Тийм учраас энэ стратеги төлөвлөгөөнд Улсын Их Хурлын үнэт зүйл дээр ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх, иргэдийн оролцоог хангах, ёс зүйтэй, хариуцлагатай хариуцан тайлагнадаг байх гэсэн энэ зарчмууд тусгагдаж байгаа. Тэгээд та түрүүн хэлж байгаа тэр 3.1 дээр бол энэ хуулийн төслийг хэлэлцэх, батлах, биелэлтэд хяналт тавих гээд нийтэд сурталчлах гээд энэ бүх үе шатад бид нар аль болохуйц энэ мэдээллийн цусны эргэлт шиг энэ урсгалыг инновацад суурилсан технологийн дэвшлийг дэмжиж ашиглах нь өөрөө асар чухал байгаад байгаа. Тэгэхээр иргэдэд эргэх холбоотой маш зөөлөн чигтэй парламент байх нь, Иргэдийн үзэл бодлыг сонсдог байх нь энэ стратегийн нэг амин чухал зүйл.

Тэр 3.3-д бол тэр цахим парламентыг хөгжүүлэх бодлогыг тууштай баримтлах талаар тусгасан. Таны хэлж байгаа сая 5 дугаар зорилго дээр бол Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа үр нөлөөг дээшлүүлэх зорилгыг бол олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх, парламентын боловсрол олгох, сурталчлах, таниулах нийгмийн хэрэгцээ гэдэг дээр маш их ач холбогдол өгч байгаа. Тэгээд түрүүн бас Сайнзориг гишүүн эд нар хэлж байна лээ. Хүнд төвт гэдэг бол ногоон хөгжил уур амьсгал гээд. Нэгэнтээ Засгийн газрын хөтөлбөрт орчихсон байж байгаа зүйлүүдийг энд авчирч бид нар бол ингээд овоолох гээгүй. Зөвхөн Улсын Их Хурлаас гарч байгаа бодлогын шийдвэрийн эхлэлээс өгсүүлээд төгсгөл хүртэлх энэ процесс нь өөрөө хүний эрхийг дээдэлсэн энэ шалгуурыг л хангадаг болчихъё гэж байгаа.

Ихэнх Их Хурлын гишүүд бас шүүмжлэлтэй хандаж байгаа нь яагаад энэ энэ зүйлүүд оруулаагүй юм бэ гэж асуугаад байгаа. Бид нар бүхнийг оруулах шаардлагагүй гагцхүү бид нар энэ 4 жилийн хугацаанд ямар зарчим шалгуурыг тэргүүн эрэмбэ болгож авч үзэх ёстой юм бэ гэдгийг л энд оруулж байгаа юм шүү. Үүнийг та бүхэн ойлгоорой. 2050 он хүртэлх манай алсын хараа хөтөлбөр байгаа. Энэ дээр бол 3 үе шат байгаа. Үе шат болгон нь өөрөө парламентын засаглалыг ингээд апгрид гэж хэлж байгаа тийм үү? Сайжруулж явна гэсэн зорилтууд байгаа. Тэгэхээр эд нар бол 2028 он хүртэл жишээлбэл энэ хөтөлбөр маань стратеги маань хэрэгжих гэж гэж байгаа ч гэсэн 2030 он хүртэл энэ дунд хугацааны хөтөлбөртөө бид нар бас тусгаж байгаа. Монгол Улсын урт хугацааны дунд хугацааны бодлогын 11 бичиг баримтад энэ стратегиа нийцүүлж гаргаж байгаа юм аа. Тэр олон ажлын хэсэг гээд шүүмжлээд байгаа юм. Энэ дээр бид нар нэг ийм рентгенээр скрийнээр, ингээд MRI-д хүн эрүүл мэндээ хардаг шиг Монголын энэ парламентын энэ засаглалыг чадавхжуулахад бид хаана нь юу нь болоод байгаа болохгүй байна гэдгээ бас тооцох ийм шинжилгээ өгөх шаардлагатай болчихсон байгаад байгаа юм.

Тэгээд ингээд нэгдсэн уялдаатай шийдвэр гаргалтыг парламентаас гаргадаг болохгүй бол хуулиуд нь хоорондоо зөрчилдөөд хүний эрхийг зөрчөөд байдаг журмууд нь хоорондоо зөрчилдөөд байдаг. Дарга нь хуулиасаа том журмаасаа том болчихсон шийдвэр гаргалт яваад байна аа. Энэ дээр л бид нар бас нэг парламент

хазаарлах хязгаарлах гэхдээ нээлттэй, ил тод, иргэндээ ойрхон байх шийдвэр гаргалтыг л энэ стратегиараа бид нар шалгуур үзүүлэлт болгоё гэсэн байгаа.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандухай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Би яах вэ ингэсэн л дээ нөгөө яг үнэн хэлэхэд Улсын Их Хурлын гишүүд тэр болгон иргэд бизнес энд ТББ иргэний нийгмийн байгууллагуудтай уулзаад яг энэ хэрэгжиж байгаа хууль тогтоомж хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой мэдээллийг тэр болгон авч чаддаггүй шүү дээ. Тэгэхлээр ядаж энэ өөрөө стратеги төлөвлөгөөгөөр дамжуулаад бид нар энэ төлөөллөөс яаж мэдээллийг бодитой цаг алдахгүй авдаг байх вэ? Бид нарт тодорхой хэмжээнд Улсын Их Хурлын гишүүдэд тайлан хэлбэрээр өгөх юм уу? Цаг үеийн мэдээллийг и мэйлээр бид нар авдаг байх юм уу? Бид нар яг ингээд цаг үетэйгээ холбогдож байгаа мэдээллийг зүгээр сошиалаар ийм шүүлтүүргүй мэдээлэл авдаг учраас үнэн зөв бодитой тэр болгон дээр бид нар хяналт тавьж чадахгүй.

Тийм учраас энэ дээр ажлын хэсэг яаж энэ стратеги төлөвлөгөөндөө тэр мэдээллийн урсгалыг цаг алдахгүй байхаар.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн гүйцээж хариулъя.

С.Эрдэнэболд: Энэ маш чухал асуудал Мандухай гишүүнээ та бас чухал асуудал хөндөж байна. 1992 оноос хойш өнөөдрийн хугацаанд 34 жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурал нийтдээ 82400 өргөдөл гомдлыг хүлээж авсан байдаг юм байна лээ. Сүүлийн 4 жилд зөвхөн хүний эрхийн чиглэлээр ирсэн иргэдийн өргөдөл гомдол 103, тэрний дөчөөдийг нь цагдаагийн газар 50 гарныг нь прокурор руу шилжүүлсэн байгаа юм. Ер нь бол уламжлалт ёсоор шийдвэр гаргалтад иргэд үзэл бодлоо илэрхийлдэг гэдэг бол нэг бичгээр ингээд бичдэг. Нөгөөдөх нь ингээд аягүй удаан процесс туулдаг. Дунд нь ямар нэгэн байдлаар даргын ширээн дээр уддаг шийдвэр гаргалт уддаг. Ингээд цаг хугацааны нөгөө алдагдал гээд байгаа чинь энд тулгамдаад байгаа юм. Тэгээд тухайлбал жишээлбэл бид нар ингээд энэ стратеги дотор энийг цахимжуулъя. Одоо жишээлбэл 2 төрлийн платформ явж байгаа. Нэг нь болох иргэд тодорхой асуудал дээр гарын үсэг цахим гарын үсэг цуглуулаад бодлого боловсруулах шийдвэр гаргалтад нөлөөлдөг байх нэг боломж байгаа.

Нөгөөдөх нь ди парламент буюу бид нарын өнөөдрийн хэлэлцүүлэгт иргэд тодорхой.

Д.Амарбаясгалан: Эрдэнэболд гишүүн гүйцээж хариулъя.

С.Эрдэнэболд: Тийм иргэд бол энд ингээд хандаж байгаа. Гэхдээ нэг асуудал байгаад байгаа нь бид нар нөгөө цахим веб сайт суурьтай яваад байгаа. Гэтэл иргэд мэдээллийнхээ 80, 90 хувийг сошиал медиагаар аваад байгаа. Тэгэхээр ирэх жилийн 1 дүгээр улиралд багтааж иргэдийн өргөдөл гомдол дээр респонсив буюу олон төхөөрөмжид нийцсэн ийм өргөдөл, гомдлын платформыг авах, санал авах энэ платформыг бид нар хөгжүүлэх гэж байгаа. Энд бол Улсын Их Хурлын тамгын газар, ЗГХЭГ, ХЗДХЯ, Цахим хөгжлийн яам, ХЭҮК, Хүний эрхийн дэд хороо гээд хамтарсан ажлын хэсэг байгуулаад илүү хурдтай, шуурхай, иргэдийн үзэл бодлыг шийдвэр гаргалтдаа тусгадаг байх энэ л платформыг бид нар дээр оруулж байгаа.

Тэгэхээр энэ стратеги батлагдсаны дараагаар нарийн ажлын төлөвлөгөөнүүд гараад явна аа. Энэ төлөвлөгөөг бол бид нар Улсын Их Хурлын Тамгын газраараа дамжуулаад гишүүддээ мэдээлээд явах юм байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна аа.

Л.Соронзонболд: Ингээд стратегийн бичиг баримттай танилцахаар зарчмаа л стратеги болгочихсон юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл ямар ч хуулийг боловсруулах бүх үе шатад баримтлах ёстой зарчмууд байгаа. Тэр зарчмаа Стратеги 1, 2, 3, 4, 5 гээд болгочихсон гэж харагдаад байгаа юм. Тэгээд уул нь стратеги гэхээрээ би ойлгохдоо бол эдийн засгийн хувьд бол байгаа хууль эрх зүйн орчноо сайжруулаад гадаадын хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр хөрөнгө оруулагч татах чиглэлээр бид нар яг юу хийх юм бэ ч гэдэг юм уу. Нийгмийн энэ боловсрол, эрүүл мэндийн асуудал дээр байгаа хууль эрх зүйн асуудал бид нар яг юу хийх ёстой юм бэ? Энд ирэх тэр 4 жилийн хугацаанд гээд. Ийм байдлаар энэ стратеги маань гарах ёстой юм шиг л харагдаад байгаа юм. Тэгээд ингээд харахаар яг ингээд ямар ч хууль боловсруулахад шаардлага баримтлах ёстой зарчмаа стратеги болгочихсон харагдаад байгаа нэг ийм дутагдал харагдаад байна аа. Энэ дээр тайлбар өгөөч.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын дэд дарга, ажлын хэсгийн дарга Булгантуяа гишүүн хариулъя.

Х.Булгантуяа: Яах вэ зарчим маань алдагдаад байгаа болохоор л энийг бид нар ямар ч байсан энэ 4 жилийн хугацаанд тэгэхдээ ахиад бид нар таны хэлж байгаа үнэн. 4, 4 жилээр ахиад бид нар хувааж үнийг нь авч үзнэ. Жишээлбэл манай хууль тогтоомж дээр хүний эрх, эрх чөлөөг сайжруулахад ямар хуулиудын ямар зүйл заалтууд нь болохгүй байгаа юм бэ гэдгийг нь дүн шинжилгээнүүдийг нь гаргаад Хууль зүйн яам энийгээ өөрснөө ч гаргаж чадахгүй байгаа юм. Тэгээд 1 хэсэг эрдэмтэн судлаачдын гаргасан тоог энэ зөв буруу гэж яриад байгаа юм. Уг нь бол энүүнийг Хууль зүйн яам өөрөө энүүнийг хийчихсэн байх ёстой байхгүй юу. Аль хуулийн хэчнээн зүйл заалт нь зөрчилтэй байгаа юм бэ гэдгийг өөрснөө хийхгүй бол хөндлөнгөөс л тэрийг чинь үнэлнэ. Үнэлсэн байгууллагын тоог бид нар аваад ярихаас өөр аргагүй болно гэсэн үг.

Дээрээс нь нэмээд ил тод нээлттэй хүртээмжтэй байдал нь хангагдахгүй байгаа нь үнэн. Улсын Их Хурал дээр нэг ер нь чуулган 100 гаруй хууль тогтоомжууд баталдаг. Энэ талаар иргэд олон нийтийн зүгээс төдийлөн сайн мэдээлэл байхгүй. Түрүүний Мандхай гишүүний хэлж байгаа яг ад яг үнэн. Энд манайтай холбоотой хууль батлагдаад дуусчихсаныг саяхан сонслоо шүү дээ бид нар гэж ярьж байгаа мэргэжлийн төрийн бус байгууллагууд ч гэсэн зөндөө их байдаг. Тэгэхээр аль болохоор бидний яах вэ энэ удаагийн 4 жилийн парламент бол илүү их нөгөө оролцоог нь хангая, ингэе, тэгье. Энэ бол бүх салбарт л хамаарагдана нөгөө талдаа бид нар бас гүйцэтгэх засаглал биш ээ. Тэгэхээр бид нар үүнийг жишээлбэл юу гэдэг юм ДНБ-ий өсөлтийг тэдэн хувьд аваачна гэдэг бол тооцооллынх нь гүйцэтгэх засаглал хийгээд энд эрх зүйн орчныг нь бид нар гаргаж өгөхийн төлөө л ажиллана гэсэн үг. Харин эрх зүйн орчноо бид нар сайжруулахын төлөө ийм ийм гол зарчмуудыг баримтална. Энэ нь цаашаагаа Байнгын хороо болгон дээр ийм ийм ажлууд хийгдэнэ гэдэг ийм л зарчмаар бид явъя гэж байгаа юм. Эдийн засгийн байнгын хороон дээр гэхэд жишээлбэл нөгөө тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд жишээлбэл эдийн засгийн өсөлтийг сайжруулахад саад болоод байгаа хууль процессын манай алдаа дутагдлууд байвал тэрүүнийгээ л бид нар

сайжруулах ажлыг л Улсын Их Хурал дээр хийнэ гэсэн үг. Хууль тогтоомжийн хуулийн дагуу уг нь бид нар, ялангуяа нөгөө Транспаренси гримтийг ил тод байдлын гэрээг АНУ-тай энэ тэр байгуулахад хөрөнгө оруулалтад чиглэгдэж байгаа хуульд өөрчлөлт оруулахад хэлэлцүүлгүүд хийнэ энэ тэр гээд л. Уг нь манай хууль дээр байгаа юм л даа. Тэгэхдээ харамсалтай нь тэгж чадахгүй л байгаа. Тэр үнэн. Тэгэхээр энэ ядаж хэлэлцүүлгүүдээ хийхгүй бараг Улсын Их Хурал энэ хуулиудыг нь хүлээж авдаггүй. Энэ хэлэлцүүлэг хийсээр байгаад Улсын Их Хурал нь баталдаггүй бараг тэрүүнийг хүлээн зөвшөөрдөггүй болж байж л бид нар энэ хууль тогтоомжууд нь гардаггүй болж байж л бид нар үүнийг хийнэ.

Нөгөө талдаа нэг ийм зовлон бас байна лээ. Түрүүн Мандхай гишүүний асуулт дээр нэмж хариулахад нөгөө талдаа Улсын Их Хурал зарим нэг хууль тогтоомжуудыг хэлэлцэх гэхээр мэргэжлийн төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллага нь бас яг хэн нь юм бэ гэдэг нь их тодорхойгүй. Жишээлбэл ингээд зарим нэг би өнгөрсөн парламентад харж байхад татварын зөвлөх, үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ гээд л. Тэгэхэд 100 гаруйхан мэргэжилтэнтэй яг тэр салбарын. Тэгээд нөгөөдөх нь 2-оос 3 ТББ-д хуваарилагдчихдаг, хуваачихдаг. Тэгээд нэгэнтэй нь уулзахаар нөгөөдөх нь уурлаад байдаг. Тэгээд 1 удаа нэг хууль батлах гэж аль ТББ-тай нь ажиллах нь их хэцүү.

Тийм ч учраас энэ удаагийн парламентад бид нар Худалдаа аж үйлдвэрийн танхимын, Үйлдвэрчний эвлэлийн гээд салбар салбарын төлөөллүүдийг бас урьж оролцуулж байгаа нь бид нар энэ хэлэлцүүлгүүдийг хийхэд их нэмэртэй юм болов уу. Ингээд дээрээс нь нэмээд Холбоо сангийн тухай хууль, Мэргэжлийн байгууллагын тухай хууль, ТББ-ын тухай хууль гээд эд нар нэг жоохон бас нэг учиртай болохгүй бол бид нар яг аль холбоотой нь ажиллах ёстой юм уу, сантай нь ажиллах ёстой юм уу, танхимтай нь ажиллах ёстой юм уу, хэнтэй нь ажиллах ёстой юм гэдэг нь бас их тодорхойгүй. Тэгээд манай холбогдох Байнгын хороод нөгөө ажлын хэсгийн гишүүд салбарын яам нь ч гэсэн хэнийг урьж энэ хэлэлцүүлэгт оролцуулах вэ гэдэг нь их хэцүү. Тэгээд нөгөө түрүүний хэлсэнчлэн 100 хүн дотроо 3 хуваагдчихаар л бид нар хэнтэй нь ажиллах нь хүртэл тодорхойгүй болчихоод бас байдаг аа.

Тэгэхээр энэ удаагийн яах вэ стратеги төлөвлөгөө гэдэг бараг уг нь 2 тусдаа л эд л дээ. Бодлогын стратеги нь нэг тусдаа. Ажлын төлөвлөгөө гэдэг нь нэг тусдаа. Тэгээд бид нар бол энэ удаа илүү их стратегиа батлаад төлөвлөгөө нь жил жилээр тусдаа батлагдаад энүүнийг нь Байнгын хороо, Байнгын хороодоороо байна аа. Тэгээд үүн дээр бас Соронзонболд гишүүн Эдийн засгийн байнгын хорооноос гэхэд яг саналаа өгөөд энэ.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууна аа.

Б.Уянга: Стратеги төлөвлөгөөний төсөл дээр Монгол Улсын Их Хурлын алсын харааг харах нь Монгол Улсын Их Хурал эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлнэ. Хүн төвт бодлогыг эрхэмлэн Монголын ард түмний засаглах эрхийг хангана гээд. Ер нь бол ойлгоход хялбар тэгэхдээ агуулга нь их өргөн. Ийм алсын хараа тэгээд ер нь стратеги төлөвлөгөө ч гэсэн ойлгоход их амархан хялбар байна гэж хэлэхийг хүссэн юм. Гэхдээ ер нь энэ Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөний төсөл маань энэ Монгол Улсын бусад бодлогын баримт бичигтэй хэрхэн нийцэж байгаа вэ? Энийг ажлын хэсгээс тодруулахыг хүссэн юм. Алсын хараа 2050 тэгээд бас сая батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй хэр нийцэж байгаа вэ? Яах вэ Улсын Их Хурлын стратеги

төлөвлөгөө тэгээд өөрсдөө бид нар батална гэж байгаа ч гэсэндээ нөгөө хүний эрхийг хангах үзэл санааг шингээсэн тэр хууль эрх зүй бичиг баримтыг Засгийн газраас оруулж ирэх ёстой учраас ингэж бас асуумаар байна. Ер нь бол бодлогын бичиг баримтуудтай бодлогын уялдаа холбоо хэрхэн хангагдаж байгаа вэ? Энийг тодруулах гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Энэ ХЗБХ-ны дарга манай Дамдины Цогтбаатар гишүүн Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээр бас нэр бүхий гишүүдийн хамтаар ажиллаж байгаа юм. Яг тэр дээр бол ер нь бид 1992 оны Үндсэн хуулиа батлахдаа хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлнэ гэсэн зорилго тавиад тэр яг өнөөдрийг хүртэл бүрэн хангагдаж ялангуяа хууль эрх зүйн орчиндоо баталгаажсан уу үгүй юу гэдэг дээр бид бас анхаарч харах шаардлагатай зарим зүйл байгаа учраас цаашид өргөн баригдах хууль Үндсэн хуулиар олгогдсон хүний үндсэн эрхийг зөрчиж байгаа эсэх дээр тогтмол дүгнэлт гаргадаг тэр хэлбэр рүү бол шилжих нь зүйтэй юм байна. Цаашдаа ер нь энэ хууль өөрөө би түрүүнд хэлсэн байгууллагын зохицуулалтыг хийдэг биш. Боловсролын хуулиар Боловсролын сайд Их Сургуулийн захирлыг яаж томилох вэ гэдгийг зохицуулдаг биш суралцагч хүүхдийн, суралцагч оюутны, эрхийг хэрхэн хангаж хамгаалах вэ гэдэг энэ үзэл санаа руу суулгаж өгөх ажил явж байгаа нь бидний энэ нэгдүгээрх стратеги, хоёрдугаарх хууль тогтоомжийн хуулийн өөрчлөлтийн гол утга учир нь орших юм гэж ингэж бол үзэж байгаа гэдгийг бас хариулт болгоод хэлчихье ээ.

Эрдэнэболд гишүүн нэмж хариулах уу? Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн хариулъя.

С.Эрдэнэболд: Болдын Уянгаа гишүүн маш чухал асуулт тавьж байна аа. Ер нь бол бид нар ингээд баахан тунхаг, уриа лоозон болоод ялангуяа сонгуулийн өмнө бол ингээд л иргэдэд очоод л аягүй гоё гоё үлгэр ярьдаг. Тэгэхдээ сонгуулийн дараа бодит амьдрал хэрэгжилт 2 зөрөөд байдаг аа. Тэгэхээр энэ удаагийн парламентад бол хамгийн гол зүйл бол энэ урт, богино, дунд хугацааны бодлогын бичиг баримт нь амьдралд хэрэгждэг. Нөгөө хүн төвтэй байх ёстой тэр бодлого нь бол эдийн засгийн агуулгаараа ч улс төрийн агуулгаараа ч нийгэм соёлын агуулгаараа ч эрх чөлөөний агуулгаараа ч амьдрал дээр хэрэгждэг байх нь асар чухал байгаа.

Тийм учраас энэ алсын харааны 2050-ийн засаглалын чиглэлийн зорилт байгаа. Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг, тогтвортой засаглал гээд. Дээрээс нь цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжих гээд. Улмаар хүний эрхийг бүрэн хангасан шударга ёсны тогтолцоо, төлөвшсөн, авлигагүй улс гээд. Эдгээр зарчмуудыг бол энэ зорилгыг бол бас стратегийг бас уялдуулж байгаа. Мэдээж 1921-1930 он, 1931-1940, 1941-1950 онд бол парламентыг бол энэ алсын хараан дээр тодорхойлсон байгаа. Тухайлбал 1930 он хүртэл бид нар Улсын Их Хурлын хууль тогтоох бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чадавх сайжирсан энэ парламентын төлөө явна гэдэг зорилгыг бид нар батлаад явж байдаг. 2031-2040 онд бол хариуцлагатай, мэргэшсэн ёс зүйтэй гишүүдээр Улсын Их Хурлыг бүрдүүлэх 2041-2050 онд бол ард түмний засаглах эрхийг хангасан. Итгэл хүлээсэн Улсын Их Хурал төлөвшинө өө гээд ийм зорилтууд байгаад байгаа юм.

Тэгэхдээ эдгээр зорилтуудыг бол мөрөөдөл чигээр нь үлдээхгүй бодлогын хэрэгжилт бодит амьдрал дээрх биелэл болгохын тулд энэ стратеги маань яг шүүлтүүр байдлаар ажиллана л гэсэн үг. Одоо ингээд бид нар бол мэдээж

маргаантай олон галтай сэдвүүд орж ирлээ гэхэд сая жишээлбэл төсвийн асуудлууд орж ирлээ гэхэд энэний шалгуур нь өөрөө нөгөө хүн төвтэй буюу хүнлэг энэрэнгүй нийгэм рүүгээ бүхий л салаа мөчрөөр буюу энэ шийдвэр гаргалтаар энэ шүүлтүүрийг л давдаг байхгүй бол болохгүй байна гэдэг санаа явж байгаа юм аа. Сая энэ 8 сарын 30-ны өдөр Засгийн газрын 4 жилийн хөтөлбөрийг бид нар бас баталсан.

Тэрний 4.1.1 дээр хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого дээр бид нар энэ хүний эрхийг бүх талаар хангахыг зааж өгсөн. Мөн Монгол Улсын энэ хүний эрхийн 2 дугаар үндэсний хөтөлбөрийг батална гээд ингээд зорилгууд тавьчихсан байж байгаа. Тэгэхээр аль болохоор энэ олон талд явж байгаа бодлогын бичиг баримтууд дээрээ уялдуулж нарийн тэр зохицуулалтуудыг нь хангаж, давхардал, хийдэлгүйгээр. Ямар нэгэн логикийн зөрчил алдаа тэр байтугай хэл зүй, найруулга томъёоллын хувьд нэр томъёоны хувьд хүртэл бид бид нар бас ингээд л аль болохоор давхар шинжих гэж үзсэн юм байгаа юм аа. Ямар ч байсан бол стратегийн бодлогын бичиг баримтуудтай бол уялдуулаад явж байгаа. Тэгээд мэдээж энэ төлөвлөгөөний юу стратегийн дарааллын төлөвлөгөөнүүд жил жилдээ жишээлбэл ТББХ-оор ороод явахаар байгаа. Энэ дээрээ бол яг бүүр нарийвчилсан тооцоо судалгаа нь Их Хурал Засгийн газар болон бусад энэ бодлогын бичиг баримтуудтайгаа хэрэгжилтийг нь яаж уялдуулах вэ гэдэг асуудлууд яригдах байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Ринчэндоржийн Батболд гишүүн алга байна. Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууна аа.

Ж.Галбадрах: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. 2019-2024 оны стратеги төлөвлөгөөтэй танилцсан. 6 зорилготой 12 зорилт нэг 60-аад үйл ажиллагаа төлөвлөсөн байсан. Тэгээд биелэлт нь ер нь хэр байсан бэ гэдгийг тодруу. Тэрэн дээрээс маш сайн биелэлттэй байсан. Ер нь биелэлт нь хэдэн хувьтай вэ гэдгийг бас сонирхож байна. Тэрэн дотор зорилго 2 дотор Улсын Их Хурлын хянан шалгах үр дүнг дээшлүүлэх гэсэн том зорилтын доор жишээлбэл 2.1.4 гэсэн нэг ийм хэрэгжүүлэх арга хэмжээ байсан. Энэ дотор бол улсын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад тавих Улсын Их Хурлын хяналтын үйл ажиллагааг төгөлдөржүүлнэ гээд маш их тодорхой заасан байсан. Тэгээд бид бол шинэ гишүүдийн хувьд анхны төсөвт сая орлоо оролцлоо. Тэгээд энэ үнэхээр ийм төгөлдөржсөн зүйл байсан уу гэвэл тийм харагдсангүй. Маш их мэдээлэл дутуу тооцоолол нь бид нарт хангалттай ирсэнгүй. Тэгээд төлөвлөлтөө л бид нар ингээд хийлээ. Одоо цаашаа хуваарилалт тэр зарцуулалтад Их Хурлын гишүүний хувиар оролцоод явах тал дээр энэ төгөлдөржүүлэх гэдэг энэ зорилт хэр биелсэн юм бэ гэдгийг асуумаар байна. Энэ талын юм бол тодорхой үйл ажиллагаагаар 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд ороогүй бол харагдаж байна. Энэ 5 зорилго дотор. Тэгэхдээ энийг Байнгын хороон дээрээ бас энэ үйл ажиллагаануудаа төлөвлөнө өө гэсэн нэг зүйл харсан.

Тэгэхээр одоо бол бид нар чинь ийм юм байна шүү дээ энэ зарчмын зөрүүтэй санал жишээлбэл гаргая. Тэгээд энэ зүйлийг дахиж оруулж ирье гэх ийм бололцоогүй юм байна. Харин ийм том бичиг баримт байгууллагын стратеги төлөвлөгөө хэлэлцэж байх үед бид нарын дуу хоолой бас надаас болсон ч байж магадгүй. Тэгэхдээ би одоо ажлын хэсэгт орсонгүй. Байнгын хороонд байсангүй. Ийм учраас энэ дээр бол санал хэлж чадсангүй нь харамсалтай байна аа.

Шинэ ажлын хэсгийн тэр алсын хараа үнэт зүйлсийг уншаад үнэхээр энд их ойлгомжтой тийм тодорхой зүйлүүд орсон байна. Ялангуяа хүн төвт бодлогыг эрхэмлэнэ гээд. Хүнээ хөгжүүлэхийг бол нэгдүгээрт тавьж байгаа нь маш сайшаалтай байна. Үнэт зүйл дотор бол хүний эрх эрх чөлөөг баталгаажуулна гэсэн. Тэгээд энэ зүйлүүд маань ийм нэг их гоё үг лоозон болоод явчих вий. Үнэхээр одоо бид нар яг цаг үеэ олсон ийм чухал зүйлийг тавьсан байгаа учраас хэрэгжүүлье. Энийгээ бүүр зорилго стратегийн зорилго нэг дотроо Монгол Улсын Их Хурал нь хүн төвт, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлнэ гээд нөгөө ахиад төгөлдөржүүлнэ гэдэг үг маань ороод тэгээд хүрэх үр донт дотроо хууль тогтоомжид.

Д.Амарбаясгалан: Галбадрах гишүүнд нэмэлт нэг минут.

Ж.Галбадрах: Тэгэхээр энэ хамгийн гол нь хүрэх үр дүнд маань хуульд аливаа хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байна гэсэн энэ заалт орсонд маш их сайшаалтай байна. Тэгэхээр боловсролын салбарт хүний эрх, ялангуяа хүүхдийн эрх маш ноцтой зөрчигдөж байгаа. Би одоо энийг нэг дэх өдөр бүлгийн хурал дээр бас ярихаар бэлдсэн байгаа. Жишээлбэл одоо 30 хүүхэдтэй байна аа. Нэг анги танхим, нэг сургууль 1400 хүүхэдтэй байна гэхэд энийг дээшлүүл гучаа больё 35-аа больё 40-өөс дээш гэхэд л 214 мянган хүүхэд сурч байна. Энэ бол маш ноцтой зөрчигдөж байгаа. Мөн 1400 хүүхдээ больё гэхэд 1800-аас дээш сургууль гэхэд 124 сургууль байгаа. Тэгээд энэ дотор чинь нөгөө спорт заалнаас эхлээд анги танхимын хүрэлцээнээс эхлээд 360-аад мянган хүүхдийн эрх ингээд зөрчигдөөд байгаа.

Тэгэхээр бид нар сая хууль тогтоомжид хүний эрх эрх чөлөө баталгаатай хангагдана гэхийн тулд зайлшгүй сургууль байгуулах болоод байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн ахлагч Булгантуяа гишүүн хариулъя.

Х.Булгантуяа: Галбадрах гишүүний хэлж байгаа үнэн. Өнгөрсөн удаагийн парламентын стратеги төлөвлөгөөн дээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэж үзэхэд 90 гаруй хувийн үнэлгээтэй гарсан. Ингэхэд ялангуяа өнгөрсөн парламентад бол 3 ди буюу дижитал, дээрээс нь нэмээд илүү их зөвшилцлийн аргачлалыг дэмжсэн нээлттэй байх гэх мэтчилэн эдгээр бол нэлээдгүй сайн хэрэгжсэн байна. Мөн хяналт шалгалт бол Улсын Их Хурал дээр бид нар анх ийм хуультай болж Улсын Их Хурал дээр хэд хэдэн хяналт шалгалтууд явагдсан. Үүн дээр бол олон нийт бас нэлээдгүй сайн үнэлсэн байна лээ. Үүнийг бид стратегийн 2.2 дээр бас тусгасан. Номинчимэг гишүүн түрүүн бас ярьж байсан. ТББХ-ны хороон дээр нэмэлт санал гаргаад бас нэмж оруулж өгсөн. Ингэхээр Монгол Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлж хууль тогтоомжийн үр нөлөөг тогтмол судлан, үр дүнг үндэслэн хуулийг нь боловсронгуй болгож хэвшинэ гэж.

Бид нар Улсын Их Хурлаас бас маш их хуулиуд батлангуут үнэндээ гэж хэлэхэд манай гүйцэтгэх засаглал бас сонголттойгоор хэрэгжүүлээд байдаг юм. Ингээд өөрөө өөрийнхөө бүтцийг томсгох, орон тоогоо нэмэх, дарга томилохыг бол их хурдан шуурхай хийчхээд байдаг. Яг заримдаа иргэд олон нийт рүү яг хүсэн хүлээгээд байсан нөгөө өөрчлөлтүүд нь зарим хуулиуд тэр битгий хэл гарчхаад журам нь батлагдаагүй хэчнээн жил болчихсон байдаг. Ингээд л иргэд олон нийтийн зүгээс нөгөө хууль тогтоомж чинь ордонд нэгээр яригдаад, гудамжинд нэгээр яригдаад байна гэж ойлгогдоод байна гэдэг чинь яг л үүнээс үүдээд байгаа учраас

бид нар Улсын Их Хурал хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлбэ гээд одоо бүр үүнийг хариуцсан Улсын Их Хурлын Тамгын газар дээр бүтэцтэй болж орж ирсэн байж байгаа.

Ингэхээр жишээлбэл Боловсролын багц хууль хэрэгжээд 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж байна гэхэд яг хуулийнхаа анх батлагдсан утга агуулгаар хэрэгжиж байна уу, үгүй юу гэдгийг Улсын Их Хурлаас гарсан манай Галбадрах гишүүн өөрөө ахалж байгаа. Энэ ажлын хэсгийн өөрөө үүн дээр нь үнэлэлт дүгнэлт өгөөд хэрвээ энэ сайн хэрэгжээгүй байх юм бол зарим зүйл заалтууд нь журмууд нь батлагдаагүй байх юм бол Улсын Их Хурал өөрөө араас нь баталсан субъектийн хувьд араас нь бас энэ хяналт тавьдаг байх нь бол зөв зүйтэй юм аа. Ер нь иргэдийн зүгээс шүүмжлэлтэй хандаад байгаа зүйл нь хууль тогтоомжууд улам л их төрийн эрх мэдлийг данхайлгасан, бүтэц орон тоогоо нэмсэн, яг иргэд олон нийт рүү чиглэсэн хүний эрхийг илүү хангасан ийм байдал дутуу дулимаг байна гэж шүүмжлээд байгаа учраас бид нар илүү хүнд төвтэй гэж оруулж өгсөн. Энэ манай бас алсын хараа 2050-д ч гэсэндээ бас орж өгсөн. Хүнд төвтэй байна аа, төрийн бүтэц, орон тоо, зохион байгуулалт ч гэсэн ийм байна гэж оруулж өгсөн нь эхнээсээ хууль нь л тийм байж байж тийм бүтэц зохион байгуулалттай болно гэсэн үг. Үүнийгээ дагаад сургууль цэцэрлэгийн асуудал ч гэсэн орно. Энэ бол ерөөсөө л хамгийн хүн төвтэй бодлого бол боловсрол, эрүүл мэндээсээ гээд л тэгээд л ингээд л хүний эрхийн хууль тогтоомжуудаас авхуулаад л явдаг. Тэгэхээр боловсролыг дэмжинэ гэдэг бол хүн төвтэй бодлогын нэг гол цөм нь болж орж өгнө өө л гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн нэмж хариулъя. Нэг минут.

С.Эрдэнэболд: Одоо яг амьдрал дээр болж байгаа жишээг би Галбадрах гишүүн дээр тайлбарлах гээд байгаа юм л даа. Юу вэ гэхээр бид нар ингээд сая ингээд төсөв баталж байгаа юм. Төсөв яаж байна гэхлээрээ 2025 оны хөгжлийн хөтөлбөрийг дагаж орж ирж байгаа юм. Хөгжлийн хөтөлбөрийн эрэмбийн 3-д нь хүн, 4-д нь хүний эрх чөлөө. Нэгд нь эдийн засаг, 2-т нь бүсчилсэн хөгжил гээд ороод ирж байгаа байхгүй юу. Эрэмбэ нь ингээд уруу гарчихсан. Тэгэнгүүт яаж байна гэхлээр энэ төсвийг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлж хянах тухай асуудал явагдангуут аудит хянаж чадахгүй байгаа юм. Хууль дээрээ байгаа мөртөөсөө хянаж чадахгүй. Яагаад хянаж чадахгүй гэхээрээ хэмжих нэгж нь тодорхойгүй гэдэг нь шалтгаан болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр үндсэндээ бол энэ парламентаас гаргаж байгаа төсөв ч юм уу энэ томоохон шийдвэрүүд дээр бид энэ шалгуур буюу эрэмбийн асуудал, хэмжих нэгжийг оруулж өгөх нь өөрөө маш чухал ач холбогдолтой байгаад байгаа юм аа. Энэ 1 дүгээр ач холбогдол.

Хоёрдугаарт та сая жишээлбэл хүүхдийн эрхийн асуудлыг ярьж байна. Энэ бол удиртгал зарчим бөгөөд одоо 2003 оны Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоолоор Монгол Улсад хүний эрхийг хангахтай холбоотой үндэсний 1 дүгээр.

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя. Галбадрах гишүүн тодруулъя.

Ж.Галбадрах: Баярлалаа. Ер нь тийм эрэмбийн асуудал байгаа. Үнэхээр л одоо бид нар яг энэ стратеги төлөвлөгөө дотор маань хүний эрх, хүн төвт гэдгийгээ бид нар 1 дүгээрт тавьж барьж байгаа нь маш чухал аа. Тэгээд би тэр хэлээд байгаа

хүрэх үр дүн гэдэг дотор л хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байна. Тэгэхээр яг энийг баталгаатай хангая гэвэл үнэхээр тэр 214 мянга, 360 мянган хүүхдийн асуудлыг хангая гэвэл сургууль барих л шаардлагатай болдог. Энэ төсөв дээр энэ жилийн төсөвт боловсролд оруулсан хөрөнгө оруулалт маань бүүр багасаад ирсэн. Тэгэхээр нэгэнт эрэмбээ тогтоогоод боловсролын салбар маань, эрүүл мэндийн салбар маань тэргүүлэх салбар учраас бид нар энэ тал дээр маш том хөрөнгүүдийг л оруулж ирж сургууль, сургууль, сургууль барьж байж л энэ нөгөө баталгаатай хангагдана гэдэг зүйл маань орох гээд байгаа. Тэгэхээр энэ би эхний алхам их сайн зорилт гэж ингэж талархалтайгаар хүлээж авч байгаа. Ийм учраас их зоригтойгоор Сургууль, сургууль, сургууль.

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуултаа асууя.

Г.Очирбат: Оройн мэнд хүргэе ээ. Тодорхой 5 асуулт байна.

Нэгдүгээрт энэ стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгааны хүрээлэнгээс хэчнээн санал яг яаж ирсэн бэ? Яагаад гэхээр бас би төсвийн төсөвтэй холбоотой 1 дүгээр хэлэлцүүлэг дээр хэлж байсан. Бид өөрсдөөсөө манлайллаа эхлэх ёстой гээд. Тэгээд энэ байгууллага дээр асар их хэмжээний мөнгө тавигдсан. Үр дүн нь яаж гарч байгаа, яг энэ стратеги төлөвлөгөөтэй холбоотой хэчнээн санал ирсэн бэ? Энийг нэг сонсчихъя.

Хоёрт гэх юм бол стратеги төлөвлөгөөний төсөлд тусгагдсан зорилго зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зүйлийг жил бүрийн төсөвт тусгаж байх заалтыг бас тогтоолын төсөлд оруулж ирсэн байна лээ. Тэгээд энэ бас хэчнээн хэмжээний мөнгө татвар төлөгч иргэдийн карманаас хэчнээн хэмжээний мөнгийг яаж төсөвлөх гэж байгаа юм. Энэ дээр бас нэг хариулт авчихъя.

Гуравдугаарт гэх юм бол ер нь энэ Улсын Их Хурлын дээр батлагдсан бүх хуулиуд чинь өөрөө энэ хүний төлөө ААН-ийнхээ төлөө батлагдсан хуулиуд шүү дээ. Тэгэхээр яг энэ хүн төвтэй гэдэг чинь Үндсэн хууль чинь өөрөө энэ чинь хүн төвтэй хууль иргэдийнхээ хүмүүнлэг ардчилсан нийгмийг цогцлоон бүтээнэ гэж байгаа ийм хууль байдаг. Тэгээд энэ дээрээсээ хүн төвтэй гэдгээ үзэл баримтлалын хувьд нэлээн тийм тайлбарыг тодорхой өгчихвөл зүгээр байна.

Дараагийнх нь бол иргэдээс олон хууль энэ Их Хурал баталдаг. Тэгээд яг амьдрал дээр хэрэгжиж байгаа хуулиуд чинь байхгүй байна гэдэг санал санаачилга гардаг. Хэрэгжиж байгаа гол хуулиуд нь юу вэ гэхээр нөгөө татвар авдаг, нөгөө Зөрчлийн хууль торгодог тийм ээ. Энэ хуулиуд бол их сайхан идэвхтэй хэрэгждэг яг нөгөө боломж олгосон эрх чөлөөг нь хамгаалсан энэ хуулиудын хэрэгжилт их сул байна гэдэг. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын хууль тогтоох чиг үүргээс гадна хууль тогтоомжийн биелэлтийг хянах, шалгах, хуулийн хэрэгжилтийг хянах, чиг үүргийг сайжруулах талаар яг ямар зорилтууд орсон юм бэ гээд үндсэн ийм 5 асуултдаа хариулт авчихъя.

Д.Амарбаясгалан: Эхний асуултад ЕНБД Баасандорж дарга хариулъя. Судалгаа хөгжлийн хүрээлэнгийн оролцоо ямар байсан талаар.

Б.Баасандорж: Гишүүний асуултад хариулъя аа. Ер нь нэлээдгүй гишүүд энэ оролцоо хүртээмжийн олон нийтийн оролцооны талаар асууж байна. Тэгэхээр манай энэ стратегийн баримт бичиг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг маань

яг байгуулагдсанаасаа авхуулаад энэн дээр онцгой анхаарсан. Яг энэ өөрөө энэ баримт бичгийг боловсруулахдаа иргэдийнхээ оролцоог, олон нийтийнхээ оролцоог илүү хангаж ажилласан байгаа. Тухайлах юм бол 2 удаагийн хэлэлцүүлгийг хийсэн. Энэ 2 удаагийн хэлэлцүүлэг дээр нэг удаагийн хэлэлцүүлэг нь бол 800 хүний оролцоотой 37 байгууллагын төлөөлөл оролцсон. Ийм 800 хүний оролцоотой хэлэлцүүлгийг хийгээд үүнээс нэлээдгүй олон би буруу санаагүй бол 50 гаруй санал гараад яг ажлын хэсгийн ахлагчид бүүр албан ёсоор санал, дүгнэлт зөвлөмжийг гардуулж өгсөн.

Дараа нь бид нар ахиад 150 гаруй хүний оролцоотой 30 орчим байгууллагын төлөөлөл оролцсон ийм хэлэлцүүлгийг хийгээд энэ дээр 48 орчим орчим санал гараад энэ санал нийтдээ 100 орчим саналыг Булгантуяа даргаар ахалсан. Ажлын хэсэг дээр санал тус бүрийг нэг бүрчлэн хэлэлцсэн байгаа.

Дээрээс нь мөн Булгантуяа дарга Номинчимэг нарын одоо ОУПХ-ны хуралд оролцсон. Энэ хурал дээрээ мөн ОУПХ-ны ЕНБД-д манай энэ стратегийн баримт бичгийг танилцуулсан байгаа. Тэгээд энэ дээр яг ОУПХ-ноос яг 9 зүйл заалт бүхий тодорхой саналуудыг өгөөд ялангуяа тэрэн дээр онцолсон санал нь энэ. Танайх энэ стратегитай энэ хүн төвт, хүн төвтэй гэдгийг онцолж хүний эрхийг илүү яаж байгаад чинь их сайшаалтай байна гэдэг саналууд нь ирсэн байгаа. Би хэрвээ шаардлагатай бол гишүүддээ танилцуулахад бэлэн байна гэдэг зүйлийг хэлье ээ. Мөн манай ажлын хэсэгт Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэн өөрөө ажлын хэсгийн бүрэлдэхүүнд байгаа. Энэ дээр бол яг олон улсын туршлага талаас нь бүүр голлож ажиллаж ажилласан байгаа гэдгийг гишүүндээ хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Хуулийн хувьд хүн төвт байна гэдэг утга зорилго бол 1 дүгээрт хуулийн философи нь өөрөө хүнийхээ төлөө байх ёстой, байгууллагын төлөө биш.

Хоёрдугаарт хуулийн бичдэг арга хэлбэр нь хүний эрхийг хамгаалах хангах чиглэлээсээ бичигдэж эхэлдэг байх ёстой. Түүрэн Эрдэнэболд гишүүн маш тодорхой нэг зүйлийг хэлж байгаа шүү дээ. Засгийн газрын хөгжлийн төлөвлөгөө ороод ирэхэд эдийн засгийн бодлого нэгдүгээрт, хүний асуудал 4 дүгээрт бичигдээд байна гэж. Тэгэхээр бид хүнийхээ асуудлыг 1 дүгээрт авч үздэг байя. Ялангуяа манай хууль үндсэндээ бол 20 дугаар зуунаас үндсэндээ үүсэлтэй гаралтай боловсорсон боловсон хүчний бүтээсэн хуулиуд голцуу явж байгаа юм. Жишээ нь Иргэний хууль 2002 оноос хойш шинэчлэгдэж өөрчлөгдөж чадаагүй, Дампуурлын хууль 1997 онд батлагдсанаас хойш шинэчлэлт хийгдэж чадаагүй. Тэгэхээр энэ нөгөө цаг үе хөгжил дэвшилтэйгээ хөл нийлүүлэх хүнийхээ асуудлыг бид урдаа барьсан эрх зүйн орчинтой болгох гэдэг бол энэ Улсын Их Хурлын стратегийг гаргаж байгаа үндсэн зорилго байгаад байгаа юм аа. Мэдээж хэрэг маш олон төрлийн хууль бол дандаа байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой салбарын дотоод асуудалтай холбоотой зохицуулалтыг хийхэд чиглэгдэж байгаа. Гэхдээ тэнд ахиад хүн байдаг гэдгийг бид дандаа санаж эрх зүйн орчиндоо хүн төвтэй бодлогыг хэрэгжүүлэх нь энэ стратегийн үндсэн зорилго юм гэж ингэж хариулах юм.

Эрдэнэболд гишүүн нэмж хариулах уу? ТББХ-ны дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн нэмж хариулъя аа.

Ж.Бат-Эрдэнэ: Манай гишүүдээс гарч ирж байгаа саналууд асуултууд дотор голчлон дэгтэй холбоотой асуудлууд бас яваад байх шиг байна аа. Сая Ганбаатар гишүүнийхтэй холбоотой асуудал дээр жишээ нь одоо хууль хэрэгжих нь яг хөрсөн

дээрээ буугаагүй хууль баталж бид нар баталчихдаг гэдэг ч юм уу энэ нь хөрсөн дээрээ бас их хэрэгжихгүй байна ч гэдэг юм уу нэг иймэрхүү зүйлүүд гарч ирээд байна. Тэгэхээр энэ стратеги дотор бол бид нар бүх зүйлийг нээлттэй байх ардчилсан байх гэсэн энэ гол зарчмыг энэ дотор хийлгээд байгаа юм. Энэ дотор хийлгээд байгаа юм.

Дээрээс нь энэ дотор жишээ нь бид жил бүрийн төлөвлөгөөгөө батлаад мэргэжлийн Байнгын хороод болон дэд хороод төлөвлөгөөнүүдийг нь оруулж ирээд энэ төлөвлөгөөнүүдийг ТББХ-н дээр төлөвлөгөөг нь хянаад ингээд явчих, баталж байгаад тэгээд энэ маань буцаад эргээд юун дээр очиж байна гэхээр нөгөө хэрэгжилт дээр яваад оччих юм. Хяналт дээр, хэрэгжилт дээр, хэрэгжилт дээр яваад очно гэхээр чинь нөгөө мэргэжлийн Байнгын хороод дээрээ бид нар буцаж эргэж очих ёстой.

Д.Амарбаясгалан: Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье. Гүйцээж хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Мэргэжлийн Байнгын хороодоос гарч ирж байгаа хууль, баталж байгаа ажлын хэсгүүд, хуралдаанд оролцож байгаа нөхцөл байдал энэ бүгд дээр чинь хүссэн хүсээгүй дахиад энэ дотор жишээ нь 2.2 дээр бол хууль тогтоомж хөгжлийн бодлогын уялдаа холбоо хангагдсан үр нөлөө нь дээшилсэн байна гээд. Ингээд гараад ирэхээр мэргэжлийн Байнгын хороогоо шахаад ирэх юм байгаа шүү. Тэгэхээр энд бол хөндлөнгөөс харж байхад бол урьд нь гишүүд маань бол хөндлөнгөөс хараад энэ Улсын Их Хурал юу хийгээд байдаг юм бэ гэсэн бол одоо дотор нь ороод ирэхээр Улсын Их Хурал дотор бүх боломж бололцоо чинь байгаа. Ажлын хэсэг дотор орох бололцоо байж байна. Тэр мэргэжлийн Байнгын хороон дотор орж асуудалтай нь танилцах саналаа хэлэх боломж чинь байж байна. Ингээд бүх боломж бололцоо нь хангаж байгаа учир ганцхан стратегийг нь бид нар энэ дотор тодорхойлоод энүүгээрээ шахаад явчихад бол бид нарт нэлээн том үр нөлөө бол гарна гэсэн ийм л ойл тоглолтыг хэлэх гээд байгаа юм шүү.

Д.Амарбаясгалан: Очирбат гишүүн бас төсвийн үеэр хөндөж байсан. Ер нь энэ парламент, Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнгийн төсөв ямар учиртай юм бэ? Төсөв тавьсан байна гээд асуудал хөндөж байсан.

Нэгдүгээрт парламент мэргэжлийн судалгааны байгууллагуудтай, тинк танкуудтай, эрдэмтэн судлаачидтай ажилладаг болох шаардлага гараад байгаа юм. Хууль боловсруулах үүрэг үндсэндээ Улсын Их Хурлын гишүүд дээр байгаад байдаг. Яг мэргэжлийн байж чадаж байна уу, үгүй юу гэдэг асуудал бас тэнчээнээс гараад байгаа учраас парламентын дэргэдэх Судалгаа хөгжлийн хүрээлэн түүгээр дамжуулаад мэргэжлийн эрдэмтэд судлаачдыг оролцуулдаг болж байгаа юм. Би өглөө хэлж байсан. Одоо Хууль зүйн сайд Алтангэрэл сайд бид одоо бас ярилцаад парламентын түүхэнд бараг анх удаагаа Мэргэжлийн хуульчдын холбоо мэргэжлийн өмгөөлөгчдийн холбоотой парламент энэ ажлын хэсгүүдийн хүрээнд, мэргэжлийн Байнгын хороодын хүрээнд нягт хамтарч ажилладаг жишгийг энэ удаа бид эхлүүлж байгаа юм. Жишээлбэл энэ бүх зүйл чинь тэр эрдэмтэд, судлаачид, мэргэжлийн төрийн бус байгууллагуудын оролцоог хангах, хөлс мөнгө төлөх олон асуудал энийг дагаад бий болдог гэдгийг бол их зөв ойлгох хэрэгтэй. Түүнээс тэр мөнгийг юу гэдэг юм, зөвхөн судалгаанд зориулаад юм уу, зөвхөн гишүүдийн хууль санаачлах процесс үйл ажиллагаанд зориулна гэсэн тийм ойлголт бол бас байхгүй ээ. Бүх талын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэл дээр ажиллана. Жишээлбэл

одоо Болдын Уянга гишүүнээр ахлуулсан ундны устай холбоотой хууль эрх зүйн орчны томоохон шинэчлэлтийн ажил эхэлчихсэн явж байгаа.

Тэгэхээр яг Улсын Их Хурлын гишүүн дангаараа тэр хуулийн нэмэлт, өөрчлөлтийг юм уу шинэчилсэн найруулгыг санаачлаад явъя гэхээр салбарын эрдэмтэд, судлаачид, төрийн бус байгууллагуудын оролцоо зайлшгүй шаардлагатай. Ахиад гаднын сайн туршлагаудыг судлах зайлшгүй шаардлагууд гарч ирдэг. Тэгэхээр энэ бүгд дээр л зөвхөн ажлын хөлс олгох тэр хэмжээн дээр бол асуудлууд нь яригдаж явна гэдгийг бас тайлбарлаж хэлье ээ.

Ингээд Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууна.

О.Батнайрамдал: Баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө орж ирж байна. Энэ баримт бичигт бол их сайшаалтай хандаж байна. Монгол Улсад парламентын ардчилал хөгжөөд 30 гаруй жил боллоо. 76 гишүүнтэй парламент нэг 30 гаруй жил үйл ажиллагаагаа явууллаа. Тэгээд түрүү зөвхөн жилийн өмнө бид нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө хийгээд парламентын дараагийн шатдаа нэг ёсондоо бараг энгийнээр залуучуудын хэллэгээр хэлэх юм бол парламент 2.0 руугаа орсон шилжилтийн үе явж байна гэж ойлгож байгаа. 76 гишүүнтэй байсан парламент өнөөдөр ингээд 126 гишүүнтэй анхны намрын чуулганаараа ингээд Их Хурал нь стратеги төлөвлөгөөгөө оруулж ирж байгаа нь бас зөв хэрэг л дээ. Ер нь ямар ч байгууллага бусад улсын парламентыг аваад үзсэн ч гэсэн стратеги төлөвлөгөөгөө бүрэн эрхийнхээ хугацаандаа бас гаргадаг ийм жишгүүд маш олон байгаа юм. Тэгээд энэ баримт бичгээ бас ОУПХ-н дээрээс бас цаг хугацаанд нь тааруулаад санал авна гэдэг аягүй их сайшаалтай.

Ер нь бусад орны жишгийг ялангуяа парламентын ардчиллыг илүү төгөлдөршүүлж чадсан орнуудаас ингээд харах юм бол хамгийн энгийн жишээ бол Англи улс байгаа юм. Англи улсын 2 танхимтай шүү дээ. Тэ хаус оф коммон буюу доод танхимдаа яг парламентын стратегийн төлөвлөгөө гэж бүрэн эрхийнхээ хугацаанд баталдаг стратегийн бичиг баримт байгаа юм л даа. Тэгээд яг энэ дээрээ яг бидний өнөөдөр хэлэлцэж байгаа парламент ард түмнийг төлөөлж, бага ард түмний, бага ард түмэн байхдаа ямар ч стратеги төлөвлөгөөний хүрээнд, цаашдаа ажлаа бүрэн эрхийнхээ хугацаандаа хэрэгжүүлэх вэ гэсэн стратегиа тодорхойлж явж байгаа юм. Тэгэхээр эндээс бас ажлын хэсгийн даргаас үүнтэй улбаатайгаар асуумаар байгаа юм л даа. Ер нь сая ОУПХ-ноос санал авснаас гадна ер нь бусад улсын ялангуяа парламентын ардчиллыг илүү төгөлдөржүүлж чадсан орнуудын жишгийг бас ингээд хир харж эндээ бас тусгасан юм бол оо? Олон жишээнүүд бас байгаа л даа. Тэгэхээр энийг бас сонсож байгаа хүмүүст ч гэсэн энэ ойлголтыг бид нар заавал олон талаас нь ойлгуулах ёстой. Зөвхөн өнөөдөр ингээд хэлэлцээд орхичих биш бусад үзэж байгаа ард иргэд ч гэсэн яг стратеги төлөвлөгөө баталчихсанаараа бас ямар давуу талтай юм яг ярина. Бид нар парламент илүү сайн, парламентын ардчилал илүү хөгжүүлж чадсан орнуудад бас ямар жишиг явдгийг бас ойлгох ёстой гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ асуултыг бас ажлын хэсгийн даргаас асууя.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн хариулъя.

С.Эрдэнэболд: Батнайрамдал гишүүн маш чухал асуудал хөндөж байгаа. Энэ ОУПХ-нд бол манайх 1962 онд гишүүнээр элссэн. Тэгээд 180 орныг багтааж байгаа гэдэг утгаараа яг энэ 180 орны парламентын туршлага сайн муу түүх ингээд

бүгд байгаа. Ер нь зүгээр шулуухан хэлэхэд сүүлийн жилүүдэд бол энэ дэлхий нийтийн хувьд, энэ ээдрээтэй бүс нутгийн асуудлууд гээд маш олон асуудал.

Дээрээс нь энэ сүүлийн үед энэ Европт болж байгаа энэ тогтворгүй байдал руу чиглэсэн гээд энэ бүх зүйл үйл явцууд бол энэ парламентын засаглалд маш том шалгуур болж байгаа. Хэдийгээр олон 100 жил болсон парламентын засаглал төлөвшсөн орнууд ч гэсэн тэр нь парламент нь төгс төгөлдөр гэсэн үг биш. Байнгын л популизмын асуудал. Дээрээс нь шашин хоорондын асуудал дээрээс нь ингээд бүс нутгийн хямралтай холбоотой маш олон асуудлууд байгаа юм. Тэгэхээр ер нь бол энэ парламентын ОУПХ ч гэсэн энэ шинэ тутам гарч ирж байгаа нийгмийн сорилт бэрхшээл, дээрээс нь технологитой холбоотой эдгээр асуудлууд дээр ер нь яаж иргэдийнхээ санал бодлыг илүү түлхүү тусгаж байх юм бэ гэдэг дээр бол маш чухал анхаарч байгаа.

Бидний хувьд гэх юм бол энэ 126 суудалтай парламентын дизайныг бол авахдаа бол Шинэ Зеланд улсаас бас нэлээн ингээд туршлага судалж байсан. Миний хувьд бол Монгол Шинэ Зеландын парламентын бас бүлгэмийн ахлагчаар ажиллаж байгаа. Энэ чиглэлээс бас нэлээн судалгаануудыг бас Их Хурлын даргын чиглэлээр бас ингээд хийж байгаа. Ер нь бол сайн туршлагууд дээр бол нэлээн ажиллаад явж байгаа.

Хоёрдугаарт нь таны нэг хариуцаж байгаа ажлын хэсэг бас байгаа юм аа? Стандарттай холбоотой. Ер нь бол энэ иргэний эрхийг хангана гэдэг иргэн төвд байна гэдэг бол ерөөсөө л стандартын асуудал юм байна лээ. Зам талбай барьсан ч тэр, хүнсний аюулгүй байдал ярьсан ч тэр усны хатуулгийн асуудал ярьсан ч тэр, түгжрэл, агаарын бохирдол ярьсан ч тэр бүх л юман дээр стандартын асуудал яригдаж байгаа юм. Ийм эзэн биегүй хүн төвтэй гэдэг ингэж чихэр долоолгосон биш, яг тодорхой хүн төвтэй бодлогын чинь шалгуур өөрөө тэр бүх төрлийн хүндээ чиглэсэн л стандарт юм байна гэж үзэж байгаа юм.

Тийм учраас бас Батнайрамдал гишүүн энэ маш чухал ажлын хэсгийг ахалж байгаа. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хуулиудад стандартыг зөв оновчлолтойгоор гаргаж ирэх. Энэ нь уг угтаа цаашлаад хүний эрх, эрх чөлөөг хангасан нөгөө хүндээ чиглэсэн ээлтэй хүмүүнлэг иргэний нийгмийг л одоо байгуулахад энэ стандартыг бид нар авч үзэж байгаа юм шүү. Тийм учраас бас энэ таны санал санаачилга, цаашдаа таны ажлын хэсгээс гарах тэр стандартын ач холбогдолтой шийдвэр гаргалтууд чинь бас эргээд энэ парламентын шийдвэр гаргалт болон энэ зохицуулалт дотроо бас ингээд шалгуур үзүүлэлт болоод ороод явах ёстой гэж бодож байгаа. Тэгээд ер нь бол бид нар 180 оронтой бүгдтэй нь бол нэг бүрчлэн мэдээж туршлага судлаагүй. Гэхдээ гол санаануудаа ОУПХ-ноос ирсэн 9 саналыг энд тусгасан байгаа юм. 9 саналыг тусгасан. Урьд нь бол санамж бичгийн түвшинд байнга ингээд ажлуудаа уялдуулаад яваад байгаа гэсэн үг.

Тийм учраас энэ бол олон улсын чиг хандлагад нийцсэн олон улс дахь хүний эрхийг хамгаалах шийдвэр гаргалтын чиг хандлагад нийцсэн стратеги болгох гэж бид нар бас хичээсэн байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ ээ.

А.Ганбаатар: Би Булгантуяа даргын ахалсан энэ ажлын хэсэгт ажиллаж байгаа. Тэгээд ажлын хэсгийн хуралдаан дээр өөрийн санал бодлоо бас

илэрхийлээд явж байсан. Энэ удаагийн парламентын стратеги төлөвлөгөө бол зайлшгүй шинээр батлагдах ёстой. Учир нь юу вэ гэвэл Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт Сонгуулийн хуульд бас өөрчлөлт орсонтой холбоотойгоор энэ удаагийн парламент, олон намын төлөөлөл, олон ургалч үзэл бодол хуримтлагдсан ийм баян бүрд болчихсон ийм парламент болсон гэж үздэг. Тэгээд шинэ спикер өөрийн үзэл санаа бас өөрийнхөө ажиллах зарчим стратегиас авхуулаад институцийн соёл хүртэл нь бас харсан байх гэж бодож байгаа. Тэгээд энэ хүн төвтэй гэж онцлоод байгааг нь бол сая Эрдэнэболд гишүүн манай ажлын хэсгийн гишүүн гол нурууг нь бас нугалсан гишүүдийн нэг хэлж байна.

Хүн төвтэй байна гэдэг чинь ерөөсөө л энэ хүний төлөө хууль эрх зүй нь үйлчилдэг. Хүнд нийцсэн стандартаа барина л гэсэн үг л дээ. Энэтэй бол санал нэг байгаа. Тэгэхээр энэ Их Хурал энийг стратегидаа онцолж байгаа юм байна аа. Төлөвлөгөө бол стратегиасаа тусдаа зүйл. Төлөвлөгөөндөө энэ ажил тусаад явах нь гэж харж байгаа. Парламентын засаглалаас ухрахгүй байх гэдэг зарчмыг бол энэ стратегийн төлөвлөгөөнд тусгасан байх.

Нэгдүгээр хамгийн чухал асуудал парламентын засаглалаас ухрахгүй байх гээд. Гишүүд өөрсдөө үлгэрлэгч байна. Ирцээсээ авхуулаад л мэдээж хүндэтгэх шалтгаантай хүмүүсийг хэлэхгүй байна. Оролцоо нь маш чухал байгаа. Олон ажлын хэсэгт олон Байнгын хороо чуулгандаа сууж байгаа ч гэсэн сууж бүртгүүлэхээс өгсүүлээд санаа бодлоо тусгуулах нь бидний үндсэн үүрэг. Ёс зүйн хариуцлагын асуудал мэдээж яригдана. Их Хурал хууль баталж байгаа. Хууль дүрмийн хэрэгжүүлэлт хяналт бол бидний бас тавих ёстой үүргийн нэг байгаа. Ингээд мэдээж нээлттэй хэлэлцэж бүгдээрээ хэлэлцээд бүлээн усаар угаагаад хиргүй болсны дараа нэгэнт хиргүй болсон тэр хууль дүрмээ олонхынхоо гаргасан шийдвэрээ дагаад явдаг энэ зарчимд суралцах ёстой гэсэн ийм байр сууриудыг илэрхийлсэн тэгээд бүгд туссан байна. Баярлалаа.

Ажлын хэсгийн дарга Булгантуяа дарга танд баярлалаа. Ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

Гишүүд маань бас дэмжиж баталж өгөөрэй гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Энэ Ганбаатар гишүүний саяын тайлбар дээр бас нэг тийм судалгаа байдаг юм байна лээ. Бид бас тэрийг их онцгой анхаарах ёстой. Иргэдийн дунд явуулж байгаа судалгаагаар хуулийн хэрэглээ хэдэн хувьтай байна вэ гэхээр 30-аас дөчхөн хувьтай. Хуулиа хэрэглэж байгаа юм мэдэж байгаа нь гэсэн үг болчхож байгаа юм. Энэний яг тэр судалгаа хийсэн судлаачдын дүгнэлт юу вэ гэхээр хууль 1 дүгээрт өдөр тутмынх нь амьдралд шууд хэрэг болохгүй байгаад байна. Хэт их ерөнхий байгаад байна. Тэгэхээр нөгөө хуулийн талын ойлголт, хуулийн хэрэглээ ийм сул байгаад байгаа шүү гэдэг зүйлийг тэр судалгаан дээр бол дүгнэсэн байдаг юм байна лээ.

Тэгэхээр бид бол энэ хуулийг амьдралд нийцдэг хэрэгждэг болгож өгнө гэдэг бол хүний асуудлыг зөв хөндөж, асуудлыг нь шийдвэрлүүлэх, хэрэглэдэг байх тэр боломжийг бүрдүүлж өгнө гэдгээрээ бас их тийм онцлогтой зүйл болж орох юм билээ. Тэгээд ажлын хэсэгт ажилласан гишүүд бол маш их тийм дэвшилтэт үзэл хандлагаар энэ стратегийг боловсруулж орж ирж байгаа. Энэ бол шинээр бүрдсэн 126 гишүүнтэй парламентын одоо нүүр царай болох юм л гэдэг талаасаа ач холбогдол өгч гишүүд маань ч гэсэн өнөөдөр төсөв хэлэлцэж байгаа юм шиг маш

олон гишүүд асуулт асууж, үг хэлж байна. Энэ бол чухал ач холбогдол өгч байгаагийн том илэрхийлэл байна гэж ингэж харж байна.

Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууж, үг хэлнэ ээ.

Д.Пүрэвдаваа: Оройн мэндийг хүргэе ээ. Ажлын хэсгийнхэн болон энэ холбогдож ажилласан хүмүүсээс хэд хэдэн юм асуумаар байна.

Нэгдүгээрт одоо төлөвлөгөө батлах гэж байгаа бол өмнө нь хэрэгжээд энэ 2024 он хүртэл хэрэгжсэн төлөвлөгөө маань яаж үнэлэгдсэн юм бэ хэдэн хувиар үнэлэгдсэн юм бэ? Бүх юм л амжилттай сайхан болж байна л гээд л. Ялангуяа сонгуулийн үеэр бол 2020-2024 оны парламент онцгой ажиллалаа л гээд тэгж байсан юм. Тэгээд миний нэг санаж байх юм энэ манай Нийслэлийн иргэдийн хурлын дарга Дагва гээд хүн нэг тэгсэн юм. Улаанбаатарчууд 92 хувь нь аз жаргалтай байгаа шүү дээ, гараад хараач гээд. Тэгээд би бол тэгж л санал нийлэхгүй байгаа юм тэрэнтэй нь. Одоо тэгээд та нар дүгнэхдээ хэдэн хувь аз жаргалтай, энэ 2020-2024 оны парламент яаж дүгнэсэн юм бэ? Эхлээд өнгөрсөн тэр үйл ажиллагаагаа нэг дүгнээд стратегиа ярих нь зүйтэй байх гэж харж байгаа юм.

Хоёрдугаарт эргэж буцсан шийдвэр маш олон гарсан. Хүн төвтэй байгаагүй юм шиг л байсан. Яагаад Төсвийн тухай хууль өргөн баригдахдаа жишээгээр 10 сарын 1, 9 сарын 1 гэхэд 8 сарын 30-нд заавал ер нь яг ингэж тулгаж өргөн барьдаг юм. Сонгуулийн хууль батлагдах болгондоо шинэ жилийн өмнө 6 сарын өмнө тулгаж Сонгуулийн хуулийг өөрчилдөг, тойргийг өөрчилдөг. Хүн төлөвлөх, үйл ажиллагаагаа төлөвлөх бүх боломжийг хаадаг. Ийм л парламент байсан юм шүү дээ одоо. Одоо тэрийгээ та хэд хэд гэж үнэлэх юм?

Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд нэг удаагийн нэг илтгэл дээр би санаж байх юм 700 гаруй хөтөлбөр бодлогын бичиг баримт Улсын Их Хурал батлаад өдөр тутам ашиглагдаж байгаа нь нэг 20 хүрэхгүй байдаг гээд нэг удаа яригдаж байсан. Яг тоо нь хэд байдаг юм? Тэгээд хүн төвтэй гэж ярьж байгаа юм бол яагаад энэ ордныхоо хашааг авчхаж чадахгүй байгаа юм. Нийслэл хот чинь ингээд хашаануудаа буулгаад байдаг. Хотын төвдөө цайз хэрэмтэй байж байж өнөөдөр Их Хурал өнөөдөр ингээд хүн төвтэй гэж ярих юм. Иргэдтэй уулзъя гэхээр зэрэг төрийн хамгаалалт нь хаачихсан. Өглөө эрт 7 цагт хүнтэй уулзъя гэхээр 9 цагаас нааш нь нээдэггүй, орой 5 цаг гэхэд бүгдээрээ гар гээд яадаг. Өнөөдөр ажлаа тараад хүнтэй уулзаж болно шүү дээ. Гэтэл өнөөдөр энэ парламент чинь хаалттай л байна шүү дээ. Нэг давхарт ядаж иргэдтэй, ААН-үүдтэй уулзах өрөө ч байхгүй шүү дээ. Тэгэхэд захын компани өнөөдөр иргэдтэй уулзах өрөөтэй байдаг.

Тэгээд өнөөдөр энэ зорилт, хүрэх үр дүнг нь харах юм бол энэ бас л нэг сонин л харагдаад байх юм. Урьд өмнө нь юу ч хийж байгаагүй юм шиг, цоо шинээр өнөөдөр өглөөнөөс эхэлж байгаа юм шиг л ийм стратеги төлөвлөгөө орж ирж байна шүү дээ. Тэгээд хэдэн хүнээс санал авсан юм, хэдэн удаагийн уулзалтаар энэ стратеги, төлөвлөгөө, иргэдтэй уулзсан юм? Саналыг нь авсан юм бэ гэдгийг бүр тодорхой асуумаар байна. Тэгээд миний саяын асуусан эргэж буцсан шийдвэр хэд байгаа юм. Бид нарын жижиг Үндсэн.../минут дуусав/.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Булгантуяа гишүүн хариулъя аа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөг Тамгын газрын хяналт шалгалт, үнэлгээний газраас 2022 онд 68.7 хувийн

хэрэгжилттэй 2024 онд 92 орчим хувийн хэрэгжилттэй байна гэсэн. Гэхдээ өнгөрсөн удаагийн стратеги бол шинэ Үндсэн хууль батлагдаад дээрээс нь нэмээд илүү их дотоод үйл ажиллагаагаараа илүү их чиглэсэн байсан. Хяналт шалгалтын тухай хуультай болъё, энэ хуулийн хэрэгжилтийг хангая дээрээс нь нэмээд дижитал шилжилтийг хийе, цахимжилт тэгээд дээрээс нь нэмээд олон нийтэд нээлттэй байх дээр илүү их ажиллая гэх мэтчилэн ийм зүйл дээр илүү их анхаарсан байсан.

Тийм учраас бас хэрэгжилт бол харьцангуй гайгүй сайн гарсан. Тэгээд өнгөрсөн удаа анх удаа бид нар ди парламенттай болсон. Хяналт шалгалтын тухай хуультай болсон. Олон удаагийн сонсгол явуулсан. Тэгэхдээ энэ нь бол бас хангалттай биш байна гэдэгтэй бол тантай санал нэг байна. Тийм учраас бид нар үүнийг үргэлжлүүлэн тусгаж байгаа юм.

Тийм ч учраас сая дэлхийн улс орнуудыг аваад үзэхэд нөгөө парламент нь бүүр төлөвшчихсэн ийм олон жилийн түүхтэй улс орнуудын хуулийн ийм стратеги төлөвлөгөө байхгүй байгаад л Улсын Их Хурлын тухай хуулиараа том дүр зургаараа Үндсэн хуулиа хэрэгжүүлнэ гээд л ингээд явахад хангалттай байна гэсэн үг. Зарим улс орнуудын хувьд бол яг тулгамдсан асуудал дээрээ стратеги төлөвлөгөө гаргаж байна. Жишээлбэл Английн парламент гэхэд дижитал шилжилтийнхээ чиглэлээр 2024-2028 он гээд стратеги төлөвлөгөө гаргаж байх жишээтэй. Манайд бол юм болгон тулгамдсан асуудал болж байна. Хүний эрх, эрх чөлөөг хангах дээр, дижитал шилжилт хийх дээр олон ургалч үзлийг бэхжүүлэх дээр тэгээд өнгөрсөн 2 удаа цагийн парламент бол 76 гишүүнээс 60 гаруй хувь нь гишүүд нь, одоо МАН-ын гишүүд байсан шүү дээ.

Тэгэхээр илүү их энэ удаагийн Улсын Их Хурал парламент бол илүү онцлог гэдгийг бид нар бас нөгөө талдаа бас хүлээн зөвшөөрөх ёстой. Тэгэхээр энэ үүднээсээ бид нар энэ удаа илүү их гадагшаагаа 1 дүгээрт чиглэсэн байя.

Дээрээс нь нэмээд илүү их ургалч, олон ургалч үзлийг, дээрээс нь шинэ цагийн хэрэгцээ шаардлагыг ч гэсэн бид нар тусгаж авч үзэх ёстой гэж. Тэгэхдээ ер нь бид нар нэг ингээд харахад нөгөө ийм үгнүүдээс нэг татгалзах ёстой юм шиг байна лээ. Төгөлдөржүүлнэ, бүрэн хэрэгжүүлнэ гээд. Яагаад гэвэл энэ хэзээ ч гүйцэшгүй юм байна лээ. Тэгээд өнөөдөр нэг эрхийг нь ингээд хангаж байтал шинэ төрлийн эрх үүсэхийг үгүйсгэхгүй. Дижитал девайстай дижитал байдлаар мэдээлэл авах бол нэг төрлийн шинэ эрх болчихоод байгаа шүү дээ. Тэгэхээр энүүнийг цахимжилтаас үүдээд жишээлбэл шилэн кабельгүйгээс үүдээд мэдээллээс хоцрох гээд байгаа ард иргэд ч гэсэн үүний дотор байгаа гэсэн үг. Тэгэхээр аль болохоор бид нар энэ шинэ цагийн хэрэгцээ шаардлагад тулгуурлаж үүнийг бид нар хэрэгжүүлэхийн төлөө ажиллана гэж тусгасан байж байгаа. Зарим нэг нь Улсын Их Хурлын Тамгын газраас нэмж хариулах уу?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон. Хосжаргал зөвлөх хариулъя.

А.Хосжаргал: Сайн байцаана уу? Ажлын хэсэгт хөндлөнгөөс орж судлаачаар ажилласан Хосжаргал. Бид нар олон улсын 30 гаруй улсын парламентын жишгүүдийг судалсан.

Дээрээс нь бол судалгааны хүрээлэнтэйгээ хамтраад бид нар нийт 21 аймгийн, 9 дүүргийг хамруулсан 2500 иргэдээс бас хүлээлтийн судалгаануудыг авсан. Энэ дээр бол 60 гаруй хувь нь илүү иргэдэд чиглэсэн асуудлуудыг парламент

энэ удаад шийдээсэй гэсэн ийм хүлээлтийг бас илэрхийлсэн. 2 удаагийн хэлэлцүүлгээр түрүүн бас Баасандорж дарга дурдаад өнгөрсөн. 2 удаагийн хэлэлцүүлгээр нэг удаагийн хэлэлцүүлэгт нь 800 гаруй иргэд 37 байгууллагын төлөөллүүдийг оролцуулаад хэлэлцүүлэг хийснээс бол 50 гаруй санал зөвлөмж ирснийг ажлын хэсгийн гишүүдээрээ хэлэлцээд тодорхой байдлаар тусгаж явсан байгаа гэдгийг бас нэмж хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Тавьхан хүний санал авсан юм уу? Би тэгээд энэ асуултад хариулаадхаач. Энэ хэдэн удаагийн уулзалтаар яаж зарлаад хэчнээн хүнээс санал авчихсан юм бэ гэдгийг асуусан.

Хоёрдугаарт энэ 4 жил болохдоо энэ гадаа байгаа энэ цайз хэрэм шиг хашаагаа авч хаяад иргэддээ нээлттэй гишүүн бүртэй чөлөөтэй уулзах тэр үүд хаалгыг нээхэд саад болоод байгаа шалтгаан нь юу байдаг юм? Нэмээд нэг асуухад энэ хууль болгоныг хугацааг нь тулгаад яагаад ингээд эцсийн өдөр нь ингээд заавал өргөн барьж байдаг юм? Энийг тэгээд хүн төвтэй гэж нэрлэх юм уу. Өнгөрсөн удаад тэгээд хэр их хүн төвгүй байсан юм бэ? Одоо тэгээд тэр хүн төвийнх нь хэд дахин нэмэгдэх юм.

Д.Амарбаясгалан: Нэгдүгээрт Улсын Их Хурлын гишүүн бол Монголын нийт ард түмнийг мажоритар тогтолцоогоор сонгогдсон гишүүд бол бас газар нутгийг бүрэн төлөөлөх эрх үүрэгтэйгээр ажилладаг гэдгийг бас Пүрэвдаваа гишүүн өөрөө маш сайн мэдэж байгаа байх.

Монгол Улсын иргэн бүрээс нэг бүрчлэн санал авч асуудлыг шийдвэрлэнэ гэвэл өнөөдөртөө тийм боломж бол бүрэн хангалтгүй. Яагаад энэ судалгаа гэж байдаг юм бэ гэдэг чинь нийт иргэдийг төлөөлөх чадвартай төлөөллөөс санал сонсох, судалгаа авах гэдэг бол өөрөө шинжлэх ухаан. Шинжлэх ухааны үндэстэй зүйл. Тэгэхээр Монгол Улс орон даяар 2500 иргэн дунд явуулсан судалгаан дээр үндэслэж төслөө боловсруулж, зөвлөх үйлчилгээгээ үзүүлж, энэ төсөл босож ирсэн гэж ингэж бол бас маш тодорхой тайлбар өгч байна. Нэг дэх асуудал.

Хоёр дахь асуудал. Хүн төвтэй гэдэг дээр уурлаж унтууцах зүйл ерөөсөө байхгүй. Бид хүний эрх, хүний эрхийг бүрэн баталгаатай хангадаг болохын төлөө өдөр болгон алхам хийж байх ёстой. Өдөр болгон сайжруулалтыг хийж байх ёстой. Өчигдөр өнөөдрөөс өөр. Маргааш өнөөдрөөс бас ахиад өөр. Тийм учраас хөгжил дэвшлийн энэ хурдыг гүйцсэн хууль эрх зүйн орчны өөрчлөлт шинэчлэлт гэдэг зүйл ус агаар мэт хэрэгтэй. Түрүүн Сайнзориг гишүүн үгэндээ хэлж байсан.

БНСУ 3 жил тутамд иргэн, аж ахуйн нэгж, төр, парламент гээд бүх талын оролцоотойгоор хуулийн нийцлийг хангаж хоцрогдлыг арилгаж явж байдаг. Бид өнөөдөр энийгээ хийх замаа тодорхой болгож өнөөдрийн энэ стратеги батлагдаж байгаа гэдгийг бас гишүүд маань бүх талаас нь харж ойлгох ёстой. Бид хэн нэгнээс хариуцлага нэхэж биш энэ сонгогдчихсон байгаа Улсын Их Хурлын 126 гишүүн ард иргэдэд яг энэ тулгамдаад байгаа, эрх нь зөрчигдөөд байгаа, эрх нь хязгаарлагдаад байгаа энэ зүйлүүдийг бид найдвартай баталгаатай бий болгож өгөхийн төлөө өнөөдөр энэ стратеги орж байна гэж ингэж ойлгож болно.

Улсын Их Хурлаас 3 төгөлдөршлийн бодлогыг бас дэвшүүлж ажиллаж байгаа. Улсын Их Хурлын гишүүдэд энэ талын бүх танилцуулга мэдээллүүд очсон.

Нэгдүгээрт хүний эрхийн зөрчилгүй хууль эрх зүйн орчин болъё. Ингэхийн тулд хуулийн заалт тус бүрээр нь авч үзэж хүний эрхийн зөрчлийг арилгах энэ дотроо хуулийнхаа философийг хүн төвтэй болгох том зорилго орж ирж ажиллаж байгаа. Энэ бол одоо түрүүн ярьж байна. 20, 21 дүгээр зууны чиг хандлагын маш том ялгаа. Ардчилсан Үндсэн хууль батлагдаад 32 дахь жилдээ орж байна. Бид 21 дүгээр зууны иргэдийн хэрэгцээг хангасан иж бүрэн зохицуулалттай хууль эрх зүйн орчныг бүрэн баталгаатай болгож өгөх нь энэ Их Хурлын үүрэг юм аа. Тийм учраас өнөөдөр Их хурал стратегиа тодорхойлж энэний төлөө 15 гишүүн 2 сар гаруйн хугацаанд эрдэмтэд судлаачидтай, парламентын дэргэдэх судалгааны байгууллагатай мэргэжлийн зөвлөх компанитай, зөвлөхүүдтэйгээр ажиллаж байж өнөөдрийн стратеги гарч ирсэн гэдгийг бас хариуцлагатайгаар хэлье ээ.

Ингээд Сайнбуянгийн Амарсайхан Шадар сайд асуулт асууж, үг хэлнэ.

С.Амарсайхан: Би санал хэлнэ ээ. Энэ Улсын Их Хурлын стратеги үндсэндээ бол хууль эрх зүйн сайжруулалт тэгээд хүн төвтэй хөгжлийн тогтвортой бодлого, иргэний оролцоо, хяналт цаашлах юм бол эдийн засаг, байгаль орчин, мөн аюулгүй байдал, тусгаар тогтнол, нийгмийн хамгаалал, хариуцлагын тогтолцоо гээд Улсын Их Хурлын стратегийн чиг үүргийн бүхий л агуулгыг оруулсан ийм товч тодорхой стратеги болсон байна гэж дүгнэж байгаа. Тэгээд энэ стратегийг ингээд батлаад цаашаа хэрэгжүүлнэ ээ. Хэрэгжүүлэхэд бид одоо энэ Улсын Их Хурал өөрөө стратегиа, стандарттай хэрэгжүүлэх ёстой гээд. Сая хэд хэдэн гишүүн ярилаа. Нөгөө загатнасан газар маажна гэдэг шиг. Энэ стандарт гэдгийг яагаад яриад байгаа юм? Яагаад стандарттай байх ёстой юм гэдэг зүйл энэ танхимаас эхлэх ёстой гэж бодож байгаа юм.

Улсын Их Хурлын энэ танхим бол өөрөө Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, ард түмний итгэл найдвар, итгэл үнэмшил, сэтгэл итгэл бүр цаашлах юм бол энэ нийгмийн ёс суртахууны оргил гал голомт болсон ийм чухал танхим гал голомт нь. Мөн энэ ард иргэдийнхээ хүсэл тэмүүллийг ирээдүй хойч үеийнхээ итгэл үнэмшлийг тээж орж ирсэн гишүүд энд сууж байна гэж бодож байгаа. Бид бас амаргүй нөхцөл байдалд ажиллаж амьдарч байгааг та бүхэн маань мэдэж байгаа. Ковидын үед ямар их хүнд нөхцөлтэй ард түмнээрээ байлаа. Одоо бас эдийн засгаа босгох гээд энэ асуудлуудаа шийдэх гээд явж байгаа. Тэгэхдээ хэд хэдэн зүйл дээр анхаармаар байна.

Нэгдүгээрт энэ бүс нутаг олон улсын геополитикийн нөхцөл байдал улам ээдрээтэй, энх тайван, аюулгүй байдал тогтворгүй, эмзэг болж байна. Улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явцууд тодорхойгүй бөгөөд мухардмал байдалд орж байна. Хаа сайгүй хөгжингүй улс орнуудын сэтгэлгээ соёлын цаашлах юм бол мэдээлэл, технологи, хиймэл оюун ухааны давлагаанд хөгжиж байгаа жижиг буурай улс орнууд цохигдох нэрвэгдэх ийм эрсдэлүүд бий болж байна. Том улс гүрнүүдийн гео стратегийн байр суурь бас тодорхойгүй таахын аргагүй нөхцөл байдалд явж байгаа. Энэ нөхцөлд Монголчууд та бүхэн гэж биднээс асууж байна. Нарийн ярих юм бол бидний энэ улс эх орны торгон хилийг тогшиж байна Монголчууд гэж. Төрийн бодлогын хар хайрцгийг бас тогшиж байна аа. Шийдвэр гаргагчид аа, Монгол хүн бүрий бүрийн оюун санааг бас тогшиж байна. Монголчууд та нар юу бодож байна аа? Юу сэтгэж байна аа? Яаж цаашаа энэ хурдтай өөрчлөгдөж байгаа хувьсан өөрчлөгдөж байгаа ертөнц дэлхийд амьдарч аж төрж.

Д.Амарбаясгалан: Нэмэлт нэг минут өгье.

С.Амарсайхан: Гэдэг ийм асуултын тэмдгүүд хаа сайгүй биднийг тогшиж байна аа. Тэгэхээр бидэнд бид эв нэгдэлтэй энэ улс орноо авч явах зайлшгүй шаардлагатай. Төрийн түшээ гэдэг бол бүхнийг мэдэх ч биш, бүхнийг үгүйсгэх ч биш. Би одоо энэ танхимд шинэ Улсын Их Хурлын энэ чуулган танхимд бол ерөнхийдөө сүүлийн чуулган эхэлснээс хойш ажиглах маягтай байгаа. Тэгэхдээ зарим зүйл дээр гэрийн эзэгтэй шиг, эсвэл айлын нөхөр шиг аашилж байгаа энэ улс төрийн хандлагууд бол арай хэтэрч байна. Гэрийн хүн биш төрийн хүн болсон гэдгээ, төрийн түшээ болсон гэдгээ зарим нь жоохон ойлгож ухаарч энэ улс орны нэгдмэл эрх ашиг нийтлэг үнэт зүйлтэй холбоотой асуудал дээр жоохон бодолтой бодлоготой хандахгүй бол иймэрхүү байдлаар цаашаа яваад хувийн эрх ашиг жижигхэн амбицаа улс төрийн жижиг тоглолт болгож улс орныг хуваадаг, талцуулдаг, гадна дотнын нөлөөнд автдаг, ард түмнийг төөрөгдүүлдэг, амьдрал ахуйд нь сөргөөр нөлөөлдөг ийм увайгүй үйлдлүүд бол бас байж болохгүй.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. Ажлын цаг дуусаж байгаа учраас чуулганы нэгдсэн хуралдааны өнөөдрийн хуралдааныг өндөрлүүлье. Маргааш өглөө өнөөдрийн хэлэлцсэн асуудлуудаар санал хураалтууд явагдана аа. Чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөлөө.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*